



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

## ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

**2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 16
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	17 - 155
<hr/>	
1. <i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/</i>	21
2. <i>Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	21 - 105
3. <i>Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	105 - 154
4. <i>Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай</i>	154 - 155

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 20-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 11 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилоттой: А.Адъяасүрэн, Б.Баттөмөр, С.Бямбацогт, Б.Жаргалмаа, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор;  
Эмнэлгийн чөлөөтэй: Г.Дамдинням, Ж.Чинбүрэн;

Тасалсан: С.Батболд, Х.Болорчулуун;

Хоцорсон: Э.Батиугар – 06 минут, С.Ганбаатар – 19 минут, Х.Ганхуяг – 2 цаг 26 минут, Т.Доржханд – 03 минут, Б.Жавхлан – 01 минут, М.Оюунчимэг – 04 минут, Ж.Сүхбаатар – 2 цаг 47 минут, Ч.Ундрам – 03 минут, Д.Цогтбаатар – 04 минут, Б.Энх-Амгалан – 03 минут, Б.Энхбаяр – 39 минут, Ж.Эрдэнэбат – 16 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 78 жилийн өмнө 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг тусгаар тогтносон улс байлгахын төлөө бүх ард түмний санал хураалт явуулсан түүхэн өдөр болохыг тэмдэглэж, Улсын Их Хурлын гишүүдэд мэндчилгээ дэвшүүлэв. /алга ташив/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо. /10:16/

**Нэг. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр,

Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ, Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэг, Эдийн засаг, хөгжлийн дэд сайд Г.Түвдэндорж, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Соёлын дэд сайд М.Батбаяр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Х.Хашбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ц.Батбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын дарга, тэргүүлэх аудитор Я.Самбууням, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасаням, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Зам, тээврийн хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Цэвэлмаа, мөн хэлтсийн шинжээч Ш.Гүнсэндарь, мөн яамны Авто замын бодлого, зохицуулалтын газрын шинжээч Б.Цэрэнсодном, Батлан хамгаалах яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Оюунгэрэл, Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны Ажлын албаны дарга Ц.Батгэрэл, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Оюун-Эрдэнэ, мөн хорооны Хилийн боомтын захиргааны Захиргаа, санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Я.Дүгэржав, Гаалийн ерөнхий газрын дарга Р.Отгонжаргал, мөн газрын Тариф, татварын газрын гаалийн улсын ахлах байцаагч Д.Ганцэцэг, Татварын ерөнхий газрын Татварын удирдлагын хэлтсийн дарга Д.Цогтжаргал нар оролцов.

---

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн гаргасан, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна гэсэн санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43  
Татгалзсан: 5  
Бүгд: 48  
89.6 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

**Г.Занданшатар:** Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42  
Татгалзсан: 6  
Бүгд: 48  
87.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод

хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга Т.Батболд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга Г.Мөнхбаяр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч Г.Оюунболд, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын шинжээч Б.Дуламсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Янжмаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Гэрээт зөвлөх, Хүүхэд хамгааллын судлаач С.Энхтуяа, Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн Б.Жавзанхүү, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний зохицуулагч П.Цэвээн, “Хүйсийн тэгш эрхийн төв” Төрийн бус байгууллагын тэргүүн Г.Ганбаясах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн хэлтсийн референт Г.Нямсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 10 цаг 35 минутаас хуралдааныг даргалав.*

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Б.Энх-Амгалан, Д.Батлут, Т.Энхтүвшин, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, П.Анужин, Т.Аубакир, Ц.Мөнхцэцэг, Б.Баярсайхан, Г.Ганболд, Ш.Адъяа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан,

Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Хуулийн зөвлөх, өмгөөлөгч П.Баттулга, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Гэрээт зөвлөх, Хүүхэд хамгааллын судлаач С.Энхтуяа, Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний зохицуулагч П.Цэвээн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ж.Сүхбаатар, Б.Бейсен нар “дэмжсэн” байр суурьтай үг хэлэв.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 59 минутаас хуралдааныг даргалав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 14 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн хэлэлцэх асуудлын дараалалд орсон Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцүүлэх гэсэн горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 17

Бүгд: 45

62.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулж байгааг мэдэгдэв. /14:10/

*Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, мөн яамны Хөгжлийн бодлого, газрын харилцаа, хот байгуулалтын газрын дарга Э.Батболд, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Санчир, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Энхманлай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нар танилцуулав.



Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, Н.Энхболд, Г.Тэмүүлэн, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Ж.Батсуурь, Ж.Батжаргал нар “эсрэг”, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр “дэмжсэн” байр суурьтай үг хэлэв.

**Г.Занданшатар:** 1.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 19  
Бүгд: 46  
58.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Байнгын хорооны саналаар Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

---

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 15  
Бүгд: 46

67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

5.Байнгын хорооны саналаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 15  
Бүгд: 46

67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Байнгын хорооны саналаар Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 14  
Бүгд: 46

69.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Байнгын хорооны саналаар Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 16  
Бүгд: 46

65.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

8.Байнгын хорооны саналаар Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 15  
Бүгд: 46

67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Байнгын хорооны саналаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

---

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 15  
Бүгд: 46

67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

10.Байнгын хорооны саналаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 14  
Бүгд: 46

69.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Байнгын хорооны саналаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 16  
Бүгд: 46

65.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

12.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 18  
Бүгд: 46

60.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

13.Байнгын хорооны саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 16  
Бүгд: 46

65.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

---

14.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32  
Татгалзсан: 15  
Бүгд: 47

68.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

15.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 4 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага авав./13:50/

16.Байнгын хорооны саналаар Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 17  
Бүгд: 47

63.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

17.Байнгын хорооны саналаар Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 20  
Бүгд: 47

57.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

18.Байнгын хорооны саналаар Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 17  
Бүгд: 47

63.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

19.Байнгын хорооны саналаар Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.



Дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 17  
Бүгд: 48  
64.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

20.Байнгын хорооны саналаар Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 14  
Бүгд: 47  
70.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

21.Байнгын хорооны саналаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал үг хэлэв.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 15  
Бүгд: 46  
67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

22.Байнгын хорооны саналаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 17  
Бүгд: 47  
63.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

23.Байнгын хорооны саналаар “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

---

Дээрх Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24  
Татгалзсан: 22  
Бүгд: 46  
52.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

24“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23  
Татгалзсан: 23  
Бүгд: 46  
50.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 17  
Бүгд: 46  
63.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

25.Байнгын хорооны саналаар “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33  
Татгалзсан: 10  
Бүгд: 43  
76.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

---

26.Байнгын хорооны саналаар “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28  
Татгалзсан: 25  
Бүгд: 43

65.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

27.Байнгын хорооны саналаар “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 14  
Бүгд: 43

67.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

28.Байнгын хорооны саналаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43

69.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл Тусгай хяналтын дэд хорооны гишүүний асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн завсарлагын хугацаа дууссанд тооцож, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгаланд Ардчилсан намын бүлгийн саналыг авч үзэж, Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний асуудлыг шийдвэрлэх чиглэл өгөв. /16:28/

***Дөрөв.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

**Г.Занданшатар:** “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 13  
Бүгд: 42  
69.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./16:28/

*Уг асуудлыг 16 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

**Бусад.**Монгол Улсын тамирчид олимпын наадмаас анхны медаль хүртсэн 55 жилийн ойн өдөр олимпын медальт тамирчдаа төлөөлж Мехико 1968 олимпын наадмын хүрэл медальт чөлөөт бөхийн тамирчин, Монгол Улсын Ардын багш, гавьяат тамирчин Ч.Дамдиншарав, Д.Сэрээтэр, Барселона 1992 олимпын наадмын хүрэл медальт боксчин, Монгол Улсын гавьяат тамирчин Н.Баярсайхан нар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 11, 13 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Нийслэлийн ерөнхий боловсролын “Үй-Цай” сургуулийн 10-ын Б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяагийн урилгаар ерөнхий боловсролын “Байгаль эх” сургуулийн 12-ын А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат, Ч.Ундрам, Д.Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Сүхбаатар, Мандал сумдын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн багш, сурагчид, Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Хууль тогтоомж сурталчлах төв хариуцсан албан хаагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн 11-ийн А ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан, Ц.Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн “Хүлэгт” төрийн бус байгууллагын гишүүд Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.



Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхцоож, шинжээч С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 19 минут үргэлжилж, 72 гишүүнээс 54 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 11 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

Нэгд нь, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 онд төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Энэ дэмжигдсэний дараа Төсвийн байнгын хороо хуралдах ёстой шүү. Төсвийн байнгын хорооны гишүүд хуралдана.

Энэ хооронд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Мөн Монгол Улсын 2024 онд төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 онд Төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Мөн зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэнэ.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т гишүүн энэ хуулийн 9.5-д заасан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаанаас өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос албан бичиг ирүүлсэн байна.

Уншиж танилцуулья. Хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөхтэй холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж гэсэн байна.

Б.Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Г.Занданшатар гишүүн НӨАТ-ын буцаалтыг 5 хувь болгох хуулийн төслийг санаачилж олон нийтийн анхааралд энэ НӨАТ-ын асуудлыг оруулж ирлээ.

Тэгэхээр энэ НӨАТ ямар их үр дагавартайг би бас та нарт тайлбарлаж өгье гэж бодож байна. Ард иргэдэд.

Энэ ус үйлдвэрээс мянган төгрөгөөр гардаг. Энэ үйлдвэрээсээ мянган төгрөгөөр гараад 100 төгрөгийн НӨАТ бичигдээд Улаанбаатар хотын бөөний төв дээр очдог.

Улаанбаатар хотын бөөний төвөөсөө Ховд аймгийн бөөний төв рүү энэ ус тээврийн зардал, дээрээс нь Ховд аймгийн бөөний төвийн ашиг, бусад зардлууд нэмэгддэг.

Дээрээс нь НӨАТ нэмэгддэг. Дахиад Ховд аймгийн бөөний төвөөсөө Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын дэлгүүр лүү энэ ус очдог.

Дахиад тээврийн зардал, дэлгүүрийн ашиг нэмэгддэг, бусад зардлууд нэмэгддэг. Дээрээс нь дахиад яах вэ, НӨАТ нэмэгдэнэ.

Ингээд худалдаа, үйлчилгээний үе шат болгон дээр нэмэгддэг энэ НӨАТ-ын татвар ялангуяа алслагдмал бүс нутагт амьдарч байгаа ард иргэдийн хувьд хармааг нь хоослох ийм гол хэрэгсэл болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ үйлдвэрлэгчээс Улаанбаатар хотын бөөний төв рүү НӨАТ-ын падаан шидээд өгчихнө. Улаанбаатар хотын бөөний төвөөсөө Ховдын бөөний төв рүү НӨАТ-ын падаан өгнө. Ховдын бөөний төвөөсөө дэлгүүр лүү НӨАТ-ын падаан өгнө.

Эд нар хоорондоо НӨАТ-ын падаан шидэлцээд байна. Хэн ч НӨАТ төлөхгүй.

Хэн төлж байгаа вэ гэхээр яг Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн Дорж гуай хамгийн эцэст энэ усыг 1600 төгрөгөөр худалдаж авахдаа бүх НӨАТ-ыг нь төлдөг байхгүй юу даа.

Тэгэхээр Улаанбаатар хотод иргэд 1100 төгрөг 1150 төгрөгөөр энэ усыг хэрэглэж байхад Ховд аймгийн

Эрдэнэбүрэн дээр баахан НӨАТ нэмэгдсэн энэ барааг 1600 төгрөгөөр манай ард иргэд худалдаж авч байна.

Ийм учраас энэ НӨАТ-ын татварыг багасгах нь амьдралд маш хэрэгтэй байгаа.

Тэгэхээр Г.Занданшатар даргын өргөн барьсан 10 хувийн НӨАТ-ын татвар, тэрнээс 5 хувийг буцаах энэ хуулийн төслийг яагаад би дэмжиж байгаа юм бэ гэхээр 2020 оны 5 сарын 24-ний өдөр буюу Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэрэгжихээс хоёр өдрийн өмнө би энэ хуулийг өргөн барьсан.

Тэрнээс хойш Их Хурлын гишүүн татварын болон эрүү, иргэний, тэгээд зөрчлийн хуулиудаар өөрчлөлт хийх боломжгүй болсон байгаа.

Хууль санаачлах эрхгүй болчихсон байгаа.

Үүнийг Засгийн газар л санаачлах эрхтэй болсон байгаа.

Тэгэхээр Г.Занданшатар дарга нэг аргыг нь олоод энэ хуулийг санаачилж байгаа байх.

Ингээд энэ асуудлыг хэлэлцээд эхлэхээр миний энэ 2020 оны 5 сарын 24-ний өдөр өргөн барьсан энэ НӨАТ-ын хууль зайлшгүй хамтатгаж хэлэлцэгдэх ёстой болоод байгаа юм.

Тэгэхээр энэ НӨАТ-ын хуулийг 5 хувь болгосны гол ач холбогдол нь ямар юм байгаа вэ гэхээр өнөөдрийн байдлаар нийтдээ 140 мянган идэвхтэй үйл ажиллагаа явж байгаа аж ахуйн нэгжүүдийн 80 мянга нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн байгаа.

250 мянган хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн хувьд 50 мянга нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн байгаа.

Жишээ нь, Замын-Үүдээр орж ирж байгаа бараа, бүтээгдэхүүн нэг том машин дээр мянга мянган төрлийн бараа ачигдлаа гэхэд тэрийг яаж бүрдүүлэлт хийж байна вэ гэхээр амраар нь цемент гээд бүрдүүлчхэж байгаа юм.

Тэгээд анхнаасаа хилээр орж ирэхдээ энэ бараа, бүтээгдэхүүний импорт нь зөв бичиг баримтын үндсэн дээр бүрдүүлэлт хийгдээгүй болохоор Улаанбаатар хотын зах дээр ирээд захаасаа аймгууд руу явахдаа бүгдээрээ ямар ч бүртгэлгүй бараа, бүтээгдэхүүний борлуулалт болоод явчхаж байгаа юм.

Тийм учраас энэ НӨАТ-ын татварыг 5 хувь болгох нь татварын бааз суурийг буюу өөрөөр хэлбэл үлдсэн тэр 40 мянган аж ахуйн нэгжийг НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх тэр боломжийг нь нээж өгөх.

Хоёрдугаарт нь, 200 мянган хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй байгаа тэр хүмүүсийг НӨАТ төлөгчөөр бүртгүүлсний үндсэн дээр татварын бааз суурь нэмэгдсэнээр Сангийн яаманд төвлөрч байгаа танай орлого чинь багасахгүй байна гэсэн тооцоолол бүрэн гарсан байгаа.

Тэгэхээр миний өргөн барьсан хуулийг өнөөдрийн эрх баригч нар угаасаа батлахгүй. Би мэдэж байгаа.

Тэгэхдээ ямар ч байсан Г.Занданшатар даргын хуультай хамтарч хэлэлцүүлнэ гэсэн ийм зорилттой байна.

Тэгэхдээ та нар баталж чадахгүй учраас би үүнийг 2024 оны Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт оруулна. Ардчилсан нам 2024 онд ялахаараа НӨАТ-ын татварыг 5 хувь болгоно.

Баялаг бүтээгчдээ бэлэг барина.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-д хууль, тогтоолын төслийг татан авах бол хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль, тогтоолын төслөө татан авах үндэслэл бүхий саналаа бичгээр Улсын Их Хурлын даргад ирүүлж, түүнийг нэгдсэн хуралдаанд танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Хуулийн төсөл татан авах тухай ЗГ/136 тоот албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг татан авч байгаагүйгээр мэдэгдэж байна. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ гэсэн байна.

Хуулийн төслийг татан авсанд тооцлоо. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орно. Одоо санал хураалт явуулна.

Энэ хуулийн төсөл санаачлах асуудал биш байгаа юм. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн

15.3-т НӨАТ-ын буцаан олголт болон урамшуулал нэмэгдсэн өртгийн албан татварын төлөлтийн 30 хувиас хэтрэхгүй байна гээд заалттай. Угаасаа.

НӨАТ-ын хуулийн 15.2.1-д буцаан олголт 20 хувиас хэтрэхгүй гээд заачихсан. Өөрөөр хэлбэл 20 хувь. Одоо 7.7 хувь байгаа юм.

Тийм учраас хуульд өөрчлөлт орохгүй.

Энэ бол хууль өргөн барьсан асуудал биш.

Иргэний хувьд ч тэр, гишүүний хувьд ч гэсэн хууль өргөн барьсан асуудал биш. Энэ бол төсвийн асуудалтай хамт хэлэлцэж байгаа юм.

Б.Жавхлан сайдтай бас энэ гаргалгаа, үндэслэлүүдийн талаар ярилцаж ойлголцохоор ярилцсан байгаа.

Тийм учраас төсвийн үеэр үүнийг хэлэлцээд боломжит олон хувилбаруудыг судалж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

Энэ бол болох талаас нь болон хувилбаруудыг боловсруулж байгаа.

Тийм учраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явна. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг гэж дуулсан.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69.5-д заасны дагуу санал хураалт явуулна.

Эхлээд нэг зүйл анхааруулж хэлье.

Өчигдөр санал хураалт явуулах үед Засгийн газрын гишүүд байгаагүй.

Төсөв хэлэлцэж байх үед бүх салбарын сайд нар заавал салбарын асуудал ярьж байхад байх ёстой.

Ганцхан Сангийн сайд л тооройгоод үлдсэн.

Л.Энх-Амгалан сайд байсан. Тийм ээ. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд асуултад сайн хариулсан. Байсан.

Ц.Даваасүрэн сайд байгаагүй. Ипотекийн зээл энэ тэртэй холбоотой Д.Тогтохсүрэн гишүүн олон асуулт асуухад хариулаагүй та.

Асуулт дээр хариулахад Та байгаагүй. Орой санал хураалт явуулахад байгаагүй.

Ийм учраас энэ сайд нарыг үүнээс хойш гадаад, дотоод томилолтоор явахгүй, төсөв үлдэж байгаа үед явахгүй байх шаардлагатай. Ийм зарчим тогтоож байна.

Ер нь бусад улсад ч гэсэн төсөв хэлэлцэж байгаа үед сайд нар, Гадаад хэргийн сайд нараа бүр явуулахгүй байгаа шүү дээ.

Ийм учраас үүнийг анхаарвал зохино. Үүнийг өчигдөр сануулсан.

---

**Нэг. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,  
Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,  
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд**  
*/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
нэг дэх хэлэлцүүлэг, үргэлжилнэ/*

---

Одоо ингээд өчигдрийн санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна. Санал хураалтаар минийх эсрэг гарсан, сайд нарынх эсрэг гарсан учраас.

Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.  
*/алх цохив/*

Содномын Чинзориг сайд олон юм яриад л байж байдаг байсан. Өчигдөр байхгүй. Санал хураалт дээр. Байгаагүй.

89.6 хувийн саналаар санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Санал хураалтыг хүчингүйд тооцсон тул төсвийн төсөл.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 22.1-д заасан

шаардлага хангасан талаар санал хураалт явуулна. Санал хураалт. */алх цохив/*

87.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд НӨАТ-ын 5 хувийн асуудлыг ярилцъя гэсэн үндэслэлтэй Сангийн сайд маань дэмжсэн учраас ингээд үргэлжлүүлэх боллоо.

Тэгээд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Байнгын хороод, мөн Төсвийн зарлагын дэд хороонд шилжүүлж байна.

---

**Хоёр. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**  
*/Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/*

---

Хэлэлцэх асуудал гурав.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нийт хүн ам **3.4** сая болж, өмнөх оноос **1.4** хувиар өсөж байгаа.

Нийт хүн амд эзлэх **18** хүртэлх насны хүүхдийн эзлэх хувь **36.2** хувь буюу **1 сая 252 мянган хүүхэд** байна.

Монгол Улсад 2022 оны байдлаар 941.5 мянган өрх бүртгэгдэж, өмнөх онтой харьцуулахад 2.3 хувиар өссөн байна.

- Хагас өнчин хүүхэд **36.3 мянга**,
- Бүтэн өнчин хүүхэд **2911**,
- Үрчлэгдсэн хүүхэд **1478**;

- хүнсний эрхийн бичигт хамрагддаг хүүхэд **76063**,
- нийгмийн халамжийн зайлшгүй дэмжлэг, туслалцаа шаардлагатай өрхөд амьдарч байгаа **460344**,

Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд:

-2022 онд **14207**,

-2023 оны 8 дугаар сарын байдлаар **8081** хүүхэд байна.

Улсын хэмжээнд 35 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж, тус төвүүдээр 2018-2023 онд 19 мянга 231 хүн үйлчлүүлсний 67.7 хувь нь буюу 70.0 хувь нь хүүхэд, 32.3 хувь нь насанд хүрсэн хүн байна.

Хүүхдийн асрамж, халамжийн 30 төвд 18 хүртэлх насны 974 хүүхэд, 18-аас дээш насны 86 залуу амьдарч байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн 2022 онд нийтдээ 111 мянга 776 дуудлага ирсэн байна.

2023 оны 9 дүгээр сарын байдлаар 78 мянга 30 дуудлага ирсний 57 хувийг нь зорилтот дуудлага эзэлж байгаа билээ.

Цагдаагийн байгууллагын мэдээллээр 2022 онд:

-хүүхэд оролцсон гэмт хэрэг **1540**,

-гэмт хэргийн улмаас хохирсон хүүхэд **2014**,

-гэмт хэргийн улмаас нас барсан хүүхэд **92**,

-гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд **177**,

-бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд **358** хүүхэд байсан ба бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн 70 орчим хувь нь гэр бүлийн орчинд, ураг төрлийн хүрээнд хүчирхийлэлд өртсөн тоо баримт байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Хүүхэд хамгааллын тухай хуулийн давхардал, хийдлийг арилгах, уг хуулиар хүүхэд хамгааллын үйлчилгээний хувьсах зардлыг батлах эрх зүйн үндсийг бий болгох, хүүхдийн эрхийг хамгаалахад эцэг, эх, олон нийт, байгууллага, хуулийн этгээдийн үүргийг

нарийвчлан тусгах, түүнчлэн хүүхэд хамгаалал, гэр бүлийн чиглэлээр ажиллах нийгмийн ажилтныг давтан сургах, лицензжүүлэх, үйлчилгээний үр дүнг тооцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг илүү нарийвчлан зохицуулах гэж заасныг үндэслэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

2020 онд хийгдсэн Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хүүхэд хамгааллын үнэлгээний зураглалын судалгаанууд нь хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалтыг хууль эрх зүй, төсвийн шинэчлэл, нийгмийн өөрчлөлт, хандлага, олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байгааг дүгнэж зөвлөсөн.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн төрийн бүх шатны байгууллага, хүн, хуулийн этгээдийн үүрэг оролцоотой уялдуулж Засгийн газар хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, хамгааллын үйлчилгээний хэлбэр, үйлчилгээ үзүүлэх “**кэйс менежмент**”-ийн үе шат, хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, хуулийн давхардал, хийдлийг арилгаж, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх эрх зүйн үндэслэлийг бий болгохыг зорьж ажиллаа.

#### Үүний үр дүнд:

**Нэг.** Хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төр болон байнга оршин сууж байгаа хүүхэд, Монгол Улсын харьяат эсэхээс үл хамааран энэ хууль үйлчлэхээр тусгасан.

**Хоёр.** Хүүхдийн эрхийн тухай хуультай нийцүүлэн хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлж, хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл, нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, нийгмийн ажилтан, хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны чиг үүргийг хуульд шинээр нэмж тусгасан.

**Гурав.** Сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд нэмж нийгмийн ажилтны үүргийг заасан.

Сум, хороонд ажиллах нийгмийн ажилтан хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоог тухайн орон нутгийн хүн амын тоо, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлыг харгалзан Засгийн газраас тогтоох, салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжлийн эрх олгох заалтуудыг шинээр тусгалаа.

Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгө:

- 2017 онд **900.1 сая** төгрөг,
- 2018 онд **6.4 тэрбум** төгрөг,
- 2019 онд **7.6 тэрбум** төгрөг,
- 2020 онд **6.4 тэрбум** төгрөг,
- 2021 онд **8 тэрбум** төгрөг,
- 2022 онд **8 тэрбум** төгрөгт



хүрсэн байна.

Гэвч үйлчилгээний санхүүжилтийн үр дүн гүйцэтгэлд суурилж төлөвлөгддөггүй. Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан хөгжөөгүй байна гэсэн дүгнэлт гарсан.

**Дөрөв.** Хуулийн шинэчлэлээр хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, хүүхэд хамгааллын цахим хувийн хэрэг үүсгэж ашиглах шинэ зохицуулалт нэмж орууллаа.

**Тав.** Гэр бүл, нийгмийн орчинд хүүхдийг хамгаалах харилцааг өргөжүүлж, шинээр хурдан морины уралдаанч хүүхдийг хамгаалах, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын зохицуулалтыг шинээр тусгалаа.

Тухайлбал, эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хориглох зүйл, хүүхэд хамгааллын сургалтад хамрагдсаны үндсэн дээр халамж, тэтгэмж олгох зэрэг тодорхой нөхцөлийг заалаа.

Боловсрол, сургалтын байгууллага болон сургалтын бусад байгууллага, дотуур байр, сүм хийд, сүм хийдийн дэргэдэх дотуур байран дахь хүүхэд хамгааллыг тодорхойлж, боловсролын орчинд үе тэнгийнхний дээрэлхэлт, хүүхдийн эрхийн зөрчлийн мөрөөр авах арга хэмжээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх процессыг боловсронгуй олголоо.

**Зургаа.** Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, хүүхэд хамгааллын кэйс менежментийн 6 алхам,

хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг шинээр тодорхойллоо.

**Долоо.** Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгож, хүүхэд хамгааллын үйлчилгээний хэлбэр тус бүрээр улс, орон нутгийн төсөвт тусгах, хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кэйст тулгуурлаж дараа онд зарцуулах мөнгөн дүнг тогтоодог байх эрх зүйн зохицуулалттай болгосон байна.

Хуулийн этгээдийн цалин нийт сангийнхаа нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд төлөвлөх, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн оролцогчийн ерөнхий шаардлагыг магадлах хэсэгт “хүүхэд хамгааллын бодлогогүй этгээд” гэх шаардлага нэмж тусгалаа.

Салбар бүр Засгийн газраас баталсан Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын аргачлал, нормативын дагуу хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, төлөвлөгөө хэрэгжүүлэх зардлыг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх шинэ зохицуулалтыг оруулсан болно.

Хүүхэд хамгаалал нь бүх нийтийн хэрэг юм.

Тиймээс хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх түвшний үйлчилгээг мэргэшсэн төрийн бус байгууллага, олон нийт, сайн дурын ажилтны дэмжлэг, туслалцаа, хүүхдийн

оролцоотойгоор зохион байгуулахаар тусгагдлаа.

Барилга байгууламж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийн улсын байцаагч, эсхүл хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөөлөл ажиллах эрх зүйн зохицуулалтыг тусгалаа.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд, мөн хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдлыг тодорхой болгож, хүүхдийн хөгжлийн үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох, хөгжлийн үйлчилгээний аргачлал, нормативыг батлах нэмэлт, өөрчлөлтүүдийг орууллаа.

Хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа 20 удаагийн хэлэлцүүлэг хийж, Засгийн газрын гишүүд, төрийн бүх шатын байгууллага, олон улсын болон иргэний нийгмийн байгууллага, их дээд сургуулийн эрдэмтэн, багш, судлаачид 1300 гаруй хүүхдийн дунд хэлэлцүүлэг явуулж саналыг авсан болно.

Хууль батлагдсанаар хүүхэд хамгаалах төрийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүрэг бүх түвшинд тодорхойлогдож хүүхэд хамгааллын үйлчилгээг мэргэжлийн түвшинд шаардлагатай хүүхэд бүрт хүргэх болно.

Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоо мөн бэхжих боломжтой болно.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, үйл явц, төрөл хэлбэрийг тодорхойлж, хүүхэд хамгаалалд

зориулсан төсвийн үр ашиг, өгөөж сайжирч, хамгаалал шаардлагатай хүүхэд бүрт чанартай цогц үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Хүүхэд хамгааллын кэйс менежментийн алхмуудыг тодорхойлж, мэргэжлийн удирдлагын чиг үүргийг хуульчилснаар хүүхэд хамгааллын үйлчилгээг цаг алдалгүй үр дүнтэй хүргэх, хүүхдийн сайн сайхан байдлыг дэмжих, үр дүнг үнэлэх, хянах механизм сайжирна.

Магадлан итгэмжлэгдсэн, мэргэшсэн төрийн бус байгууллагаар хүүхэд хамгааллын мэргэжлийн үйлчилгээг анхан, дунд шатанд шаардлагатай хүүхэд, гэр бүлд хүргэх, санхүүжилт, хяналт, хариуцлагын эрх зүйн зохицуулалттай болно.

Сум хороонд 534 хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай болсноор хууль тогтоомжийн хэрэгжилт анхан шат нь сайжирч, хүүхэд хамгааллын үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.

Салбар бүр хүүхэд хамгааллын бодлоготой байхыг хуульчилснаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих хандлага олон нийт, нийгмийн дунд бий болохоос хүүхдийн эсрэг хүчирхийлэл буурч хүүхдэд ээлтэй хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.

Хэдийгээр тус хуулийн дагуу улсын төсвөөс гарах зардал цаашид нэмэгдэх боловч хуулийг хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулахад хамгийн чухал нөлөө, үр дүн үзүүлнэ хэмээн бид үзэж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын

гэрээ болон холбогдох бусад хууль, уг хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан бөгөөд төсөлтэй холбогдуулан хуулийн төслийг дагалдан 14 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зочид танилцуулъя.

Монгол Улсын тамирчид олимпын наадмаас анхны медаль хүртсэний 55 жилийн ойг тохиолдуулан олимпын хүрэл медальт, Монгол Улсын ардын багш, гавьяат тамирчин Ч.Дамдиншарав, Д.Сэрээтэр, Монгол Улсын гавьяат тамирчин Б.Баярсайхан нар Улсын Их Хурлын чуулганы танхимд зочилж байна.

Өдгөөгөөс 55 жилийн тэртээ Мексик Улсын нийслэл Мехико хотод болсон зуны олимпын XIX их наадмаас Монголын тамирчид олимпын анхны медалиа хүртэж, олимпын тэнгэрт Монгол Улсынхаа алтан соёмбот төрийн далбааг мандуулсан түүхтэй.

Энэ түүхэн үйл явдлын 55 жилийн ой өнөөдөр тохиож байна.

Монголчууд 1964 онд анх удаа олимпод оролцсон.

Хоёр дахь олимп буюу Мехикокийн олимпоос чөлөөт бөхийн тамирчин Чимэдбазарын Дамдиншарав, Данзандаржаагийн Сэрээтэр, Төмөрийн Артаг нар хүрэл медаль, Жигжидийн Мөнхбат мөнгөн медаль хүртэж олимпын тэнгэрт Монгол Улсынхаа алтан соёмбот төрийн далбааг мандуулсан. /алга ташив/

Өнгөрсөн 55 жилийн хугацаанд Монгол Улсаас олимпын 2 аварга, мөнгөн медальтан 11, хүрэл медальтан 17 төрж, нийт 30 медаль хүртээд байна.

Монгол Улсын тамирчид олимпын наадмаас анхны медаль хүртсэн 55 жилийн ойн өдөр олимпын медальт тамирчдаа төлөөлж Мехико 1968 олимпын наадмын хүрэл медальт чөлөөт бөхийн тамирчин, Монгол Улсын Ардын багш, гавьяат тамирчин Чимэдбазарын Дамдиншарав, Данзандаржаагийн Сэрээтэр, Барселона 1992 олимпын наадмын хүрэл медальт боксчин, Монгол Улсын гавьяат тамирчин Намжилын Баярсайхан нар Улсын Их Хурлын чуулганы танхимд зочилж байна.

Та бүхэндээ цог золбоо, аз хийморь, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Та бүхнээр уламжлаад нийт олимпын тамирчдаа, олимпоос медаль авч байсан үе үеийнхэндээ, тэдний гэр бүл, ар гэрийнхэнд нь халуун баяр хүргэе. /алга ташив/

Монгол Улсынхаа тамирчдад ирэх 2024 онд болох Парисын олимпод амжилт дүүрэн оролцож, олон медаль хүртэж, Монгол гэдэг эрхэм нэрийг дэлхийн чихнээ дуурсгахыг, алтан соёмбот төрийнхөө далбааг ахин дахин мандуулахыг хүсэн ерөөе. /алга ташив/

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**М.Оюунчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төр болон байнга оршин сууж байгаа хүүхэд, Монгол Улсын харьяат хэсгээс үл хамааран энэ хууль үйлчлэхээр, Хүүхдийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, Хүүхдийн эрхийн тухай хуультай нийцүүлэн хүүхэд хамгааллын тогтолцоог өргөжүүлж, хүүхэд хамгааллын байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг шинээр тодорхойлох, Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн сан, Хүүхэд хамгааллын цахим хувийн хэрэг үүсгэх, ашиглах, барилга байгууламж, авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хүүхдийн эрхийн улсын байцаагч, эсхүл хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдийн төлөөлөл ажиллуулахаар, сургуулийн орчинд гардаг үе тэнгийнхний дээрэлхэлт, хурдан морины уралдаанч хүүхдийг хамгаалах, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал, гэр бүл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, цахим орчин, соёл, спортын арга хэмжээ,

үйлчилгээ, олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээний үе дэх хүүхэд хамгааллыг өргөжүүлж салбар бүр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам баталж, шаардагдах санхүүжилтээ Засгийн газраас баталсан нормативын дагуу төсөвлөн жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх шинэ зохицуулалтуудыг хуулийн төсөлд тусган боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар сум, хороодод хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны 534 орон тоог шинээр бий болгоход шаардагдах ажилчдын цалин хөлс, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийн зардал 16.4 тэрбум төгрөг төрийн байгууллагад шинээр үүснэ гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг **D-Parliament.mn** цахим сайтад байршуулж олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед **Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир** хуулийн төсөл боловсруулахад хэдэн удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох газруудын саналыг бүрэн авч, Хууль тогтоомжийн тухай хуультай нийцүүлсэн эсэх, эцэг, эхэд хүлээлгэх үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх талаар төсөлд хэрхэн тусгасан болон хуулийн төслийг дагаж өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд ямар өөрчлөлт орж байгаа талаар;

**Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг** нэг сум, дүүрэгт оногдох хүүхдийн эрхийн улсын байцаагчийн орон тоо хангалтгүй байдаг бөгөөд

хуулийн төсөл, бүтэц, орон тоо, зардал, салбар дундын уялдаа холбоог сайжруулахыг хэрхэн тусгасан талаар;

Хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан төсвийг зориулалтын бусаар зарцуулсан этгээдэд хуулийн хариуцлага тооцсон эсэх болон цаашид ийм төрлийн хууль бус үйлдлийг таслан зогсоох, төсвийн зарцуулалтын задаргааг нарийвчлан хуулийн төсөлд тусгасан эсэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас 2021 онд хийсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлтийн хүрээнд хуулийн төслийг боловсруулсан эсэх, үр хүүхдээ асран хамгаалах иргэний үүргээ биелүүлээгүй эцэг, эхэд хариуцлага тооцсон жишээ баримтын талаар, хуулийн төсөлд сум, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан нэг байна гэсэн нь олон хүн амтай багийн түвшинд хэрхэн хүрч ажиллах тооцоо судалгааны талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан** хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээнд үндэслэсэн эсэх, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас өгсөн зөвлөмжийг төсөлд хэрхэн тусгасан талаар, хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан төсвийг нэмэгдүүлснээр хүүхэд хамгааллын асуудал бүрэн шийдэгдэх эсэх, хамтарсан багийн гишүүдийн тогтвортой ажиллуулах зохицуулалтыг төсөлд хэрхэн тусгасан талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн** эрүүл мэндийн ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, эсхүл цагдаагийн байгууллага, хүүхдийн тусламжийн утсанд нэн даруй заавал мэдэгдэх зохицуулалт хэрэгжиж байгаа эсэх талаар.

Мөн өндөр өртөгтэй хагалгаа болон Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчнөөр өвдсөн хүүхдүүдийг гадаадад эмчлүүлэх зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцдаг болох талаар.

**Улсын Их Хурал хурлын гишүүн Д.Батлут** хүүхэд хамгаалалд зориулагдсан төсвөөс өнгөрсөн хугацаанд иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлд хэдэн төгрөг зарцуулсан, хуулийн төсөл, цахим орчинд сөрөг агуулгатай мэдээлэл тарааж байгаа тохиолдолд тавигдах хяналт болон хэрхэн таслан сэргийлэхээр тусгасан талаар, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалтай хүүхдийн талаарх судалгаа хийгдэх эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан **Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг** хүн амын тоотой уялдуулан хүүхдийн эрхийн улсын байцаагчийн хүний нөөцийг бүрдүүлэх, Эрүүгийн хуульд эцэг, эхэд оногдуулах хариуцлагын зохицуулалтыг чангатгах болон салбар дундын уялдаа холбоог нарийвчлан тусгах талаар;

**Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар** хуулийн төсөлд хүүхдээ хамгаалах, хүмүүжүүлэх талаар монгол

ардын зан заншил, түүх, өв, соёл, соён, гэгээрүүлэх аргуудаас оруулахад анхаарах, хуулийн төслийн бичилтийг хууль зүйн техникт нийцүүлэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат** хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд боловсролын байгууллагуудаар дамжуулан хяналт тавих боломжтой талаар.

Мянгаас дээш сурагчтай сургуульд ахлах, дунд, бага ангийн гэсэн чиглэлээр нийгмийн ажилтан ажиллуулах, бүх шатын Засаг даргын чиг үүрэгт тухайн шатын жилийн төсвийн төсөлд хүүхэд хамгааллын санхүүжилтийг заавал тусгах, сум, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсвөө батлахдаа Засаг даргын үүрэгт сум, багийн хамтарсан багийн үйл ажиллагаа явуулах төсвийг тусгахыг хуульчлах талаар.

**Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа** нийгмийн ажилтны ажлын ачаалал их, зарим шаардлагагүй тайлан, мэдээллийг хасаж, ажлын ачааллыг бууруулахад анхаарах, дүүргийн Хүүхэд хамгааллын комиссын дарга томилогдоогүй 8 сар болсноор хуулийн хэрэгжилт хангагдахгүй байгаа талаар.

Мөн хүүхдийн эрхийн улсын байцаагчийг төрийн албан хаагч болгосон нь учир дутагдалтай.

Хүний эрхийн Үндэсний Комиссын хүүхдийн эрхийн хамгаалах гишүүний орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен** хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа зарим албан

тушаалтнууд ажилдаа сэтгэлгүй, хангалтгүй ажиллаж байгаа, хууль сахиулагч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс хохирогч хүүхдүүдийн эрх ноцтой зөрчигдөж гэмт этгээдүүд хил даван явсан талаар.

Цэцэрлэг, сургуулийн орчныг аюулгүй байлгах иж бүрэн камержуулалтын асуудлыг шийдвэрлэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир** боловсролын салбарт хүүхдийн нас ачаалал даах чадварыг харгалзан гэрийн даалгавар өгөхгүй байгаагаас хүүхдүүд гэрийн хүмүүжлээс холдож, сургалт хүмүүжлийн доголдолтой болж байгаа болон улсын төсөв батлахад хүүхэд хамгааллын чиглэлээр тусгасан төсвийг хасахгүй байхад анхаарах талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан** цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангалтгүй, ажил хариуцсан яам, агентлагийн дарга нар ажилдаа анхаарлаа хандуулж ажиллах арга барилдаа өөрчлөлт оруулах.

Хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан төсвийг зориулалтын бусаар зарцуулсан эсэхэд тодорхой мэдээлэл өгөх талаар.

Мөн Монголын телевизүүдийн холбоо, Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлтэй байгуулсан хүүхдийг сэрүүн байх хугацаанд хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөөтэй контентуудыг гаргахгүй хязгаарлах, хугацаагүй санамж бичгийн хэрэгжилт хангалтгүй байгаа анхаарах талаар тус тус саналаа илэрхийллээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр ажил, бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**С.Одонтуяа:** Баярлалаа.

Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн 11, 13 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд ажлын амжилт, эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулья.

Хүрэлбаатарын Булгантуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сархадын Зулпхар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд, Жаргалсайханы Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Нарантуяагийн Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Лхамтогмидын Нямгэрэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга, Начиндагвын Өлзийхутаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тойруулын Батболд Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга, Сүхээгийн Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Пүрэвээгийн Баттулга Хуулийн зөвлөх, өмгөөлөгч, Дугаржавын Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Аюурзанын Өнөржаргал Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний

газрын дарга, Лхагвасүрэнгийн Нямдорж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга, Жанцандоржийн Азжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, Батсүхийн Батсайхан Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга, Батсуурийн Дуламсүрэн Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын шинжээч, Энхбаатарын Оюун-Эрдэнэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн, Бумцэндийн Янжмаа Хүний эрхийн Үндэсний Комиссын судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Гансүхийн Мөнхбаяр Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, Ганчулууны Оюунболд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч, Сүхбаатарын Энхтуяа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Гэрээт зөвлөх, Хүүхэд хамгааллын судлаач, Балжиннямын Жавзанхүү Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн, Пэрэнлэйн Цэвээн Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний зохицуулагч, Гэлэгийн Ганбаясах “Хүйсийн тэгш эрхийн төв” Төрийн бус байгууллагын тэргүүн.

Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг авъя.

Салдангийн Одонтуяа гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууна.

**М.Оюунчимэг:** Бид Хүүхэд хамгааллын тухай хуульд эмэгтэй гишүүд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг 2020 онд өргөн бариад яаралтай хэлэлцүүлэх гээд шахаж байсан.

Засгийн газар шинэчилсэн найруулгаар оруулж ирээд хамтарч хэлэлцэнэ гээд.

Тэгээд сая нэг кэйсийн дараа одоо ингээд яаралтай горимоор орж ирээд хэлэлцэж байна л даа.

Тэгээд энэ бол ганц Хөдөлмөр, нийгмийн хамгааллын ч ажил биш, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэнд гээд салбар хоорондын уялдаа холбоо маш чухал.

Тэгээд өнөөдөр эндээс харахад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 534 орон тоог шинээр бий болоход шаардагдах ажилчдын цалин хөлс, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж гээд нэмэлтээр 16.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж тусгах шаардлага байгаа гэсэн тооцоог бас оруулж ирж байна гэж би ойлголоо.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд холбогдох төсөв нь 8 тэрбум байгаа. Үүнийг 14 тэрбум болгохоор бид төсөвт тусгасан гэж бид ойлгож байгаа.

Тэгэхээр энэ 14 тэрбум нь тусдаа байна уу? Эсвэл 14 тэрбум маань одоо саяын 534 орон тоо нэмсэнтэй уялдаад 16.4 тэрбум төгрөг болох шаардлага үүсэж байна гэж ойлгож болох уу?



Яагаад гэвэл энэ тоо, ялангуяа төсөвтэй холбоотой юман дээр маш тодорхой байхгүй бол зарцуулалтад зориулалтын бусаар зарцуулсан ч гэдэг юм уу, янз янзын асуудлууд.

Өмнө нь бид Хүний эрхийн Үндэсний Комисс, аудиттай хийсэн судалгаануудаар маш тодорхой гарч байсан л даа.

Орон нутагт гэвэл өвс тэжээл, эсвэл баяр наадам тэмдэглэхэд явчихдаг ч гэдэг юм уу. Тийм ээ. Тэгээд ямар ч хариуцлага хүлээдэггүй.

Тэгэхээр эхлээд төсөвтэй холбоотой маш тодорхой зарцуулалтын судалгааг авъя гэж бодож байна.

Хоёр дахь зүйл нь, аливаа юмыг хүн хийдэг.

Тэгэхээр бид өмнө нь бүх судалгааг харахад одоо ялангуяа аймаг, сум, дүүрэгт хүүхдийн эрхийн байцаагч нэртэй маш цөөхөн хүн байдаг. Нийгмийн ажилтан гээд. Тэр нь тэнд түлээ нүүрс, одоо бараг л бүх ажлыг 200, 300 төрлийн ажлыг давхар хийдэг тийм хүнээс хүүхэд хамгаалал гэж шаардах ямар ч боломжгүй.

Энэ нь өөрөө Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас хийсэн судалгаагаар ч маш тодорхой болсон.

Тэгэхээр одоо яг энэ 534 орон тоог бий болголоо гэхэд энэ хүүхэд зөвхөн хүүхэд хамгаалах л кэйс дээр ажиллана. Бусад давхар ажил гүйцэтгэхгүй гэдгийг хуулиар яг яаж зааж өгч байгаа вэ?

Учир нь бид энэ дээр үнэхээр тодорхой арга хэмжээг төсөвтэй нь уяж

хүний нөөцийн бодлогыг авч хэрэгжүүлэхгүй өнөөдөр бид төсвийг нь нэмээд л байдаг, нэмээд л байдаг. Үр дүн гарахгүй.

Үүнээс гадна хүүхдийн эрхийн байцаагчдаа орон тоог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр “**нийгмийн ажилтан**” нэрээр ингээд нэмж байгаа юм байна.

Бид Хууль зүй, дотоод хэргийн яаманд Хууль зүйн сайдын багц дээр өмнө бас л эмэгтэй гишүүд санаачилж байж төсвийг нь 8 тэрбум болгосон. Хүүхдийн байцаагчийн орон тоог 130 болгосон.

Тэр “**хүүхдийн байцаагч**” нар Хууль зүй, дотоод хэргийн яамны тэр нөгөө гэр бүлийн хамтарсан баг дээр хамгийн сайн ажилладаг. Яагаад гэвэл тэр яг хүүхдийн байцаагчийн үүрэг гүйцэтгэдэг учраас.

Тэгэхээр энэ “**нийгмийн ажилтан**” яг ямар үүрэг гүйцэтгэх вэ? Хүүхдийн байцаагчийн статустай ажиллах уу? Энэ дээр хоёр дахь асуулт.

Гурав дахь нь, энд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас, Эрүүл мэндийн яамнаас, Боловсролын яамнаас ажлын хэсэгт орсон хүмүүсээс асууя.

Энэ хууль яг хүүхэд хамгаалал дээр үнэхээр сайн болж чадсан. Үүнийг яаралтай батлах нь зөв өө гэж одоо тэнд ялангуяа төрийн бус байгууллага, олон нийтийн байгууллагын төлөөлөл сууж байна. 93 дээр сууж байх шиг байна.

Тэр хүмүүсээс яг энэ хууль өнөөдөр хүүхэд хамгаалах цогцоор нь, тэр байгууллага хоорондын уялдаа

холбоо, санхүүжилт, хүний нөөц, хууль эрх зүйн хувьд нь үнэхээр сайн хууль болж чадаж байгаа юу?

Энэ дээр та бүхний байр суурь ямар байгаа вэ? Бидэнд ямар зөвлөмж өгөх вэ? Ийм гурван асуулт байна. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй. Нэмэлт тайлбар өгөх 2 минутаас илүүгүй. Х.Булгантуяа сайд юм уу.

Хариулах ажлын хэсгийн гишүүд микрофонухоо дугаарыг өргөөд. Эхлээд Х.Булгантуяа сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль анх батлагдаж байсан. Энэ хуулийг анх батлахад Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүүхдийн сан, олон улсын зөвлөхүүд бас оролцож байсан.

2016 онд энэ хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд 11 тэрбум төгрөг жилд төсөвлөх шаардлагатай гэж үзэж байсан юм билээ.

2016 онд энэ дээр 300 гаруй сая төгрөгтэйгөөр эхэлж байсан. 11 тэрбум төгрөгт хэзээ ч хүрч байгаагүй.

2016 оны 11 тэрбум төгрөг гэдэг бол өнөөдрийн бараг 20 гаруй тэрбум төгрөг шаардлагатай гэсэн үг болох байх гэж бодож байна.

Тэгэхээр одоогийн нэмэгдэж байгаа төсөв нь 2020 онд хийсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн

сангийн энэ хууль дээр хийсэн үнэлэлт, дүгнэлтийн дагуу кэйс дээр ажилладаг төсөв, санхүүжилт дутуу байгаад байна гэсэн үүднээс энэ 14 тэрбум төгрөгийг ерөнхийдөө кэйсийг бүрэн шийдвэрлэхэд одоогийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ ажиллахад шаардлагатай төсвийг тавьсан.

Нэмэлт 330 сум, мөн хороод дээр ажиллах боловсон хүчин, түүнтэй холбоотой зардал үүн дээр нэмэгдэж орж ирнэ гэсэн үг.

**С.Одонтуяа:** Нэмж хариулахаас өмнө зочид танилцуулъя.

Нийслэлийн ерөнхий боловсролын “Үй-Цай” сургуулийн 10-ын Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлагын өндөр амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Нэмж ажлын хэсгээс хариулах юм уу? 81 хариулъя гэсэн. Дэд сайд.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн асуултад хариулъя.

Хүүхэд хамгааллын тогтолцоо нь өөрөө мэргэшсэн байхаар энэ хуульд зарчмыг нь тодорхойлсон.

Энэ мэргэшсэн байх зарчим, үүнтэй уялдсан тогтолцооны гол үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь өөрөө хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан “нийгмийн ажилтан” байгаа юм.

Тэр “нийгмийн ажилтан” өөрөө бидний өнөөдөр ярьж байгаа хамтарсан

багийг гол арга зүйгээр нь хангах, дэмжлэг үзүүлэх ийм үүрэгтэй.

Түүнээс гадна анхан шатад буюу засаг захиргааны анхан шатад энэ ажлыг удирдан зохион байгуулахад бүхий л уялдааг хангах үүрэгтэйгээр энэ хуульд маш нарийн оруулж өгсөн процессын шинжтэй хууль болсон гэж бид ойлгож байгаа.

Өмнөх хуульд процессыг зааж өгөөгүйгээс болоод чиг үүргүүдийг журамладаг. Журам дээр бас тодорхой зохицуулалт хийгддэггүй, түвшин тавигддаггүй байсан учраас энд ингэж оруулж өгсөн.

**“Хүүхдийн эрхийн байцаагч”** **“нийгмийн ажилтан”**-аас ялгаатай. Энэ хүүхдийн эрх зөрчигдсөн ямар нэгэн зөрчил гарах юм бол энэ дээр ажилладаг.

Энэ дагуу тодорхой эрх хэрэгжүүлж, үүнтэй уялдсан үүрэг хүлээдэг ийм хоёр тусдаа чиг үүрэг бүхий субъект байгаа.

**С.Одонтуяа:** Төрийн бус байгууллагаас хариулт авъя гэсэн. 91. НҮБ-ийнх. Тийм ээ.

Микрофондоо нэр, байгууллагаа хэлээд.

**С.Энхтуяа:** Би С.Энхтуяа. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Гэрээт зөвлөх.

Ерөнхийдөө энэ удаагийн Хүүхэд хамгааллын хууль Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцын зарчимд бүрэн нийцсэн тийм хууль болсон.

Яагаад гэвэл ерөнхийдөө өмнөх хуулиудад, сая бас дэд сайдын хэлснээр яг энэ ажлыг хариуцах хүнгүй байсан. Тэгээд хариуцах хүнгүй, тодорхой биш байсан нь хүүхэд хамгааллын үйлчилгээг яг хүүхдэд хүрэхэд нь, тэгээд урьдчилан сэргийлэх хариу үйлчилгээг үзүүлэх боломжийг хязгаарлаж байсан.

Энэ хуулиар яг үйлчилгээг нарийвчлан зааж өгсөн байгаа. Жишээлэх юм бол **“кэйс менежментийн үйлчилгээ”** гэж байгаа. Энэ “кэйс менежментийн үйлчилгээ” олон улсад яг **“нийгмийн ажлын үйлчилгээ”**-г эмзэг бүлгийн хүмүүст хүргэхэд үзүүлэх ёстой яг мэргэжлийн шинжлэх ухаанаар нотлогдсон ийм үйлчилгээ байгаа.

Энэ үйлчилгээг үзүүлэхгүйгээр үр дүн гарахгүй.

Тэгэхээр “кэйс менежментийн үйлчилгээ”-г энэ хуульд маш нарийвчлан үе шат бүрээр нь зааж өгсөн нь бас ач холбогдолтой.

Дээрээс нь хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг гол хэсэг бол одоо тэр эцэг, эх нь үнэхээрийн хүүхдээ асарч хамгаалах боломжгүй юм уу, хязгаарлагдсан, эсвэл хүчирхийлэгч байвал хаана хамгаалах вэ гэдэг зарчим байдаг.

Энэ зарчмыг 2009 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргын зөвлөмж байдаг. Тэр зөвлөмж дээр хүүхэд аль болохоор гэр бүлийн орчинд өсөх ёстой.

Тийм учраас гэр бүлийн орчинд нийцсэн хамгааллын үйлчилгээг үзүүлэхийг улс орнуудад даатгасан байдаг.

Үүнээс өмнө манай улс энэ хамгаалалт хэрэгтэй хүүхдүүдийг асрамж халамжийн газраар үйлчилгээ үзүүлж байсан бол энэ хуулиар “Асралт гэр бүл” гэдэг шинэ ойлголт орж ирсэн.

Энэ нь олон улсад хүүхдээ хамгаалж байгаа гол арга зүй байгаа.

Тэгэхдээ Монгол Улс ч гэсэн энэ нь уламжлал болсон арга зүй. Яагаад гэвэл Өүлүн эхийн өсгөсөн хүүхдэд.../минут дуусав/

**С.Одонтуяа:** М.Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Х.Булгантуяа сайд энэ ажлынх нь санхүүтэй холбоотой юмыг маш тодорхой яримаар байна.

Өмнө бид яг энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн хүмүүстэй уулзаад жишээ нь 2017 онд энэ 300 сая байсан төсвийг.

Одоо би өөрөө бүр төсвийн ажлын хэсгээ ахалж байгаад, эмэгтэй гишүүд маань орж байгаад өнөөдөр 8 тэрбум болгосон.

Тэр үед 11 тэрбум төгрөг шаардлагатай. Тэгвэл бас нэлээд боломжийн гэж хэлж байсан.

Тэгээд өнөөдөр мөнгийг нь нэмэх. 20 тэрбум ч хүртэл шаардлагатай гээд л яриад байна л даа.

Гэтэл Хууль зүй, дотоод хэргийн яам. Одоо жишээ нь яг хамтарсан багийг харахад хамгийн их хүүхэд дээр очдог нь “цагдаа”, нөгөө “хүүхдийн эрхийн байцаагч” байдаг.

Тэгэхээр энд Б.Энхбаяр сайд сууж байна.

Хүүхэд хамгааллын төсвийн хэдэн хувь нь Хууль зүй, дотоод хэргийн яам дээр бас байгаад байна аа?

Энд тэндгүй бид төсөв, мөнгө хуваарилаад байдаг. Үр дүн гарахгүй байгаад байдаг. Зарим нь Хууль зүй, дотоод хэргийн яамны яг тэр хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг тэр “хүүхдийн эрхийн байцаагч” нар хэлээд байгаа байхгүй юу. Бүх төсөв та нар Хөдөлмөр, нийгмийн хамгаалал дээр тавьчихаад тэгээд бид нараас бас ингээд ажил хийгээч гээд шаардаад байдаг гээд.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? 83. Н.Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

**Н.Баярмаа:** М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Хүүхэд хамгааллын зардлын асуудал дээр 2017 оноос эхлээд зардал нэмэгдсэн байгаа.

Тэгээд энэ дээр тулгуурлаад яг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар тухайн зардлынхаа одоо яг 60 хувийг нь урьдчилан сэргийлэх үйлчилгээнд, 40 хувийг нь хамгаалах үйлчилгээнд 2020 он хүртэл хуваарилж ирсэн.

Яг энэ зардлын дүн шинжилгээтэй холбогдуулаад Хүүхэд хамгааллын хууль талаар хүүхэд хамгааллын үйлчилгээг яаж зарцуулах вэ, санхүүжүүлэх вэ гэдэг энэ эрх зүйн зохицуулалт байгаагүй.

2017-2019 оны хүүхэд хамгааллын үйлчилгээний зарцуулалтад бас Сангийн

яамтай хамтарч бид дүн шинжилгээ хийсэн.

Энэ дүн шинжилгээгээр үнэхээр хүүхэд хамгааллын үйлчилгээндээ зарцуулагдах хувь нь бага байна. Хүүхдийн хөгжил оролцоо, урьдчилан сэргийлэх үйлчилгээндээ илүү байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээгээ үзүүлэх эрх зүйн зохицуулалттай болох ёстой гээд.

Тэгээд 2021 онд 2022 оны төсвийн хуулийг дагалдуулж хүүхэд хамгааллын хуульдаа бас санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг хийгээд яг энэ хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд нийгмийн ажилтан сэтгэл зүйч хэрхэн нэг кэйс дээр ажиллаж байна вэ гэдэг энэ нийгмийн ажил, үйлчилгээний дүн шинжилгээ хийсэн. 350 гаруй нийгмийн ажилтнуудтай ажиллаж яг энэ хүүхдийн хүчирхийллийн төрөл хэлбэрээрээ ажиллах цаг хугацаа ондоо байдаг юм байна.

Тэгэхээр одоо нэг нийгмийн ажилтан нэг хүүхдэд цаг хугацааг хэрхэн зарцуулдаг вэ гэсэн нийгмийн ажилтны нэг цагийн хөлсөөр нь тооцож энэ хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн дүн шинжилгээ хийж, яг энэ норматив аргачлалыг 2022 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд баталсан байгаа.

Тэгээд энэ дүн шинжилгээгээр хүүхэд хамгааллын үйлчилгээгээ бас тодорхой болгох ёстой юм байна гэсэн дүгнэлт гарсан.

Одоогийн байгаа хуулиар хамгааллын үйлчилгээ тодорхойгүй. Одоо үзүүлж байгаа тэр **“кэйс**

**менежмент”**-ийнхээ явцтай холилдсон байна.

Тэгээд энэ дээрээ тулгуурлаад урьдчилан сэргийлэх үйлчилгээ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Б.Энхбаяр сайд. Төсөв байдаг уу? Хүүхэд хамгаалалттай холбоотой.

**Б.Энхбаяр:** Цагдаагийн байгууллага бүх төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх бодлогыг хэрэгжүүлдэг.

Батлагдсан төсвийн хүрээнд энэ ажлыг хариуцдаг.

Яг тухайлсан гэмт хэрэг болгоноор нь төсвийг нь хуваарилдаггүй.

Бид **“хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх”** дээр тухайлсан мөнгө төгрөггүй учраас тэмцэхэд дутаад байна гэж хэлэхгүй.

Ер нь **“гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”** асуудлыг Улсын Их Хурал хуульд ч чангалсан, зөрчилд чангалсан.

5 жил хэрэгжиж байна. Энэ хуулийн харин хэрэгжилтийг хангах хүрээнд ажлыг эрчимжүүлэх шаардлага байгаа.

Нэг хэсэг бас энэ цагдаа хэт “гэр бүлийн хүчирхийллийн асуудал” дээр хууль хатуу байгаагаас, одоо бараг л үүнээс болоод л гэр бүл салаад байна гэдэг асуудал бас яригдсан шүү. Түүрүүчийн парламентын үед.

Миний хувьд үүнтэй санал нийлэхгүй. Парламент баталсан хуулийнхаа бодлого дээр хатуу зогсох ёстой. Хүчирхийлэл үйлдэж байгаа этгээдийг төр өөгшүүлэх учир байхгүй.

Тийм учраас хуульд заасан арга хэмжээнүүдээ авч цаашид хэрэгжүүлнэ гэсэн ийм бодолтой байгаа.

Урьдчилан сэргийлэх асуудал хамгийн цөмд байна.

Миний хувьд Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд цагдаагийн байгууллагад гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг нэг номерын асуудал болгож бүтцийн өөрчлөлт хийнэ. Тийм бодолтой байгаа.

Үүнийг батлагдсан төсвийнхөө хүрээнд багтааж асуудал ярина гэдгийг танд хэлье.

**С.Одонтуяа:** Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар ерөнхий боловсролын “Байгаль эх” сургуулийн 12-ын А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байна.

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуултаа асууя.

**Д.Сарангэрэл:** Энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл бас нэг хүүхдийн амиар л нэлээн цочоо авч ингэж шуурхай байдлаар орж ирж байна л даа.

2020 оноос авхуулаад С.Одонтуяа гишүүн, М.Оюунчимэг гишүүн, Б.Баярсайхан гээд манай Улсын Их Хурал дахь 13 эмэгтэй гишүүн энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийг гаргах гэж нэлээн хөөцөлдсөн.

Тэгээд өнөөдөр ингээд орж ирж байгаад бас баярлаж байна.

Тэгээд өнөөдөр энэ хуульд яг ямар өөрчлөлт орж байгаа юм гэдэг талаар тодорхой яримаар байна. Бид ерөнхий зүйл яриад байна. Тухайлбал, Эрүүгийн хуульд Б.Энхбаяр сайд маш тодорхой заалтууд, хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой ялын бодлогоо чангатгасан ийм тодорхой заалтууд оруулж ирээд ингээд хэлэлцүүлээд дэмжүүлээд явж байгаа.

Хүүхэд хамгааллын хууль дээр ямар ямар заалт ороод одоо байгаа нөхцөл хэрхэн яаж өөрчлөгдөх юм бэ гэдэг тооцоо, судалгаа байна уу?

Яг хүүхэд хамгаалалттай холбоотойгоор үр дүн нь гарах өмнө нь байгаагүй ямар ямар заалтууд орсон бэ? Хэдүүлээ ерөнхий юм ярихгүй, тодорхой зүйл ингээд яримаар байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, бид эцэг эхийн хариуцлагагүй байдал, эцэг эхийн хяналт муу гэдэг баахан шүүмжлэл байгаад байна.

Өдөржингөө ажил төрлөө хийж байгаа хүмүүс өдөржингөө хүүхдийнхээ

хойноос хөөцөлдөж бас анхаарахад түвэгтэй л дөө. Бусад орнуудын жишгийг харж байхад энэ ээж, аавуудад тусалдаг юм байна.

Н.Учрал сайд харин маш яаралтай тэр хүүхдээ хаана байгааг хянаж болох ийм цахим аппликэйшн нэвтрүүлснээ хэлж байна.

Тухайлбал, бид хүүхдийн хүчирхийлэгчийн жагсаалтыг гаргаад, зургийг нь тавиад анхааруулна гэсэн. Энэ нь хаанаа орж байгаа юм? Энэ хэзээ, хэн, яаж хийж хэрэгжүүлэх юм бэ?

Энэ талаар бид тэгнэ л гээд өнгөрсөн удаа яриад өнгөрсөн. Одоо хэн хариуцах юм гэдэг нь одоогоор ингээд тодорхойгүй байгаад байна.

Гуравдугаарт, Ерөнхий сайд Улсын Их Хурал дээр үг хэлэхдээ ер нь үндэсний хэмжээнд нэг камержуулалтын ажлыг хийе. Энэ урьдчилан сэргийлэх, гэмт хэргээс. Мөн шуурхай илрүүлэх гэмт хэргийг гэх мэт олон үр дүнтэй учраас Хууль зүйн сайдын багцад энэ камержуулалтын асуудлын төсвийг эмэгтэй гишүүд санаачлаад оруулаад ирээрэй гэсний дагуу 13 эмэгтэй гишүүн гарын үсэг зураад өгчихсөн байгаа.

Засгийн газар дээр төсөв ярилцахад Б.Энхбаяр сайд болон Х.Булгантуяа сайд энэ камержуулалтын санхүүжилтийн асуудал дээр онцгойлон анхаарч суулгах ёстой. Ерөнхий сайд өөрөө дэмжинэ гэдгээ илэрхийлчихсэн байгаа учраас энэ дээр би Та бүхнийг анхаараасай гэж бодож байна.

Ингээд сонсоод байхад тэгээд сая тухайлбал, эхний гишүүн асуултаа асуугаад ингээд хариулт явахад энэ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөл 2016 онд батлагдаад ингээд 2023 онд өөрчлөлт орох гээд ингээд байж байна.

Тэгээд тэр үеийн хуулийн заалтаас ямар ямар заалтууд нь өөрчлөгдөөд ямар дэвшил гарав? Үр дүн нь яаж гарна гэж тооцож байгаа юм бэ?

Аливаа хуулийн төсөл, аливаа хууль чинь өөрөө гарах үр дүнгээ тооцчихсон байдаг. Хугацааг нь төлөвлөсөн байдаг.

Тэгээд энэ зүйлүүд огт яригдахгүй байна. Үүнийг хэн хариулах юм бэ? Надад энэ дээр нэг тодорхой хариулт өгөөд. Тэгээд би цааш нь тодруулья гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Дэд сайд. 81 дүгээр микрофон. С.Зулпхар.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн асуултад хариулья.

Энэ хүүхэд хамгааллын хуулийн хамгийн гол онцлог нь тогтолцоог бүрэн болгоход чиглэсэн байгаа.

Хүүхэд хамгаалал нь өөрөө түрүүн гишүүдийн хэлсэнчлэн их олон талын оролцоотой. Гэр бүлээс эхлээд сургууль, түүнээс гадна жишээ нь цагдаагийн байгууллага, цаашлаад гэр бүл, хүүхэд залуучуудын асуудал хариуцсан төрийн байгууллага, засаг захиргааны анхан шатын нэгж, иргэдийн оролцоотой байх ийм л үйл ажиллагаа байгаа юм.

Тэгэхээр өмнөх хууль дээр эдгээр тодорхой субъектүүдийн үүргийг ер нь ерөнхийлж заасан байсан.

Энэ удаагийн хуульд бүгдийг нь тохоож оруулсан гэдгийг энд онцлох хэрэгтэй. Тухайлбал, гэр бүлийн орчинд хүүхэд хамгаалах, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр эцэг, эх үүрэг хүлээнэ.

Тэр хүүхэдтэйгээ харилцах дээр. Түүнээс гадна хүүхдэд эрсдэлт орчин бий болгохгүй байх тал дээр. Тэр нь зөвхөн гэр бүлийн хүрээнд биш гэр бүлээс гадна сургуулийн орчинд ч гэсэн бий болж болох тэр эрсдэлийг үнэлэх, үүнтэй уялдсан байдлаар хамгаалах арга хэмжээнд оролцох энэ харилцааг зохицуулсан байгаа.

Өмнө нь гэр бүл дээр тодорхойлсон үүрэг яг нарийвчлаагүй байдаг.

Цаашлаад бид **“хамтарсан баг”** гэж нэрлэж байгаа. Энэ үйл ажиллагаанд оролцдог “хамтарсан баг” байдаг. Засаг захиргааны нэгжүүд Засаг даргаар ахлуулсан мэргэжлийн болон тухайн асуудалд хамаарал бүхий талууд байдаг. Эмнэлгийн байгууллага байдаг, цагдаагийн байгууллага байдаг гэдэг.

Тэгэхээр эдгээрийн үүргүүдийг нарийвчилсан.

Энэ дээр хүүхэд болгоны тохиолдолд хэрвээ хүчирхийлэлд өртөх юм бол, хүчирхийлэлд өртөж болзошгүй нөхцөл байдал үүсэх юм бол кэйсийн түвшинд буюу тохиолдлыг өөрөө удирдаад явах процессыг бүр нарийвчилж өгсөн.

Тухайлбал, тэр **“эрсдэлийг яаж үнэлэх юм”**, эрсдэлийг үнэлсэнтэй холбоотойгоор **“төлөвлөгөөг яаж гаргах юм”**, төлөвлөгөөг талууд **“яаж**

**хэрэгжүүлэх юм”** гээд энэ бүгдийг зааж өгснөөрөө энэ хуулийн онцлог байгаа юм.

Олон улсын байгууллагын зөвлөхүүд, түүнээс гадна энэ чиглэлээр ажиллаж байсан төрийн бус байгууллагууд, манай өөрийн ажил хариулж байсан талуудын гол ярьж байсан зүйл “процесс тодорхой биш” учраас энэ дээр эрх, үүргээ зарим.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Нэмээд Х.Булгантуяа сайд хариулна.

**Х.Булгантуяа:** Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас 2020 онд хийсэн үнэлэлт, дүгнэлтэд энэ нь хуультай болж, “108” утас.

Та бүхэн санаж байгаа бол олон улсын байгууллагын санхүүжилттэйгээр явдаг байсан.

Энэ нь одоо төрийн нэг бүтэц болоод, хүүхдийн эрх зөрчигдөж байгаа мэдээллүүд байнга ирдэг. Энд ирж байгаа дуудлагуудын 50 гаруй хувь нь зорилтот дуудлагууд. Зарим нь зөвлөгөө авах дуудлагууд байдаг.

Мөн үүнтэй уялдаад бидэнд өгсөн гол зөвлөмжүүд нь бүтэц, зохион байгуулалтуудыг сайжруулмаар байна.

Дээрээс нь нэмээд санхүүжилт тодорхой бус байна.

Тийм ч учраас Гэр бүл, хүүхэд хөгжлийн газар байнга хязгаарлалттай дүгнэлттэй гардаг байсан.



Тэгэхээр санхүүжилтийнх нь норм, норматив, аргачлал, бүх юмыг тодорхой болгоогүйгээс тэнд ажиллаж байгаа хүмүүс, энэ байгууллага хязгаарлалттай дүгнэлт авах эрх зүйн орчин бүрдээд байна гэсэн үүднээс үүнийг улам их тодорхой болгосон.

Шинэлэг зүйлүүд гэх юм бол хэд хэдэн зүйлүүд.

Нэгдүгээрт, манай хүүхэд хамгааллын тогтолцоо газар нутгийн засаг захиргааны нэгжийн бүтэцтэйгээр явдаг.

Тэгэхээр ерөнхийдөө манай 400 гаруй мянган хүн амтай дүүрэг ч адилхан, 40, 50 мянган хүн амтай аймаг ч адилхан. Яг адилхан бүтэцтэй. Гэтэл мэдээж хүн амынхаа тоогоороо гарч байгаа кэйсийн тоо онцгой их.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор. Жишээлбэл, саяын Дорноговь аймагт гэхэд аймгийнх нь хүн ам нь бага. Гэхдээ хөл хөдөлгөөн ихтэй аймаг учраас ийм кэйс гарах тохиолдол их байгаад байгаа учраас энэ хууль дээр бид “**хүүхэд хамгааллын улсын байцаагч**”, энэ чиглэлийн ажилтнуудыг кэйстэй уялдуулан Засгийн газар 3 жил тутам шинээр тодорхойлохоор болсон.

Мөн хоёрдугаарт, хүүхэд болгон төрсөн цагаасаа “**Төрсний гэрчилгээ**”-тэй болдогтой адилхан “**Хүүхэд хамгааллын хувийн хэрэг**”-тэй больё.

Аймаг, орон нутгаас хот руу шилжиж нүүж ирэхэд тухайн хүүхдийн тухай өмнө нь хүчирхийлэлд өртөж байсан эсэх, гэр бүл нь эрсдэлтэй гэр бүл эсэх талаарх мэдээллүүд ирдэггүй.

Дараагийн дүүрэг дээрээ, аймаг дээрээ ирээд ахиад хүчирхийлэлд өрттөл бид тэр тухай мэдээлэл байдаггүй.

Тэгэхээр үүнийг бид хувийн хэрэгтэй болгоё.

Мөн гуравдугаарт, анх энэ удаа “**цахим орчин дахь хүүхэд хамгаалал**”-ын асуудлыг бид Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран оруулсан.

**С.Одонтуяа:** Гүйцээгээд хариулчих. Х.Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Мөн “**үе тэнгийн дээрхлэлт**”-ийг хуулийн дагуу, олон улсын жишгийн дагуу бид хуульчилж оруулж өгсөн.

Мөн хүүхэд хамгааллын асуудлаар бусад салбарууд бас бодлоготой байх ёстой.

Барилга, хот байгуулалтын яам “**хүүхэд хамгааллын бодлоготой байх ёстой**”.

Зам, тээврийн яам “**хүүхэд хамгааллын бодлоготой байх ёстой**”.

Хүүхэд сургуулиасаа гараад зам дээрээ осолд орчихдоггүй байх ийм салбар болгон бодлоготой байх ёстой гэдгийг суулгаж өгсөн.

Мөн үүнтэй хамт барилга, зам хүлээн авах комиссуудад энэ чиглэлийн улсын байцаагч нарыг орж ажиллуулах хууль эрх зүйн тогтолцоог бас бий болгож оруулсан байгаа.

Ер нь хүүхдийг нэгдүгээрт, урьдчилан сэргийлэх.

Хоёрдугаарт, энэ хууль бас нэлээн процессын хууль. Хүүхэд ямар нэгэн эрсдэлд ороход хэн төрөөс эрхийг нь хамгаалахын төлөө хэрхэн ажиллах вэ гэдгийг нэлээн нарийн процессоор зааж өгөх ёстой байдаг.

Бид орон тоог гаргая гэж байгаа нь “**хамтарсан баг**”-ийн хүн болгон өөр давхар олон ажлыг хийдэг.

Тэгэхээр энэ бол хүүхэд хамгааллын ажил. Хүмүүс олон ажлынхаа дундуур давхар хийдэг ажил биш юм.

Хэв журмыг сахиулахын хажуугаар, архидалттай тэмцэхийн хажуугаар, зөрчилтэй тэмцэхийн хажуугаар үүнийг хийдэг ажил биш юм.

Соёл, спортын тэмцээнд орсон уу, үгүй юу гэдэг тайлан гаргахын хажуугаар хүүхэд, хамгааллын ажлыг “**хорооны нийгмийн ажилтан**” хийх ёсгүй юм гээд өнөөдөр “хүүхэд хамгааллын тусгайлсан мэргэжилтэн”-тэй больё.

Монгол Улсын хэмжээнд хүүхдийн асуудал тулгамдсан асуудал хэвээр байна гэж хороо болгонд, сум болгонд “**хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан**”-тай байхаар зохицуулж өгсөн байгаа.

**С.Одонтуяа:** Д.Сарангэрэл гишүүн тодруулах юм уу? Тодруулга 1 минут.

**Д.Сарангэрэл:** Асуултаа нэг л ойлгохгүй байна даа.

Би их тодорхой асуултууд асуусан шүү дээ. Жагсаалтаа яах юм бэ гэж.

Тухайлбал, эцэг, эхийн хариуцлагын асуудлыг ярилаа.

Тэгвэл хариуцлагын асуудал дээр ямар заалт байгаа юм?

Угаасаа Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хууль хоёулаа холбоотой байгаа учраас би Б.Энхбаяр сайдыг ч гэсэн энд оролцоод бас мэдээллүүд өгөөсэй гэж бодож байна л даа.

Тухайлбал, саяын 12 настай охины энэ асуудал дээр хугацаанаас нь өмнө суллаагүй байсан бол охин өнөөдөр амьд байх магадлалтай л гэж байгаа юм.

Үүнийгээ хоёр яам хоорондоо ярьсан уу? Тэр жагсаалтаа яахаар болсон бэ гээд түрүүн би зөндөө асуусан. Өмнө нь хэлэлцэхэд ч гэсэн энэ тухай ярьсан.

Аль яам нь, хэн нь хариуцаад энэ жагсаалтаа тухайн танай амьдарч байгаа дүүрэг, тойрогт чинь нэг ийм нөхөр байгаа шүү гэдгийг хүмүүстээ яаж мэдээлж байх юм бэ? Ингэж байж эцэг, эхдээ тусална гэж би хэлээд байна шүү дээ. Үүнийгээ ер нь ойлгож байна уу, ойлгохгүй байна уу? Ямар түвэгтэй юм бэ.

Тэгэхээр энэ дээр тодорхой заалтууд юу байна гэхээр зэрэг одоо тэрийг чангатгаж байгаа, тэр баг ингэж ажиллана гээд тодорхой.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Б.Энхбаяр сайд хариулъя.

**Б.Энхбаяр:** Д.Сарангэрэл гишүүний хөндөж байгаа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлогын хүрээнд

уржигдар буюу Лхагва гарагт Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, түүнийг дагалдаж оруулж ирсэн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх эсэхийг дэмжсэн.

Тэр маньякуудын тухайтад бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн бөгөөд тэгээд суллагдсан байгаа этгээдүүдийг нэр ус, гол шинж тэмдгүүдтэй нь цахим гав зүүчихнэ.

Мөн олон нийтэд нээлттэй мэдээлэх ажлыг нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн өөрчлөлтөөр бид оруулаад Улсын Их Хуралд дэмжчихсэн байгаа.

Үүний хэрэгжилтийг нь манай яам хариуцаж зохион байгуулна.

Цахим гавд нь байнгын хяналт тавих ажлыг нь цагдаагийн байгууллага хариуцаж зохион байгуулна.

Үүнийг бид 2024 оны төсөвтөө зохион байгуулах боломжтой гэж үзсэн байгаа.

Ер нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд хязгаарлалт тогтоохтой холбоотойгоор цаашид үүсэж болох орон тоо, төсөвтэй холбоотой судалгааг хийж үзэхэд 100 гаруй орон тоо. 2024 оны тухайд шүү. 1.6 тэрбум төгрөгийн төсвийн нэмэлт ачаалал үүсэх тооцоо гарсан.

Миний хувьд үүнийг 2024 оны батлагдсан төсөвтөө дотор нь хөдөлгөөн хийх замаар. Орон тооны тухайтад мөн батлагдсан орон тоондоо багтааж зохицуулах боломжтой гэж үзэж байгаа.

Эмэгтэй гишүүд маань бас камерын асуудал дээр онцгой анхааруулж санаа тавьж байгаад их баярлалаа.

Энэ дээр бид тооцоо хийж үзэхэд ер нь нэлээн том тоо гараад байгаа. Би тоог нь хэлэхээс айгаад байна. Та хэдийг бас цочоож ч магадгүй их.../минут дуусав/

**С.Одонтуяа:** 81 гүйцээж хариулна. С.Зулпхар дэд сайд.

**С.Зулпхар:** Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхтэй холбоотой харилцаа Гэр бүлийн тухай хуулиар тухайлан зохицуулсан байсан.

Бид Хүүхэд хамгааллын хууль дээр үүнийг тухайлан оруулж ирсэн.

Хүүхэд хамгааллын хуулийн 3 дугаар бүлэг гэр бүл, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллыг тодорхойлсон байгаа. Энд 9 зүйлээр үүнийг тодорхойлсон. Энд эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхтэй холбоотой хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэх.

Түүнээс гадна нийгмийн хамгааллаа хангах чиглэлээр зөвлөн туслах үүргийг оруулсан. Эцэг, эх хүүхдээ эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үнэлгээ хийх, түүнтэй уялдсан байдлаар хамгаалах харилцааг оруулсан.

Дөрөвт нь, эцэг, эх хүүхэдтэй холбоотой эрхээ урвуулан ашигласан байх юм бол ямар нэгэн байдлаар хариуцлага хүлээлгэхээр оруулсан.

Эцэг, эх хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хүүхдээ хөдөлмөр эрхлүүлэхийг хориглосон. Хуулиар

хориглосон боловч бид энэ дээр бас тухайлан оруулж өгсөн.

Эцэг, эх хүүхдийнхээ эрх, нэр төрд сөргөөр нөлөөлөх мэдээлэл, дуу бичлэгийг түгээхийг хориглосон байдлаар оруулж өгсөн.

Энэ нь эцэг, эхийн хүүхэд хамгаалалттай холбоотой гэр бүл нийгмийн хүрээн дэх үүргийг тухайлан зааж өгсөн ийм шинэ заалтууд орсон байгаа.

Цаашлаад боловсролын орчинд, эрүүл мэндийн орчинд, эрүүл мэндийн харилцаанд, цаашлаад нийгмийн харилцаанд, олон нийтийн харилцаанд оролцох явцад эцэг, эх тодорхой үүрэг хүлээхээр бусад зүйлүүд дээр нь тухайлан заасан байгаа гэдгийг хэлье.

Энэ удаад гэр бүлийн орчин дахь эцэг, эхийн үүргийг энд тухайлан оруулж өгөхгүйгээр энд эцэг, эх хүүхэд хамгаалалд яаж оролцохоо мэдэхгүй. Оролцоогүй нөхцөлд яаж энэ дээр бид зохицуулалт хийхийг тодорхойгүй байна гэдгийг судлаачид, хууль боловсруулагчид энэ дээр онцгойлон авч үзсэн учраас үүнийг ингэж оруулж өгсөн гэдгийг хэлье.

**С.Одонтуяа:** Д.Сарангэрэл гишүүн 1 минут.

**Д.Сарангэрэл:** Саяын тайлбараас чинь сонсоход эцэг, эхчүүд хүүхдээ эерэг хүмүүжүүлээгүй байгаа учраас гаднын хандлагад өртөөд байгаа юм шиг л ийм юм болох гээд байна.

Хамгийн гол нь бид энэ Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхдийнхээ эрүүл мэнд, амь насыг хэрхэн яаж

хамгаалах тодорхой заалтууд орсон бэ гэдгийг гурав дахиа асууж байна.

Чи яагаад ийм ойлгомжгүй байдал яриад байна. Энэ дээр эцэг, эх, гэр бүлийн доторх хүмүүжлээс боллоо гэдэг асуудал яриагүй байна шүү дээ.

Хүүхдүүд хүчирхийлэлд өртөөд байна, хүүхдүүдийн амь насыг бүрэлгээд байна, хүүхдүүд гэмтээд байна, согтуу жолооч хүүхдийг ослоор амь насыг нь бүрэлгэж байна. Гэх мэт ийм асуудлуудаа, хүүхдүүдээ хэрхэн яаж хамгаалах вэ? Тийм ямар заалт орсон бэ?

Тэгвэл та нарын яриад байгаа тэр хариуцлагагүй эцэг, эхчүүдэд ямар хариуцлага хүлээлгэхээр наана чинь орсон юм.

**С.Одонтуяа:** Нэн хариулах вэ? 84. Нэрээ хэлээд, байгууллагаа хэлээд.

**П.Баттулга:** Хуульч П.Баттулга. Д.Сарангэрэл гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр хүүхэд хамгаалал гэдэг маань маш олон хууль тогтоомжийн зааг дээр оршдог бас ийм онцлогтой ийм асуудал байгаа.

Гэр бүл дэх эцэг, эхийн хариуцлагын асуудал зөвхөн Хүүхэд хамгааллын хуулиар биш бас Гэр бүлийн тухай хуулиар нарийвчлан зохицуулагддаг.

Хуулийн төслийн [4 дүгээр бүлэг](#) “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гээд тодорхой бүлэг байгаа.

Энэ дээр хамгийн эхлээд мэдээж “хүүхэд амь нас, эрүүл мэнд нь эрсдэлд

орсон бол шуурхай тусламжийн үйлчилгээг нэн даруй үзүүлнэ” гэдэг ийм зохицуулалтыг оруулж өгсөн.

Ингээд хүүхдийг гэр бүлийн орчинд орчинд нь байлгах боломжгүй бол хүүхдийг “**Асралт гэр бүл**”, төрөл садны асрамжид байлгах. Бүр боломжгүй бол асрамж, халамжийн байгууллага руу шилжүүлэх ийм тодорхой процессуудыг хуульчилсан байгаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар мэдээж тэр түр хамгаалах байранд байршуулах, нэг цэгийн үйлчилгээнд байршуулах гэдэг бүх асуудал нь тэр хуулиараа бас давхар зохицуулагдаад явж байгаа.

**С.Одонтуяа:** Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 43 дугаар цэцэрлэгийн багш, ажилтнуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Манай 43 дугаар цэцэрлэг нийслэл болон улсын хэмжээнд жишиг цэцэрлэг.

Тэгээд цэцэрлэгээ ийм сайхан жишиг цэцэрлэг болтол ажиллуулж байгаа багш, сурган хүмүүжүүлэгчдэд баяр хүргэе. /алга ташив/

Манай М.Оюунчимэг гишүүн маань цэцэрлэгийн асуудалд онцгой анхаардаг гишүүн байгаа. М.Оюунчимэг гишүүндээ бас баяр хүргэе.

Одоо Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуултаа асууна.

**Б.Энх-Амгалан:** Нэг үг байдаг. “Ямар үр тарина тийм л жимсээ хураана” гэж.

Хүүхэд бол манай нийгмийн толь байгаа юм.

Тийм учраас юу сонсоно, юу харна, юу мэдэрнэ яг түүнийгээ даган дуурайдаг.

Тэгэхээр бид эхлээд нэг зүйлийг л бодмоор байгаа юм л даа. “**Эх нь булингартай бол адаг нь булингартай**” гэж үг бий шүү дээ.

Тэгээд манай нийгэм өөрөө энэ хүүхдүүдэд ээлтэй нийгэм мөн үү, биш үү гэдгээсээ эхлээд бодох ёстой юм.

Түүний төлөө бид алхам хийх ёстой байхгүй юу. Монгол Улсад **2.8 сая интернэт хэрэглэгч** байгаа. Түүний **1.5 сая нь сошиал хэрэглэгч**. Түүний 1.5 сая нь хуурамч аккаунт байгаа, хаяг байгаа.

250, 300 мянга гаруй бүртгэлгүй дугаар байгаа. Хэчнээн телевиз байна. Нэг хүнд ногдох. Хэчнээн контент үйлдвэрлэдэг вебсайтууд байна.

Ингээд ийм юмаа харахаар зэрэг бид хүнээсээ их ийм мэдээллийн замбараагүй орчинд амьдраад байгаа байхгүй юу.

Тэгээд хүүхдүүддээ юу үзүүлж байгааг бид харах ёстой юм.

**Телевиз, facebook, кино контент, дуу хөгжим.** Сонсож байгаа, мэдэж байгаа энэ бүх зүйл чинь хүүхдүүдэд ямар нөлөө үзүүлж байна гэдгийг анхнаасаа бид бодох ёстой байхгүй юу.

Одоо та нар энэ **UNIVISION**-ийг аваад үзээрэй. Кодоо өөрчилж болохгүй. 1234 гэж хийгээд л хүссэн юмаа үзнэ.

**Facebook** дээр ямар ч хүүхдүүдийг үзэж болохгүй гэсэн хориглолтой юм байхгүй.

Тийм учраас хүүхдүүд цахим халдлагад өртөөд байдаг. Тэгээд сүүлдээ дэлгэцийн хамааралтай хүүхдүүд маш их болсон.

Ийм учраас бид эхлээд нөгөө **“Бусдын толгой дээрх өвсийг харахаар өөрийнхөө толгой дээрх бухлыг хар”** гэж нэг үг байдаг шүү дээ.

Түүн шигээр бид нийгмээ цэвэрлэх асуудлыг нэгдүгээрт бодох цаг болсон байгаа юм. Энэ эх нь булингартсан байгаа. Тэрийгээ цэвэрлэх цаг болсон байгаа юм. Энэ дээр бид яг юу хийх вэ?

Сургуулийн орчинд хүүхдүүдийг зүс царай, тэр өмссөн зүүсэн, бие бялдрын хөгжил, тэгээд тэр үзэл бодол, есөн шидийн юмаар нь ялгаварлан гадуурхдаг ийм юмыг яаж болиулах юм?

Тэр сургалтын хөтөлбөр, заах арга чинь зөв байгаа юм уу, буруу байгаа юм уу? Монгол хүүхэд тохирч байгаа юм уу, үгүй юм уу гэдгийг яагаад бодохгүй байгаа юм.

Энэ чинь бид хүүхдээ хүмүүжүүлэх, хүүхдээ боловсруулах хамгийн чухал суурь нь энэ.

Хоёр дахь нь, монголчууд бас ярьдаг. **“Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг”** гэж. **“Буруу эрхэлсэн**

**хүүхэд бухын хүзүүнээс хатуу”** гэж ярьдаг шүү дээ.

Гэр бүлийн хүмүүжлийн асуудлыг бид хамгийн сайн тавихгүй бол яг л эцэг, эх нь ямар байна хүүхэд нь яг тийм болж байгаа юм. Сургуулийн орчиндоо ч тэрийгээ гаргаад байгаа юм.

Тийм учраас хүүхдүүдийг хүмүүжүүлэх гэр бүлийн орчныг сайжруулах, тэр хүүхдүүдийг зөв хүн болгох тал дээр онцгой анхаарах шаардлага хэрэгцээ байгаа юм.

Бид энэ дээр олон улсын туршлага гэж яриад хэрэггүй. Эхлээд Монгол хүн болох ёстой. Дараа нь тэр дэлхийн хүн болдог юм байгаа биз.

Тийм учраас монгол аргаараа хүмүүжүүлдэг, зан заншлаа мэдрүүлдэг, тэр үлгэр, домгоо сонсгодог, тэр зааж сургадаг, үлгэрлэдэг тэр юмнуудыг гэр бүлийнхээ орчинд хийх шаардлага хэрэгцээ байгаа юм. Үүнийг нь та бүхэн маань юу гэж бодож байна?

Гурав дахь нь, нүгэлгүй бурхад бол хүүхдүүд байгаа юм шүү дээ.

Тэгээд энэ учраа олохгүй байгаа, юугаа ч мэдэхгүй байгаа тэр гэнэн цагаан оюуныг буртагладаг энэ хүүхдийн эсрэг гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг чангатгах ёстой гэдэг дээр хатуу байр суурьтай байгаа.

Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд бид тэр бохир нийгмээ л цэвэрлэх ёстой байхгүй юу. Тэр юм руу уруу татаад байгаа нөхдүүдийг цэвэрлэх ёстой. Бэлгийн буруу чиг хандлага руу явуулаад байгаа тэр хүмүүсийг цэвэрлэх ёстой. Энэ дээр яах ёстой юм?

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ?  
Х.Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** Б.Энх-Амгалан  
гишүүний хэлж байгаа үнэн.

Бид яах вэ, Хүүхэд хамгааллын хуулийг улам чангаруулж болно. Энэ дээр илүү их мөнгө тавьж болно. Гэхдээ үнэнийг хэлэхэд өнөөдрийн ядуурал, ажилгүйдэл, архидалт, нийгмийн сэтгэл зүй ийм хүнд байгаагийн сүүдэр л хүүхэд дээр хамгийн хүчтэй, өөрөө өөрийгөө хамгаалах чадваргүй хүүхэд дээр л тусаад байгаа юм.

Дээрээс нь нэмээд өнөөдөр хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 70 гаруй хувь нь гэр бүлийн орчиндоо байна гэдэг бол эцэг, эх болчихсон байгаа энэ цаг үеийг тухайн үед бид хүмүүжүүлж, боловсруулж, хариуцлагатай нийгмийн эд эс, эцэг, эх болгож чадаагүй бас нэг л ийм тогтолцооны алдаа өнөөдөр харамсалтай нь гарч байна л гэсэн үг.

Хүүхдэд ээлтэй нийгэм өнөөдөр байж чадаж байна уу гэж. Хүүхдэд ээлтэй битгий хэл том хүнд ээлтэй нийгэм биш байна шүү дээ.

Өнөөдөр хүүхэд гэрээсээ гараад л машинд дайруулчхаж байна гэж байна. Том хүн ч мөн адилхан байгаа юм. Юмнаас унаад, бэртээд ингэхэд ерөөсөө Монголын нийгэмд үнэнийг хэлэхэд Үндсэн хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ бүх боломж өнөөдөр хүүхдэд битгий хэл том хүнд бий болоогүй учраас өнөөдөр бид ингээд энэ асуудлыг бас яриад сууж байгаа.

Эхлээд монгол хүн болоод дараа нь дэлхийн хүн болох ёстой гэж байна.

Одоо бүр хүүхдээс нь яаж нэг насанд хүрсэн хүн болгочих вэ? Эрүүл, аюулгүй, хүчирхийлэлд өртчихгүйхэн шиг хүн болгочих уу гэдэг л өнөөдөр тийм асуудлаа л хэдүүлээ бараг яриад сууж байна л даа. Одоо бүр дэлхийн хүн ч одоо бүр дараагийн асуудал байх.

Тэгэхээр яах вэ, энэ хууль ийм юм. Нэгдүгээрт, хүүхдийг яаж эрсдэлд оруулахгүй байх вэ гэдэг урьдчилан сэргийлэх. Үүнийгээ дагаад маш их мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг хийх ёстой.

Хүмүүс үүнийг ерөөсөө багаас нь заах ёстой гээд байдаг.

Гэтэл манай боловсролын салбарынхан хүүхэдтэйгээ 4-өөс 6 цаг л сургууль дээр байгаа. Цэцэрлэг дээр 8 цаг, 10 цаг л байгаа байх. Их л удаж. Үлдсэн хугацаанд нь эцэг, эхтэйгээ байгаа гэдгийг бодож эцэг, эхчүүд рүү чиглэсэн ажлыг бид бас давхар хийх ёстой гэж манай эрдэмтэн, судлаачид үздэг юм билээ.

Энэ хүмүүс хүүхдэдээ хамгийн хүчтэй нөлөөлж байгаа хүмүүс байгаа. Тэгээд нийгэм байгаа, цахим орчин байгаа.

Энэ хууль дээр бид бас анх удаа энэ хүүхдийн цахим орчны асуудлыг бид хуульчилж сайн оруулж өгсөн байгаа.

Тэгэхээр одоо энэ хуулийн хүүхдийн эсрэг хэрвээ гэмт хэргийг бууруулья гэвэл, хүүхдэд ээлтэй нийгэм больё гэвэл манай бараг хууль болгонд л яригдах ёстой юм билээ.

Тэгээд дээрээс нь нэмээд ялангуяа манай Хэрэг эрхлэхийн дарга маш их ярьж байгаа юм. Энэ стандартын асуудлуудыг л сайжруулж байж л ер нь хүүхдэд ээлтэй нийгэм бүрдэхээр байгаа.

Тэгээд яах вэ, манай хууль бол хүүхдийн эрсдэлд орохоос яаж нэгдүгээрт урьдчилан сэргийлэх вэ. Хүүхэд эрсдэлд орвол төр яаж үүн дээр хамгаалж ажиллах вэ.

Гэр бүлийн орчинд гэх юм бол Гэр бүлийн хуулиар бас нэлээдгүй зохицуулагдах. Хүүхдээ хүчирхийлээд байвал, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдээд байвал эцэг, эх байх эрхийг нь хэрхэн яаж хасах вэ, ямар үүрэг, хариуцлага хүлээх вэ. Эрүүгийн шинж чанартай байх юм бол Эрүүгийн хуулиар явна.

Тэр хүний эрхтэй холбоотой асуудлыг Б.Энхбаяр сайд хариулах уу?

**С.Одонтуяа:** Н.Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Б.Энх-Амгалан гишүүн бас чухал асуудлыг хөндөж байна. Тийм.

Харилцаа, холбооны зохицуулах хорооноос өргөн нэвтрүүлгийн телевизүүдэд тавигдах шаардлагыг баталсан байдаг.

Тэгээд тэр шаардлагад насанд хүрэгчдэд зориулсан контентыг үзэх болоод хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээ, мэдээллээс хамгаалах тухай байнгын хяналт, мониторингийг хийдэг.

Энэ мониторинг мэдээж энэ контентоос урьдчилан сэргийлэх

зорилгоор **IPTV**<sup>[Internet Protocol television]</sup> энэ интернэтийн үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагууд дээр эцэг, эхийн хяналтын тохиргооны функцүүдийг нэвтрүүлж хяналт тавьж байгаа.

Тэгээд эцэг, эхчүүд бас төдийлөн ойлголтгүй байх шиг байна. Энэ **black-list.mn** гээд ийм веб хуудас ажиллаад. Энэ нь нөгөө **DNS**<sup>[Domain Name System]</sup> системийн бүртгэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээг Харилцаа, холбооны зохицуулах хороо авдаг.

Нэг ёсондоо хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээ, мэдээллийг түгээж байгаа веб хуудсуудад энэ **black-list** рүү хэрвээ илгээчих юм бол тэр **report**-ыг нь үндэслээд үүнд нь хяналт тавиад явж байгаа.

Дээрээс нь **IWF**<sup>[Internet Watch Foundation]</sup> гэж олон улсын стандарт репортын дагуу **ekids.mn** гээд веб хуудас ажиллаад. Энэ дээр яг энэ хүүхдэд сөрөг нөлөө үзэхүйц контентуудыг бүртгэж аваад хариу арга хэмжээнүүдийг аваад явдаг.

Гэтэл энэ **ekids.mn** яг тийм хандаж байгаа хандалт өнөөдөр бараг 10 жил ажиллаж байхад тийм өндөр биш байгаа.

Тийм учраас бид үүнийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр хүүхэд хамгаалалттай холбогдуулаад 1.6 сая хэрэглэгчтэй төрийн үйлчилгээний мэдээлэл солилцооны **e-mongolia** систем дээр анх удаа хүүхдийг таньдаг болголоо.



Хүүхдийг танина гэхээр хүүхэд өөрөө регистрийн дугаараар бичээд орохоор.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Багш нарт сурган хүмүүжүүлэх үйлсэд нь өндөр амжилт хүсье.

Өнөөдөр Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай хууль яг хэлэлцэж байгаатай Та бүхэн таарч байна.

**Б.Энх-Амгалан** гишүүн тодруулья.

**Б.Энх-Амгалан:** Бид хүүхдүүд юу сонсоно, юу харна, юу мэдэрнэ тэрийгээ л даган дуурайдаг гэж хэлээд байгаа юм.

Тийм учраас хүүхдүүдээ зөв байлгах, тэр хүүхдүүдийг хамгаалах үүднээс бид хэдэн зүйлийг хийж болох бололцоотой юм.

Нэг дэх нь, үзэж байгаа, харж байгаа юмыг нь цэгцлэх бололцоо боломж байгаа.

Хоёр дахь нь, хүүхдүүдэд тэр РС тоглоомд донтдог, дэлгэцийн хамааралтай болох юмыг хязгаарлах боломж бид нарт байгаа.

Гурав дахь нь, хүүхдүүдийг хар тамхи, мансууруулах бодис, энэ сэтгэцэд нь тэлдэг эм бэлдмэлийг хэрэглүүлэхгүй байх талаас нь анхаарах ийм боломж бид нарт байгаа.

Дөрөв дэх нь, хүүхдүүдийг нялх балчраас нь бэлгийн чиг хандлагыг нь зөв тогтоох ийм юм бодохгүй бол хүний эрхийн асуудал ярьж байгаад учраа ч олохгүй хүүхдүүд жагсаад явж байсныг би нүдээрээ харсан шүү.

Багаасаа үүнийг сонирхоод ингээд буруу чиг хандлагатай болчих юм бол аюултай гэдгийг бид бодох ёстой.

Дөрөв дэх нь, бид цахим халдлагаас хүүхдүүдээ хамгаалах бололцоотой. Ийм зүйлүүдийг бид.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Н.Учрал сайд хариулья.

**Н.Учрал:** Хүүхдүүд бас энд ирсэн байна.

Одоо энэ **e-mongolia** дээр **e-kids** рүү регистрийн дугаараар ороод код гарч ирвэл кодыг нь эцэг, эх уншуулаад хүүхдүүд холбогдчихож байгаа. Үзсэн үү? Тийм ээ.

Тэгээд гэртээ ирлээ, сургуульдаа ирлээ гээд. Тийм ээ. Нэг кноп дарахаар гурван үгтэй хаяг шууд та нар луу илгээгдээд. Тэгээд эцэг, эхдээ мэдээлэл хэлж байна.

Дээрээс нь цагдаагийн байгууллага руу хүсэлт явуулж байгаа шүү дээ. Гэмт хэрэг зөрчилтэй гудамжинд таарах юм бол, янз бүрийн

халдлага болох юм бол зургийг нь аваад зургийг нь эцэг, эх рүүгээ шид ээ. Дээрээс нь цагдаагийн байгууллага руу шид.

Одоо Хууль зүйн сайд энд сууж байна. Б.Энхбаяр сайд цагдаагийн байгууллага руу, танайх руу манай **e-kids.mn**-хэн ингээд хүүхдүүд зураг илгээж байгаа.

Үүнийг нь, зохих арга хэмжээг нь, хурдан арга хэмжээг нь аваад эхэлчихээч. Ингээд хаа хаанаа хурдан шуурхай ажиллах нөхцөл бололцоог бид энэ **e-mongolia**-р нээсэн юм.

Тэгэхээр би хүүхдүүддээ уриалж байна.

Нэг дэх өдөр нээсэн гэхэд **e-kids.mn** өнөөдөр 5888 хүүхэд бүртгүүлчихсэн байна. 5888 шүү дээ. 3 өдрийн дотор. Өчигдөр гэхэд.

Тэгэхээр энэ 5888 хүүхэд гэмт халдлагад өртөөд цахим орчинд янз бүрийн контент гаргаад байгаа мэдээллүүдийг шууд цагдаагийн байгууллага руу илгээ.

Дээрээс нь онцгой тохиолдолд эцэг, эх рүүгээ **“sos”** маягаар захиа илгээгээд.

Ингээд **“Хүүхдийн төлөө за гэж хэлье”** гээд дуулдаг байсан бол өнөөдөр бас нэг ийм заавал хийх шаардлага бид нарт үүсэж байна шүү дээ.

Тэгэхээр би Х.Булгантуяа сайдаас бас хүсээд байгаа юм. Энэ хууль дээр янз бүрийн дүрэм, журам батлах гэдэг үгүүд оруулбал хэдүүлээ ер нь тал талдаа төрийн байгууллагын ажил чинь удаан.

Тэгээд ухнатсаар байгаад хэдүүлээ сонгуульд ойртоно.

Тэгэхээр Цахим хөгжлийн сайд гэр бүлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтарч батална энэ тэр гэдгийг ер нь болиод зүгээр л хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээг Цахим хөгжлийн сайд хариуцна гээд биччихмээр байгаа юм. Тэгээд хаа хаанаа л хариуцъя.

**С.Одонтуяа:** Ж.Хунан дарга. Хүний эрхийн Үндэсний Комисс. 80 дугаар микрофон.

**Ж.Хунан:** Б.Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя.

Бэлгийн цөөнх мөн ялгаа байхгүй бидний адил хүн.

Тийм учраас төрөхөөсөө нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Монгол Улс бэлгийн чиг баримжаанд үндэслэж ялгаварлан гадуурхахыг гэмт хэрэгт тооцсон байгаа.

Тийм учраас бэлгийн чиг баримжаа нь өөрөөс болоод хүүхдийн хүчирхийлэл бий болж байгаа, эсвэл хүүхдийн хүчирхийлэл нэмэгдэж байгаа гэдэг энэ ойлголт ташаа гэдгийг бас хэлэх нь зөв байх.

Тийм учраас энэ дээр бас бэлгийн цөөнхийн эрх мөн ялгаа байхгүй хүний эрхийн асуудал.

Тийм учраас бидний адил эрх үүрэгтэй, эрх чөлөөтэй гэсэн үг.

**С.Одонтуяа:** Одоо Дамбын Батлут гишүүн асуултаа асууна.

**Д.Батлут:** Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Ер нь иргэд хүүхэдгүй юм шиг ажиллаж, ажилгүй юм шиг хүүхэд харах тийм нөхцөлд л ажиллаж амьдарч байна даа.

Үнэхээр сэтгэл гэгэлзүүлсэн маш хүнд хүнд асуудлууд их гарч ирж байгаа.

Монгол Улсын Засгийн газар цахим хөгжлийн яамтай болсноороо бас тодорхой хэмжээний дэвшлүүд гарч байна. Гарч байгаа. Дэвшил гарч байгаа талаар ч гэсэн сайд өөрөө хэлж байна.

Тэгэхдээ бид хүүхдийн хэрэглээ, цахим хэрэглээ тал дээр онцгой анхаарч ажиллахгүй ерөөсөө болохгүй байгаа. Энэ хуурамч хаягуудыг хэрхэн цэгцлэх юм. Цахим дээр явж байгаа хүүхдийн сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлчихээр тийм видео контентуудыг хэрхэн хязгаарлах юм гээд.

Бид нарт боломж байгаа юм уу? Яг тийм. Байгаа бол байгаагаа хэлээд хийчихмээр байгаа юм. Байхгүй бол байхгүй нь гэдгээ хэлээд харин тэр эцэг, эхийнх нь оролцоог хангаад энэ цахим тал дээр нь дэлгэцийн хамаарлаас нь татан авах, хүүхдийг донтуулахгүй байх тал дээр нь анхаарч ажиллах хэрэгтэй гэж харж байгаа юм. Энэ дээр сайд хариултаа өгөөч ээ.

Би Байнгын хороон дээр асуусан боловч хариулт бүрэн дүүрэн авч чадаагүй.

Хоёрдугаарт нь, хуулийн төслийг боловсруулсан хүмүүсээс асуумаар байгаа юм.

Энэ хууль батлагдсанаараа хүүхэд хамгааллын тогтолцоо бүх түвшинд бий болж, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын орчин бий болно л гээд байна л даа.

Тэгээд ганцхан жишээ ярья. Хуулийн төслийн 3.8.2-т хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал гээд хүүхэдтэй холбоотой асуудлыг хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулсан таатай орчин бүрдүүлнэ гээд заачихсан байгаа байхгүй юу.

Мэдээж энэ орчин бүрдүүлэхэд тодорхой хэмжээний хөрөнгө, санхүү хэрэгтэй л байх. Цаг хугацаа хэрэгтэй.

Өнөөдөр Монголын шүүх ямар байгааг Та бүхэн мэдэж байгаа юу? Орж үзсэн хүн байна уу?

Хууль зүйн байнгын хорооныхон ярьж байсан юм. Монголын шүүх ерөөндөө багтахаа байчихсан. Өөрсдөө ерөөндөө багтахгүй байгаа учраас ширээгээ жижгэрүүлээд суучихсан, өөд өөдөөсөө хараад суучихсан. Юун нөгөө хүүхдэд таатай орчин бүрдүүлж, сэтгэхүйн онцлогт нь тохирсон тийм орчинд хүүхэд хамгааллын асуудал ярих вэ. Тийм боломжгүй л шүүх байгаа шүү дээ. Яг үнэндээ.

Тэгээд юу гэж бодож, ойлгож, ямар хэмжээний хөрөнгө оруулалт төлөвлөж хийж хэрэгжүүлнэ, хэзээнээс яг энэ нөхцөл байдлыг бий болгоно гэж бодож төлөвлөж хийсэн юм бол оо. Энэ заалтыг оруулж ирж байгаа юм бол оо.

Бодитойгоор хэзээ хэрэгжих юм. Яг энэ. Гээд ганцхан жишээ ярихад энд үл бүтэх, боломж, нөхцөл нь хязгаарлагдчихсан заалтууд олон байгаа

байхгүй юу. Гишүүд үүнийг л хараад яриад байгаа юм.

Тэгээд энэ дээрээ нэг хариулт өгөөч ээ.

Гуравдугаарт нь, 358 хүүхэд хүчирхийлэлд өртсөн. Түүний 70 гаруй хувь нь ураг төрлийн хүрээнд гэж тодорхойлсон байгаа.

Ингээд харахаар ажлаа хийгээд байгаа юм шиг. Тэгвэл яг ийм эрсдэлд орох нөхцөл байдалд хэчнээн хүүхдүүд байгаа юм? Хэчнээн гэр бүл байгаа юм?

Энэ тал дээр судлаад цаашлаад хамтран ажилласан, тодорхой үр дүн гарсан, соён гэгээрлийн ажил хийсэн зүйлүүд байгаа юм уу? Манай яам, бусад холбогдох байгууллагуудад.

Бид мэдээд байгаа юм шиг мөртлөө мэдээд байгаа юм шиг энэ тайлангаа бичдэг, төслөө боловсруулдаг. Тэгээд асуунгуут мэдэхгүй байгаад байгаа нь их сонин болчихоод байна л даа.

Хариул ч мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэгээд үүнийг бид юу гэж ойлгох юм? Эсвэл зүгээр зохион бичлэг бичээд байгаа юм уу? Хариулт авъя. Дараа нь тодруулъя. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам, Жаргалтулгын Эрдэнэбат, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулийн 11-ийн Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Багш, сурган хүмүүжүүлэгчдэд мөн ажлын амжилт хүсье.

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар яг Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байна.

Хэн хариулах вэ? Н.Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Олон нийтийн сүлжээний маш олон аппликэйшн байгаа.

Тэгэхээр тэр олон нийтийн сүлжээний олон аппликэйшнүүд өөр өөрсдийн сүлжээний хяналтын системтэй, өөр өөрийн мониторингтой, өөр өөрсдөө нэгдсэн коммунити стандарт буюу нийтлэг шаардлага стандарттай.

Ингээд тэр нийтлэг шаардлагуудыгаа тавиад хэрэглэгч нарыг бүртгээд үйл ажиллагаагаа явуулдаг.

Одоо жишээ нь зөвхөн **Facebook** дээр гэхэд өнөөдөр хиймэл оюун ухаан ажиллаад, контентын зөрчилтэй, оюуны өмчийн зөрчилтэй, гэмт хэрэг, садар самуунд сурталчилсан контентуудыг өөрөө хиймэл оюун ухаан ажиллуулаад хяналт тавиад хязгаарлалт хийдэг болсон байна.

Тэгэхээр үүнд нөгөө өөр өөрсдөө бие даасан ийм аппликэйшнүүдээр бид шууд технологийн тусламжтайгаар түүнийг хянах бололцоо төдийлөн байхгүй.

Харин бид энэ Харилцаа холбооны Зохицуулах Хорооноос тавьсан хяналт дээрээ орж ирж байгаа тэр сүлжээн дээр нь технологийн тусламжтайгаар тодорхой хяналт тавиад тэр **Black List**-д бүртгэлтэй хаягуудыг нь хязгаарлаад ингээд хууль хяналтын байгууллагуудтайгаа хамтран ажилладаг дэлхийн бусад улс орнуудын жишгийн дагуу л явж байгаа юм. Жишээ нь, өнгөрсөн хугацаанд нэг жилд гэхэд дэлхий даяар бараг 1.5 тэрбум хуурамч хаяг хаагдсан байгаа.

Ингээд ер нь цаашдаа сая Европын Холбоо **The Digital Services Act** гээд Европын Холбооны улсуудад баримтлах бодлогын баримт бичгээ батлаад, одоо бусад нөгөө **Facebook** шиг, **Twitter** шиг тэр бусад компаниудтайгаа харилцан гэрээ хийгээд манай хууль эрх зүйн орчинд ажиллаач ээ гэдэг хүсэлтийг тавиад тохиролцоод явж байгаа ийм л жишиг мөрдөгддөг.

Манайд бие даасан тийм хууль эрх зүйн орчин байхгүй. Гэхдээ бид хуульгүйгээр энэ асуудлыг шийдье гэвэл тухайн байгууллагуудын өөрсдийн стандартынх нь дагуу холбогдох харилцаагаа сайжруулаад явах ийм л нөхцөл бололцоо байгаа гэдгийг бас хэлэх ёстой байх гэж бодож байна.

Гишүүд та бүхний асууж байгаа асуултуудад би бас нэг ерөнхий агуулга хариулт өгөхөд. Жишээ нь, Боловсролын яам, манай яам хамтраад энэ **Google**-тэй хамтын ажиллагааны хүрээнд **Google Family Link**-ийг өчигдөр гэхэд монгол хэл дээр орчуулаад Монгол Улсад нутагшуулах ажлыг эхлүүлсэн.

**Google Family Link**-ийг жишээ нь би одоо ингээд хэрэглэж байна. **Google**

**Family Link** дээр би өөрийнхөө хүүхдүүдийг оруулчихсан.

Ингээд өдөр хэд хэдэн минут интернэт хэрэглэх вэ, хэдэн минут **Facebook** хэрэглэх вэ, хэдэн минут **YouTube** үзэх вэ гэдгийг нь энд ингээд бүртгэчихсэн.

Ингээд локэйшнүүдийг, байршлыг нь тодорхойлж байна. Хүүхдийнхээ. Нэг ёсондоо Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага өдөрт 2 цагаас илүү хэмжээд интернэт хэрэглэхгүй гээд зөвлөмж өгчихсөн.

Гэтэл манай хүүхдүүд өнөөдөр 238 цаг буюу хоёр дахин. Бараг илүү их интернэт хэрэглэдэг.

Тэгэхээр энэ интернэтийн хязгаарлалтуудыг, контентыг хязгаарлахыг, байршил тодорхойлохуудыг, цахим орчин дахь заавар, зөвлөмжүүдийг **Google Family Link** шиг бараг бүхий л төрлийн аппликэйшн ийм өөр өөрсдийн аппликэйшн тусламжтай. Үүнийг хэрэглэж хэвш.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Х.Булгантуяа сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** Энэ хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотойгоор Б.Энхбаяр сайд бас хүүхэд, гэр бүлийн ийм тусгайлсан шүүхтэй больё гэж байгаа юм.

Тэгээд энэ тусгайлсан шүүхтэй больё гэж хуульчлахаас ч өмнө жишээлбэл манай Сүхбаатар дүүрэг, Чингэлтэй дүүрэг хоёр бүр тусгайлсан шүүгчтэй болсон. Энэ нь ялангуяа

хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, мөн гэр бүл салалттай холбоотой, мөн тусгайлан мэдүүлэг авах хүүхдийн өрөө зассан байдал нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа энэ гэмт хэрэг дээр хүүхдүүд очоод мэдүүлэг өгөхөд нэн тааламжтай байдлыг бүрдүүлж байгаа.

Үнэнийг хэлэхэд хүүхдүүд ийм газарт очиход мэдээж айна, том хүн ч айдас хүрдэг. Тэгэхэд тэр өрөө нь арай хүүхдэд ээлтэй байдалтай.

Дээрээс нь нэмээд уг нь эцэг, эх нь хамтдаа очдог байсан бол зарим тохиолдолд эцэг, эх нь өөрснөө хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгч болчихоод байгаа учраас улсаас хуульчид, өмгийлэгч бүр цалинжуулж ажиллуулдаг. Одоо энэ төсөвтэй холбоотой нэмэгдэл ч гэсэн үүнтэй холбоотойгоор нэмэгдэж орж ирж байгаа.

Тэгэхээр бид норм, норматив гаргаад ингээд хуульчдыг хамтдаа ажиллуулаад ийм мэдүүлгийн өрөөнд аль болохоор мэдүүлэг авахыг бас зөвлөж байгаа юм.

Гэхдээ үнэн. Манай Б.Энхбаяр сайд үүн дээр нэмж хэлэх байх.

Шүүх байгууллагуудын барилга, байгууламжийн асуудлууд үнэхээр хүнд байгаа. Үүн дээр ахиад өөрсдөө багт чадан ядан сууж багталцаж байхад хүүхдэд зориулсан мэдүүлгийн өрөө гаргана гэдэг хэцүү юм биш үү гэдэг асуудал тавигдана.

Гэхдээ бид нөгөө талдаа замаа олигтой барьж ч юун хүүхдийн осол аваар орчихгүй зам барих гэж байгаатай яг адилхан асуудал.

Тэгэхээр үүнийг хамтдаа л хийгээд явахаас өөр арга байхгүй. Хүүхдийн эсрэг жилд 2 мянга орчим гэмт хэрэг үйлдэж байна. Хүүхэд өөрөө 1500 орчим гэмт хэрэг үйлдэж байна.

Дээрээс нь нэмээд тусгайлсан шүүхтэй болчих юм бол өөрийн эрхгүй тэнд гэр бүл салалтаас авхуулаад. Миний ойлгосноор иргэний шүүхийн бараг 10 орчим нь гэр бүлтэй холбоотой асуудлууд. Тусгайлсан шүүх болох юм бол энэ нэлээдгүй ачаалалтай болохоор байна гэж үзэж байгаа.

Тэгэхээр ингэнэ гэх юм бол энэ тусгайлсан мэдүүлгийн өрөөнүүдийг бид гаргаж явахаас өөр арга байхгүй.

**С.Одонтуяа:** Б.Энхбаяр сайд нэмж хариулья.

**Б.Энхбаяр:** Эрх нь зөрчигдсөн хүүхдийн эрхийг хамгаалах, ялангуяа энэ гэр бүл салалттай холбоотой хүүхдийн эрхийг хамгаалах гээд Гэр бүлийн шүүх байгуулах тухай хуулийг ирэх долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Улсын Их Хуралд өргөн барина.

Энд бэлтгэл ажил их шаардах юм байна лээ.

Бидний хийж байгаа тооцооллоор гэр бүлийн шүүх 2027 оноос нааш бид яг нөгөө ажиллаж эхлэх бэлтгэл ажил 3 жил хийх шаардлага байна.

Яг одоо гэр бүлийн шүүх, хүүхдийн асуудлаар мэргэшсэн шүүгч алга. Сэтгэл зүйч алга байна. Энэ их нарийн ажил байна.

Ердийн хүн амины хэрэг шийдэж байсан шүүгч дээр эрх нь зөрчигдсөн хүүхдийн асуудлыг гэхэд тэрийг ойлгох сэтгэл зүй их нарийн юм байна.

Тэр байтугай хүүхдийн насны үечлэлтэй холбоотойгоор 10 настай хүүхэд, 14-тэй хүүхэд, 16-тай хүүхэд, 18-тай хүүхдүүдийн бүх сэтгэл зүйн онцлогууд өөр өөр байна. Энд нь таарсан, үүнийг нь мэддэг, ойлгодог, харьцдаг хүний нөөцийн асуудал үнэхээр дутмаг юм билээ.

Тэр байтугай бид өөрөө өөрсдөө хүүхдүүдтэйгээ хэр ярилцдаг билээ. Хүүхдүүдээ ер нь хэр сонсдог билээ. Хүүхдүүдээ хэр ойлгодог билээ гэдгээс эхлээд маш их олон асуудлууд дээр өөрчлөлт, хандлагын ялгаа гарах шаардлага байгаа.

Гэр бүлийн хууль дээр бид нэг асуудал оруулж ирэх гэж байгаа нь хүүхдийн өөрийн өмч гэдэг ойлголтыг оруулж ирэх гэж байгаа юм. Хүүхэд зөвхөн өөрөө өөртөө хэрэглэдэг бие даасан тийм өмчтэй байх хүртэл тэр асуудлыг.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууна.

**Т.Энхтүвшин:** Би гүйцээгээд асуучихъя.

**С.Одонтуяа:** 83. Н.Баярмаа нэмж хариулъя.

**Н.Баярмаа:** Д.Батлут гишүүний асуултад хариулъя.

Хүүхэд хамгааллын хуулиар манай аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд,

залуучуудын хөгжлийн газар, хэлтсүүд тухайн харьяалах орон нутгийнхаа эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүл дээр 50 үзүүлэлтээр судалгаа хийж, жил болгон үүнийг шинэчилж ажилладаг.

2019 онд 20 мянган хүүхэд эрсдэлийн программд яг энд бүртгэлтэй. 2020 онд 21 мянга, 2022 оны байдлаар 14 мянга, 2023 оны байдлаар 8 мянган хүүхэд эрсдэлийн программд бүртгэлтэй байна.

Энэ хүүхдүүдэд чиглэсэн хамгааллын үйлчилгээг бид үзүүлдэг.

Урьдчилан сэргийлэх үйлчилгээ буюу хүүхдүүддээ чиглэсэн сургалт, эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл, эцэг, эхчүүддээ хийсэн сургалт, нөлөөллийн ажил хийдэг.

2023 оны 9 сарын байдлаар 13 мянган хүүхдэд эрсдэлийг нь тодорхойлох нөхцөл байдлын үнэлгээ хийсэн.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 10 мянган хүүхдэд үзүүлсэн.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд дээрээ нэмээд нийт масс 58 мянган хүүхдүүдэд сургалт нөлөөллийн ажил хийсэн гэсэн ийм мэдээлэлтэй байгаа.

Тэгээд энэ шинэ хуулийн төслөөр бид эрсдэлийг тодорхойлохоос гадна хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн үйлчилгээний системтэй байх асуудал.

Дээрээс нь нэмээд хүүхэд бүрт нэгдсэн цахим хувийн хэрэгтэй байх асуудлыг шинээр оруулж ирж байгаа.

Тэгэхээр энэ зохицуулалт илүү тодорхой болж үйлчилгээний тоо, мэдээлэл, хамтарсан багийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн систем салбар дундын урсгал сайжирна гэж үзэж байгаа.

**С.Одонтуяа:** Д.Батлут гишүүн тодруулъя. 1 минут.

**Д.Батлут:** Тийм. Одоо ингээд бид зүгээр мэдээ цуглуулагчийн л үүрэгтэй. Энэ тэгээд тэрийгээ нэг тайлан болгож бид нарт хэлдэг л ийм үүрэгтэй байна л даа.

Би хүүхэд хамгааллын баг бүрэн дүүрэн ажилладаг гэж хэлж чадахгүй. Яг үнэндээ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 269 дүгээр нэг тушаал байгаа.

Энэ тушаал дээр дурдагдсанаар хүүхэд хамгааллын үйлчилгээг, тэр цэцэрлэг, сургууль, бусад байгууллагууд дээр авч хэрэгжүүлдэг хүүхэд хамгааллын нэгж гэж ер нь тун цөөхөн шүү.

Тэгэхээр бид ингээд энд гоё юм яриад байдаг, гоё шийдэл гаргах гээд оролдоод байдаг. Сайн шийдэл. Гэтэл яг үндсэндээ бидний тэр доор хийж гүйцэтгэж байгаа ажлууд маань ямар байгаа вэ, ямар мэдээллийг бид цуглуулаад байгаа вэ гэдэг дээр анализ хийх цаг болсон.

Ингэж байж бид зөв голдиролд орж, зөв мэдээлэлд суурилагдсан төлөвлөлтүүд цаашдаа явах болно гэдгийг хэлмээр байгаа юм.

**С.Одонтуяа:** Баярлалаа. Одоо Төмөртогоогийн Энхтүвшин гишүүн асуултаа асууна.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Би айхтар нэг их юм хэлэхгүй. Зүгээр бас жоохон бодитой юм ярьдаг юм уу.

Ер нь хүүхэд хамгаалал, төлөвшилийн асуудал, хүүхэд хамгааллын асуудал ярина гэх юм бол бүхий л хуулийг л өөрчлөх асуудал яригдана л даа.

Монгол Улс ер нь хуулиа л мөрдөөд явж байсан бол өдийд ийм асуудал гарахгүй шүү дээ.

Тийм учраас юу гэдэг юм бид нэгдүгээрт хуулиа сайн мөрдөх хэрэгтэй байна. Хүүхэд гэлтгүйгээр насанд хүрсэн хүн ч гэсэн муу хүмүүжилтэй, муу хандлагатай ийм хүмүүс маш олон болсон байна шүү дээ.

Тийм учраас цаашдаа бид хуулиа ягштал биелүүлж явдаг байх тийм ёс суртахууны хүмүүжлийг бүх шатад нь л хийж өгөх ёстой гэсэн байр суурьтай байна.

Өнөөдөр буруу талтай, зөв талдаа рултэй машин явж л байна. Өнөөдөр орон сууц барихдаа юу гэдэг юм авто зам тулгаад барьж л байна. Одоо юу гэдэг юм уул уурхайн компаниуд дээр насанд хүрээгүй хүүхдүүд ажиллаж байна гээд л яриад байх юм бол энэ дуусдаггүй сэдэв.

Хамгийн гол нь бид гаргасан хуулиа ягштал биелүүлдэг ийм орчныг, ийм төлөвшилтэй иргэдийг л бид хүмүүжүүлэх ёстой л гэдэг байр суурьтай байдаг.



Би тэгээд цаашид ер нь юу хийх ёстой юм бэ гэдэг дээр ганц хоёр асуултыг хэлье.

Ер нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам цаашдаа энэ хилийн аймгууд дээр их онцгой анхаарах хэрэгтэй. Ялангуяа дэд бүтэц хөгжсөн, уул уурхайтай, хил орчим олон улсын болон байнгын ажиллагаатай хилтэй аймгууд дээр нэлээн онцгой анхаарах ёстой юм болов уу л гэсэн байр суурьтай байна.

Яагаад гэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр хүүхэд хамгаалалттай холбоотой зардал тавихаар 21 аймагтай ч гэх юм уу, дүүргүүдтэй адилхан төсвөө хуваарилаад өгчихдөг. Энэ ялгааг олж харах асуудал дээр онцгой анхаарах хэрэгтэй.

Уул уурхайтай аймаг уул уурхайн тоосжилт, уул уурхай дээр ажиллаж байгаа насанд хүрээгүй хүүхдүүд байж байна. Сүүлийн жилүүдэд энэ боомтын сэргэлттэй холбогдуулаад маш олон боомт дээр ийм суурьшлын бүсүүд бий болж байгаа шүү. Тэнд тог цахилгаан алга байна. Тэнд усны асуудал хүндрэлтэй байна гээд.

Тэгэхээр энэ асуудал руугаа та хэд илүү түлхүү анхаарлаа хандуулж төсөв хөрөнгийг нь тавьж өгөөч гэж хэлж байгаа юм.

Дараагийн асуудал, ер нь амьдрал дээр янз янзын л юм гардаг. Аймгууд дээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар гээд байж байдаг. Босоо удирдлагатай.

Үүнийгээ нэн түрүүнд тэр аймаг, орон нутаг нь томилдог эрх зүйн орчныг нь энэ хууль дээр хийгээд өгчих хэрэгтэй.

Тэр нийгмийн даатгал ч гэдэг юм уу, хөдөлмөр, халамж үйлчилгээний газар тэр мөнгө төгрөг захиран зарцуулдаг газрыг нь яах вэ тэр босоо удирдлагатай байдаг бол энэ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг тэр аймгийн дарга нь томилдог, чөлөөлдөг, аймгийн дарга нь тэр ажил үүрэг дээрээ үүргээ биелүүлдэг ийм орчныг бид хийж өгөх хэрэгтэй.

Тэгэхгүй нэг босоо удирдлагатай гээд хаашаа явсан нь мэдэхгүй, хот руу томилолтоор ч явж байдаг, гадагшаа явж л байдаг, сургууль, сургалтад ч явж байдаг гээд.

Ингээд аймаг, орон нутаг босоо удирдлага, хэвтээ удирдлагаас чинь болоод янз янзын зөрчил гараад байдаг юм.

Тийм учраас энэ асуудлаа бас нэг мөр болгоод аймаг нь шийддэг, аймаг нь хариуцлагаа үүр үүрээд явдаг, аймаг нь Засаг дарга одоо юу гэдэг юм аливаа асуудал гарахад бүхий л ялыг үүрээд л явдаг шүү дээ.

Тийм учраас энэ томилгооны асуудал дээр бас нэлээн анхаарах хэрэгтэй.

Тийм учраас энэ асуудлыг бас нэг мөр шийдэх ёстой л гэсэн ийм бодолтой байна.

Дээр нь би Х.Булгантуяа даргатай бас санал солилцож байсан.

Ер нь улсын төсвөөс хүүхэд хамгаалалттай холбоотой зардлыг тавихаасаа гадна нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, аймаг, нийслэлийн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь АМНАТ-ийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдаж байгаа мөнгөний 1-ээс 5 хүртэлх хувийг нь энэ хүүхэд хамгаалал.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ?  
**Х.Булгантуяа** сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** Санхүүжилт маш чухал.

Одоогийн хуульд орон нутаг хүүхэд хамгаалалд төсөв зарцуулна гээд яг тэдэн хувь гэсэн хувь байхгүй.

Тэгэхээр энэ дээр нэг юм зарцуулж болох ч юм шиг, үгүй ч юм шиг. Зарим аймаг, орон нутаг нэлээдгүй дэмжлэг үзүүлж, хүүхэд хамгааллын нэмэлт яг энэ орон тоог бүр нэмж гаргаад ажиллуулж байгаа үлгэр жишээ аймгууд бас байгаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссын сүүлийн хоёр жилийнх нь тайлан дээр байлаа. Хүүхдийн эрхээр бүр бүлэг гаргасан байсан.

Зарим нь мэдэхгүй, энэ босоо тогтолцоотой. Танай байгууллага надад ер нь хамааралгүй. Тэр сайдаасаа мөнгө аваарай гээд ерөөсөө зарцуулдаггүй аймгууд ч бас байна.

Зарим нь бүр тэр битгий хэл түр хамгаалах байрыг нь орон нутгийнхаа төсвөөр барьж байгуулаад урсгал зардлынх нь тодорхой хувийг нь нэмээд санхүүжүүлээд явж байгаа аймаг, дүүргүүд ч бас байгаа.

Тэгээд бид энэ дээр орон нутгийн төсвөөс бүр тодорхой төсөв тавихаар уг нь тавьж өгөх гэж үзсэн юм. Тэгээд энэ нь орон нутгийн эрх рүү халдах гээд байна гэж үзээд. Тэгээд энэ бол яах вэ Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал. Та бүхэн маань өөрснөө хэрвээ үүнийг дагуулаад энэ төсөв дээр нь орон нутаг зайлшгүй тод тодорхой хувийг зарцуулах ёстой гэх бол ялангуяа урьдчилсан сэргийлэх үйл ажиллагаа дээр камержуулалт, гэрэлтүүлгээс авхуулаад траншейны нүх хүртэл онгорхой байгаад л байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ бүгд дээр орон нутаг өөрсдөө төсөв санхүүжилтээ, урьдчилсан үнэлгээг нь гэр бүл, хүүхэд, хөгжлөөс хамтарсан багаас гаргахад очоод үүнийг нь хүүхэд хамгаалал, урьдчилан сэргийлэх хүрээнд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд ядаж зарцуулаад өгдөг болбол хүүхдийн эрх ашиг үнэхээр их сайн хамгаалагдана.

Одоо улсын төсвөөс жишээлбэл дүүргүүдийн тохижилтын ажил дээр бид төсөв, санхүү санхүү тавихыг хориглочихсон.

Бид камержуулалт хийж чадахгүй байна, зам харгуй засаж чадахгүй байна, траншейны нүхийг бид бөглөх төсөв санхүүг тавих эрх Улсын Их Хурал дээр байхгүй.

Тэгсэн мөртлөө нөгөө талдаа Хүүхэд хамгааллын хуулийг хэрэгжүүлэх үүрэг нь байгаад байдаг. Бид нарт. Энэ зовлонг нь, шүүмжлэлийг нь бол хүртээд байдаг.

Тийм учраас орон нутаг руу тодорхой эрхийг шилжүүлэх ёстой гэдэгтэй санал нэг байна.

Тогтолцооны хувьд босоо байх уу, хэвтээ байх уу гэдгийг заавал үүнийг сайд томилох гээд байгаадаа биш ээ. Зарим аймгуудад манай салбарынхан ингэж ярьдаг юм билээ. Улс төржүүлээд байх юм. Хүүхэд огт мэдэхгүй хүнийг миний сонгуульд явж байсан гээд томилчхоод байх юм.

Тийм учраас сая Боловсролын хууль дээр боловсролын салбарыг босоо болгоё. Яагаад гэвэл энэ нарийн мэргэжлийн салбар юм гээд дээрээс нь томилдогтой адилхан магадгүй нэг хэсэг энэ салбар тогтворжтолоо. Одоо энэ чинь хуультай болоод 8 жил л болж байна шүү дээ.

Тэгэхээр хүүхэд хамгааллын тогтолцоо бий болоод дөнгөж 8 жил болж байгаа учраас нэг хэсэгтээ мэргэжлийн салбараар нь явуулах нь илүү их зөв зүйтэй юм гэж харж байгаа юм.

Тэгээд энэ дээр тавих шаардлага нь арай өндөр, сайн байх ёстой болов уу гэж бодож байна.

Үүн дээр П.Цэвээн багш. 93 номер дээр та нэмээд. Тэгэх үү. Манай мэргэжлийн төрийн бус байгууллагууд энэ дээр юу гэж үздэг юм.

**С.Одонтуяа:** 936 П.Цэвээн дарга хариулья.

**П.Цэвээн:** Т.Энхтүвшин гишүүний асуултад хариулья.

Хүүхэд хамгааллын хууль 2016 онд батлагдсан. Одоо ингээд явж байгаа хууль.

Ер нь хүүхэд хамгааллыг бид асуудалд суурилсан биш тогтолцоонд суурилсан хүүхэд хамгааллын асуудал байх юм гээд энэ процессын хууль батлаад явж байгаа.

Тэгээд энэ юу гэж хэлж байна гэхээр хүүхэд хамгааллын асуудал өөрөө маш их эмзэг, амь нас аюулгүй байдал нь цаг, минутаар хэмжигдэж байдаг учраас мэргэжлийн цогц үйлчилгээг шаардаж байдаг. Үйлчилгээ нь гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын мэргэшсэн үйлчилгээ гэж байгаа.

Мөн удирдаж байгаа хүмүүс нь ч гэсэн аль болохоор мэргэжлийн байх, улс төрөөс ангид байх гэсэн иргэний байгууллагуудын дуу хоолой энэ л чиглэлээр явж байдаг.

Хүүхэд хамгааллын асуудал өөрөө мэргэжлийн бөгөөд цогц үйлчилгээ гэж байгаагийн утга учир нь энэ бол сэтгэл зүйн үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээ, хууль зүйн өмгөөллийн үйлчилгээ ч гэдэг юм уу дандаа ийм мэргэшсэн хүмүүсийн мэргэжил дээр тулгуурласан байдаг учраас бид хүүхэд хамгааллыг аль болохоор ийм байх ёстой л гэж үзэж байдаг.

**С.Одонтуяа:** Т.Энхтүвшин гишүүн тодруулья.

**Т.Энхтүвшин:** Би зүгээр нэг санал хэлсэн юм.

Хөдөлмөрийн тухай хууль дээр тэр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой зардлыг яаж шийддэг

вэ гэхээр барьж байгаа барилга, байгууламжийн 2 хүртэлх хувийг юу гэдэг юм энэ хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын зардал дээр заавал суулгаад ингээд хангаад явдаг л юм байна л даа.

Тэгэхээр аймаг, орон нутагт энэ АМНАТ-ын төлбөр гээд. Яах вэ, энд байж байгаа хүмүүс АМНАТ гээд ярихаар сайн мэдэхгүй байж магадгүй.

АМНАТ-ын төлбөр чинь өөрөө орон нутгийн хөгжлийн сан болж очиж байгаа. Нэг аймагт 13-аас 45 тэрбум төгрөгийн тийм зардлууд очиж байгаа. Энэ зардлынхаа 1-ээс 5 ч гэдэг юм уу хувийг хүүхэд хамгааллынхаа зардалд суулгаад явдаг ийм нутгийн удирдлагын байгууллагад нь ч гэдэг ч юм уу энэ хууль дээр нь ингээд хуульчлаад өгвөл илүү их бодитой юм болов уу гэдэг асуудлыг яриад байна л даа.

Тэр дарга, цэргийн асуудал яах вэ. Тэр яах вэ, тэгээд та хэд шийднэ биз. Зүгээр аймгийн Засаг дарга сонгуульд явсан гэдгээрээ нэг их хүн томилоод байдаг асуудал байхгүй шүү дээ. Аймгийн дарга энэ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Санал уу?

Одоо Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа.

Хүүхэд хамгааллын хуулийг ярихаар л Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд хоёрын асуудал юм шиг асуудалд ханддаг болоод.

Яах вэ, хуулийн нэмэлт, өөрчлөлт, энэ кэйсийг дагаад орж ирээд батлагдах л юм шиг байна.

Хүүхдийн асуудал маш өргөн хүрээтэй шүү. Төсөв хэлэлцэхэд Засгийн газрын бүх сайд нар байх ёстой байдагтай адилхан энэ хүүхдийн асуудлыг хэлэлцэхэд бүх Засгийн газрын гишүүд байж, хүүхдийн асуудал хамаарахгүй яам, Тамгын газар гэж байхгүй байлгүй дээ.

Хүүхдийн асуудал ярихаар л Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны, хэдэн харьяа байгууллагын асуудал юм шиг ийм ойлголт, хандлагатай байвал эцсийн үр дүн, зорилго чинь биелэхгүй.

Хэдэн камержуулалтын асуудал яриад, тогтолцоог нь босоо болгоод, хороо, суманд хэдэн нийгмийн ажилтны орон тоог нэмээд. Ингээд үр дүн гарахгүй ээ. Бахь байдгаараа байна.

Эцсийн зорилго чинь тогтолцоогоор нь асуудлуудыг бүх яам, Тамгын газар нэгдэж байж, сайдууд нэгдэж байж хүүхдийн төлөө гэсэн үнэхээр нэг сэтгэл гаргаж байж, хаанаа манай яамтай ямар асуудлаараа холбогдож байгаа юм. Ингэж ярьж байж үр дүн гарна уу гэхээс биш Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам өргөн барьсан хуулиа батлуулах гээд хичээгээд ингээд нэг батлагдаад гарахаараа асуудал шийдэгдээд, хүүхдийн эрхийн зөрчил байхгүй болчхож байна гэж ойлгож байгаа бол эндүүрэл.

Тийм учраас энэ хандлагаа өөрчлөх хэрэгтэй байна.

Эцсийн зорилго нь бид хүүхдийн эрхийн зөрчлийг л арилгах. Бүх шатанд, бүх салбарт шүү дээ.

Тийм учраас энэ удаагийн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлбэр төдий гэдэг юм уу, илсэн ийм л болох нь дээ л гэж би харах гээд байна.

Гэр бүлийн хуультайгаа уялдаж орж ирээгүй. Хүүхдийн асуудал чинь гэр бүлийн орчинд л асуудал яригдана шүү дээ. Ийм байна гэдгийг нэгд хэлье.

Хоёрт, үгүй бид чинь ер нь хүүхдээ мэдэхээ больсон, танихаа больсон л юм байна лээ дээ. Ер нь бол.

Ямар монгол хүүхдийг хүмүүжүүлж, төлөвшүүлж бий болгож байна вэ. Хүнээр хүн хийнэ гэдэг.

2 настай хүүхдийн бие сэтгэхүй, онцлогт тохирсон судалгаа, 3 настай хүүхдэд, 4 настай хүүхдэд. Гадаад улс орон чинь ерөөсөө нас насаар нь тухайн хүүхдэд зориулсан бие, сэтгэл санааны онцлогт тохирсон сургалт хүмүүжлийн ажлыг л зориулж явуулдаг юм байна лээ шүү дээ.

Манайд ерөөсөө энэ чиглэлийн ажил байхгүй. Сургуулийн өмнөх боловсрол дээр, ерөнхий боловсролын сургууль дээр.

Үнэхээр хүмүүжлийн асуудал орхигдсон учраас, хүн хүнээ хайрлах, ээж аавыгаа хайрлах, найз нөхдөө хайрлах асуудал байхгүй. Өнгө мөнгөнд шунасан, өндөр төлбөртэй сургуульд л сурч байвал тэнд сайн хүүхдүүд хүмүүжиж байгаа, боловсорч байгаа гэж ойлгодог болчихсон. Брэндийн хувцсаар л гоёж

гоодсон байвал сайн мундаг хүүхэд гээд ойлгочихсон.

Эцэг, эхчүүд нь ч ингэж ханддаг болчихсон. Хүүхдүүд нь ч ийм ойлголттой болчихсон.

Нөгөө хүүхдүүд нь бүгдээрээ гоё ганган, утаагүй тамхи татдаг болчихсон. Дэлгэцийн донтолод орчихсон. Үзэж байгаа кино нь дандаа садар самуун, аль эсвэл хүчирхийлэл, алаан хядлага. Ийм орчинд яаж бие биеийгээ хүндэлсэн, хайрласан, хайранд хүүхэд өсөж хүмүүжих юм бэ.

Тийм учраас сургалт хүмүүжлийн ажил, боловсролын тогтолцоо, сургалтын үйл ажиллагаанд, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт амьдрах урлаг, хүн хүнээрээ байх, хүнийг хайрладаг байх энэ чиглэлийн хичээл, сургалтын юмнууд үнэхээр хоцрогдолтой байна л гэж би хувьдаа ойлгож байгаа.

Тэрнээс хүн болоод хүмүүжчихсэн хойно нь хүнийг засаж хүмүүжүүлнэ, сайн хүн болгоно.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Нэн хариулах вэ? Л.Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Ц.Сандаг-Очир гишүүн маш чухал асуудалд хөндөж байна.

Хүүхэд хамгааллын асуудлыг ганц хууль батлаад, тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам хоёр хариуцаад дорвитой өөрчлөлт гаргана гэдэг бас их гэнэн төсөөлөл гэж ойлгож болно.

Яах вэ, хүүхдийн байцаагчдын тоо нэмэгдэж болох байх.

Х.Булгантуяа сайд бид хоёр ч гэсэн ярьж байгаа. Хүүхэд хамгааллын энэ мөнгө яг хүүхэдтэй очдог нэг ийм тогтолцоог л хийх ёстой.

Түүнээс биш нэг байгууллага санхүүжилтийн тогтолцоо, эсвэл байцаагчийн цалин маягаар очдог биш. Нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал гэж байгаа. Энэ хувьсах зардал дээр тодорхой бүрэлдэхүүнүүд нь энэ хүүхэд хамгааллын зардлууд ордог байж энэ мөнгө нь хүүхдэдээ хүрч очдог нэг ийм тогтолцоо байж энэ тодорхой үр дүн гарна. Үүнтэй санал нэг байна.

Хоёрдугаар асуудал. Ц.Сандаг-Очир гишүүн сая хэллээ шүү дээ. Үндсэндээ манай бүх сургуулиуд. Би их айж байгаа. Үндсэндээ дарьтай торгох шиг л болчихсон шүү дээ. Яг гашуун үнэн бол.

Өнөөдөр бид энэ гашуун үнэнтэй нүүр тулах ёстой гэж ойлгож байгаа. Сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа нь үнэн.

Өнөөдөр энэ цахилгаан тамхины асуудал байна. Цахим дээрэлхэлтийн асуудлууд байна.

Ганцхан цахим дээрэлхэлт ч биш. Үе тэнгийн дээрэлхэлтийн асуудлууд байна. Насанд хүрээгүй хүүхдийн жирэмслэлтийн асуудлууд байна. Насанд хүрээгүй хүүхдүүдийн үр хөндүүлж байгаа тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Сургуулийн орчинд мансууралт явагдаж байна. Энэ бол үнэхээр нийгмийн нэг ийм том дарьтай торх шиг болчихсон асуудал үнэхээр мөнөөсөө мөн байгаа байхгүй юу.

Тийм учраас Ц.Сандаг-Очир гишүүнтэй санал нэг байна.

Боловсролын хөтөлбөрийн асуудал байх ёстой. Ганцхан иргэний ёс зүй гэдэг хичээл ороод хүүхдийг хүмүүжилтэй хүүхэд болгоно гэж бид гэнэн төсөөлж болохгүй.

Тэгэхээр саяын боловсролын хуулиар бид хүүхдийг ганцхан мэдлэг олгодог биш мэдлэг, чадвар, төлөвшил.

Ер нь хүмүүжилгүй боловсрол хамгийн аюултай боловсрол байдаг гэж хэлдэг.

Тийм учраас бид сүүлийн 30 жилд үнэхээр шилжилтийн, зах зээлийн зэрлэг капитализм гэж нэрлэе л дээ. Энд хүнээ бодоогүй, ирээдүйгээ бодоогүй.

Одоо бид энэ альфа үеийнхэн гэж ер нь ямар үе өсөж торниод байна гэдгийг бид ойлгох ёстой байхгүй юу. Үнэхээр ойлгохоо больчихсон. Бид нар. Яг юу хүсээд байгаа юм, яаж сураад байгаа юм гэдэг энэ зүйлийг бид тодорхой системийн том шинэчлэлүүд хийж, нийгмийн сэтгэлгээнийхээ өөрчлөлтүүдийг хийж байж л энэ дээр тодорхой дэвшлүүд гаргахаас өөр бид нарт гарц байхгүй. Өөр аврал ерөөсөө байхгүй.

**С.Одонтуяа:** Ц.Сандаг-Очир гишүүн тодруулъя.

**Ц.Сандаг-Очир:** Тэгээд л нэг хүүхдийн эрх, оролцоо, хамгаалал, хөгжил яриад л. Асуудлыг ярьж ярьж байгаад л яг төсөв батлах болохоор л хүүхдээсээ төсвөө харамлачихдаг.

Х.Булгантуяа сайд аа, танай яамныхан бүрэн бүрэлдэхүүнээрээ Багахангай дээр очиж үзэж танилц.

Тэнд Багахангай дүүргийн хүүхдийн хөгжлийн асуудал гээд өнөөдөр 1972 онд баригдсан, актлагдаад хэдэн жил болж байгаа ийм байранд л Хүүхэд хөгжлийн төвийн асуудал яригдаад л явж байна шүү дээ.

Тийм байранд яаж хүүхдийг хамгаалах юм, яаж хөгжүүлэх юм, яаж харж хандах юм, яаж бодлого боловсруулах юм.

Тэгээд л төсөв дээр нь газар нь байна, зураг төсөв нь байна. Ирэх жилийн төсөв дээр суулгаад өгөөрэй л гэсэн. Тэгээд л байхгүй. Одоо ингээд л өргөн баригдсан төсөвт хасагдаад л явчхаж байгаа юм.

С.Зулпхар сайд бүрэн бүрэлдэхүүнээрээ очиж үзсэн. Судалъя, барья, хөөцөлдье л гэсэн.

Гэх мэтчилэн ингээд л хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын асуудал ярихаар л. Энэ бол жижиг жишээ. Бүх орон нутагт ийм асуудал байгаа.

**С.Одонтуяа:** Санал хэллээ. Зочид танилцуулья.

Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Хууль тогтоомж сурталчлах төв хариуцсан албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Өнөөдөр Хүүхэд хамгааллын тухай хууль хэлэлцэж байна. Та хэд

батлагдахаар нь бас энэ хуулийг сайн сурталчилж өгөөрэй.

Та бүхэнд ажлын амжилт хүсье.  
/алга ташив/

Ц.Сандаг-Очир гишүүн асуултдаа хариулт авъя гэж байна. Хэн хариулах вэ? 81.

**С.Зулпхар:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулья.

Бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бүрэн бүрэлдэхүүнээр Багахангай, Багануур, Налайх дүүрэгт ажилласан.

Энэ үеэр манай салбарын байгууллагуудаас байгууллагын үйл ажиллагаа явуулах байртай холбоотой саналууд гарсан.

Тэр нь яг саяын Багануур дүүрэгтэй холбоотой санал байгаа юм. Бид энэ саналыг улсын төсөвт оруулахаар саналаа тусгасан. Гагцхүү улсын төсөвт оруулсан тодорхой саналуудыг эрмэлзсэн байдлаар хассан байсан. Эндээс хасагдсан байсан гэдэг мэдээлэл байгаа.

Энэ асуудлыг та хууль санаачлагчдын хувьд Улсын Их Хурлаас төсөв хэлэлцэж байгаа үед бас дахин энэ асуудлыг хөндөж болох байх гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Батсүхийн Саранчимэг гишүүн асуултаа асууя.

**Б.Саранчимэг:** Баярлалаа.

Тэгэхээр өнөөдөр бид Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг цаг үеийн

асуудлаар яаралтай горимоор хэлэлцэж байна.

Ер нь цаашдаа бид ганц хүүхдийн асуудал гэлтгүй нийгэмд тулгамдаж байгаа чухал асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэж байх ёстой юм.

Өнөөдрийн нийгэм, эдийн засгийн маш олон шалтгаануудаас болж хүүхэд эрсдэлт байдалд орж эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах асуудлууд буурахгүй байгаа.

Тэгэхээр өнөөдөр бид ийм яаралтай горимоор ярьдаг шиг ер нь аливаа асуудлыг нэг асуудал гарахаар ярьдаг биш шийдвэрлэдэг, хойш нь тавилгүй, мартаад орхидоггүй л баймаар байгаа юм.

Тэгэхээр энэ төсөл хэлэлцэж байгаатай холбогдуулаад тодруулах зүйл байгаа юм.

Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгө жилээс жилд нэмэгдэж байгаа.

2016 онд Улсын Их Хуралд сонгогдсон эмэгтэй гишүүд эхлээд санаачлаад анх улсын төсөвт 5 тэрбумыг тавьж байсан. Тэгээд хүүхэд хамгааллын төвгүй байсныг төвтэй болгоод бид яг бодит ажлуудыг хийж ажил болгосон. Тэгээд жилээс жилд энэ төсвийг бас нэмж байгаа.

Тэгээд өнөөдөр яг газар дээрээ тийм шүүмжлэлүүд гараад байгаа. Энэ төсөв нь өөрөө зөвхөн тавилга, яг зориулалтын бусаар ашиглагдсан байна гээд байгаа юм.

Тэгэхээр энэ дээр хүүхдийн хамгааллын чиглэсэн бодит үйл ажиллагаа дээр яг энэ мөнгө нь яг зориулалтаар зарцуулагдаж байна уу гэдэг дээр та бүгд дүн шинжилгээ хийсэн үү?

Дараагийн асуудал бол энэ шат шатын байгууллагуудын зохион байгуулалт, чиг үүрэг нарийн тодорхой бус байна гэсэн ийм дүгнэлт гарсан байна.

Тэгэхээр энэ хуулийн төслөөр энэ тодорхой бус байдлыг зохицуулж чадсан уу гэсэн нэг ийм асуулт байна.

Нөгөө талаар бас энэ цаг үед хүүхдүүд өөрчлөгдөж байна. Шинжлэх ухаан технологи ч гэсэн өөрчлөгдөж байгаа.

Тэгээд Засгийн газар шинээр Цахим хөгжил, харилцаа холбооны яам байгуулагдсан нь өнөөдөр маш их үр дүнгээ өгч байгаа шүү дээ. Ялангуяа би тэр **e-mongolia** дээрх **e-kids**-ийг онцолж хэлмээр байгаа юм.

Тэгэхээр e-kids-тэй болсноор өнөөдөр e-mongolia-гаас маш олон мэдээлэл авахаас гадна эцэг, эхчүүд өөрсдийнхөө хүүхдийг юу хийж байна, хаана байна ч гэдгийг тодорхойлж чадах боломжтой энэ цаг үед зарим эхчүүд бас яг энэ **e-kids** рүү орж чадахгүй байна гэсэн мэдээлэл байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр Н.Учрал сайд нэг тодруулга өгөөч.

Ер нь хүүхэд хамгааллын асуудал зөвхөн Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын асуудал биш гэдгийг ч гэсэн олон гишүүд онцолж байна.



Цаашдаа бид боловсрол, эрүүл мэнд, соёл, спорт, зам тээвэр, энэ хууль хяналтын байгууллага, мөн орон нутгийн удирдлага, хот тохижилт гээд олон салбарын цогц арга хэмжээний үр дүнд бид хүүхдээ хамгаалж чадна.

Тэгэхээр энэ хууль, эрх зүйгээр салбар хоорондын уялдаа, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхой болгох зохицуулалтыг хэрхэн тусгасан бэ? Энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

**Нөгөө талаар “гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн үндсийг бий болгохыг зорьж байна” гэсэн байна.**

Тэгэхээр хүүхэд хамгаалах үндсэн эрх зүйн тогтолцоогүй явж ирсэн гэсэн үг үү? Тэгээд түрүүний хэлсэнчлэн хүүхэд хамгаалалттай холбоотой асуудлыг хугацаа алдалгүй шуурхай зохицуулдаг, шийдвэрлэдэг байх асуудал энэ төсөлд хэрхэн туссан бэ гэсэн ийм асуултуудад хариулт авъя. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? Х.Булгантуяа сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** Б.Саранчимэг гишүүний асуултад хариулъя.

2016 онд түрүүн хэлсэнчлэн энэ хуулийг анх баталж байхад олон улсын зөвлөхүүд хуулийн хэрэгжилтийг хангахад төсвийн үнэлгээ хийдэг. Тэгэхэд 11 тэрбум төгрөг гаруй төсөв хэрэгтэй гэж байсан.

Тэгээд анх 2016 онд 300 гаруй сая төгрөгийн төсөвтэй байсан бол өнөөдөр ямар ч байсан 21 аймаг, 9 дүүрэгт

нийтдээ 33 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ гээд.

Дээрээс нь хамтран ажилладаг төрийн бус мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтарч ажиллаад өнөөдөр цар хүрээгээ нэлээн нэмсэн.

Тэгэхдээ энэ байгууллага үүсгэн байгуулагдсан цагаасаа дандаа хязгаарлалттай дүгнэлттэй байсан. Би Үндэсний аудитын газрын дүгнэлтийг үндэслэж ярихаас зүгээр хувь хүний зүгээс би энэ дээр үнэлэлт, дүгнэлт өгч мэдэхгүй байна. Өмнөх төсвүүд дээр.

Албан шаардлагууд жил болгон доор хаяж 1, 2020 онд гэхэд 3 албан шаардлага. Сүүлийн 5 жилд аваад үзэхэд 1 акт тавьсан байна.

Тэгээд жил болгон 5 юм уу, 6 зөвлөмжүүдийг Үндэсний аудитын газраас өгдөг байсан байна.

Ялангуяа урсгал зардалтай холбоотойгоор анхан шатын баримтуудыг зөв буруу бүрдүүлсэн, зарцуулсан гэсэнтэй холбоотойгоор ийм зөвлөмжүүдийг, зөрчлүүдийг тавьсан байна гэж Үндэсний аудитын газрын тайлан мэдээллээс гарсан байна.

Миний ойлгосноор акт ганцхан байна гэхээр бүр хууль зөрчсөн зарцуулалт гэдэг утгаараа биш юм болов уу гэж гэж би ойлгож байна.

Шаардлагатай бол Н.Өлзийхутаг дарга нэмээд энэ дээр хариулаарай.

Тавилга, эд хогшил нь тухайн үед энэ нэг цэгийн үйлчилгээний түр хамгаалах байруудыг нэлээдгүй барьж байсантай холбоотойгоор түр хамгаалах

байр, нэг цэгийн үйлчилгээний тохижилтын зардал гэж би ойлгосон. Энэ Аудитын газрын дүгнэлтүүдийг би бүгдийг нь манай цахим вебсайт дээр тавигдчихсан байгаа.

**Н.Өлзийхутаг** дарга нэмж хариулах уу?

**С.Одонтуяа:** 85 дугаар микрофон.  
Н.Өлзийхутаг дарга хариулъя.

**Н.Өлзийхутаг:** Гишүүний асуултад хариулъя.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хүүхдийн хөгжил хамгааллын улсын төсвийг 2017 оноос.

Ер нь үүнээс өмнө Хүүхдийн төлөө үндэсний газар байхдаа манайх ямар нэгэн хүүхдийн хөгжил хамгааллын зардал гэж байгаагүй.

Ингээд 2017 оноос 900 сая төгрөг, 2018 оноос гээд 2020 оноос 2023 он хүртэл 20 тэрбум төгрөгөөр манай төсөв батлагдаж явж байгаа.

Энэ 8 тэрбум төгрөгийн төсвийг бид үндсэндээ 38 байгууллагад хуваарилдаг. Жишээ нь, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, мөн харьяа байгууллагууд, яамны бодлогын үйл ажиллагаа, агентлагийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах зардал гээд 38 байгууллага 8 тэрбум төгрөгийг хуваарилдаг.

2022 онд бид орон нутагтаа 5.2 тэрбум төгрөг хуваарилсан байна.

2023 онд 5.9 тэрбум буюу бараг 6 тэрбум төгрөгийг нийт

санхүүжилтийнхээ 75.4 хувийг бид орон нутагтаа хуваарилсан.

Тэгэхээр Та бүхэн мэдэж байгаа. 21 аймаг. Энэ хүн амынхаа нягтаршилт, хүн амын тоо, хүүхдийн тоо, мөн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн энэ кэйсийн шийдвэрлэлт, үйлчилгээний зардал гээд үйлчилгээ маань 3 түвшиндээ өнөөдөр үйлчилгээ үзүүлж байгаа.

Энэ бүх зардалд энэ 8 тэрбум төгрөгийг хуваарилж байгаа юм.

Тэгэхээр зөвхөн агентлагийн үйл ажиллагааны зардалд гэхэд энэ жил бид 2023 онд 20.3 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг л энэ агентлагийн үйл ажиллагаанд гэж хуваарилагдсан байгаа.

Тэгэхээр тэр өмнөх аудитын дүгнэлтүүдийг харахад энэ дүгнэлтүүд дээр яг тийм ерөнхийдөө нөгөө бүтэц, орон тоо хэтрүүлсэн гээд. Манайд үйлчилгээний ажилтан, албан хаагчдын орон тоо байдаггүй. 6 хүн гэрээтээр ажилладаг.

Энэ хүмүүсийн.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Н.Өлзийхутаг дарга дуусгаад хариулчих. 85.

**Н.Өлзийхутаг:** Манайх 40 орон тоотой. Гэтэл Хүүхдийн төлөө үндэсний газар байхдаа яг энэ орон тоогоор ажиллаж байсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, агентлаг байгуулагдсанаас хойш орон тоо нэмэгдээгүй.

40 орон тооны, 23 нь төрийн захиргааны албан хаагч. Гэтэл манайд

өнөөдөр тэр 4 давхар байшинд үйлчлэгч, нярав, нягтлан гэх мэт энэ орон тоо огт байдаггүй.

Энэ хүмүүсийг гэрээтээр ажиллуулахаар энэ дээр цалин урамшууллын асуудал бид нар дээр аудитын дүгнэлт бас хязгаарлалттай, зөрчилтэй гэдэг ийм дүгнэлтүүд тавигддаг. Ийм ийм учир шалтгаанууд байгаа.

Бид өнөөдөр 21 аймаг, 9 дүүрэг, салбар байгууллагууд маань үндсэндээ 2016 оноос хойш байгуулагдсан.

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв 34 байгууллага. Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих зардал гэх мэтчилнээр манай хүүхдийн хөгжил хамгааллын зардал маань олон чиглэлээр зарцуулагдаж байгаа.

Би ганцхан жишээ хэлье. Сүхбаатар дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс өнөөдөр 141 мянган хүн амтай. Гэтэл энэ дүүрэгт 141 сая төгрөг хуваарилагддаг.

Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг 400 гаруй мянган хүн амтай. Энд 168 сая төгрөг л өнөөдөр бид энэ хүүхэд хамгааллын зардлаас хуваарилагдаж байгаа.

2023 оны 9 сарын байдлаар нэг улирал он дуусахад дутуу байхад манай хүүхэд хамгааллын зардал өнөөдөр 89.9 хувьтай гүйцэтгэл нь ингэж гарч ирж байгаа юм.

Тэгэхээр хүүхэд хамгааллын зардал маань яг үнэндээ бид энэ аргачлал, нормативын дагуу зардлыг зарцуулахад

үнэндээ хүүхэд хамгааллын зардал маань бас учир дутагдалтай байна гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж ингэж бодож байна.

**С.Одонтуяа:** Зочид танилцуулья.

Нийслэлийн ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн 11-ийн А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлагын амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Өнөөдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж байна.

Н.Учрал сайд нэмж хариулья.

**Н.Учрал:** Б.Саранчимэг гишүүний асуултад хариулья.

Эцэг, эхчүүд нэг дэх өдрөөс хойш яг **e-mongolia** дээр хүүхдээ бүртгүүлээд, регистрийн дугаараа хийгээд, **QR** уншуулж холбогдоод ингээд алдаа гараад байна, ямар асуудал байна гээд хэд хэдэн асуулт ирээд байгаа.

Үүн дээр би бас анхааруулж хэлье.

Google Family Link, Ekids гэдэг хоёрыг бас холих тохиолдлууд байна.

**Google Family Link** бол **Google** компаниас гаргасан интернэтийн зохистой хэрэглээг бий болгох чиглэлээр **IWF**-ээс гаргасан өөрсдийн тийм аппликэйшн байдаг. Тийм ээ. Манай энэ хүүхдүүд мэдэж байгаа.

**Google** дээр ээж, аав нар та нарын интернэтийн цагийг хязгаарлаж болдог. Тэгээд та нарын байршлыг хаана байгааг тогтоож болдог.

**YouTube** хэдэн минут үзэх вэ, **Facebook** хэдэн минут үзэх вэ. Энэ бол тусдаа.

Бидэнд байгаа нь 1.6 сая хэрэглэгчтэй **e-mongolia** буюу та бүхний ээж аав хэрэглэж байгаа, тэнд анх удаа хүүхдүүд ордог болсон.

Би бол одоо яг та нар шиг 10 дугаар ангийн охинтой. Тэгээд би охиныхоо утсан дээр нээгээд ингээд **QR** уншуулаад ингээд охинтойгоо холбогдоход над руу сая **“би гэртээ ирлээ”** гээд ийм гурван үгтэй мессеж байнга ирээд, очоод ингээд хараад байж байгаа.

Тэгэхээр ээж, аавууд хэрвээ **e-mongolia**-ийн **e-kids** рүү орж болохгүй бол эцэг, эх өөрчлөгдсөн, эцэг, эх болон хүүхэд нэрээ сольсон тохиолдолд регистрийн дугаар хүүхэдтэйгээ зөрөх тохиолдол гарч байгаа болохоос бусад тохиолдолд гарахгүй.

Яагаад гэвэл анх удаа төрийн үйлчилгээний систем 18-аас доошлуулсны хүүхдийг таньдаг болсон.

Тэгэхээр Та бүхэн бүгдээрээ **e-mongolia** дээр ороод **“хүүхдээр нэвтрүүлэх”** гэж ороод нээгээд ээж, аавдаа яаралтай тусламж дуудах, байршлаа явуулах ийм бололцоо бүрдэж байгаа.

Тэгээд цагдаагийн байгууллага руу ч гэсэн Та бүхэн маань хүсэлтээ илгээгээд ямар нэгэн гэмт хэрэг, зөрчилд

холбогдох юм бол шууд яаралтай тусламж дууд.

**С.Одонтуяа:** Баярлалаа та наадхаа сошиалаар ер нь нэлээн сурталчлах хэрэгтэй байх.

Тодруулга болчихсон уу? Б.Саранчимэг гишүүн ээ. Пүрэв-Очирын Анужин гишүүн асуултаа асууна.

**П.Анужин:** Баярлалаа. Хүүхэд хамгааллын хуулийг Улсын Их Хурал хэлэлцэх нь зүйтэй. Цаг алдалгүй хэлэлцэх нь зүйтэй.

Гэхдээ ул суурьтай авч үзэх шаардлагатай гэж харж байна.

Ер нь энд өнөөдөр гишүүдийн асуултад хариулаад байгаа хууль боловсруулсан энэ эрх бүхий хүмүүс, мэргэжилтнүүд та бүхэн маань хүүхэд хамгааллын асуудал гэж яг юуг хэлэх вэ гэдгээ ер нь хэр ойлгож байна вэ?

Зөвхөн Та бүхэнд төдийгүй бид өөрсдөө ер нь энэ хүүхэд хамгаалал гэж юуг хэлэх вэ гэдгээ ойлгож байгаа юм уу? Бүрэн дүүрэн.

Би бол үүнийг ойлгохгүй байна. Ул сууриар нь гэж харж байна.

Яагаад гэвэл хэрвээ бид хүүхэд хамгааллын асуудлыг бүрэн цогцоор нь харж чадсан бол, харж байгаа бол энд зөвхөн Боловсролын сайд, аль эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хоёрхон сайд сууж байхгүй байх байсан.

Хүүхэд хамгааллын асуудал гэдэг өнөөдөр нийгмийн асуудал. Бүх нийтээрээ түвшин бүрд харж хэлэлцэх ёстой хамгаалах ёстой ийм асуудал юм.

Тэгэхээр бид өөрсдөө хүүхэд хамгааллынхаа асуудлыг дутуу харж байна. Нэгдүгээрт.

**Хоёрдугаарт**, та бүхний өргөн барьсан хууль бас маш их учир дутагдалтай байна.

Ер нь сүүлийн үед хэлэлцэгдэж байгаа хуулиудыг харахаар орчуулгын шинж чанартай хуулиуд маш их.

Монголын нийгэмд гарч байгаа нийгмийн харилцаа, тэр дундаа гэр бүлийн нандин энэ үр хүүхдийн талаарх асуудлыг зохицуулах нь байтугай монгол хэл дээрээ бүрэн сууж амжаагүй, орчуулагдаж чадаагүй ийм хуулиуд орж ирж байна.

Үүний нэг жишээ Хүүхэд хамгааллын хууль. “Кэйс менежмент” гээд л та бүхэн оруулаад ирсэн. Юу хэлж байгаа юм бэ гэхээр өөрсдөө ч хариулж чадахгүй.

Тэгэхээр энэ чинь уг нь Хүүхэд хамгааллын хууль буюу хүүхдийг ямар нэгэн эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх хууль байтал “кэйс менежмент” гээд л оруулаад ирж байгаа юм.

Тэгэхээр энэ яах вэ хөөх хууль юм уу, яах юм? Дандаа л араас нь хөөж бодлого боловсруулах хууль юм уу. Эсвэл зүгээр камер нэмсэн хууль юм уу.

Та нар өөрсдөө боловсруулсан хуульдаа ямар ч ойлголт алга. Өөриймшүүлээгүй байна гэдгийг хэлэх гэсэн юм.

Дээрээс нь хүүхэд хамгааллын бодлогыг жоохон зүрх сэтгэлээ өгсөн хүн энд байна уу. Дандаа л тооцоолол, хамтарсан баг, төсөв яриад байна. Үгүй шүү дээ.

Хүнээр хүн хийх, хайран дотроо хал нь гаднаа гэдэг. Энэ алдагдсан бодлогын золиос өнөөдрийн энэ нийгэмд болж байгаа үйл явдлууд. Үүнийг ч та бүхний асуулт бүхний дараа хариулж байгаа энэ тоо баримт илтгэж байна.

Хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 70 илүү хувийг дандаа ахуйн орчинд, гэр бүлийн орчинд үйлдэгдэж байна гэж байгаа.

Энэ юу вэ гэхээр Монголд соён гэгээрэл нийгмийн бодлогын тэргүүлэх чиглэл болох ёстой гэдгийг л анхааруулж хэлээд байгаа юм.

Шат шатандаа бид хүн чанар, хүний мөс, хүнлэг нинжин сэтгэл гэдэг энэ анхаарах ёстой зүйлээ юу ч биш гэж тэр хөсөр хаясны л гол илрэл өнөөдөр энэ.

Тэгэхээр Нийгмийн бодлогын байнгын хорооны хурал болж байхад Та бүхнээс асуусан шүү дээ.

Энэ хууль одоо энэ гарч байгаа асуудлуудыг шийдэх юм уу, хүүхдээ хамгаалж дийлэх юм уу гэхээр хариулдаг хүн нэг ширхэг байхгүй.

Энэ хууль олон хуулиудтай уялдаа холбоотой хэлэлцэгдэх ёстой юм. Гэр бүлийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль, Хүмүүнлэг боловсролын хууль, Боловсролын хуулиудтайгаа хэр уялдсан бэ гэдэгт мөн Та бүхэн хариулт өгч чадахгүй байгаа.

Энэ хуулиар ганцхан зохицуулагдаж хамгаалагдах асуудал биш учраас та нар ч бас хариулж чадахгүй байгаа.

Тэгэхээр боловсруулсан хүмүүс нь хариулж чадахгүй байхад сонсож байгаа хүмүүс энд яг юу бид ярих вэ, хэр үр дүнтэй ийм хуулийн хэлэлцүүлэг болох вэ гэдгийг би бас та бүхэн хэрвээ дэмжигдэж хэлэлцэгдэх эсэхийг нь шийдвэл цаашаа анхаараасай гэж бодож байна.

**С.Одонтуяа:** Л.Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** П.Анужин гишүүн ээ, Засгийн газар дээр ярьсан.

Энэ өргөн барьж байгаа, хэлэлцэгдэж байгаа хуулиуд хоорондоо огт холбоогүй гэж арай ойлгож болохгүй байх.

Одоо Гэр бүлийн хуулийг Б.Энхбаяр сайд удахгүй өргөн барих юм билээ.

Сая бид дөнгөж батлаад будаг нь хатаагүй байгаа Боловсролын хууль байгаа. Боловсролын хууль дээр яг таны хэлж байгаа **“Сэтгэл зүрхний боловсрол”** гэдэг хамгийн чухал асуудал гэдэг дээр бид бүгдээрээ ойлгож, мэдэрч, ер нь **“боловсрол”** гэдэг өөрөө **“хүмүүнлэг байх ёстой”**. Бид хүн төлөвшүүлэх, хүн бэлдэх. Монголчууд **“хүнээр хүн хийх ухаан”** гэж ярьдаг шиг манай боловсролын тогтолцоо өөрөө хүнээр хүн хийх ийм тогтолцоо байх ёстой гэж харж байгаа.

Одоо манай боловсролын тогтолцооны ерөөсөө сул тал тийм байгаа шүү дээ. Юу гэхээр ерөөсөө илүү их тийм анги, танхимаар мэдлэг өгөөд байна. Тийм ээ.

Гэтэл тэр анги, танхимаар авч байгаа мэдлэгээ хүүхэд яг ур чадвар болгож чадаж байна уу. Ур чадвараа амьдралд хэрэглэж чадаж байна уу. Яг энэ мэдлэгээрээ дамжиж хүүхэд ер нь төлөвшиж чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юм уу гэдэг асуудал манай боловсролын сүүлийн 30 жилийн л тогтолцооны гажиг л даа.

Хуучин П.Анужин сайд чинь харьцангуй залуу учраас мэдэхгүй байх.

Зүгээр бид нарыг дунд сургуульд сурч байхад **“хүмүүжлийн эрхлэгч”** гэж байдаг байсан шүү дээ. Хүүхдийн хүмүүжил бараг боловсролоосоо илүү их тийм ач холбогдол тавьж ойлгогддог байсан ийм зүйл.

Тийм учраас тантай нэг зүйл угаасаа бид энэ тогтолцооныхоо зураглалыг л их зөв гаргах ёстой. Одоо энэ хууль батлагдаж гарснаар зөвхөн нэг хууль батлаад орхичих биш яг үнэхээр Монгол Улсад хүүхэд хамгааллын чиглэл дээр үнэхээр дорвитой шинэчлэл, дорвитой тогтолцоо, дорвитой систем болж чадах юм уу л гэдэг асуултад бид хариулт өгөх ёстой л гэж ойлгоод байгаа юм.

Яах вэ тэр утгаараа сүүлийн жилүүдэд хийгдэж байгаа дорвитой ажил гэх юм бл бид сургуулиуд дээр **“сэтгэл зүйч”** нар ажиллуулж байна. Одоо төрийн өмчийн ямар ч байсан 680 сургуулийн 3 сургуулийн 2 нь энэ жил гэхэд сэтгэл зүйчтэй болсон. Үүнийг сая

бид Боловсролын хуулиар бас баталгаажуулж өгсөн.

Цаашлаад сургуулиуд дээр бид илүү

- нийгмийн ажилтан,
- сургалтын менежер,
- сургуулийн эмч,
- сэтгэл зүйч,
- хоол зүйч

гэсэн ийм ажилтнууд бий болж байгаа учраас хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал дээр баг болж ажиллах шаардлагатай байгаа.

Тийм учраас таны хэлээд байгаа энэ асуудал дээр яг энэ хууль чинь өөрөө ийм тогтолцооны шинэчлэл хийж чадах уу, чадахгүй юу гэдэг асуудал дээр мэдээж олон хуулийн уялдааны асуудлууд, салбар дундын зохицуулалтын асуудлууд, нийгмийн сэтгэл зүй, нийгмийн сэтгэлгээ, хандлагын өөрчлөлтүүд орж байж л энэ дээр бид өөрчлөлтүүд, шинэчлэлтүүд гарах байх гэсэн ийм хүлээлттэй байгаа шүү дээ. Тийм.

**С.Одонтуяа:** П.Анужин гишүүн тодруулъя. 1 минут.

**П.Анужин:** Л.Энх-Амгалан сайдын хариулж байгааг ойлгож байна.

Засгийн газар дээрээ эдгээр хуулиудын уялдаа холбоог хангаж ярилцаж байгаа гэдгийг ч би үгүйсгэхгүй.

Гэтэл энд хариулж байгаа мэргэжлийн яамд, энэ мэргэжилтнүүд оруулж ирж байгаа хуулийнхаа концептыг ойлгохгүй. Яг ямар шинэчлэл хийгээд хүүхдээ яаж хамгаалах юм гэдэг

ганцхан асуултад хэзээ ч хариулж чадахгүй байгаа энэ хүмүүсийг хаацайлах шаардлагагүй гэж ойлгож байна.

Эдгээр хүмүүсийн хариулах хариултын жин, даац, цар хүрээнээс энэ хуулийн агуулга гишүүдэд ойлгогдох ёстой. Ийм хариулт ирэхгүй байгаа учраас энэ асуултууд дахин дахин давтагдаж байгаа гэдгийг би хэлж байгаа юм.

Түүнээс биш Засгийн газар дээр боловсруулагдаж байгаа бодлогын уялдаа холбоог би энд дурдаагүй гэдгээ би бас ахин хэлэхийг хүсэж байна.

Хоёрдугаарт, оруулж ирж байгаа хуулийнхаа мөн чанарыг яриач ээ. Яг тодорхой юуг өөрчлөх гээд байгаа юм, юуг зориод байгаа юм, юу нь өөр болчихсон юм, юу нь ашигтай юм, юу нь ашиггүй болсон юм гэдгээ л зүгээр хэл л дээ.

Тэгээд эд нараас дахин дахин асуулт асуугаад юунд ч хүрэхгүй гэдгийг ойлгосон учраас асуулт асуухгүй.

**С.Одонтуяа:** Хэн нэмж хариулах вэ? 84.

Хүлээж байгаарай. Уучлаарай, зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жаргалтулгын Эрдэнэбат, Чинбатын Ундрэм, Дамдинсүрэнгийн Өнөрболор нарын урилгаар Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын сургуулийн 12-ын Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Өнөөдөр Хүүхэд хамгааллын тухай хуулийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж байна.

Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсье. /алга ташив/

Одоо 84 байсан уу? Тийм ээ. 84 дүгээр микрофон.

**П.Баттулга:** П.Баттулга. П.Анужин гишүүний асуултад хариулъя.

2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн энэ тайлан 2021 оны 8 сард гарсан байдаг.

Үүгээр маш тодорхой нэг санал, коммент дүгнэлт хийсэн зүйл нь Монгол Улс энэ хүүхдийг аюултай нөхцөлөөс холдуулаад түр хамгаалах байр, асрамж, халамжийн төвд байлгаж байгаа энэ тогтолцоо сайн ажиллаж байна.

Харин хүүхдийг гэр бүлийн орчинд асрах, хамгаалах энэ үйлчилгээ дутагдалтай байна. Үүнийгээ хөгжүүл гэдэг ийм тодорхой зүйлийг хэлсэн.

Гэр бүлийн орчин гэдэг бол зөвхөн биологийн гэр бүлээр ойлгохгүй. Түүрүүн С.Энхтуяа зөвлөхийн хэлсэн “**Асралт гэр бүл**”, төрөл садны гэр бүлд яаж хүүхдийг байлгах вэ.

Цаашлаад хүүхдийг үрчлүүлэх асуудал ч гэсэн.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Микрофон нь унтарчихлаа. 84.

**П.Баттулга:** Одоо үнэхээр хүүхдээ хүчирхийлээд байгаа, эрхийг нь зөрчөөд байгаа эцэг, эхчүүдийн эрхийг

хасах, хязгаарлах замаар, дараа нь хүүхдийг өвчлүүлэх асуудал бас л хүүхдийн эрх ашгийг гэр бүлийн орчинд хамгаалах ийм чухал арга хэрэгсэл. Энэ бол өөрөө Гэр бүлийн тухай хуулиар зохицуулагддаг.

П.Анужин гишүүнтэй нэг зүйл дээр 100 хувь санал нэгдэж байна.

Тэр нь **хүүхэд хамгаалал** гэдгээ тодорхойлоод үүнээс цаашаа энэ хуулийн зохицуулалт маань улам нарийсаад явах ёстой гэдгээр 100 хувь санал нэг байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд энэ хуулийн төслийн **зохицуулах харилцааны хальсан шинжтэй асуудлыг тус хуулийн төсөлд тусгахгүй** гэдэг шаардлага тавьж байгаа.

Нөгөөтээгүүр хуулийн **хуулиар зохицуулах асуудлыг бүрэн тусгах** гэсэн ийм шаардлага тавьж байгаа юм.

Тэгэхээр мэдээж урьдчилан сэргийлэх ажил бүх түвшиндээ явагдана гэж бид ойлгож байгаа.

Хүүхэд эрсдэлт нөхцөлд орсны дараа ямар арга хэмжээ авах вэ гэдэг энэ процессын зохицуулалт одоогийн хууль дээр тодорхой байхгүй учраас үүнийг тодорхой болгоё.

Ямар үндэслэлээр хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах вэ. Тусгаарлахаад түр хамгаалах.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Одоо Тилеуханы Аубакир гишүүн асуултаа асууна.

**Т.Аубакир:** Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл явж байгаа.



Манай улсын хэмжээнд энэ асуудлыг бас нухацтай авч үзэх цаг болчихсон л доо.

30 гаруй жил үндсэндээ нүүрс, уул уурхай ярьсаар байгаад бас хүүхдүүд рүү чиглэсэн төрийн бодлого тийм хангалттай биш байсан.

**С.Одонтуяа:** Гишүүд бусдадаа садаа болохгүй байхыг хүсье. Хурал үймүүлээд байна.

**Т.Аубакир:** Хоёр асуулт байна. Х.Булгантуяа сайдаас.

Хэд хэдэн гишүүд хэлээд байгаа юм. Ц.Идэрбат гишүүнээс авхуулаад.

Хүүхэд хамгаалалттай холбоотой зардлыг маш тодорхой болгож өгмөөр байна. Т.Энхтүвшин гишүүнтэй би санал нэг байна.

Зарим аймаг, орон нутгууд дээр аймаг, орон нутгийн иргэдийн Хурал нь яг хүүхэд хамгаалал дээр энэ зардлуудаа бас хангалттай тавьж өгдөггүй. Үүнийг нь энэхүү хуулиар шууд ерөөсөө заавал тавьж өгдөг байх гэдэг ийм зохицуулалт оруулж болох уу?

Одоо чиг үүрэг дээр байх нь байгаа юм. Гэхдээ заавал оруулахгүй ч байж болох ч юм шиг нэг ийм. Зарим боломжтой аймгууд дээр тэрбум гаруй төгрөг тавьж болдог байх. Зарим төсөв, санхүү муутай аймгууд дээр 10, 20 сая төгрөг ч тавьж чаддаггүй байдалтай байгаа юм.

Тийм учраас Х.Булгантуяа сайд ээ, энэ боломжийг бид бас хармаар байна.

Сум болгон дээр хүүхэд хамгааллын мэргэжилтэн томилох, тэдгээрийн цалин, урамшууллыг нь бас боломжийн түвшинд тавьж өгөх. Энэ хүүхэд хамгааллынхаа мэргэжилтэнг төрийн үйлчилгээгээр томилчихдог боломж бий юу?

Яг төрийн **ТЗ**-ээр гэхээр төрийн албаны шалгалт энэ тэр өгөөд тэнцээд яваад байх хүмүүсийн боломж юу билээ.

Аймгийн төв болбол. Жишээлбэл, Баян-Өлгий аймгийн хувьд аймгийн төв дээр 40 гаруй мянган хүнтэй. Нэг хүн одоо яг энэ хүүхэд хамгааллынхаа энэ мэргэжил, энэ ажлыг хийгээд гүйгээд байх боломж тааруу, хүрэлцээ муутай болчих байх.

40 мянган хүнд нэг хүн байх нь өөрөө бараг байхгүйтэй л адилхан гэсэн үг л дээ.

Тийм учраас энэ хүн амын тоотой нь уялдуулаад төрийн үйлчилгээ хэлбэрээр, Баян-Өлгий аймаг бол 10 мянга гаруй хүнтэй сумд ч бас байдаг. Нэг хүний хүрэлцээ юу билээ гэсэн ийм хоёр дахь асуулт.

ТҮ-гээр томилоод хүн амынхаа тоотой уялдуулаад томилох ийм бололцоо бий юу гэсэн ийм хоёр дахь асуулт байна.

Энэ цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах бол яах арга байхгүй маш чухал л даа. Энэ зөвхөн манай улсын хэмжээнд биш дэлхий даяар бид чинь энэ цахим орчны хяналтыг тавихад маш амаргүй ийм шинэ нөхцөл байдал л даа. Н.Учрал сайд аа.

Энэ хууль дээр цахим орчинтой холбоотой маш олон заалтууд орсон байна. Өнгөрсөн жил бид энэ цахим орчныгоо бас цэгцлэх гээд хуулиа их л аятайхан хууль гарч ирж байсан. Баталж болсонгүй.

Бид энэ цахим орчин дээр тэр хүүхдийн гарт байгаа утас гэдэг бол ерөөсөө маш нууцлаг ийм ертөнц болчихлоо шүү дээ. Ний нуугүй хэлэхэд.

Тэр гар утсан дотор байж байгаа тэр нууц группүүд, жоохон хүүхдүүд, 6, 7 дугаар ангийн хүүхдүүдийг архи, тамхинд уруу татдаг. Элдэв бас буруу зүйл рүү уруу татсан, хэнтэй нийлж юу ярьж байгааг нь хяналт тавихад эцэг, эхчүүдийн хувьд маш хэцүү болчихсон.

Яах вэ, энэ дээр орж ирсэн л байна л даа. Хууль, хяналтын байгууллагууд хамтран хяналт тавина энэ тэр гээд. Энэ бол яах вэ дээ, Н.Учрал сайд хэлж байгаа нь маш сайхан сайхан аппликэйшнүүд бас хийгээд гаргаж байгаа.

Алслагдсан орон нутгууд дээр сүлжээ байхгүй сумдууд их бий. Н.Учрал сайд аа.

Үүнийгээ танай яамтай холбоотой төсөв ярьж байгаа үед бас зарим сумдыг сүлжээтэй болгох зайлшгүй шаардлага үүсэж байгаа.

Би танай яамны санхүүжилтийг дэмжиж байгаа. Сүлжээтэй болгох тал дээр.

**С.Одонтуяа:** Хариултаа аваад тэгээд нэмэлтээ авдаг горимтой. Хэн хариулах вэ? Н.Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Т.Аубакир гишүүний асуултад хариулъя.

Цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудал энэ хуульд туссан байгаа.

Тэгэхдээ би бас Засгийн газарт орж ажиллаад жил гаруй хугацаанд нэг зүйлийг их ойлгож байгаа. Бид их олон хууль баталсан хэдий ч энэ олон хуулиудыг дагаж гарах журам дээрээ асар их цаг алддаг юм байна.

Хууль боловсруулаад батлуулдаг. Тэгээд дагалдан гарах журам асар их цаг хугацаа алддаг. Ингээд нөгөө Захиргааны ерөнхий хуулийн дагуу бүртгүүлэх гэсээр байтал хэдэн сар.

Тэгээд энэ Хүүхэд хамгааллын хууль гараад шууд хэрэгжинэ гэхээр журмууд дээрээ гацсаар байгаад хэдэн сар болно.

Тийм учраас энэ хуулийг бүхэлдээ Х.Булгантуяа сайд байна, Л.Энх-Амгалан сайд байна. Бүгдээрээ энэ хуулийг олон журам шаардахгүйгээр шууд бичье.

Тэгэхгүй бол гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн сайд, харилцаа холбооны асуудал эрхэлсэн сайд журам гаргана, батална гэсээр байтал, бие бие рүүгээ бичиг шийдсээр байгаад энэ цаг алдана.

Тэгэхээр ерөөсөө яг энэ цахим орчинд хүүхэд хамгаалах асуудлаа яг цахим орчин дахь хэсгийг нь хэн хариуцах юм гээд ингээд шийдээд шийдээд явах нь зөв өө гэж би ингэж үзэж байгаа.

Тэгээд Т.Аубакир гишүүн сая их зөв асуудлыг хөндөж байна.

Яг Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага өдөрт 2-оос доошгүй цаг хэрэглэнэ гээд зөвлөөд байтал манай хүүхдүүдийн хэрэглээ 4 цаг сүүлийн судалгаагаар гарсан байна.

Тэгэхээр энэ хэрэглээг хязгаарлахад бид ч биш өнөөдөр дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад гаргасан сайн аппликэйшнүүд, өөр өөрсдийнхөө ийм шийдлүүдийг танилцуулж байгаагийн нэг нь л тэр **Google Family Link** ч юм уу, интернэт хязгаарлаад яваад байдаг.

Тэгэхээр нөгөө алслагдсан сум, суурин газар сүлжээгүй газар, **e-mongolia** нэвтрэхгүй байгаа газар яах вэ гэдэг эхний асуулт юу вэ гэхээр датагүй яах вэ гэсэн.

Ингэхээр нь 5 операторыг бид хүссээр байгаад та хүүхдийн төлөө нэг үйлдэл хийгээдхээч ээ гэсэн. 5 оператор өөрсдөө **e-mongolia**, **e-kids**-ийг хийцийг ямар нэгэн дата унагахгүй болгоод шийдчихсэн. Одоо интернэттэй газар болчхож байна.

Ингээд дараагийн асуудал нь юу вэ гэхээр манай улсад 191 баг байна. Сүлжээнд огт ороогүй. XXI зуунд сүлжээнд огт ороогүй 191 баг.

Тэгэхээр үүнийг шийдвэрлэхийн тулд энэ оны төсөв дээр 100 багийг ирэх жил шийдье гэдэг ийм төсвийн санал орж ирж байгаа юм.

Энэ батлагдчихвал бид 05 дугаар сарын 01-нээс өмнө сүлжээ ороогүй

багуудын ядаж 50 хувийг шийдчихье гэж зорьж байгаа.

Хоёрт, цаашдаа угаасаа тэр малчдын өвөлжөөн дээр, малчны хотонд, сумаас сумын хооронд явахад, багаас багийн хооронд явахад сүлжээ унждаг байдлыг шийдэх цорын ганц арга бол хиймэл дагуултай л болох ёстой. Манай улс.

Тийм учраас сая Францад айлчилсан үеэр Монгол Улс анх удаа сансрын үндэсний хиймэл дагуул Монгол хөөргөх, бүтээх ажил дээр Францтай хамтарч ажиллахаар болсон.

Үүнийг шийдээд 3-аас 4 жилийн дараа манай улсын хаана ч сүлжээ харгалзахгүйгээр шууд гар утас нь ажилладаг. Цаашлаад нөгөө **emergency** дуудлага ирдэг. Хүүхдүүд гар утсаа ашигладаг. Ухаалаг утасгүй байсан ч дохиолдол ирдэг ийм л системд шилжинэ.

**С.Одонтуяа:** Х.Булгантуяа сайд нэмж хариулах юм уу.

**Х.Булгантуяа:** Т.Аубакир гишүүний энэ байгууллагын хувьд заавал төрийн захиргааны байгууллага байх албатай юм уу? Төрийн үйлчилгээ гэх юм бол хүн авах энэ процесс нь арай амар юм биш үү гээд.

Би тантай санал нэг байна.

Яах вэ, өнөөдрийг болтол энэ төрийн захиргаагаараа явчихсан юм байна лээ. Тэгээд яах вэ, зарим тохиолдолд төрийн захиргааны албан хаагчдыг халах солих процесс нь их амаргүй байдаг учраас магадгүй миний бодлоор эхэн үедээ үүнийг тогтвор

суурьшилтай ажиллуулах үүднээс ингэсэн байх.

Тэгэхдээ анхан шат дээрээ бид нарт ямар проблемууд үүсээд байгаа гэхээр төрийн захиргааны албан хаагчдын хувьд гүйцэтгэлийн урамшуулал авахад хэцүү байдаг.

Гэтэл бид уг нь кэйс дээр сайн ажиллаж байгаа хүмүүстээ гүйцэтгэлийн урамшуулал олгодог байна гэх юм бол ялангуяа шинээр авах гэж байгаа нийгмийн ажилтнуудыг анхан шат дээр ажиллаж байгаа хүмүүс “ТҮ” байх нь бараг зөв байх гэж бодоод байгаа юм.

Тэгээд бүр агентлаг нь бодлогын агентлаг гээд “ТЗ” байдаг юм байгаа биз. Бусад нь бараг “ТҮ” байх боломж байна байх.

Харин бас нөгөө талдаа энэ төрийн албан хаагчдыг амархан халаад солиод байдаггүй байх дээр нь, мэргэшсэн хүмүүсээ алдаад байдаггүй байх дээр нь бид давхар анхаарахгүй энэ салбар маань дөнгөж үүсэж хөгжөөд арай гэж мэргэжлийн боловсон хүчинтэй болоод бас удаагүй байгаа.

Б.Энх-Амгалан сайд сайн мэднэ. Үнэнийг хэлэхэд бид нарт хүүхдийн чиглэлийн энэ нарийн мэргэжлийн хүмүүсээ авна гээд хуульчлаад байхад олдохгүй байгаа.

Манай нийт сургуулиудын бараг 20 хувь нь. Тийм ээ. Л.Энх-Амгалан сайд ээ. Сэтгэл зүйчгүй л одоо хүртэл байгаа. Уг нь сэтгэл зүйч гэдэг орон тоог нь гаргачихсан. Төсөв мөнгө нь бэлэн. Тэгсэн мөртлөө байхгүй.

Одоо бид ингээд нийгмийн ажилтантай боллоо гэж хуульчлахад ирэх жилийн бүх төгсөгчдийг аваад аваад бид амжихгүй юм билээ. Нийтдээ **15 их сургууль** байна уу даа. **Нийгмийн ажилтнаар бэлдэж байгаа.** Тийм ээ. П.Цэвээн багш аа.

Тэгэхэд бид нарт бас л хүрэлцэхгүй. Жилд 300 орчим хүмүүс төгсөж гарч байна. Боловсролын салбарт ч хэрэгтэй. Нийгмийн ажилтан. Манайд ч хэрэгтэй.

Тэр битгий хэл боловсролын салбарт хүүхдийн тоогоор нь зааж байгаад хэрэгтэй юм билээ. Ангиар нь хэрэгтэй. Дунд анги, ахлах анги, бага анги хариуцсан “нийгмийн ажилтан” гэж бараг байх ёстой болчихоод байгаа юм. Насны онцлогоор нь.

Мянга хүртэлх хүүхэдтэй сургуульд магадгүй нэг. Дээрээс нь нэмээд 3 мянга, 4 мянган хүүхэдтэй сургуулиуд ч байна. Тэнд нь арай олон байхаар гээд.

**С.Одонтуяа:** Тодруулах юм уу? Та.

Одоо Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуултаа асууна. Тэгээд Н.Учрал сайд, Л.Энх-Амгалан сайд яг хууль санаачлагч шиг хариулаад байгаа хэрнээ та хоёр бас асуух юм уу? Үг хэлэх дээр яах юм уу?

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Хүүхэд хамгааллын тухай хуульд тодорхой хүүхдийн эрхтэй холбоотой заалтууд маань хэр орсон бэ? Тухайлбал, хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, тэгээд бүх төрлийн цахим хэрэглээ болон бусад мансууруулах бодисын донтолт, дээрээс

нь хүүхдийн амиа хорлолтын асуудлаар хамгаалах заалтууд юу гэж орсон бэ?

Ер нь цагдаагийн мэдээ баримтаас үзэхэд өсвөр насныхны дунд саяын дурдсан сэтгэцийн асуудлууд, сэтгэл гутрал, амиа хорлолт жил ирэх тутам нэмэгдэж байна.

Тэгээд энэ тал дээр манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нийгмийн хамгааллын бас нэг чухал асуудал байх ёстой. Энэ ямар заалтууд орсон бэ?

Энэ ташрамд хэлэхэд өнгөрсөн хаврын чуулганаар батлагдсан Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуульд манай **“ерөнхий боловсролын бүх сургуулиуд сэтгэл зүйчтэй байна”** гэдэг заалтыг манай Байнгын хорооны гишүүд оруулсан байгаа.

Тэгээд дээрээс нь **“цэцэрлэг ч гэсэн мөн сэтгэл зүйчтэй байж болно”** гэсэн ийм заалт байна.

Тэгэхээр өнөөдөр Монгол Улсад төрийн өмчийн болон төрийн бус өмчийн 848 сургууль байгаа.

Ер нь бүгд сэтгэл зүйчтэй болоод ажиллах ёстой. Тэгээд энэ асар чухал юм. Яг үе тэнгийн дээрэлхэлт. Тэгээд гэр бүлийн болон бусад ямар нэгэн асуудлаас үүдсэн сэтгэл цочрол байна уу, сэтгэлийн гэмтлүүд байна уу. Энэ болгон дээр тулж ажиллах гол хүн бол сургууль дээр сэтгэл зүйч байгаа.

Тэгэхээр ер нь хүүхдийн хамгааллын асуудлаар манай Боловсрол, шинжлэх ухааны яам, сайд нэлээн манлайлан ажиллаж байгаа.

Тэгвэл энэ хууль дээр сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой хүүхдийн хамгааллын заалтууд юу байна гэдгийг асууя.

Хоёрдугаарт нь, хуулийн маань нэг сайшаалтай шинэ зохицуулалт. **“Асралт гэр бүл”** гэдэг юу орж ирсэн байна.

Ер нь Монгол дахь хүүхдийн эрхийн болон бусад тайлан, зөвлөмжүүдэд, олон улсын байгууллагын өгсөн нэг зөвлөмж бол энэ хүүхдийг аль болох гэр бүлийн орчинд асран хамгаалж хүмүүжүүлэх нь их чухал. Тэр дотор тэнэмэл болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд аль болохоор гэр бүл дотор өсөх нь чухал гэдэг энэ зөвлөмжүүдийг өгсөн байдаг юм.

Тийм учраас Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн газрын сүүлийн 10 гаруй жилийн туршид энэ “Асралт гэр бүл” гэдэг ийм төслүүд хэрэгжүүлж ирсэн байдаг.

Тэгэхээр ер нь одоо яг Монголын нөхцөлд энэ хүүхдийг “Асралт гэр бүл” буюу ийм айлд үйлчлүүлж өсгөөд нийт хэдэн хүүхэд ингэж өссөн бэ?

Энэ “Асралт гэр бүл”-д өссөн хүүхдүүдийн маань зан чанар, төлөвшил ер нь хэр байна?

Ер нь монголчуудын дунд “Асралт гэр бүл” гэдэг энэ шинэ хүүхэд хамгааллын, гэр бүлийн энэ соёл нэвтрүүлэхэд хүмүүс маань хэр хүлээж авч байна аа?

Нийгмийн хамгааллын тухай хуулиар яг “Асралт гэр бүл” тодорхой

хэмжээний мөнгөн дүн бүхий хүүхэд харсны урамшуулал авдаг. Тэр нь одоо энэ хуулиа дагаад нэмэгдэх үү гэдгийг асуумаар байна.

Гуравдугаарт нь, яг гэр бүлийн орчин дахь. Түрүүн бас зарим гишүүд маань асуугаад байна л даа.

Энэ ураг төрлийн болон гэр бүлийн орчинд хүүхдийн хүчирхийлэл хамгийн их гардаг. Тэр дотроо гэр бүл дэх бэлгийн хүчирхийлэл ураг төрлийн хүрээнд их гараад байгаа.

Тийм учраас яг нэгж дээр ажиллаж байгаа хорооны нийгмийн ажилтан, анхан шатын хамтарсан баг маань маш чадварлаг байж тэр эрсдэлт нөхцөл бүрийг үнэлж хамгаалах ёстой.

Тэгэхээр яг нийгмийн хамгааллын энэ хуулийн төсөлд маань яг анхан шатын байгууллагын үүрэг оролцоо, санхүүжилтийг хэр нэмж байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

**С.Одонтуяа:** Л.Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Ц.Мөнхцэцэг гишүүнд талархаж байгаа.

Манай Ц.Мөнхцэцэг гишүүн маань анх удаа гэж хэлж болно доо.

Сургуулийн үе тэнгийнхний дээрэлхэлтийн асуудлуудыг, энэ сэдвийг гаргаж ирж нийгэмд шүгэл үлээсэн гишүүн. Маш их далд болж байгаа.

Ер нь бид нарын нүдний далд яг юу болоод байна, юу тохиолдоод байна гэдгээ бид бүрэн мэдэж чадахгүй байгаа шүү дээ.

Өнөөдөр статистикийг хархад манай хоёр яам хоёулаа өөр тоотой сууж байгаа. Одоо жишээ нь манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саяын Их Хурал дээр өгч байгаа тоо эрсдэлтэй хүүхдүүд 14 мянга 270 хүүхэд гээд тоо ярьж байхад манай яаман дээр хийж байгаа сургуулийн хэмжээнд нийт суралцагчид эрсдэлийн үнэлгээний хийсэн байдлаар 55 мянга 961 хүүхэд гэж гарч байгаа.

Тэгээд Монголын төр ингэж ажиллаж болохгүй л дээ. Нэг л тоотой байх ёстой бид. 14 мянган хүүхэд эрсдэлд байгаад байгаа юм уу, эсвэл үнэхээр 55 мянга 961 хүүхэд эрсдэлд байгаа юм уу гэдэг.

Ингэж байж бид зөв асуудлуудаа тодорхойлж байж, оношоо зөв тавьж байж эмчилгээгээ л хийх ёстой шүү дээ.

Тэгэхээр нөхцөл байдал бас ийм байгаа. Бид гашуун үнэнийг хэлж байх ёстой гэж ойлгож байна.

Ингээд энэ 55 мянга 961 хүүхдээс яг үе тэнгийн дээрэлхэлтийн тохиолдол гэхээр 11 мянган хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн байна гэдэг энэ аймшигтай тоо шүү дээ. Бас их том тоо.

Тэгээд бид ямар ч байсан нэг дэвшил бол энэ Боловсролынхоо хууль дээр сургууль бүхэн сэтгэл зүйчтэй байх ийм эрх зүйн зохицуулалттай болсон.

Сүүлийн хоёр жилд манай боловсролын салбарт хийсэн томоохон ажил, нүдэнд харагдахуйц, гарт барьцахуйц ажил бол энэ сургуулийн сэтгэл зүйчдийг бэлдсэн ажил байгаа.

Ер нь ингээд судалгаа хийгээд үзэхээр КОВИД-ын энэ сургууль удаан хугацаагаар хаасны хор холбогдол, сөрөг нөлөөнүүд маш их гарсан. 3 хүүхдийн 2 нь сэтгэл гутралтай байна гэдэг ийм тооцоо судалгаанууд гарч байгаа юм.

Тэгэхээр хүссэн хүсээгүй цаашдаа бид энэ альфа үеийнхний нэг онцлог бас байна.

Тийм учраас энэ “сэтгэл зүрхний боловсрол” буюу одоо ингээд энэ хүүхдийн төлөвшлийн асуудлуудыг бид ер нь нийгмээрээ нэг шүтэл үлээж, нийгмээрээ нэг ойлгож, дүгнэлт хийж, сэтгэлгээ хандлагаа өөрчлөх ийм цаг үнэхээр ирчихсэн байна. Хаалга тогшоогүй хаалга нээгээд ороод ирсэн байна гэдгийг нийгмээрээ энэ асуудлуудыг ярих ёстой.

Тийм учраас эцэг, эхчүүд асран хамгаалагчдын үүрэг энэ дээр маш чухал. Ерөөсөө хүүхэд бол ихэнх цаг нь сургууль. Нөгөө цаг нь гэр бүлдээ зарж байгаа.

Тийм учраас хүүхдийн эрх хаана зөрчигдөж байна вэ гэхээр саяын хийсэн, Х.Булгантуяа сайдын хийсэн судалгаагаар үндсэндээ гэр бүлийн орчинд энэ хүүхдийн эрх зөрчигдөж байгаа гэмт хэргийн асуудлууд гарч байгаа гэмт хэргүүдийн чинь, хүчирхийллийн чинь 70 хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдээд байна гэсэн ийм статистик судалгаа байна шүү дээ.

Тэгэхээр энэ чиглэл рүү бид яг өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа, батлах гэж байгаа энэ хууль маань ингээд Монгол Улсад.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Х.Булгантуяа сайд нэмж хариулъя.

**Х.Булгантуяа:** Ц.Мөнхцэцэг гишүүн маш зөв асуулт ярьж байна.

Би бүр ингэж бодоод байгаа юм. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сэтгэл зүйн эрүүл мэндийн үндэс үндэсний хөтөлбөр 2019 онд дуусчихсан юм билээ.

Түүнээс хойш шинэчлэгдэж гарсан юм уу, үгүй юм уу. Бүү мэд.

2020, 2021 онд би гишүүний хувьд энэ сэтгэцийн эрүүл мэндээр, сэтгэл зүйн төсөв, санхүүжилт тавих гэхээр хөтөлбөр нь дуусчихсан гээд мөнгө тавьж болохгүй байсан. Хувь гишүүний хувьд.

Гэтэл КОВИД-ын үед дэлхий даяараа сэтгэл гутрал, сэтгэл зүйн эрүүл мэндэд маш том асуудал болоод салбар салбарын онцлогоор гаргасан байж байгаа.

Гадаадын Гадаад хэргийн яам гэхэд 24 цагийн онлайн утас гаргаад хүртэл гадаадад байгаа Элчин сайдын яамны манай ажилтан сэтгэл гутралд орох юм бол, сэтгэл зүйн хувьд тавгүйтэх юм бол ийшээ залгаарай гээд.

Бидэнд яг үнэнийг хэлэхэд сайн сэтгэл зүйч цагийн 400, 500 мянган төгрөг болсон гэсэн.

Бид яах вэ ажлын байр зарлаад л чадах ядахаараа сургууль дээр, нийгмийн бүхий л байгууллага дээр улсын хэмжээнд 4 мянга гаруй сэтгэл зүйч ажиллаж байна.

Хууль эрх зүйн орчны хувьд ч гэсэндээ бас амаргүй. Ямар ч байсан бид энэ хүрээнд нийгмийн ажилтан ажиллаж байгаа.

Тэгээд дээрээс нь нэмээд сэтгэл зүйчийн энэ сэтгэл зүйн асуудлыг ганцхан хүүхдийн гэхгүй Улсын Их Хурал дээр, эсвэл Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ч байдаг юм уу сонсвол яасан юм бэ гэдэг нэг ийм санал байгаад байна. Ганцхан хүүхдийн гэлтгүй.

Гэр бүлийн хүмүүс, ах дүү, хамаатан садан, бие биеийгээ хүчирхийлж байна. Алж байна гэдэг бол нийгмийн сэтгэл зүй тийм аймаар гутралд орчихсон байна л гэсэн үг. Одоо сошиалаас бид энэ талаар үнэн ч юм уу, зөв ч юм уу мэдээлэл аваад сууж байгаа.

Тэгэхээр үүн дээр санал нэг байна.

Дээрээс нь таны асуусан “Асралт гэр бүл”-ийн хувьд хүмүүс үүнийг хүүхэд үрчлэхтэй бас их андуураад байдаг.

“Асралт гэр бүл”-ийн хувьд бид энэ хүүхдийг өсөж торниулахад аль болох гэр бүлийн орчинд байвал зүгээр байна. Нэгдсэн журам маань одоо манай, Жишээлбэл, “Өнөр бүл” төв 150 гаруй хүүхэдтэй. Уг нь олон улсын жишгээр бид нарт аль болохоор ийм олон нэг доор байлгах биш, 40, 50-иас илүү байлгахгүйгээр нэгдүгээрт байх хэрэгтэй. Тэгээд.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Н.Баярмаа. 83 дугаар микрофон.

**Н.Баярмаа:** Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья.

Гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхийн хүрээнд бид “Асралт гэр бүл”-ийн асуудлыг шинээр оруулж ирж байгаа.

Энэ бол хүүхэд хамгааллын үйлчилгээний бас нэг хэлбэр гээд.

Одоогийн Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу Гэр бүлийн тухай хуулийн 25-д заасан гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийг гэр бүлдээ асран халамжилж байгаа иргэдийн зохицуулалтын асуудал байгаа.

Тэгээд журам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний журам байгаа.

Одоогоор энэ үйлчилгээнд 243 хүүхэд нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу хамрагдаад үйлчилгээгээ аваад явж байгаа.

Тэгээд санхүүжилтийн хувьд Нийгмийн халамжийн тухай хуулийн байнгын асаргааны тэтгэмж нэмэгдсэн. 275 мянган төгрөгийг аваад явж байгаа.

Тэгээд бид энэ хуулийн төслийг дагаад Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж энэ хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний шалгуур үзүүлэлт болон хамгааллын үйлчилгээ байнга асран хамгаалах энэ үйлчилгээний зардлыг тооцдог байх энэ зохицуулалтуудыг шинээр оруулж байна.

Хүүхдийн үндсэн эрхийн асуудал гэхээр хүүхэд хамгаалалд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх, хамгааллын үйлчилгээн дэх саналаа хэлэх энэ асуудлыг үндсэн зарчимдаа оруулсан байгаа.



Тэгээд нийгмийн ажил, үйлчилгээний бүх шатад одоо энэ хүүхдийн эрхийг харгалзаж үзэх, тусгай хэрэгцээтэй хүүхдэд бол дохионы хэлмэрч, тоноглол төхөөрөмжийг нь оруулах асуудлуудыг нь нэмэлтээр зохицуулсан байгаа.

Тэгээд хамтарсан багийн ажил, үйлчилгээг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэдээ тодорхойлох. Дээрээс нь нэмээд хамгааллын үйлчилгээг анхан шатдаа үзүүлэхэд санхүүжилтийг нь шууд олгох, урамшууллыг нь тооцох асуудлыг үүгээр нээлттэй оруулж ирж байгаа.

Хамгийн гол асуудал бол яг хүүхэд хамгаалал гэж юу вэ. Хамгааллын үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээндээ тухайн гэр бүлтэйгээ хамтарсан баг маань ажиллах. Энэ ажиллах үйл ажиллагааг нь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууна.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Энэ хууль хоёр, гурван жил бэлтгэгдэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр боловсруулагдаж байна гэж хүлээгдсээр орж ирсэн ийм хууль байгаа. Чухал хууль.

Өнөөдөр Монгол Улсын нийт хүн ам 3.4 сая, 0-оос 18 насны хүүхэд 1.2 сая байна.

Ингэхээр манай улсад 3 хүний нэг нь хүүхэд байна гэсэн үг. Дэлхийн банкны 2020 оны ядуурлын дүр төрх судалгаагаар манай Монгол Улсын 5 ядуу

хүн тутмын 2 нь хүүхэд байна гэж тодорхойлсон.

Тэгэхээр энэ статистик мэдээ нь манай улсад хүүхэд гэдэг ирээдүй маань ямар эмзэг нөхцөлд байгааг, хүүхдийн ядуурал, хүүхдийн асуудал ямар байгааг харуулсан ийм бодит тоо.

Монгол Улсын үндсэн хуулийн 16.11-д **“гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”** гэж заасан. Энэ хуулийг хэрэгжүүлэх.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцод **“Хүүхдийн эрх ашиг бүх эрх ашгаас дээр байна”** гэсэн амлалтаа биелүүлэх түүхэн боломж энэ Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгаар уг нь бидэнд олдож байгаа юм.

Харамсалтай нь ийм удаан боловсруулагдаж орж ирж байгаа хууль шаардлага хангаагүй байгаа гэдгийг би Байнгын хороон дээр ч хэлсэн. Өнөөдөр ч гэсэн хэлмээр байна.

Зүгээр зорилгоос нь аваад харахад л тогтолцоогоо хамгаалах гэдэг ийм утгатай орж ирж байгаа байхгүй юу. Тогтолцоо бий болгох, тогтолцоо хамгаалах.

Хүүхэд хамгааллын зарчмыг тогтолцоонд суурилснаар тодорхойлно гэж байхгүй.

Энэ хүний эрхэд буюу хүүхдийн эрхэд суурилагдаж хүүхэд нь дотроо хамгаалагдаж, тогтолцоогоороо хамгаалагдах ёстой гэсэн энэ утга агуулга ч гэсэн байхгүй байгаа.

Ийм учраас сэтгэлгүй хандаад байна л гэж хэлээд байгаа юм.

Энэ хариуцаж байгаа яам Хөдөлмөрийн яам байгаа. Өөрөө. Тэгээд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд хамгааллын асуудал огт ороогүй.

Хөдөлмөрийн тухай хуулийн 142.4 дээр 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно гэсэн.

Гэтэл Хүүхэд хамгааллын тухай хуульд энэ нь огт тусгагдаагүй байгаа нь дахиад л Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн эрхийн конвенцод нийцээгүй байна гэсэн үг.

Миний харж байгаагаар энэ хууль дээрээс доошоо чиглэсэн босоо тогтолцоон дээр бичигдсэн.

Өнөөдрийг хүртэл улс төржөөд энэ агентлагийн дарга нь улс төрийн хамааралтай. Томилогдоогүй байгаа.

Гэтэл нөгөө талаасаа энэ юунд түшиглэх ёстой юм гэвэл хэрэгжилт нь хэвтээ буюу хүүхдээ сонсох эрх ашгийг нь хамгаалах оролцоо гэсэн зүйлтэйгээ зөрчилдөж байна гэж харж байгаа.

Түрүүн хэлж байна. Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар зүгээр нэг бэлгэдлийн төдий орж ирсэн.

Гэтэл Эрүүгийн хуулийн 14.1 дээр ялгаварлан гадуурхалт гэдэг том эрүүгийн зүйл, заалт байж байгаа.

Яагаад энэ бүтэн зүйлээр орж ирэхгүй ингэж бэлгэдлийн төдий орж ирж байгаа юм бэ?

Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах асуудал өмнөх хуульд 8 дугаар зүйл дээр 3 зүйл, заалт байдаг.

Ташрамд хэлэхэд энэ Цахим хөгжлийн яам байгуулагдаж Боловсролын яам, Цахим хөгжлийн яам. Одоо миний санаачилж байгаа Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг дэмжиж удахгүй өргөн барихаар ажиллаж байгаад баяртай байна.

Тэгэхээр энэ бол тэр бие даасан хуулиараа зохицуулагдаад явах байх гэж харж байгаа.

Эцэст нь энд байгаа сайд, энэ үүрэг гүйцэтгэгч хүмүүсээс, бас энэ төрийн бус байгууллагууд хариулбал хариулаарай.

Хууль тодорхой хэмжээнд байгаа. Хэрэгжилт хангалтгүй байгаа гэдэг дээр та нар санал нийлж байна уу? Энэ хууль батлагдаад төсвийг нэмснээрээ хүүхэд хамгааллын асуудал бүрэн цэгцэрч чадах уу? Монголын хүүхдүүд амар тайван байж чадах уу?

Яагаад өнөөдөр бодлого дээрээ та нарт дүгнэлт хийхгүй байгаа юм бэ гэдэг ганцхан асуултыг асууя.

**С.Одонтуяа:** Хэн хариулах вэ? 81 дүгээр микрофон.

**С.Зулпхар:** Б.Баярсайхан гишүүний асуултад хариулья.

Б.Баярсайхан гишүүн  
Хөдөлмөрийн тухай хуулийн

хэрэгжилттэй холбоотой 43.3-ыг тухайлан энд асууж байна. Энэ их зөв.

Яагаад гэвэл Хөдөлмөрийн тухай хуулийг бид хэлэлцэж байх явцад Б.Баярсайхан гишүүн өөрөө үүнийг санаачилж оруулсан.

Хүүхэд хамгаалал, хүүхэд хөгжлийн чиглэлээр хуулийн этгээд үүрэгтэй байхаар ингэж оруулсан юм. Тэгээд бид энэ хуулийн хэрэгжилт бас яах вэ зохих түвшинд явж байгаа гэж ойлгодог. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, эцэг эхийн зөвлөлүүдээ байгуулаад бас тодорхой бодлоготой байхаар алхам хийгдэж байгаа боловч энэ хангалттай биш байгаа.

Тэгэхээр энэ байдлыг бид бас энэ Хүүхэд хамгааллын хууль дээр тухайлж оруулж өгсөн.

Хүүхэд хамгааллын хуулийн 6.1-д хуулийн этгээд нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна гээд ингэж зааж оруулж өгсөн юм.

Энэ байхгүйгээс болоод. Нэн ялангуяа төрийн байгууллагууд ерөөсөө энэ дээр төсөв мөнгө тавьж чаддаггүй. Тэр битгий хэл нөгөө хүүхэд хамгааллын бодлогоо хэрэгжүүлж чаддаггүй ийм байдал үүссэн байсан.

Тэгэхээр үүнийг оруулсан. Үүнийг гарцаа авахгүй оруулах ёстой гэж ойлгож байгаа юм.

Хууль байгаа боловч хууль бүрэн хэрэгжиж чадаагүй юу гэдэг ийм асуулт байна. Үүнийг бид шат шатдаа ярьж байгаа. Хуульд ямар нэгэн байдлаар байгаа. Тогтолцоо ямар нэгэн байдлаар байгаа.

Гагцхүү бүрэн ажиллаагүй. Үүнийг бүгдээрээ бид хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Гэхдээ хууль хэрэгжих явцад тогтолцооны тодорхой. Бид хэлж байгаа шүү дээ. Үүрэг хүлээсэн субъектүүд байгаа. Тэр нь Засаг дарга, хурал, цаашлаад байгууллага, төрийн байгууллага, эцэг, эх гээд. Энэ зүйлийг энэ процессын хувьд бүрэн тусгаж өгсөн хуультай болохгүй бол энэ харилцаа зохицуулагдахгүй байна, тогтолцоо өөрөө бүрэн ажиллахгүй байна гэдэг ийм л дүгнэлтийг бид судалгааны явцад, түүнээс гадна энэ хуулийг боловсруулах явцад хийсэн.

Тэгээд энэ процесс энэ дээр зохих түвшинд орж ирсэн.

Хууль өөрөө нийгмийн ямар нэгэн байдлаар шийдэгдэхгүй байгаа асуудлыг шийдэхэд чиглэгдэж байгаа учраас бидний хүлээлт энэ хууль гарснаар хүүхэд хамгаалал дээр зохих түвшний дэвшил гарна гэсэн хүлээлттэй байгаа.

Гэхдээ хуулийг батлах нэг хэрэг. Хуулийг хэрэгжүүлэх хамгийн чухал асуудал байдаг гэдгийг бид мэдэж байгаа. Энэ дээр бүх тал хамтарч ажиллах юм байна, үүрэг хүлээх юм байна л гэж ойлгож байгаа.

**С.Одонтуяа:** Хариулах гишүүд микрофоныхоо дугаарыг өргөөд. 91.

**С.Энхтуяа:** Саяын асуултад хариулъя. Б.Баярсайхан гишүүний асуултад.

Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хэрэгжилтийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангаас олон улсад энэ чиглэлээр мэргэжсэн хууль эрх зүйн байгууллага болох **Coram International** [Coram Children's Legal Centre]-ээр үнэлүүлсэн байдаг.

Энэ дээр хамгийн гол манай хууль хэрэгжихгүй байгаагийн үндсэн шалтгаан нь яг тэр ажлаа хийх хүнээ тодорхойлоогүй, тэр ажлынх нь арга зүйг гаргаж өгөөгүй байна гэсэн дүгнэлт байдаг.

Энэ бол манай П.Анужин гишүүний асуулгаад байгаа бидний нөгөө гадаад үг ашиглаад байгаа **Кэйс менежмент**[Case Management Process] гэдэг аргачлалаа бид яг амьдрал дээр нэвтрүүлээгүй байгааг хэлсэн байхгүй юу.

Ерөнхийдөө та хэд мэдэж байгаа. Эмчид очоод үзүүлэхээр шинжилгээ хийлгээд, шинжилгээнийхээ оношоор тэр хүнийг эмчилбэл илүү үр дүнтэй байдаг.

Тэгвэл манай “хүүхэд хамгааллын үйлчилгээ” чинь “**нийгмийн ажилтан**” очоод нөхцөл байдлыг нь үнэлээд буюу оношлоод тэгээд тэр хүүхэддээ яг тохирсон, гэр бүлд нь нийцсэн эмчилгээ үйлчилгээ үзүүлэх ёстой байхгүй юу.

Тэгж чадахгүй юм бол тэр хүүхэд үйлчилгээ авч чадахгүй үлдчихдэг.

Тэгээд дахиад нөгөө асуудал нь гараад байдаг.

Тэгээд ерөнхийдөө яах вэ, та хэдэд хэлэхэд манай П.Анужин гишүүн маань яг монгол хэлээрээ энэ “**Кэйс менежмент**” гэдэг үгийг оносон гоё хувилбарыг санал болгож өгөөрэй.

Бид энэ үгээс татгалзах арга байхгүй. Яагаад гэвэл энэ бол үйлчилгээний хамгийн гол арга.

Тэгээд энэ шинэ хууль дээр “**Кэйс менежмент**”-ийнхээ үйлчилгээг яг 6 үе шатаар нь яг нарийвчлан зааж өгсний хувьд хууль хэрэгжээд эхлэхээр хүүхэд болгон зөв оношлуулаад, зөв үйлчилгээ, эмчилгээ аваад, зөв нөхөн сэргээгдээд явна гэсэн хүлээлттэй байна.

**С.Одонтуяа:** П.Цэвээн багш хариулах уу? 93.

**П.Цэвээн:** Б.Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Хүүхэд хамгааллын хуулийг 2016 онд боловсруулж байсан, хууль бас оруулж байсан хүний хувьд, оролцож байсан хүний хувьд Хүүхэд хамгааллын хуулиа бид ойлгож байгаа.

Хүүхэд хамгааллын хууль гэдэг бол эрсдэлд байгаа хүүхдүүддээ л. Процессын хууль.

“**Эрсдэлд байгаа хүүхэд үйлчилгээ үзүүлэх**”,

“**Хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх**” гэсэн хоёр л үйлчилгээ үзүүлэхэд зориулсан ийм хууль.

Ерөнхийдөө энэ хуультай зэрэгцэж гарсан өчнөөн төчнөөн дүрэм журам, тэгээд л янз янзын юмаар нь зохицуулагдаж байгаа боловч хэрэгжилтийнхээ процесс үнэхээр сайн яваад үр дүн гаргав уу гэвэл зарим зүйл дээр гаргасан, зарим зүйл дээр гаргаагүй байгаа.

Энэ нь юутай холбоотой вэ гэхээр мэдээж хэрэг бид нарын одоо нөгөө тогтолцооныхоо хувьд шийднэ гэдэгт тогтолцоонд бол мэдээж хэрэг эрх зүйн орчин бүрдсэн, хангалттай гэж хэлэхэд болно.

Монгол Улс бас хүүхдийнхээ төлөө конвенцод нэгдсэнээс хойш эрх зүйн орчинд анхаарал тавьж ажилласан болон бодлогын хувьд зохих ёсоор энэ хариуцсан яамныхаа хүрээнд ер нь явж байгаа гэж үзэж байгаа.

Хэрэгжилтийн үе шатдаа нэн ялангуяа Б.Баярсайхан гишүүний удаа дараа ярьж байгаа энэ төсөв хуваарилалтын байдал, энэ үргүй зардлын тухай асуудал дээр бас асуудал байдаг болов уу гэж бодож байгаа.

Яагаад гэвэл энэ бол өөрөө ерөнхийдөө ерөөсөө далд байдаг учраас олон хүмүүсийн харыг дагуулдаг байх үндэслэлтэй.

Хоёрдугаарт нь, иргэний байгууллагууд. Уг нь гэр бүл төвтэй, мэргэшсэн, цогц үйлчилгээ гэж байгаа боловч мэргэжлийн төрийн бус байгууллагууд. Одоо энд жишээлбэл 8 тэрбумаас хэдийг нь аваад хэдэн байгууллага хийсэн юм бэ гэдэг нь энэ бас тодорхой бус. Зүгээр ерөнхийдөө 250-аас 300 сая төгрөгийг иргэний байгууллагын магадлан итгэмжлэгдсэн

иргэний байгууллагад өгдөг гэсэн тоо баримттай л ингээд явж байгаа.

Цаашдаа бид яах ёстой вэ гэхээр хүсэлтийн шатан дахь.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Дуусгаад хариулчихъя. 93.

**П.Цэвээн:** Хүүхэд хамгааллын хуульд үнэлгээ хийсэн.

Хүүхдийн эрхийн тухай хуульд үнэлгээ хийж байхад ерөөсөө хүний мэдээлэл их дутуу явагдсан. Хүний нөөц дутуу. Ерөнхий заалт ихтэй. Түүндээ зориулсан санхүүжилт дутагдалтай гэсэн ийм л үнэлгээнүүд гарч байгаа юм.

Тийм учраас бид энэ дээр санхүүгийн сахилга бат болон хүний нөөц, ёс суртахууны байдал, энэ тогтвортой байдал.

Өнөөдөр гэхэд л Та бүхэн мэдэж байгаа. Яамны сайд гэхэд хэдэн удаа солигдож байгаа вэ, агентлагийн дарга өнөөдөр хэдэн удаа солигдож байгаа вэ гэхээр энэ бол нөлөөлж байгаа хүчин зүйл мөн үү гэвэл мөн л гэж үзэж байгаа. Баярлалаа.

**С.Одонтуяа:** Б.Баярсайхан гишүүн тодруулъя.

**Б.Баярсайхан:** Баярлалаа.

Тэгвэл яам, бодлогын яам нь, олон улсын байгууллага нь ч тэр Монгол Улсад итгэмжтэй үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага нь ч тэр хэрэгжилт хангалтгүй, төсөвт итгэмжгүй байсан гэдэг дээрээ хүлээн зөвшөөрч байгаа юм байна.

Тэгэхээр Х.Булгантуяа сайд аа, би Засгийн газрын хэрэгжүүлж байгаа “5-Ш” үйл ажиллагаа танай агентлаг, яаман дээр явагдах ёстой гэж харж байгаа.

Хүүхдэд зориулсан хэдхэн төгрөгийг ингээд л одоо надад энэ аудитийн юу тавьчихсан л гээд байна. Одоо бүгдээрээ л байна л даа. Энэ архи, виски, вино юу юу ч гэнэ вэ. Нэрээрээ ингээд архи дарснууд чинь гараад ирчихсэн. Ёстой цаашаа ярих юм уу, яах юм гэдэг шиг ухах юм бол энд зөндөө ийм ёстой ёс бус ийм зүйл зөндөө байгаа.

Тэгэхээр энэ хүмүүстэйгээ хариуцлагаа тооцоо. Төсвөө хэчнээн нэмээд ийм хүмүүс чинь хэвээрээ байж байх юм бол угаасаа бүтэхгүй.

Цэдэнбал Филатова гуай шиг яг хүүхдийн төлөө зүрх сэтгэлтэй дайчин ажилладаг тийм удирдагч энд хэрэгтэй байна.

Гишүүд байхгүй л байна гээд энэ агентлаг нь манлайлаад.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Санал хэллээ. Одоо Л.Энх-Амгалан сайд асуухгүй биз. Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууна. Нэрээ татсанд баярлалаа.

**Г.Ганболд:** Нийгэм их эмзэг болжээ.

Мэдээлэл их ил цагаан болсон. Тэгээд хүүхэдтэй холбоотой асуудал гарангуут ар гэрээс нь, тухайн хохирогчдоос ч зөвшөөрөл авалгүйгээр нийгмээрээ шуурдаг. Түүнийх нь дагуу араас нь бид яарч бачимдаад Эрүүгийн хуулиа чангатгадаг. Эсвэл нэг салбарын хууль оруулж ирдэг. Тухайн чиглэлийн.

Хууль орж ирэхээрээ яаж байна гэхээр мөнгө дутаж байна гээд төсөв нэмэх, орон тоо бага байна гээд орон тоо нэмэх, эсвэл орон нутаг муу ажиллаж байна гээд томилгоог нь босоо болгох ийм л юмнууд л явдаг болж байна шүү дээ. Ер нь одоо.

Бид төсөв нэмээд өгье. Орон тоог нь нэмье. Яг гарц шийдэл нь хаана байгаа юм гэхээр энэ хууль дээр ерөөсөө гарц шийдэл гээд байх юм бараг байхгүй.

Одоо өнөөдөр энэ хуулийн төслийг энэ төр боловсруулж орж ирсэн юм уу, төрийн бус байгууллагууд боловсруулж орж ирсэн юм уу?

Ихэнхэд нь баахан төрийн бус байгууллагууд орж ирээд л энэ засгийн тогтолцоо буруу байснаас, сайд нар нь тогтворгүй байснаас болсон ухааны юм яриад сууж байж болохгүй шүү дээ.

Ер нь энэ хүүхдийн эрх аль салбарууд дээр их зөрчигдөж байгаа юм. Энэ утгаар нь ярих юм бол одоо энэ хуулийг орж ирсэн дээр салбарын хуулиуд дээр тухайн салбаруудын сайд, агентлаг, тухайн салбарынхны хариуцлагыг нэмэгдүүлэх ёстой байхгүй юу.

Зам, тээврийн салбар дээр хэдэн хүүхэд эрсдэлд орсон юм. Энэ нь эсвэл замын нөхцөл байдлаас болоод, замын эвдрэл хэмхрэлээс болж хэчнээн хүүхэд зөрчигдсөн юм.

Эсвэл сургуулийн орчинд энэ тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, ийм нөхцөлүүдээс болоод хэчнээн хүүхэд эрсдэлд орсон юм.

Тэгэх юм бол тухайн салбарынхан хариуцлага хүлээх ёстой шүү дээ. Зам, тээврийн яам. Бусад агентлагууд нь энэ дээр.

Хүүхэд замын орчин, нөхцөлөөс болж эрсдэлд орохгүй байх нөхцөлийг тэд нар бүрдүүлэх ёстой. Эсвэл эрчим хүчний чиглэлээр ил задгай, энэ тог цахилгааны утаснаас болоод юм уу, энэ трансформатор, янз бусын асуудлаас болж хэчнээн хүүхэд эрсэдсэн юм.

Тэгэх юм бол энэ чиглэлийн холбогдох яам, салбарын хуульд нэлээн чангалж өгч энэ хүмүүс чинь тухайн жилдээ хүүхэд эрсдэхгүй байх тэр орчин, нөхцөлийг бүрдүүлж өгөх ёстой шүү дээ.

Байгаль орчны сайд нь энэ угаар, агаарын бохирдлоос болж хэчнээн хүүхэд эрсдэж байгаа юм. Тэгвэл энэ чиглэлийнхээ хуулийг бид чангалж өгөх ёстой байхгүй юу.

Н.Учрал сайд байна. Цахим орчинд хамгийн их эрсдэл үүсэж байгаа гэж би ингэж ойлгоод байгаа юм.

Цахим гадуурхалт гэдэг юм сургуулийн орчинд асар их байна. Бид цахим орчинд хүний эрхийг хамгаалах хууль гэж оруулж ирээд нийгмийн шахалтаас болоод баталж чадаагүй.

Тэгвэл цахим орчин нь хүүхдийн эрхийг хамгаалах хуулийг заавал бид батлах ёстой шүү дээ.

Энэ орчинд чинь цахим гадуурхалт, дарамт шахалт, цахим дарамтаас болж амиа алдаж байгаа зүйл байна. Бэлгийн мөлжлөг асар их юм байгаа шүү дээ. Энэ хуурамч хаягаас

болж энэ хүүхдүүдтэй холбоотой асуудал орж ирсэн.

Тэгэхээр энэ чиглэлүүд рүү оруулах чиглэлээр энэ хууль дээр ямар заалтууд байна аа? Энэ чиглэлээр яг нарийн судалгаа гаргаад энэ салбарын хуулиуд дээр энэ хууль орж ирснээр дагуулж оруулж ирэх гэж байгаа зүйл ер нь яг юу байгаа юм бэ?

Энэ чиглэлээрээ тодорхой хариултууд авмаар байна.

Тэгээд бид хууль орж ирэнгүүт ер нь нэг жаахан нэг төсөв угаасаа та нарын ярьж байгаа төсөв бол орон нутгийн түвшинд бас харьцангуй хангалттай. Энэ орон нутгийн хөгжлийн сангийн чинь бараг 80, 90 хувь нь л хүүхдийн орчныг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт хангалттай байдаг байхгүй юу.

Харин тэрний оронд энэ сургуулийн орчинд эрсдэлд орж байгаа хүүхдүүд, энэ сургуулийн орчинд энэ нийгмийн ажилтнуудыг, сэтгэл зүйчдийг ажиллуулах тал дээр энэ хууль дээр бүр нэлээн том.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Н.Учрал сайд хариулъя.

**Н.Учрал:** Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын судалгааг би өмнө нь бас хэлсэн.

Тэгээд олон нийтэд хэлж болзошгүй хэмжээнд хүрсэн байгаа. Зөвхөн зүгээр нэг энгийн жишээ хэлбэл 2023 оны 9 дүгээр сард зөвхөн цагдаагийн байгууллагаас энэ цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн тоо 7042 болсон юм билээ.

Энэ тоо 2018 онд 659 л байсан. Ерөөсөө 4, 5 жилийн өмнө. Эндээс бүртгэгдсэн гэмт хэргийн зүйл ангиар нь аваад үзвэл хүүхдэд цахим орчинд садар самууныг сурталчилж уруу татах гэсэн гэмт хэрэг 2023 онд 68 бүртгэгдсэн байгаа. Тэгээд шийдэгдсэн гээд.

Ерөөсөө энэ тоо ийм хэмжээнд хүрсэн.

Тэгэхээр бид анхаарах ёстой юу гэвэл ёстой. Гэхдээ өмнө нь тэр олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хууль орж ирээд энэ хууль бас цаг үеэ олоогүй.

Дээрээс нь яах вэ хэлэлцэх процедурын хувьд бас олон нийтийн хэлэлцүүлэг хийх, олон төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, шүүмжийг сонсох гээд процедуруудын алдаа гаргасан байх гэж дүгнэлтэд хүрсэн.

Гэхдээ энэ хуулийг ирээдүйд ирээдүйд цаг хугацаа өөрөө төрүүлэн гаргана гэдэгт би итгэлтэй байгаа.

Тийм учраас үүнийг хэн нэгэн шаардахаас илүү цаг хугацаа нь болохоор цаг хугацаа өөрөө шаардаж энэ хуулийг хэлэлцэж батлах байх.

Бидний энэ удаагийн парламент биш болов уу гэж би бодож байна.

Харин бид ямар аргаар энэ цахим орчинд гэмт хэрэгтэй тэмцэх юм бэ гэдгийг Засгийн газрын зүгээс холбогдох эрхэлсэн асуудлынхаа хүрээнд сайд нар чиглэл чиглэлээр хариуцаад л ажиллачихад үр дүн гарна гэвэл гарна.

Жишээ нь, би бол Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хувиар ингээд өөрийнхөө хэмжээнд л би тэр байгаа 1.6 сая хэрэглэгчтэй аппликэйшн дээр **e-kids**-ийг оруулаад л, **Google**-тэй харилцаагаараа хүүхдүүдийн интернэтэд яаж эцэг, эхчүүд хязгаарлахыг нь явуулаад л. Энэ тоон бичиг, үсгийн чадварыг нь суулгах ажил дээр нь, соён гэгээрүүлэх ажлыг нь Л.Энх-Амгалан сайдтай хамтарч ажиллаад л, хариуцаад л.

Ингээд л цагдаагийн байгууллага руу хүүхдүүд цахим орчинд янз бүрийн садар самуун, ууруу татсан янз бүрийн мэдээ, мэдээлэл ирэх юм бол тэр мэдээллүүдийг нь наад **e-mongolia**-ынхоо аппликэйшнээр дамжуулаад л нэг ганцхан кноп дараад л цагдаа руу мэдээлчихдэг. Цагдаа нь хариу арга хэмжээг нь авчихдаг. Харилцаа холбоон Зохицуулах Хороо өнөөдөр тэр тавигдах шаардлага, өргөн нэвтрүүлгийн журмаа бариад л ажиллачихдаг. Гэр бүл, хүүхэд залуучуудын газар нь чиглэл чиглэлээрээ ажиллачихдаг болбол үүнийг зохих хэмжээнд шийдэж чадна гэвэл чадна.

**С.Одонтуяа:** 81 нэмж хариулья.

**С.Зулзахар:** Улсын Их Хурлын гишүүн ГГанболдын асуултад хариулья.

Нэгдүгээр асуулт. Энэ хуулийг төрийн бус байгууллагууд боловсруулсан уу, төр өөрөө боловсруулсан уу гэж.

Хууль боловсруулахад энэ хуулийн хүрээнд бидний авч үзэж байгаа асуудалд хамаарал бүхий талуудыг бүгдийг нь оролцуулсан байдлаар хууль боловсруулах ийм практик бидэнд нэвтрээд тодорхой хугацаа болж байна.



Энэ үүднээс гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр мэргэшсэн олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудыг энэ хууль боловсруулах үйл ажиллагаанд татан оролцуулсан гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй байх.

Хуулийн үзэл баримтлал 2021 оны 9 сард батлагдсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын.

Тэгэхээр энэ хууль бол өнгөрсөн хугацаанд бас тодорхой түвшинд хэлэлцэгдээд, саналууд авагдаад явж байгаа хууль гэдгийг энд онцольё.

Та бас их чухал зүйлийг ярьж байна.

Энэ дан ганц гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг биш. Орон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэг биш. Бусад бүх байгууллагууд оролцох ёстой гэж.

Хуулийн энэ удаагийн үзэл санаа, хуулийн өөрийнх нь бүтэц нь хуульд тусгасан тодорхой зохицуулалтууд, харилцааг зохицуулсан заалтууд яг одоо үүнийг тухайлан авч үзэж байгаа гэдгийг хэлье.

Нэн ялангуяа орон нутгийн түвшинд хурлаас баталдаг төсвүүд байдаг. Энэ төсвүүдээр урьд нь ч гэсэн хүүхэд хамгааллын чиглэлээр тодорхой төсвүүд батлагдаж байсан.

Сургуультай холбоотой, гудамжны гэрэлтүүлэгтэй холбоотой гэдэг ч юм уу.

Үүнийг энд бас тухайлан заахаас гадна бусад байгууллагууд дээр, боловсролын байгууллага өөр дээрээ бас тодорхой хүүхэд хамгааллын төсвөө батлуулаад, тэгээд тэр дагуу арга хэмжээ авдаг ийм байдал руу оруулж байгаа.

Эрүүл мэндийн байгууллагуудаар бас энэ заалтыг оруулж өгсөн.

Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаан дээр бас үүнийг оруулж өгснөөр энэ их процедурын ийм нарийн зохицуулалттай хууль болсон гэдгийг хэлье.

Өнөөдөр ярьж байгаа 8 тэрбум буюу хүүхэд хамгааллын зардал дан ганц эрсдэлт нөхцөлд орсон, орж болзошгүй хүүхдүүддээ бидний шууд хариу үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Г.Ганболд гишүүн тодруулъя. 1 минут.

**Г.Ганболд:** Б.Энхбаяр сайдаас асуулт асууна.

Бид ганц нэг эмзэг асуудал гарангуут нийгмээрээ шуурч байгаад л Эрүүгийн хууль оруулж ирээд байгаа л даа. Гэтэл сая Н.Учрал сайдын хэлж байгаагаар зөвхөн 2023 оны эхний 9 сарын байдлаар 7042 цахим гэмт хэрэг үйлдэгдсэн байна шүү дээ. Энэ ноцтой биш үү? Үүнийг яг ямар түвшинд гэж үзэж байна аа?

Хэрэв тийм бол үүнийг чинь жинхэнэ оруулж ирэх ёстой юм биш үү? Гэтэл одоо цаг нь арай биш, бид арай чадахгүй байх гээд ингээд сууж байгаа нь надад харамсалтай байна л даа. Энэ дээр нэг Б.Энхбаяр сайд нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь, түрүүн хэлсэн нэг хүүхдийн асуудал, ингээд л гэмт хэргийн асуудал гарангуут эцэг эх, ар гэрээс нь зөвшөөрөл авахгүй цахим орчинд уралдаад мэдээлдэг.

Үүнээс болоод тухайн гэр бүлийн, хүүхдийн ирээдүйн хувь заяа, нэр хүнд асар их хор хохиролтой. Энэ дээр хариуцлагын яг ямар заалтууд байна аа? Энэ дээр.

**С.Одонтуяа:** Б.Энхбаяр сайд хариулах вэ?

**Б.Энхбаяр:** Г.Ганболд гишүүний асуулт танд хариулья.

Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн гаралт хамгийн өндөр өсөлттэй байгаа гэмт хэргийн нэг болсон байна.

Энд эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг өөрчлөх гэхээс гадна байгууллага хоорондын харилцан уялдаа холбоог сайжруулах, журмаар зохицуулах шинжтэй бас нэлээн асуудлууд байна.

Яг хуулийн хүрээнд хэд хэдэн асуудлууд шийдэх шаардлагатай байна.

Нэгдүгээрт, Улсын Их Хурлаас Хувь хүний мэдээллийн тухай хуулийг баталсан. Хувь хүний мэдээллийн тухай хуулиар өөрийнх нь зөвшөөрлөөр тухайн хуулийн байгууллагууд, банк, санхүүгийн байгууллагууд, цахим орчинд үүрэн телефоны операторууд бас энэ асуудлыг шалгах дээр манай цагдаагийн байгууллага дээр энэ заалт саад учруулж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Тийм учраас энэ дээр зарим энэ гэмт хэргийг илрүүлэх, шалгахтай холбоотой хуулийн өөрчлөлтүүд өргөн баригдана.

Мөнгө угаах, терроризмтой тэмцэх цахим орчин гэсэн энэ чиглэлд хуулийн төслийг боловсруулж байгаа. Хуулийн төслийг боловсруулж байгаа.

Ер нь ялангуяа залилан, хүүхдийн эсрэг гэсэн энэ хоёр төрлийн гэмт хэрэг цахим орчинд маш богино хугацаанд өсөлттэй явж байна.

Тийм учраас үүнийг банк, санхүүгийн байгууллагуудтай ярьж тогтоох асуудал бас байна.

Ер нь тодорхой гадаад улсын бас энэ.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Гүйцээгээд хариулья. Б.Энхбаяр сайд.

**Б.Энхбаяр:** Гадаад улс оронд байгаа үйл ажиллагаа явуулж байгаа, тэгээд Монгол Улсад бас агент хэлбэрээр энэ асуудлыг зохион байгуулдаг тийм зохион байгуулалттай бүлэглэл байгаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллагад Кибер аюулгүй байдлын газрыг өргөтгөж зохион байгуулна гэсэн бодолтой байгаа. Бүтцийн өөрчлөлт хийгдэж.

Хоёрдугаарт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албыг би түрүүн хэлсэн. Бүтцийг мөн өөрчлөлт хийгдэж тэргүүн зэрэгт тавих ийм хоёр өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байгаа гэдгийг танд хэлье.

Ялын бодлогын хувьд Их Хурлын гишүүд бас энэ хуулийн төслийг өргөн баривал гэдэг бодлоор хуулийн төслийн бичилт үзэл баримтлалыг хийгээд явж байгаа гэдгийг танд хэлье.

**С.Одонтуяа:** Х.Булгантуяа сайд нэмж хариулъя.

**Х.Булгантуяа:** Г.Ганболд гишүүн их чухал асуудал тавьж байна.

Одоо хүүхдийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, эсвэл хүүхэд, түүний хууль, ёсны, төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр хүүхдийн хувийн болон эмзэг мэдээлэл, зураг, дүрс, дуу авиа, хэн болохыг нь тогтоох боломжтой бусад мэдээллийг агуулсан контентыг бүтээх, түгээхийг хориглоно гэж оруулж өгсөн байгаа.

Жишээлбэл, эцэг эхийн зөвшөөрөлгүйгээр нь саяын хүүхдийн хамаг мэдээллийг нь тавиад тэр хүүхэд олдсон яах вэ?

Дараа нь тэр хүүхэд бараг энэ Монголын нийгэмд ер нь амьдрахад их хэцүү болтол нь л амьдралыг нь ухлаа шүү дээ. Өмнөх амьдрал, ар гэр ерөөсөө.

Тэгэхээр эцэг, эхийн зөвшөөрөлгүйгээр үүнийг тавьдаггүй, түгээхийг хориглодог зүйл, заалтууд орсон.

Том хүмүүс бид өөрсдийнхөө асуудал дараагийн асуудал байх. Тэгэхдээ үүнийг ингэж хуульчилж өгөх нь зөв зүйтэй. Гэхдээ энэ хууль ганцхан батлагдсанаар эрсдэлд байгаа хүүхдүүдэд бид хяналт тавих, эрсдэлд орсон хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэх энэ

тогтолцоо, боломж бололцоо л арай сайжирна.

Түүнээс биш Монголын нийгэм өнөөдөр хүүхдэд битгий хэл том хүнд ээлгүй байгаа ийм нийгэмд нэг хууль батлагдаад хүүхдийн эрх 100 хувь хангагдана гэж ерөөсөө байхгүй.

Ядуурал буурах хэрэгтэй, ажилгүйдэл буурах хэрэгтэй, архидалт буурах хэрэгтэй, нийгмийн сэтгэл зүй арай нэг тайван амгалан болох хэрэгтэй. Эцэг, эхчүүд бид улам хариуцлагатай болох хэрэгтэй.

Өнөөдөр хот төлөвлөлт хүртэл энэ хүүхдэд ээлтэй хэлж чадаагүй байгаа цагт хүүхэд гэрээсээ гараад л явган хүний зам байхгүй. Машин замын хажуу тал нь гэрэлтүүлэг байхгүй, камержуулалт байхгүй. Сургуулийн эргэн тойрон нь бараг машинд ээлтэй, байшинд ээлтэй хот болчихсон байгаа цагт хүүхэд осол аваарт орох, эрх нь зөрчигдөх ийм нөхцөл байдал дүүрэн байна

Тэгэхээр үүнийгээ давхар сайжруулах хэрэгтэй. Тэгэхдээ бид одоо өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гээд суугаад байх биш. Хаа нэгэн газраас барьж аваад л хийх эрхтэй.

Тэгээд энэ бол одоо ямар ч байсан хүүхдийн төлөө ажиллаж байгаа энэ төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байна гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан.

**С.Одонтуяа:** Одоо Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуултаа асууна.

**Ш.Адьяа:** Хүүхэд хамгааллын тухай хууль өнөөдөр орж ирж Улсын Их Хурал дээр хэлэлцэх гэж байна л даа.

Энэ их эргэлзээ төрүүлсэн хууль оруулж ирж байна. Хүүхэд хамгааллын асуудал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам хоёр чинь хоёр толгойтой тийм могой шиг юм байгаа юм уу, ямар учиртай юм.

Тэгээд дээр нь энэ хуулийн үзэл баримтлалын талаар энэ хариулт гайхлыг төрүүлж байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүүхдийн байгууллагын ажилтан гээд нэг хүн энэ Монгол Улсын Засгийн газрын өмнөөс тайлбар тавиад байх юм. Засгийн газрын өмнөөс.

Энэ яам нь, агентлаг нь, энэ хуулийн төслийг боловсруулсан төрийн албан хаагчид юмаа мэдэхгүй байна уу, аль эсвэл хариулахыг хүсэхгүй байна уу?

Би сая нэлээн ажиглаж суулаа. Ийм хариуцлагагүй байж болдог юм уу.

Тэгээд энэ тогтолцооны өөрчлөлт гэдэг юм яриад байна. Энэ хуулийн төсөл чинь шийдэл гаргаж оруулж ирэх ёстой шүү дээ. Ямар нэгэн шийдэл байхгүй байна. Хариулж байгаа хүмүүс нь тэгэх ёстой, ингэх ёстой, ингэх ёстой л гэдэг ийм лоозонгийн шинж чанартай юм яриад байна. Яг ямар шийдэл байгаа юм.

Төсөв дагуулж оруулж ирсэн гэж байгаа. Энд төсөв дагуулж оруулж ирж энэ хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдээд, энэ шийдлийн үндсэн дээр ийм гажуудлыг, ийм сайн зүйлийг дэмжинэ, ийм буруу зүйлийг хаана гэдэг ийм бодлогоо оруулж ир л дээ.

Боловсрол, шинжлэх ухааны яам бас тодорхой асуудлыг хийсэн шүү дээ. Боловсролын 30 жилийн тогтолцооны шинэчлэлийг хийсэн гэж ойлгож байгаа.

Зүрх сэтгэлийн боловсрол гэдэг энэ хүүхдийн төлөвшлийн асуудал дээр, түүнчлэн сургууль бүхэн тэр сэтгэл зүйчтэй байлгах дээр Л.Энх-Амгалан сайд бас хичээл зүтгэлтэй ажилласан шүү.

Боловсролын яамтайгаа энэ хоёр яам нь хамтраад үүнийг оруулж ирэхгүй яасан юм бэ. Хоёр өөр ойлголт өгөөд байна энэ дээр бол. Ингэж бид явах юм бол Хүүхдийн тухай хуулийг, Хүүхэд хамгааллын тухай хуулийг ерөөсөө хэлэлцэх арга байхгүй л юм шиг надад бодогдоод байх юм.

Тэгээд энэ дээр хөрөнгө, санхүүгийн асуудал гээд юмыг нь шийддэг юм байна. Ирээдүйн өв сангаас хэдэн төгрөг энд зарцуулах юм, юунд зарцуулах юм гэдэг асуудал чинь тодорхойгүй байна.

Дээр нь би Х.Булгантуяа сайдаас нэг асуудал асууя. Хүүхдийн фондын мөнгө гээд л хэдэн тэрбум төгрөг цугларсан энэ тэр гээд л хоёр, гурван жилийн өмнө л асуудал болж байсан. Энэ чинь яг цугларсан юм уу? Энэ мөнгө нь хаана байгаа юм?

Тэгээд одоо энэ улсын төсөв дээр хаанаас ямар эх үүсвэрээр энэ хүүхэд хамгаалалтай холбоотой төрийн байгууллага үйл ажиллагааг яаж санхүүжүүлэх юм, энд иргэд яаж оролцох юм, эцэг, эхчүүд яаж оролцох юм, олон нийтийн байгууллагууд яаж оролцох юм гэдэг энэ тодорхой үзэл баримтлал байх

ёстой шүү дээ. Тодорхой бодлого байх ёстой.

Түүнчлэн өнөөдөр энэ гэр бүлийн хүрээнд, сургуулийн орчинд хүүхдийн хүчирхийллийн асуудал, ухаалаг гар утас, цахим технологитой харьцах энэ асуудлыг яаж зохицуулах юм, ямар хязгаарлалт хийх юм. Үүний үр дүнг хэн тооцох юм, яах юм. Энд эцэг, эхчүүдийн үүрэг ямар байх ёстой юм, багш сурган хүмүүжүүлэх үүрэг ямар байх ёстой юм, төрийн байгууллага ямар байх ёстой юм, хууль хүчний байгууллага ямар байх ёстой юм. Үүнийг тодорхой нэг бүрчлэн үүрэг хариуцлагатай нь, эрх үүрэгтэй нь боловсруулж байж энэ хуулийг Улсын Их Хурлыг хэлэлцэх ёстой гэж бодож байгаа.

Үзэл баримтлалын хувьд, бодлогын хувьд үнэхээр л болохгүй байна даа.

**С.Одонтуяа:** Х.Булгантуяа сайд хариулах юм уу? Х.Булгантуяа сайд хариулъя.

**Х.Булгантуяа:** Ш.Адъяаа гишүүн хоёр, гурван цаг бараг бид танилцуулга хийж тайлбар ярилаа.

Уг нь таны ярьсан бүх зүйлүүд зөв өө. Бүгдээрээ орсон.

Гэр бүл дэх хүүхэд хамгаалал 3.1 дүгээр зүйл, боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал 3.2 дугаар дугаар зүйл, 3.3 дугаар зүйл эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал, хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал, олон нийтийн арга хэмжээ үйлчилгээ дэх хүүхэд хамгаалал, соёл, спортын үйл ажиллагаан дахь хүүхэд хамгаалал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгаалал, хүүхэд хамгааллын үйлчилгээ, салбар болгон хүүхэд хамгааллын бодлоготой байх гэх мэтчилэн эд нар уг нь бүгдээрээ орсон юм.

Одоо яах вэ, би хүүхэд хамгааллын нарийн мэргэжилтэй хүн биш ээ.

Та өнөөдөө яагаад энэ төрийн бус байгууллагууд сууж байгаа юм гэхээр үнэнийг хэлэхэд энэ хууль энэ тогтолцоо бий болоод Монголд 8-хан жил болж байгаа юм.

Бид олон улсын, дээрээс нь нэмээд яг энэ дээр анхан шат дээр нь гал дээр нь ажиллаж байгаа төрийн бус байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллага гээд эдгээр байгууллагуудтай дандаа хамтарч ажиллаж байсан.

2016 онд энэ хуулийг анх батлахад ч гэсэн оролцож байсан. Тухайн үед 11 тэрбум төгрөгийн төсөв. 2016 онд шүү. Шаардлагатай гэж байсан. Одоо хүртэл 11 тэрбум төгрөгтэй бид хүрч үзээгүй.

Тэгэхдээ мэдээж таны хэлж байгаа нэг зүйл үнэн. Үүнийг ганцхан батлаад хүүхдийн эрх бүрэн хангагдахгүй.

Гэхдээ ядаж бид эрсдэлд байгаа хүүхдүүд дээрээ арай илүү очиж ажиллаж чаддаг, эрсдэлд орсон, эрх нь зөрчигдсөн хүүхдүүддээ арай илүү хүрч ажиллаж чаддаг тийм тогтолцоотой, боловсон хүчинтэй, төсөв санхүүтэй болох юм сан л гэж байгаа юм.

Түүнээс түр хамгаалах байранд сэтгэл гутралын, дээрээс нь нэмээд бие махбодын өчнөөн эрсдэл, хүнд нөхцөлд

орчхоод очиход хоол нь хүрэхгүй, байр нь хүрэлцэхгүй.

Ахиад манай ихэнх түр хамгаалах байрууд орон нутагт гурав, дөрөвхөн өрөө байдаг. Дүүргүүдээс зарим нь арай гайгүй, зарим нь их хэцүү. Тэгээд эрэгтэй хүнд хүчирхийлүүлээд очиход тэнд ахиад бараг эрэгтэй хүнтэй хажуухан талынх нь өрөөнд нь хүртэл байж байгаа газрууд байгаа.

Тэгэхээр үүнийг л сайжруулъя гэж оруулж ирж байгаа юм. Тэгээд яах вэ, бид энэ байтугай мөнгийг арьс ширний урамшуулалд, ноос ноолуурын урамшуулал жилд баталдаг юм даа. Би төсөв, санхүүгийн асуудал эрхэлж байсан хүн мэднэ шүү дээ.

Бид 20 тэрбум орчим төгрөгийг жишээлбэл ноос, ноолуурын урамшуулалд зарцуулдаг. Арьс ширэнд бас хүүхэд хамгааллын дайтай мөнгө зарцуулж байгаа.

Тэгээд Улсын Их Хурал аль нь тэгээд чухал гэж үзэж байгаа юм. Арьс ширний урамшуулалтай адилхан түвшинд авч үзэх юм уу, үгүй юм уу.

Тэгээд энэ бол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал шүү дээ. Ямар ч байсан Нэгдсэн Үндэстний Байгууллага, мэргэжлийн төрийн бус байгууллагууд, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачуудтайгаа хамтдаа бид салбарын яам болгон тэгж боловсруулж өргөн барьдаг.

Ажлын хэсгийнхээ гишүүдийг Улсын Их Хурал дээр хамтдаа оролцуулаад танилцуулдаг. Салбар салбарынхаа өөрийнхөө туршлагаас ярьдаг.

Сая Б.Баярсайхан гишүүн өөрөө тусгайлан асуусан юм. Энэ юу гэж үзэж байгаа юм бэ төрийн бус байгууллага гээд тэгээд хариулж байгаа юм.

**С.Одонтуяа:** Ш.Адьяаа гишүүн тодруулъя. 1 минут.

**Ш.Адьяаа:** Яах вэ, тэр олон улсын байгууллагын туршлагыг, тэдний зааврыг авахыг үгүйсгэхгүй. Энэ байдаг л асуудал.

Бид олон улсын бөгөөд энэ гаднын туршлага гэдэг энэ дээр л тулгуурласаар байгаад л энэ 30 жил чинь ингээд л дампуурлаа шүү дээ. Гаднын заавраар явдаг, гаднын бодлогоор явдаг, гаднын юмыг хуулбарладаг. Энэ үр дүнгээ өгсөн юм уу? Өгөөгүй шүү дээ. Хаана ч өгөөгүй байгаа. Ялангуяа боловсролын системээ бид бүр устгасан шүү дээ.

Тэгээд одоо өнөөдөр энэ хүүхэд хамгааллын асуудлаар гаднын ийм сайн, муу зүйл байгаа гэж ингэхээс илүү монгол ахуйгаа, хүн байхын утга учир, монгол хүн байхын утга учир, тэр зүрх сэтгэлийн боловсрол дээр төр бодлогоо явуулах ёстой л гэж бодож байгаа.

Гаднынхныг дуурайж болно, тэдний туршлагыг авч болно. Үүнийг үгүйсгэхгүй.

**С.Одонтуяа:** Одоо Буланы Бейсен гишүүн асуултаа асууна.

**Б.Бейсен:** Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй танилцлаа л даа.

Өнөөдөр бид ярьж байна. Хүүхдийн эрх үнэхээр зөрчигдөж байна. Түрүүчийн Байнгын хорооны хурал дээр би бас хэлсэн.

Орон тоо нэмээд нэг орон тоо батлуулснаар ажил сайжирчихгүй байх. Гол нь хүүхэд, гэр бүлийн газар, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, цагдаагийн байгууллага эд нар хамтарч ажиллаж байж ажлаа сайжруулах ёстой л доо.

Ер нь ажил хийхгүй байна. Үүнийг сайжруулах талаар бас тусгах хэрэгтэй. Энэ дээр. Хэрвээ ажил хийхгүй бол ямар хариуцлага хүлээлгэх юм. Сургуулиуд дээр сургуулийн хүмүүжлээр гэсэн эрхлэгч гээд байна шүү дээ. Зарим юун дээр орлогч захирал гээд тавьчихсан сургуулиуд ч байж байгаа.

Тийм учраас энэ асуудал дээр нэлээн анхаарах шаардлагатай.

Хэдэн жилийн өмнө жишээлбэл нэг сургуулийн хүүхдэд бэлгийн дарамт үзүүлээд, авч яваад тэгээд алчихсан тохиолдол байсан шүү дээ. Гэтэл тухайн байрны хүмүүжүүлэгч гээд байна, захирал гэж байна. Эд нар юу хийж байсан юм.

Би түрүүн бас ярьсан. Өлгийд даац хэтрүүлэн ачаа ачиж байгаад айлыг мөргөөд л тэгээд л аав, ээж нь нас барсан хүүхдийн эрх нь зөрчигдсөн. Гэтэл хуулийн байгууллага нь үүнийг хяналтад авахгүй хилээр гараад Казахстан руу зугтсан асуудал гарсан.

Зун талбайд хийлдэг тоглоом тавьж байгаад тэнд аваар осол гараад арваад хүүхэд гэмтээд, нэг нь нас барсан. Нэг нь бүр гадаадад эмчлүүлсэн. Үүнийг

бүр ар гэр нь хилээр гарах гэж байна. Та нар барь гэж байхад бас л барихгүй явуулаад ингээд юу гарсан.

Ийм ийм юман дээр хамтарч ажиллаад яахгүй бол цаана нь хүүхдийн эрх зөрчигдөж байна. Үүнтэй холбоотой хэд хэдэн асуудал тавья гэж бодож байна.

Эрүүл мэндийн яамнаас хүүхдийн эмчийн хангалт хэр байна вэ? Эмч байхгүй. Хүүхдийн эмчид үзүүлж чадахгүй л байна шүү дээ. Энэ талаар ямар бодлого баримталж байна?

Сумууд дээр 330 сум дээр хэчнээн хүүхдийн эмч байна. Охидын эмч бүх аймаг болгонд ажиллаж байна уу, охидын сувилагч ажиллаж байна уу? Хэчнээн байна?

Сэтгэцийн эмч, сэтгэл судлаач цаг нь 400-аас 500 мянган гэж байна. Энэ арай ч дээ. Дэндэж байна шүү дээ.

Энд Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний төв, Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн Сэтгэцийн тасаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны сэтгэл судлалын тэнхим энд хамтарч ажиллаад энэ мэргэжилтнийг бэлтгэх шаардлагатай байна. Энэ талаар баримталж байгаа бодлого байна уу?

Сургуулийн насны хүүхдийн жирэмслэлт байж байна. Үүнийг аймаг, суман дээр заримдаа ажлыг нь дүгнүүлэхэд хойш нь татна гээд үүнийгээ нуун далдалдаг.

Хэдэн жилийн өмнө энэ бас гарч байсан. Байрны хүмүүжүүлэгч нь жирэмслүүлдэг ийм асуудал байгаа л даа. Ийм улсууд дээр энэ хуулийн төсөл

туссан уу? Одоо ямар хариуцлага хүлээлгэх вэ? Энэ талаар ерөөсөө тусгаагүй байна.

Дараагийн асуудал. Эрүүл мэндийн даатгалын асуудал байна л даа.

Өвчтэй хүүхдүүдийг гадаадад эмчлэхэд даатгал хоорондоо улсуудтай гэрээ хийх шаардлагатай байгаа юм. Тэгвэл зөвхөн даатгалын мөнгө төлнө. Аав, ээж нь хүнд тусгах асуудлууд байна.

**С.Одонтуяа:** Нэн хариулах вэ? Эрүүл мэндийн яам. Байна уу? Тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал билүү. Тийм ээ. 86.

**А.Өнөржаргал:** Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

КОВИД-той холбоотойгоор, мөн өмнө нь ч гэсэн манай Монгол Улсад хүүхдийн эмчийг бэлтгэх тогтолцоо ер нь байхгүй. Алдагдсан.

Өмнө нь Оросын Холбооны Улсад нэлээн олон тоогоор хүүхдийн эмчийг бэлтгэдэг байсан. Одоо бол ер нь байхгүй болоод сүүлийн үед хөдөө орон нутагт ч тэр, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ч тэр хүүхдийн эмнэлгийн эмчийн тоо үнэхээр хүртээмжгүй болж эхэлсэн.

Ингээд одоо Анагаахын шинжлэх ухааны их сургуулиуд дээр хүүхдийн эмчийг бэлтгэх үйл ажиллагаанууд хийгдээд явж байгаа

Дараагийн асуудал нь, Эрүүл мэндийн сайдын тушаалаар охид, өсвөр үеийнхэнд тусламж үйлчилгээг хүргэх аргачлалуудыг батлаад явдаг.

Сайдын тушаалаар нярай үе, хүүхэд үе, бэлгийн бойжилтын үе гээд чиглэсэн ийм тусламж үйлчилгээнүүдийг хүргээд явж байгаа.

Таны хэлээд байгаа мансууруулах бодист өртдөг энэ сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалд өртдөг гээд ингэж байгаа. Энэ мөн адилхан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс бүх аймаг, орон нутагтаа сэтгэцийн эмч нарыг бүрэн орон тоогоор ажиллуулах, тэдгээрийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах гээд арга хэмжээнүүдийг бүгдийг нь аваад явж байгаа.

Түрүүн Х.Булгантуяа сайд хэлж байсан. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр дээр мөнгө тавья, санхүүжилт тавья гэхээр зэрэг хөтөлбөр нь дуусчихсан гэдэг. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуультай уялдаад явж байгаа. Гэсэн хэдий ч манай салбараас сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой бүх асуудлуудыг эмчээр тасалдахгүй байх, тусламж үйлчилгээгээ үзүүлэх, сургалт сурталчилгаагаа хийх ажлуудыг бүрэн утгаараа хийгээд явж байгаа.

Ер нь яг тэр охидын үр хөндөлт бол нэмэгдэж байгаа.

**С.Одонтуяа:** Б.Бейсен гишүүн тодруулъя. 1 минут.

**Б.Бейсен:** Би эмч хүн учраас асууж байна л даа. Энэ талаар тодорхой мэдлэгтэй болохоор.

Сэтгэцийн эрүүл мэндийн төсвийн хүүхдийн тасагт хорт бодисын донтолт, **Facebook**-ийн донтолттой хэчнээн хүүхэд эмчлүүлж байна?



Энэ талаар энэ хуулийн төсөл боловсруулалт танаас санал авсан уу? Энэ хуулийн төслийг яаж оруулах вэ? Энэ дээр.

Дараа нь, сая даатгал хоорондын гэрээ. Би гурван жил ярьж байна. Ард иргэд ихээр хохирч байна. Гадагшаа явж мөнгө алдаж байна. Энэ дээр даатгал хооронд гэрээ хийх үү? Турк юм уу, Солонгос их явж байна шүү дээ. Хятад. Даатгал хооронд гэрээ хийвэл ард түмэнд хөнгөн тусах юм.

Нөгөө талаар Эрүүл мэндийн яамны гадаадад эмчлүүлбэл хүүхдэд 5 сая төгрөгийн тэтгэмж өгдөг гэсэн. 2022 онд хүүхдэд хэчнээнийг өгсөн. 2023 онд хэчнээнийг өгч байна. Энэ талаар тооцоо байна уу? Энэ ч арай л бага мөнгө. Энэ дээр яах вэ?

**С.Одонтуяа:** С.Чинзориг сайд хариулья.

**С.Чинзориг:** Б.Бейсен гишүүний асуулт хариулахад тэр 20 хүртэлх насны охидын жирэмслэлт, үр хөндөлт сүүлийн жилүүдэд дорвитой буурахгүй байгаа асуудлууд байгаа.

Тэр дээр бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яамтай хамтарч энэ охидын дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр өгөх ойлголт, сургалт, сурталчилгаатай холбоотой асуудал. Дээр нь эцэг, эхийн хараа хяналттай асуудал дээр нэлээн анхаарахгүй бол бас одоо тийм тодорхой тоонууд дорвитой буурахгүй байгаа асуудлууд байгаа юм.

Хамгийн сэтгэл эмзэглүүлэм нь 13-аас 17 насны охидын жирэмслэлтийн

асуудлууд, үр хөндөлтийн асуудлууд ч байгаа. Тийм учир хамтын ажиллагаа, ажиллах шаардлагууд байна.

Хоёрдугаарт, манай салбарт нэг тулгамдаж байгаа асуудал нь, Б.Бейсен гишүүн өөрөө эрүүл мэндийн салбараа маш сайн мэдэж байгаа байх.

Дотооддоо оношилж, эмчилж чадахгүй байгаа өвчнөөр гадагшаагаа зайлшгүй шаардлагын улмаас эмчилгээнд явж байгаа иргэдэд үзүүлж байгаа тусламж, дэмжлэг бол үндсэндээ ний нуугүй хэлэхэд байхгүй. Бага байна.

Би салбарынхандаа шүүмжлэлтэй хандаад байгаа юм. Эрүүл мэндийн сайд тушаал гаргаад бид дотооддоо эмчилж, оношилж чадахгүй байна гээд 26 нэр төрлийн өвчний жагсаалт гаргачихсан бол энэ өвчнөөр шаналж, өвчилж зовж байгаа иргэддээ үзүүлж байгаа туслалцаа дэмжлэг байхгүй байна гэдэг чинь бас маш буруу шүү дээ.

Ийм төр байж болохгүй л гээд байгаа юм.

Одоо зайлшгүй шаардлагаар дотоодод эмчилж чадахгүй байгаа өвчний улмаас гадагшаагаа эмчилгээнд яваад ирж байгаа иргэдэд явахад нь биш гадагшаагаа яваад эмчилгээнд яваад ирсэн хойно нь зардлынх нь 5-хан хувийг л өгч байгаа юм.

Өөрсдөө дотооддоо чадахгүй гэххэд тэгээд гадагшаагаа яваад эмчилгээнд яваад ирэхээр нь зардлынх нь 5 хувийг нь өгнө гэдэг маш.../минут дуусав/

**С.Одонтуяа:** С.Чинзориг сайд дуусгаж хариулья.

**С.Чинзориг:** Тэгээд энэ дээр бид нэлээн тийм бодлогын томоохон өөрчлөлт хийх шаардлагатай.

Би ирэх долоо хоногоос Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл оруулж ирж байгаа юм.

Манайд Эрүүл мэндийг дэмжих сан гээд энэ тусгай сангийн хуулиар зохицуулагдаж байгаа сан байна. Энэ санд нөгөө архи тамхины онцгой татвар 1-ээс 2 хувийн орлогоор нь орлого бүрдүүлэх ёстой.

Жилд 10-аас 12 орчим тэрбум төгрөг төвлөрөх ёстой юм билээ. Манайд жилд 2-хон тэрбум төгрөг өгдөг. Түүгээр нь бид юу хийж байна вэ гэхээр нийгэм эрүүл мэндийн чиглэлийн сургалт, сурталчилгаа хийсэн нэртэй ингээд л үр дүнгүй өнгөрчхөөд байгаа юм.

Тэгэхээр энэ хуульд өөрчлөлт оруулснаараа бид тэр дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнийг эмчлэх шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулах зардлыг энэ сангаас олгодог больё. Нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал нь дотооддоо оношилж эмчилж чадахгүй байгаа өвчнөөр зайлшгүй шаардлагын улмаас гадаадад эмчилгээнд явсан бол тэр эмчилгээний зардлынх нь 5 хувийг нь биш. Жаахан нэмэгдүүлэх, үе шаттайгаар нэмэгдүүлэх, тэр сангаас нь өгдөг байх ийм хууль өөрчлөлт оруулж байгаа юм.

Энэ хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор 2024 оны улсын төсөв дээр энэ жил 2 тэрбум төгрөг төсөвлөгдсөн бол 2024 онд 10 тэрбум

төгрөг болгож 5 дахин нэмэгдүүлж байгаа.

Энэ хүрээндээ шинэ технологи нэвтрүүлэх чиглэлээр, зайлшгүй шаардлагагүйн улмаас гадагшаагаа эмчилгээнд явсан иргэдэд олгосон эмчилгээний зардалд нь дэмжлэг үзүүлэх асуудлууд шийднэ гэж.

Би насанд хүрэгчдэд болоод хүүхдүүдэд тэр санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа хэмжээг нь ялгавартай тогтоож болох юм гэсэн бодолтой байгаа. Хүүхдүүдэд арай ахиу хувиар тэр зардлынх нь дэмжлэгийг нь үзүүлдэг болгоё гэсэн ийм чиглэлээр ирэх долоо хоногоос хуулийн төсөл оруулна.

Тэгээд үүнийг гишүүд маань дэмжээд явбал ахиц өөрчлөлт гарах болов уу гэж бодож байгаа.

**С.Одонтуяа:** Б.Бейсен гишүүн тодруулья.

**Б.Бейсен:** Монголд эмчлэхгүй өвчнүүдээр тухайн улс оронтой даатгал хооронд гэрээ хийвэл даатгалаа л төлдөг. Тухайн эмчлүүлж байгаа оронд тэнд даатгалаас мөнгөө олж авдаг юм байна л даа.

Энэ асуудал дээр Туркийнхан чинь гэрээ хийе гэж байгаа, Солонгостой бас яриад, Хятад, Солонгос, зарим нь Орос явж байгаа. Энэ дээр даатгал хооронд гэрээ хийчихвэл нөгөө 150, 100 мянган доллар төлөхгүй. Ард иргэдэд маш хөнгөн тусна. Энэ талын асуудал дээр хэзээ гэрээ хийх вэ? Би 3 жил ярьж байна. Үүнийг.

**С.Одонтуяа:** С.Чинзориг сайд хариулья.

**С.Чинзориг:** Тийм. Энэ асуудлыг бид нэлээн судалж бас ярьж байгаа юмнууд байгаа.

Бид удахгүй Туркийн Засгийн газартай эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулахаар яамдаас санал аваад явж байгаа.

Тэгээд Эрүүл мэндийн сайдад хэлэлцээрт гарын үсэг зурах эрх олгох ийм асуудал шийдэгдэнэ.

Энэ хүрээнд бас Туркийн эрүүл мэндийн салбартай хамтран ажиллах асуудлууд бас жаахан ахиц гарах болов уу гэж бодож байгаа.

Өмнөх Засгийн газрын хоорондын хэлэлцээрээр нийгмийн хамгааллын салбарт ч гэсэн ийм гэрээнүүд байдаг. Хэрэгжиж байгаа.

Гэхдээ нэг л онцлог байдаг шүү дээ. Тухайн улс оронд нь ажиллаж амьдарч байгаа иргэдтэй холбоотой асуудлыг л шийдэхэд тухайн улс орнуудад дэмжлэг үзүүлнэ гэдэг асуудал ярьдаг.

Таны ярьж байгаа бол Монгол Улсын иргэн Туркт очоод эмчилгээ хийлгэхэд Эрүүл мэндийн даатгалын сангаас нь дэмжлэг авах тухай асуудал яриад байгаа юм байна гэж би тэгж ойлгож байгаа. Үүнийг шууд өнөөдөр шийдчихнэ гэж хэлэхэд бас жаахан бэрхшээлтэй.

Гэхдээ үүнийг бид бас нэлээн судалж үзье. Цаашдаа тэр Засгийн газрын хооронд хэлэлцээр байгуулах асуудалтай үүнийг бас оруулах боломж байна уу гэж судалъя.

Гэхдээ энэ бол одоо орчих боломжтой гэдэгт хэцүү.

**С.Одонтуяа:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо үг хэлэх гишүүд байна уу? Төгсгөлд нь би үг хэлье. Ингээд тасаллаа. Салдангийн Одонтуяа.

С.Чинзориг сайд үг хэлнэ.

**С.Чинзориг:** Засгийн газраас өргөн барьсан хууль учраас Засгийн газрын гишүүний хувьд асуулт асуугаад, үг хэлэх жаахан хүндрэлтэй.

Тийм учраас дэмжсэн үг хэлье гэж бодож байна.

Ер нь бид энэ хүүхэд хамгааллын асуудалд Монголын төр нэлээн онцгой анхаарч сууриар нь шийдэх ёстой гэсэн ийм байр суурьтай байдаг.

Олон жил бид энэ хүүхдийн асуудлыг ний нуугүй хэлэхэд нэлээн улс төржүүлсэн. Тогтолцоог нь тогтворгүй авч явж ирсэн. Нэг бол Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд аваачаад л, нэг бол Хөдөлмөр, хамгааллын хүрээнд аваачаад. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа бидний нэг дутагдал. Хүүхдийн асуудлыг эцэг эхээс нь, гэр бүлээс нь тусад нь салгаж авч үзэж шийдэх гэж олон жил явсан.

Тэгэхээр энэ тогтолцоо маань, энэ бодлого маань зөв үү, үгүй юу гэдгийг бид маш сайн зөв бодлого, анализ хийх ёстой гэсэн ийм байр суурьтай байдаг.

Үндсэн хуульд ч гэсэн тодорхой үүрэг заалт бий шүү дээ. Эцэг, эхийн. Хэн ч ярьдаггүй. Монголын төр ч ярьдаггүй, эцэг эх ч ярьдаггүй, яамд нь ч ярьдаггүй, төрийн бус байгууллага ч ярьдаггүй.

Хүүхдийн чинь асуудлыг төр хариуцах ёстой юм шиг л яриад байдаг. **Үндсэн хуулийн 17 дугаар зүйл** дээр **“эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”** гэсэн маш тодорхой бичсэн үүрэг байдаг.

Манай иргэд ерөөсөө Үндсэн хуульд заасан эрхээ л яриад байдаг болохоос биш энэ Үндсэн хуульд заасан үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэсэн энэ Үндсэн хуулийн үүргийг ерөөсөө ярьдаггүй.

Тийм учраас би цаашдаа энэ хүүхдийн эрх хамгааллын асуудал ярихдаа ер нь эцэг эхээс нь ангид авч үзэхийн арга байхгүй. Гэр бүлээс ангид авч үзэхийн арга байхгүй.

Нөгөө талдаа орон нутгийн удирдлага иргэнээ мэддэг байх, хүнээ мэддэг байгаа. Хүүхэд хамгааллын асуудалд маш том үүрэг рольтой оролцох ёстой.

Ер нь цаашдаа бидний бодлого бол тогтолцоо нь босоо байдаг юм гэхэд хүүхэд хамгааллын тусламж, үйлчилгээ нь хэвтээ байх ёстой. Ингэж байж явахгүй бол энэ бодлого явахгүй байгаа юм.

Хоёр дахь миний хэлэх гээд байгаа санаа бол ер нь энэ хүүхдийн эрх хамгааллын асуудал хаана зөрчигдөөд

байна вэ, юунаас зөрчигдөж байна вэ гэдгээ бид ер нь сууриар нь маш тийм шинжлэх ухааны үндэстэй судалгаа хийж, нотолгоо гаргаж, дүгнэлт хийж, энэ хүүхэд эрх хамгааллын асуудал хөндөгдөж байгаа, зөрчигдөж байгаа асуудлынхаа шалтгаан нөхцөлийг нь зөв оношилж чадаж байна уу, үгүй юу. Ингэж чадахгүй бол цаашдаа бид энэ асуудал үр дүнд гарахгүй шүү дээ.

Хүүхдийн эрх хамгааллын асуудал юунаас болоод зөрчигдөөд байна вэ гэхээр тодорхой гурав, дөрвөн юм л яриад байгаа шүү дээ. Судалгаа харахаар.

Нэг дэх асуудал нь, гэр бүлийн салалттай холбоотой байна.

Хоёр дахь асуудал нь, эцэг, эх нь архидалтаас хамааралтай байна.

Гурав дахь нь, хүүхэд гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаагаас шалтгаалж хүүхдийн эрх хамгааллын асуудал зөрчигдөж байна гэдэг асуудал судалгаануудаар чинь яриад байгаа шүү дээ.

Тэгэхээр ийм шалтгаануудаас болоод хүүхдийн эрх хамгааллын асуудал зөрчигдөж байгаа бол энэ суурь шалтгаанууддаа бид өнөөдөр энэ хуульд өөрчлөлт оруулснаараа хариулт өгч чадаж байна уу гэдгийг л нэлээн сайн бодох хэрэгтэй байх юм. Хариулт өгч чадаж байна уу, үгүй юу гэдэг.

Манай төрийн байгууллагуудад нэг дутагдал бий. Хуулийг яах вэ, нөгөө төрийн захиргааны төв байгууллага, яам цаанаас ч бичдэг.

Бид бичихээрээ ерөөсөө л тогтолцоогоо л хамгаалаад байдаг.

Өөрсдөдөө баахан эрх авах л юм яриад байдаг. Бүтэц, орон тоогоо нэмэгдүүлэх л юм яриад байдаг. Төсөв, мөнгө л нэхээд байдаг.

Гэхдээ яг цаана нь хүндээ хүүхдэд яг хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр яг ямар тусламж, үйлчилгээ үзүүлэх гээд байгаа юм бэ гэдгийгээ маш их бүрхэгдүүлдэг асуудлууд бий.

Тийм учраас энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна. Тэгээд тэр ажлын хэсэг дээрээ, Байнгын хороон дээрээ маш сайн ярих болов уу гэж бодож байгаа.

Бид энэ хүүхэд хамгааллын асуудлыг эцэг эхээс нь, гэр бүлээс нь тусад нь ярих асуудлыг ер нь үүнээс хойш болих хэрэгтэй.

Олон жил бид чинь гэр бүл, гэр бүл төвтэй нийгмийн хамгааллын асуудал яриад байдаг, яриад байдаг. Яг гэр бүл төвтэй нийгмийн хамгааллын асуудал гэж юу хэлээд байгаа юм, хэн нь ямар үүрэгтэй юм, ямар эрхтэй юм, ямар оролцоотой байх юм гэдгийг ерөөсөө ярьж тодорхойлж чадахгүй л байгаа байхгүй юу.

Хоёр дахь асуудал нь, миний хэлээд байгаа тэр орон нутгийн удирдлагын оролцоо асар их байх ёстой. Зөвхөн хэдэн төрийн бус байгууллагууд хүүхдийн эрх хамгааллын асуудлыг даатгаад хаяж болохгүй. Зөвхөн төрийн захиргааны төв байгууллага, яам хийх ёстой юм шиг, Тамгын газар хийх ёстой юм шиг ойлголт одоо болохгүй шүү дээ.

Тийм учраас гэр бүл, эцэг эхтэй холбоотой асуудлууд, орон нутгийн

удирдлагын үүрэг оролцоотой холбоотой асуудлыг маш.../минут дуусав/

**С.Одонтуяа:** Одоо Жамьянхорлоогийн Сүхбаатар гишүүн үг хэлнэ.

**Ж.Сүхбаатар:** Ер нь манай гишүүд тал талаас нь л ярьж байгаа юм.

Би нэлээн сонссон. С.Чинзориг гишүүн ч гэсэн сайд асуудал хөндөж байна.

Энэ хоёр юм яриад байна л даа. Нэг нь, хууль гаргаад ер нь тэгээд юу шийдэх юм бэ гээд л нэг хэсэг нь ярьж байгаа юм.

Хууль гарангуут ингээд юм шийдэгдчих үү гээд л.

Нөгөөдөх нь, хуулиас гадна орон тоо, төсөв нэмэгдээд яг одоо юм ярих юм уу, үгүй юм уу гээд.

Зүгээр энэ юу шүү дээ. Хууль гэдэг нь бид ямар бодлого баримтлах юм бэ гэдэг асуудлыг хууль өөртөө агуулна. Удирдлага, зохион байгуулалт, захиргаа нь ямар хэлбэртэй байх юм бэ гэдэгт нэг тодорхойлолт өгнө. Санхүүжилт нь ямар байх юм бэ гэдгийг хариулт өгч байгаа.

Энэ гурван талаасаа манай хуулийн төсөл ямар байж байгаа юм бэ гэдгийг л үнэлэх ёстой шүү дээ.

Дахиад хоёр дахь тусдаа юм нь хуулийг биелүүлэх буюу хуулийг гүйцэтгэх үйл ажиллагаа ямар юм гэдэг чинь тусдаа асуудал байхгүй юу.

Одоо манай хууль тогтоогчид сая миний хэлдэг гурван зүгээсээ зөв

тодорхойлж чадах нь эхлээд чухал байгаа юм.

Хууль амьдралд хэрэгжихгүй биш хэрэгжүүлэхгүй байгаа юм чинь юутай холбоотой юм гэхээр төрийн чадамжтай холбоотой болоод явчихдаг. Тэрийг нь задлаад хэлбэл тухайн салбарын удирдлагын үр нөлөөтэй холбоотой болоод явчихдаг. Тэгээд цааш нь явах юм бол нутгийн удирдлагын түвшин, иргэний нийгмийн түвшин, гэр бүлийн асуудал гээд задраад явдаг байхгүй юу.

Тэгэхээр манай улсын хамгийн гол юм бол нөгөө хуулийн оновчтой байдлаасаа илүүтэй хуулийн гүйцэтгэл буюу үр нөлөөтэй ийм тогтолцоо байхгүй байгаа шүү дээ.

Одоо ингээд л сууж байгаа Х.Булгантуяа сайдыг харах юм бол хэдхэн сар болж байгаа юм. Сайд нь, Засгийн газар нь 1.6 жилтэй. Тэгээд энэ хүүхэд, гэр бүлийнх нь дарга нар нь өөрчлөгддөг.

Тэгээд мэргэшсэн боловсон хүчин гэж яриад байдаг нь солигддог. Нийгмийн ажилтан гэж яривал бараг 70 хувь нь мэргэжлийн биш. Тэгсэн хэрнээ баахан сэтгэл зүрхээрээ хүмүүс ажиллаад байна уу гэхээр бас тийм биш.

Тэгээд 14 тэрбум төгрөг гэж байна.

Яг үнэндээ мөнгө нь үнэхээр бага, орон тоо нь үнэхээр бага. Тэгээд бодлогоо тодорхойлсон хэрнээ тэр бодлогоо үр нөлөөтэй удаан аваад явдаг тэр мэргэшсэн удирдлагын тогтолцоо нь өөрөө байхгүй байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр сая хэлээд байгаа хүмүүс энэ хуулиа гаргаад тэртээ тэргүй тэгээд хүүхэд хамгааллын юм явахгүй дээ нэг хариулт өгсөн. Энэ чинь угаасаа олон жилийн ажлын үр нөлөөтэй байхгүй юу. Чадварлаг удирдагч менежер дээд түвшиндээ, дунд түвшиндээ, анхан шатын түвшиндээ л байх асуудал.

Гэр бүлийн асуудал ярьж байгаа. Гэр бүлийн асуудал нийгмийн тэр сошиал проблем гэдгийн чинь хамгийн гол асуудал. Социологичид нэлээн үнэлэлт үйлдэх ёстой шүү дээ.

Манай Улаанбаатар хотын тулгамдсан асуудлууд, энэ хүүхэд хамгааллын асуудлууд дээр жишээлбэл нийгмийн социологийн тийм мэргэжилтнүүдийн дуу хоолой бараг байдаггүй байхгүй юу.

Одоо та бүхэн харах юм бол нэг судлаач гээд л нэг ярина, нэг мэргэжилтэн гээд л ярина, халуун зүрхтэй нэг хүн юм ярина.

Баруунд бол тэр чинь нийгмийн социологийн чиглэлийн хүмүүсийн хийчихсэн ийм нарийн нарийн юмнууд байна гэж.

Бид хэд бол нэг байгууллага хөөцөлдөнө, гэр бүл ярина, ёс суртахуун ярина. Тэгэхдээ ярих ёстой юу ярих ёстой.

Тэгэхээр энэ юу хэлэх гээд байгаа юм бэ гэхээр манайх ийм чадамжийн занга буюу аливаа юмнуудыг зөв тодорхойлсон. Түүнийгээ гүйцэтгэх тэр үр нөлөөтэй, харилцан ажилладаг, хамтран ажилладаг тогтолцоогоо засаглалын түвшинд бүх түвшиндээ олохгүй л байгаад байгаа юм.

Одоо тэгэхээр бид яах юм бэ гэхээр энэ Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулга дээр ингээд тус тусад нь юмнудаа тодорхойлчихсон байна л даа.

Ямар ч байсан мөнгө нэмэх нь гарцаагүй. Арван хэдэн тэрбум төгрөг тавьчихаад 30, 40 мянган хүн дунд нэг хүүхэд хамгаалах хариуцсан хүн тавьчихаад ингээд төр ажлаа явуулна гэх юм бол төрийн чадамж байхгүй.

Гэхдээ төр бүгдийг хийнэ гэдэг юмнаас бид татгалзчихсан шүү дээ. Одоо гэр бүл, хүүхэд гэдэг манай төр улсын нийгмийн үндэс төрийн хариуцах үүрэг гэж бид 70 жил явсан. Тэгээд сүүл нь нэг хэсэг орхигдсон. Одоо эргээд төр нь нэлээд хэсгээ бас үүрнэ. Гэхдээ та бүхэн бас нэг хэсгээ үүрнэ гэдэг энэ ухамсар луу чинь шилжилт хийгдэж байгаа.

Тэгэхээр энэ хүүхэд хамгааллын асуудал бол соён гэгээрэлтэй холбоотой, боловсролтой холбоотой, төрийн албадлагатай холбоотой. Тэгээд зөв төлөвлөлт, бодлого, үнэлгээтэй холбоотой шүү дээ.

Тэгэхээр энэ болгон тогтолцооны хувьд удаан настай юмыг одоо манай Их Хурал юу хийх вэ, энэ яам юу хийх вэ, боловсон хүчнүүдээ яаж хадгалж үлдэх вэ.

Тэгээд л дараагийн нэг засаг төр сонгууль солигддог. Дахиад л хэдэн өөр хүн орж ирээд л суудаг байх юм бол энэ явахгүй байхгүй юу. Гол нь тийм л юм байгаа юм.

Тэгэхгүй болохоор манайхан ингээд юмаа. Манай хууль тогтоогчдын

үүрэг бол гол нь саяын хэлдэг бодлогоо л тодорхойлоод өгөх л байхгүй юу. Хуулиа биелүүлэх, удаан үр нөлөөтэй тогтолцоо бий болохгүй байгаад байгаа нь бас улс төрийн түвшний асуудал ч мөн. Бас тэр нийгмийнхээ нөхцөл байдалтай ч уялдаж байгаа асуудал.

Манай олон салбарт ийм байдал байгаа шүү дээ. Одоо хүүхэд хамгааллыг бид гол нь бэлгийн хүчирхийлэл талаас нь ярьж байгаа юм. Эрх нь зөрчигдсөн талаас.

Тэгвэл энэ дээр өнөөдрийн гол поинтлох сэдэв энэ хууль дээр хэлэлцэх эсэхийг нь би дэмжиж байна.

Тэр эрх нь зөрчигдвөл хөрш айл нь мэдээлдэг л байх ёстой байхгүй юу. Илүү. Арай дунд насныхан бол эцэг, эхээ өөрөө л матдаг шүү дээ. Ер нь баруунд бол. Тийм үүднээс нь би хандах ёстой л гэж байр суурь хэлэх гэсэн юм.

**С.Одонтуяа:** Одоо Буланы Бейсен гишүүн үг хэлнэ.

**Б.Бейсен:** Сая хэллээ. Орон тоо нэмснээр ажил сайжирчихгүй байх гээд.

Энэ дээр гол нь эрүүл мэндийн байгууллага, боловсрол, Засаг даргын Тамгын газар тухайн шатуудын. Гэр бүл, хүүхэд хамгааллын газар хамтарч ажиллаж байж энэ ажлыг нэг эрчимжүүлэх шийд гаргах нь зөв байх.

Нөгөө талаар энэ хохирч байгаа хүүхдүүд, өнчирч байгаа хүүхдүүд байна. Эд нарын тухайн шатын хуулийн байгууллагын цагдаа прокурорынхон ингээд хяналт тавихгүйгээр тухайн буруутай этгээдийг хилээр гаргаад

явуулчихдаг. Энэ дээр хариуцлага тооцох шаардлагатай.

Нөгөө талаар энэ сургуулийн насны хүүхдүүд ихэнхдээ дотор байранд хүүхдэд энэ бэлгийн дарамт, янз бүрийн хэлмэгдэлд өртдөг. Энд байрны хүмүүжүүлэгч гээд байна, манаач гэж байна, сургуулийн захирал гэж байна.

Сургуулиуд дээр үзээрэй. Сургуульд хүмүүжил эрхэлсэн хичээлийн эрхлэгч гээд бас байж байгаа.

Ийм улсууд дээр хариуцлага тооцох хэрэгтэй. Эд нарын ажлыг нь дүгнэхдээ уруу татна гээд тухайн сум, энэ Засаг даргын Тамгын газар, боловсролын байгууллага үүнийг нуун дарагдуулчихдаг.

Хэрвээ тийм юм байвал хариуцлага тооцож байх хэрэгтэй. Ажлаас нь халах хүртэл арга хэмжээ авч байх хэрэгтэй.

Дараа нь энэ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв дээр эмчлүүлж байгаа хүүхдүүд байна. Хорт бодисын донтолттой, Facebook-ийн донтолттой, компьютерын донтолттой. Энэ улсуудын нууцлал чанд хадгалахгүй бол тэгээд тэнд эмчлүүлээд ирсэн гээд ярьдаг. Тэгээд сургуулийнхан бас энэ дээр ярьдаг. Хүүхдүүдийн хооронд бас нэр хүнд нь унадаг. Дахиж донтолтод ордог тийм асуудал байгаа.

Тэгээд ялангуяа хүүхдийн эмчийн талаар ярья. 90 оны сүүл хүртэл хүүхдийн эмчийн факультет байсан. Тэгээд татан буулгачхаад одоо сүүлийн хоёр жил болж байна уу. Дахиж хүүхдийн эмч бэлдэж байна.

Ер нь аймгийн төв, өрхийн эмнэлгүүд, сумын эмнэлгүүд дээр заавал хүүхдийн эмч байж байх ёстой. Энэ дээр анхаараад энэ талын асуудал дээр бас хуулийн юун дээр тусгаад эрүүл мэндийн байгууллагууд дээр сая нөгөө сэтгэл судлаачийн цаг нь 400 мянга гэсэн үү. Та тийм мэдээлэл хаанаас авав. Үүнийг бас анхаарахгүй бол.

Анагаахын шинжлэх ухааны их сургуулийн сэтгэцийн тэнхим байна. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв байна. Бусад их дээд сургуулиудын сэтгэл судлалын тэнхимүүд байж байна.

Эд нартай хамтарч ажиллаад энэ сэтгэл судлаачийг бэлдчихвэл энэ бизнес багасах байх. Тэр хүүхэд нь өвдөж байгаа хүн цаг нь 400 мянган төгрөг яаж төлөх вэ. Үнэхээр хүнд туссан биз дээ. Энэ дээр нэлээн анхаарах шаардлагатай байх аа. Энэ талаар хэлье.

**Г.Занданшатар:** 3 гишүүн дэмжсэн үг хэллээ. Дэмжсэн 3 үг хэлсэн. Одоо дэмжээгүй л үг хэлэх юм байна.

Жигжидийн Батжаргал гишүүн. Жигжидийн Батжаргал гишүүн дэмжиж байгаа учраас. Дэмжихгүй үг хэлэх хүн бас байхгүй юм байна.

Тэгээд одоо санал хураалт явуулна. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны саналаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт



оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалтаа бэлтгэе.

Ер нь манай одоо мөрдөгдөж байгаа Хүүхэд хамгааллын тухай хууль бас муу хууль биш. 2021 онд оруулсан өөрчлөлтөөр орон нутгийн удирдлагуудтай зөвшилцсөнөөр хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан томилж ажиллуулна.

Хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан нь энэ эрсдэлт орчинд байгаа хүүхдүүд, эрсдэлт бүлгийн хүүхдүүдийг тодорхойлж, ярилцлага хийж, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана энэ тэр гээд тодорхой заалтуудтай.

Гагцхүү хуулиуд хэрэгжихгүй байгаа.

Тэгээд хууль хэрэгжүүлэх механизмыг иргэдийн оролцоотой хангаж өгөх, гэр бүлийн оролцоотой хангаж өгөх, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгоно гэж байгаа юм.

Тэгээд энэ бүхэн маань тийм үндэсний тогтолцоо болгодог. Хүүхдийн зөвлөл нь ном журмаараа ажилладаг ийм ажилладаг механизм л болгох нь илүү. Тэгээд ажлаа хийх нь илүү чухал байгаа юм.

Одоо санал хураалтад бэлтгэе. Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

25 гишүүн дэмжиж, 58.1 хувийн саналаар төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Гишүүд сууцгаана уу. Одоо төсөв хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлөөс Засгийн газраас Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулж өгөхийг хүссэн хүсэлт болон Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг хэлэлцээд үдээс хойших хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг хойшлуулж, төсөв дагасан хуулиуд хугацаатай асуудал учраас хэлэлцэхээр шийдвэрлэсэн болохыг мэдэгдье.

Энэ дээр санал хураалт явуулах шаардлагагүй биз дээ.

Д.Тогтохсүрэн дарга горимын санал гаргах уу? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн горимын санал гаргана.

**Д.Тогтохсүрэн:** Өнөөдөр 14.00 цагаас дэгийн хуулийн дагуу явах Ерөнхий сайдын асуултыг хойшлуулах саналтай байгаа.

Засгийн газраас ч гэсэн хойшлуулж өгөөч гэсэн байна лээ.

Төсөв дагасан 21 хууль, 7 тогтоолыг бид өнөөдөр хэлэлцэх эсэхийг шийдэж байж ирэх долоо хоногт Байнгын хороодоор хэлэлцэх болж байгаа юм.

Тэгэхгүй бол 11 сарын 10-д дотроо төсвийн хууль хэлэлцэхэд цаг хугацааны

хувьд багтахгүй байгаа учраас миний гаргах гэж байгаа горимын санал өнөөдрийн асуултыг хойшлуулж, төсөв дагасан төсвийн хамт өргөн баригдсан хууль, тогтоолыг хэлэлцэх ийм горимын санал гаргаж байна. Дэмжиж өгөхийг хүсье гишүүдээс.

**Г.Занданшатар:** Горимын саналаар санал хураалт явуулъя.

62.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Ерөнхий сайдын мэдээллийг горимын саналаар хойшлууллаа.

Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

---

**Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,  
Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,  
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй  
хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд  
/Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,  
хэлэлцэх эсэх/**

---

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт нийт 21 хуулийн төсөл, 7 Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

**Б.Жавхлан:** Эрхэм Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн талаар дурдвал.

**Нэг.** Хөдөө орон нутагт ажиллах төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор төрийн албаны тухай хуульд

нэмэлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

**Хоёр.** Орон нутагт орон сууц барьж ашиглалтад оруулах аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх, дотоодын боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, татварын тайлагналыг хялбаршуулах зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

**Гурав.** Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар ажилладаг төрийн үйлчилгээний байгууллагуудын төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтыг оновчтой болгох, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

**Дөрөв.** Стратегийн ач холбогдолтой урт хугацаанд хэрэгжих уул уурхайн төслүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай

хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

**Тав.** Газрын зөвшөөрлийн асуудлыг цэгцэлж, газрын менежментийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

**Зургаа.** Авлигатай тэмцэх байгууллагын гүйцэтгэх ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах зорилгоор Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

**Долоо.** Түншлэлийн төвийн үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Мөн тэргүүлэх ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүдийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэмжих зорилгоор “Засгийн газарт чиглэл өгөх

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

**Найм.** Өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай, стратегийн ач холбогдол бүхий эрчим хүчний төслийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Засгийн газрын өрийн баталгааг гаргах зөвшөөрөл олгох тухай, авто бензин, дизелийн түлшний үнийг тогтвортой байлгаж нөөцийн баталгаат байдлыг хангах зорилгоор Тогтоолд өөрчлөлт оруулах тухай, хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг тус тус боловсрууллаа.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хорооны дарга Ганзоригийн Тэмүүлэн танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн 21 хууль, 7 тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчаас орон нутагт уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай болгох, тухайн жилийн батлагдсан төсвийн санхүүжилтийг дараагийн төсвийн жилд зарцуулах эрх мэдлийг боловсролын салбар болон цаашид гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар ажиллах төрийн бусад байгууллагуудад хамруулах, Улаанбаатар хотоос бусад орон нутагт ажиллах төрийн албан хаагч Төрийн албаны тухай хуульд заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан хугацаанаас нь өмнө шатлан дэвшүүлэх, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг сайжруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах үүднээс төсөвт төвлөрсөн ашигт малтмал нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад, үлдэх хэсгийн 65 хувийг Ирээдүйн өв санд төвлөрүүлэх заалтыг 2024 онд 20, 2025 онд 40, 2026 оноос эхлэн 65 хувьд хүргэх, хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд гаалийн шинэчлэлийг эрчимжүүлэх, хөдөө, орон нутагт ажиллах төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах зорилгоор аймгийн төвийн сумаас бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа гаалийн албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа 12 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгох, малчдын татварын

орчныг энгийн ойлгомжтой болгох, дотоодын боловсруулах үйлдвэрт тулгараад буй хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх, орон орон нутгийг орон сууцжуулах бодлогыг хэрэгжүүлэхэд татварын бодлогын дэмжлэг үзүүлж, орон нутаг дахь түрээсийн орон сууцын хүртээмжийг нэмэгдүүлж, 2030 он хүртэл татварын хөнгөлөлтийг түрээслэгчид олгох, малчин, мал бүхий этгээдийн татварын орчныг хялбаршуулах, энгийн ойлгомжтой болгох зорилгоор малчин, мал бүхий этгээдийн малын тоо толгойн албан татварын тайлан гаргах шаардлагыг үгүй болгож, Татварын хуулийг хэрэгжүүлэх, Засгийн газрын шийдвэрээр техник, эдийн засгийн үндэслэл бүхий үйлдвэрүүдийн үндсэн хөрөнгөөр бүртгэгдэх дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх, гаалийн албан татвараас чөлөөлөн дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах стратегийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын шийдвэр, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээний дагуу урт хугацаагаар уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах зохицуулалт нь Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хуульд хамаарахгүй байхаар Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу стратегийн ач холбогдол бүхий урт хугацааны төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах ажил, үйлчилгээг 10 жилийн хугацаатай гэрээ байгуулан худалдан авах, тендер шалгаруулалт хийх эрхийг хуульчлах, Газрын харилцаа, геодез, зураг зүйн асуудал Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарч хот,

хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалтын асуудлыг хамтад нь шийдвэрлэх, цахим гарын үсэг бүхий **QR** код буюу лавлагаа авах холбоостой зөвшөөрлийн гэрчилгээг олгох, Засгийн газарт авто бензин, дизель түлшний гаалийн албан татварт зохицуулалт хийх эрх олгох хугацааг 2026 он хүртэл сунгах, санхүүжилтийг түргэн шуурхай шийдвэрлэх, төлбөрийг цаг алдалгүй гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх зэрэг зорилгын хүрээнд хууль, тогтоолын төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед **Улсын Их Хурлын гишүүн Б.Баделхан** прокурор, шүүхийн албан хаагчдын цалинг нэмэх боломжтой эсэх талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд** төрийн худалдан авах үйл ажиллагаанд тавигдаж байгаа хяналт шалгалтын талаар болон цар тахлын үед түдгэлзүүлсэн зарим хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэхгүй байгаа бодит шалтгаан талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар** улсын хөрөнгө оруулалтыг бодитой төлөвлөж байгаа эсэх талаар тус тус хууль санаачлагчаас асуулт асууж хариулт авсан болно.

**Мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилтийн хугацааг сунгасан нь зөв эсэх талаар, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн

18.1.10 дахь заалтын томъёоллыг хэлэлцүүлгийн явцад нухацтай авч үзэх, төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь тэгш байх зарчмыг оновчтой тодорхойлсон эсэх;

**Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир** Хөрөнгө оруулалтын зардалд дахин магадлал хийсэн төсөвт өртгийн нэмэгдлийг хэлэлцүүлгийн шатанд анхаарах талаар;

**Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь** Газрын тухай хуульд оруулж буй өөрчлөлт нь Засгийн газрын баримталж байгаа төвлөрлийг сааруулах, орон нутгийг дэмжих үйл ажиллагаатай зөрчилдөж, орон нутгийн эрх мэдлийг хумих эрсдэлтэй байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналыг тус тус хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүй өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай”, “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай”, “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”, “Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын

хүрээнд хэлэлцэхийг нь гишүүдийн олонх дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагчийн илтгэл болон Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд.

Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууна.

**Г.Ганболд:** Төсөв дагаад **21** хууль, **7** Их Хурлын тогтоол орж ирсэн байна.

Тэгээд сүүлийн үед орж ирж байгаа энэ хуулиуд дээр орон нутгийн эрх мэдэл гэдэг юмыг хумьсаар байгаад орон нутгийн эрх мэдэл ер нь бараг байхгүй болж байна.

Орж ирж байгаа салбарын хууль болгон дээр л орон нутаг муу байна гээд л, томилгоог нь босоо болгоод л явсаар байгаад сүүлдээ одоо энэ орон нутгийн чинь гол Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар олгогдсон ганц том эрх нь энэ газартай холбоотой асуудал байгаа юм.

Энэ дагаж орж ирж байгаа хуулийн Газрын хуулийн 18.1.10 дээр орон нутаг, аймаг, сум газар олгож чадахаа болих нь ээ.

Шинэ хуулийн дагуу энэ газрын агентлаг Засгийн газрын дээр очсонтой холбогдуулаад одоо бүх орон нутгийн газар олголтыг Засгийн газар олгодог болж байна л даа.

Ингэхээр чинь орон нутаг ер нь яаж хөгжих юм бэ? Яг хажууд нь Их Хурлын тогтоол байна. **“Төсөв батлагдсантай холбогдуулаад авах арга хэмжээний тухай”** гээд.

Энэ дээр **2024 оныг “хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих жил болгон зарлана”**.

Энэ хүрээндээ хөдөө орон нутагт маш олон орон сууцуудыг барихыг дэмжинэ гэж тогтоол баталчхаад, эсрэгээрээ Газрын хууль дээрээ ингээд газар олгох эрхийг нь хумьчихаар зэрэг цаашдаа энэ орон нутаг ер нь яаж хөгжиж явах юм бэ? Энэ дээр нэг хариулт авъя.

Хоёр нь, энэ биржийн хууль байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн хууль гээд бид өчнөөн ажил болж, энэ байгалийн баялаг, энэ нүүрсээ биржээр зарна гээд хуулиа батлаад одоо биржээр зараад харьцангуй үнэд ороод явж байна гээд бид яриад байгаа.

Гэсэн хэдий боловч одоо яг энэ хуулийн заалтаар стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл Монгол Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уул уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг

нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацаагаар уул уурхайн бүтээгдэхүүн худалдахад энэ хуулийн 10.2 дахь хэсэг хамаарахгүй гээд заачхаж байгаа юм.

Тэгэхээр одоо ингээд олон улсын гэрээ нэрээр гэрээ хийгдсэн байгууллагуудад биржийн үнэ өргөхөө болих нь.

Тэгэхээр яг ямар үнэ баримтлах юм? Биржийн үнээр зарагдахгүй болбол. Бид биржээр нэгэнт явуулахгүй бол, дараа нь нэг өөр үнэ тогтоох аргачлал байхгүй бол үнэ нь дур зоргоор тогтоогоод явах ийм эрсдэл гарна.

Үүнтэй холбогдуулаад дараа нь тэр үнийг гэрээ хийсэн, ямар нэгэн үнэ тогтоогоод гэрээ хийсэн хүмүүс дараа нь шалгагдаад ирэхээр буруудах ийм эрсдэл гарна.

Үүнийг одоо яг яаж зохицуулах юм бэ гэдгийг би асуух гээд байгаа юм.

Гуравт нь, энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухайн хууль дээр стратегийн орд газрууд нь 10 жилээр гэрээ хийж, тухайн лицензтэй талбайд төрийн өмчит компанийн лицензтэй талбай дээрээс ам нээж ашиглуулах, 10 жилийн хугацаагаар тендер зарлаад ашиглуулах ийм зүйлийг нээх гээд байна л даа.

Үүний шалтгааныг нь ойлгож байгаа. Одоо энэ Тавантолгойн орд газар дээр нүүрсний шинэ ам нээх юм байна. “Эрдэнэс Тавантолгой” компанитай адилхан операторын үйл ажиллагаа явуулах юм байна гэж ойлгоод байгаа юм.

Гэтэл бусад яг ийм ижил төстэй бусад компаниуд яг ийм үйл ажиллагаа хийгээд явах юм бол яг энэ хуулиар яаж зохицуулах юм? Боломжийг нь нээчхэж байгаа.

Багануур дээр ч гэдэг юм уу, Эрдэнэт дээр ч юм уу, өөр стратегийн төрийн өмчит аж ахуйн нэгжүүд шал өөр оператор компанийн ам нээгээд төрийн өмчит компанитай ингээд зэрэгцээд явах ийм боломжийг нээгээд явчих учраас үүнийг ер нь энэ хууль дээрээ яаж зааж, цэгцэлж явах юм бэ гэдгийг асууя.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулья.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайхан, Цэндийн Сандаг-Очир нарын урилгаар Налайх дүүргийн “Хүлэгт” төрийн бус байгууллагын гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн түүрүнд сайн сайхныг хүсэн ерөөе. Амжилт хүсье. /алга ташив/

Болдын Жавхлан сайд хариулья. Хоёр, гурван асуулт. Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн.

**Ц.Даваасүрэн:** Г.Ганболд гишүүний асуултад хариулья.

Тэгэхээр газартай холбогдолтой нэг шийдэж чадахгүй бидний байнга ярьж байдаг нэг асуудал байгаа юм. Төлөвлөлтийн дагуу газар олголт хийгдэхгүй байна л гэж.



Тийм учраас төлөвлөлтийн дагуу газар олголтыг нэг байгууллага л олгодог болъё гэдэг л ийм арга хэмжээг Засгийн газрын харьяа агентлагт өгөөд. Тэгээд тэр харьяа агентлаг нь олгож байна. Төлөвлөлтөө аймгийн иргэдийн Хурал, Нийслэлийн иргэдийн Хурал нь батлаад явна.

Тэр төлөвлөлтийн дагуу олгоно гэдэг ийм зарчмыг л нэвтрүүлэх гээд үзээд байгаа юм. Гэхдээ нэг удаа ингээд үзсэн нь гэмгүй байж магадгүй. Амьдрал дээр үнэхээр одоо бас энэ газар олголтын асуудал чинь хөдөө, хотгүй л хэл үг болчихсон байгаа шүү дээ.

Тэгээд тийм учраас энэ дээр хэдүүлээ нэг удаа төвлөрсөн байдлаар нэг цонхоор газар олгоод ингээд үзье л гэж байгаа юм. Нэг шинэчлэл хийх гэж байгаа л хэлбэр л дээ.

Зүгээр салбарын сайдын хувьд ч гэлээ гэсэн би үүнийг нь зөвшөөрөөд байгаа юм.

Ер нь тэгээд үзэг. Одоо яршиг. Яагаад ийм байдалд оров гээд тэгвэл би нэг жишээ авъя гэж бодож байна. Сая бид гэр хорооллын дахин төлөвлөлт дээр Яармаг дээр манай төрийн орон сууцын компаниар газар чөлөөлөлт хийчихсэн. Тэгээд орон сууц барина. Одоо гэр хорооллын дахин төлөвлөлтийн дагуу иргэдтэй гэрээ байгуулчихсан байсан чинь дүүрэг тэрийг мэдэнгүүтээ тэнд нь газар олгочхож байгаа байхгүй юу.

Нөгөө ТОСК-ийг нь чөлөөлсөн, иргэдтэй ярилцаад гэрээ байгуулаад гэр хорооллын дахин төлөвлөлт хийх гэж байгаа газар дээр нь дунд нь дүүрэг газар олгочхож байгаа юм.

Тэгэхээр энэ олон газар ингэж газар олгодоггүй байя. Нэг цонхоор олгоё. Төлөвлөлтөө хийгээд яв. Аймаг, иргэдийн хурал бүрэн эрхийнхээ хүрээнд төлөвлөлтөө хийгээд яв.

Тэгээд түүн дээр нь харин газар олголтыг нэг цонхоор хийнэ шүү л гэдэг ийм л хуулийн төсөл байгаа юм.

Тэгээд нэг хэсэг нэг ингээд л үзье. Хэдүүлээ. Тэгээд болох нь уу, болохгүй юу гэдгээ бас хараад явахгүй бол яг хуучин байснаараа сайжрахгүй байгаад байгаа л гэдэг асуудал л даа.

Бид нарын одоогийн явж байгаа хууль эрх зүйн орчин, байгаа тогтолцоо маань амьдралд нийцэхгүй байна, газар олголт байнгын маргаантай байна л гэдэг асуудал.

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд хариулна.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

Энэ биржийн асуудал бас нэг тийм амархан явчхаагүй. Г.Ганболд гишүүн сая хэллээ.

Биржээр төрийн өмчит компаниудын нүүрсний бараг 35 хувийг нь бид биржээрээ зарж чадаж байгаа.

Ер нь тэгээд энэ жилдээ бид нүүрсний хэмжээг 60 гаруй тонн болгочих байх. Энэ үзүүлэлтэд гол нь бирж нөлөөлсөн.

Тийм учраас Г.Ганболд гишүүний санаа зовж байгаа биржийн үйл ажиллагаанд доголдол үүсчих вий. Зовж

зовж хийсэн энэ зүйлээсээ ухарчих вий гэдэг дээр санал нэг байна. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ бол бүлэг дээр яригдчихсан асуудал л даа. Г.Тэмүүлэн гишүүн бас юун дээр асуусан юм байна лээ.

Тэгэхээр бүлэг дээр яригдаад өргөн барьсан хэлбэрээр нь засъя гээд.

Тэгэхээр яаж засах гэж байгаа вэ гэхээр нэгдүгээрт тухайлсан төсөл дээр нь үүнээс өөр зүйл дээр үйлчлэхгүй шүү гэдгийг нарийвчлан заая.

Хоёрдугаарт, тэр зах зээлийн үнээс хямд гэдгийг нь засъя. Зах зээлийн үнээр нь байх ёстой гэсэн ийм хоёр зүйлийг бүлэг дээр яриад шийдвэрлэсэн гэж ойлгосон.

Тэгээд ер нь яг өргөн барьсан хэлбэрээрээ жоохон буруу ойлголт өгөх гээд байгаа.

Тэгэхдээ ер нь засаг дээр юу гэж яригдсан бэ гэхээр Гашуунсухайт дээрээ Ганцмодны тэр замыг л, төмөр замын холболтын ажлыг л яаралтай хийлгэх гэж байгаа юм. Энэ бол одоо төрийн бодлого л гэж харж байгаа шүү дээ. Үүнийг яаралтай хийлгэх хэрэгтэй. Энэ яаралтай хийлгэхийн тулд гаргалгаа гаргасан. Энэ гаргалгаа нь зөв байна. Ингээд маш хурдтай холбоё. Үүний дараа олон төмөр замууд бас холболтынхоо ажлыг хүлээж байгаа.

Тийм учраас үүнийг хийлгээд явуулах нь зөв байна л гэж байгаа юм.

Түүнээс биш яг үүний цаана эрсдэлүүд үүсчих вий гэдгийг нь манай

гишүүд бас сайн олон талаас нь ярьж байгаа юм билээ.

Тийм учраас тэр саналынх нь дагуу засаад явах нь зөв байх гэдэг байр суурьтай байгаа.

**Г.Занданшатар:** Тэр төрийн болон орон нутгийн өмч дээр хэн хариулах юм бэ? Хаанах боловсруулсан юм? Газрын хууль тэгээд бүрэн хариулагдсангүй л дээ.

Худалдан авах ажиллагааны газрын дарга яагаад чимээгүй суугаад байна. 88. Энэ ер нь хуулийн хулгай хийх гээд байгаа юм биш биз. Та нар. Хууль ярихаар нуугдаад алга болчихоод байдаг чинь. 88.

Газрын тухай хууль чинь арай хэтэрч байна шүү.

**Ц.Батзул:** Г.Ганболд гишүүний асуултад хариулъя.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын Ц.Батзул.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоолд заасны дагуу энэ урт хугацаатай стратегийн орд эзэмшигчийн гэрээ байгуулах нээлттэй тендер шалгаруулах зохицуулалтыг нь хуулийн 8.15-д заахаар нэмэлт оруулахаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Энэ стратегийн орд газрын эзэмшигч асуудал нь болохоор зөвхөн Монгол Улсын олон улсын гэрээ болон Их Хурлаас өгсөн шийдвэрийн дагуу гэдэг чиглэлээр хязгаарлагдсан учраас бүх орд газруудыг энд хамааруулан ойлгох боломжгүй байгаа.

Тэгээд зөвхөн Их Хурлаас зөвшөөрсөн гэрээ, эсвэл шийдвэрийн дагуу энэ сонгон шалгаруулалт маань хэрэгжих, ийм хязгаарлагдмал хүрээнд хийгдэхээр хуулийн төсөлд тусгасан байгаа.

**Г.Занданшатар:** Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууна.

**Г.Ганболд:** Гишүүд ээ, энэ Газрын хууль дээр нэг жоохон анхаарлаа хандуулаадхаач.

Одоо энэ чинь сум, аймаг газраа олгож чадахаа болих гээд байна шүү дээ. 2018 оны 01 сарын 01-нээс эхлээд аймаг, сум зөвхөн дуудлага худалдаагаар газар олгодог болсон юм.

Энэ нь өөрөө орон нутгийн хөгжилд асар чөдөр тушаа болсон шүү дээ. Дуудлага худалдааг нь завхруулдаг. Гэтэл одоо бид орон нутаг хөгжинө гээд үйлдвэр барья, янз бүрийн аймаг хөгжье, орон сууц барья гээд ерөөсөө ганц барьж байгаа юм нь газраа өгье гээд л бүх аймгууд эдийн засгийн форум хийгээд л газар олгоё, хөрөнгө оруулалт хийе гээд байдаг.

Гэтэл одоо энэ чинь Засгийн газар аймгийн төвийн, одоо ингээд сумдын газрыг олгож эхлэхээр чинь юун хөдөөгийн хөгжил вэ? Асар том ухралт гарна шүү дээ.

Тэр нийслэл Улаанбаатар хотын дүүргийнхээ завхарсан газартаа битгий орон нутгийг хутгаад бай л даа. Наадхыгаа оруулах гэж байгаа бол тэр Улаанбаатар хот, тэр дүүргүүдээ оруул.

Энэ мөрөөрөө хөгжиж байгаа аймаг, сумдуудыг битгий наадахдаа хутгалдуулаад Засгийн газраас орон нутгийн газрыг олгоно гэж юу яриад байгаа юм бэ?

**Г.Занданшатар:** Асуултад хариулъя. Газрын хууль дээр Барилга, хот байгуулалтын сайд Цэрэнпилийн Даваасүрэн.

**Ц.Даваасүрэн:** Энэ дээр ер нь хот хөдөөгүй л газрын асуудал шүүмжлэл дагуулж байгаа даа.

Тийм учраас нэг реформ хийгээд үзье л гэж байгаа юм. Мэдээж реформ бүгдэд таалагддаггүй шүү дээ.

Тэгээд хийгээд явуулаад үзье. Нэг цонхоор олгоод үзье. Төлөвлөлтөө аймгийн иргэдийн Хурал нь, нийслэлийн иргэдийн Хурал нь хийгээд л явна биз.

Тэр төлөвлөлтийн дагуу олгогдох дээр нь л босоо тогтолцоогоороо ингээд хяналтаа тавиад олгоод явъя л гэж байгаа асуудал шүү дээ. Тэгээд бүлэг дээрээ сайн ярьцгаана биз.

Ер нь Засгийн газраас хийе гэж байгаа нэг реформ бол энэ. Газар олголтыг нэг цонхоор олгодог больё. Олон газар олгохоо больё.

Одоо жишээлбэл, ингээд Байгаль орчны яаман дээр олгож байгаа газрууд нь нийслэлийн газартайгаа гэдэг юм уу, аймаг, орон нутгийн газартайгаа ингээд зөрчилтэй болчихсон.

Зарим “тусгай хамгаалалттай газар нутаг” дээр орон нутагтайгаа хэрүүл үүсчихсэн ч байдаг юм уу. Нэг ийм юмнууд зөндөө байна. Жишээлбэл,

ашигт малтмал дээр ч гэлээ гэсэн олгосон газрууд дээр давхцалтай юмнууд бий. Тэгээд энэ бүгдийг л арилгая л гэж байгаа юм л даа. Тэгээд нэг хэсэг яваад л үзье.

Тэгээд явж үзсэнийхээ дараа болохгүй байвал тэгээд л өөрчилнө биз. Тэгэхдээ шинэчлэл хийсэн нь дээр. Яагаад гэвэл болохгүй байгаа учраас шинэчлэлээ хийгээд байна шүү дээ. Тэгээд энэ дээр та хэд минь нэг их орон нутаг гэж амбицлахгүй, байгууллагын амбиц гаргахгүй уг нь хандчихвал зүгээр байх л гэж би бодож байна л даа.

Би салбарын сайдын хувьд тэр агентлагийг яахад дургүйцэхгүй байна шүү дээ. Яагаад гэвэл зөв болж байвал надад хамаа алга.

Түүнээс биш би салбарын амбиц гаргамааргүй байна. Би тийм л зүйлийг хэлье.

Түүнээс биш яаман дээрээ байсан дээр, барилгатайгаа хамт байсан дээр гээд л яривал би бас ярина шүү дээ. Тэгмээргүй байна. Угаасаа болохгүй л байгаа юмыг чинь нэг болгох гээд л үзье л дээ.

**Г.Занданшатар:** Энэ чухал асуудал юм. Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууна.

Тэгээд Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын иргэн Х.Баделхан хашааны газраа авъя гэнэ. Засгийн газар шийдвэр гаргах уу? Тэрийг нь. Яаж гаргах юм тэгэхээр. Тэрийг нэг.

Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя.

**Г.Ганболд:** Яах вэ, нэг цонхоор өгье л гээд байна л даа. Нэг цонхоор өгч байгаа газар байгаа шүү дээ.

Таны хэлж байгаа. Тусгай хамгаалалтын газар.

Тэр чинь нэг цонхоор өгөөд одоо ямар түвшинд байгааг та мэдэж байгаа шүү дээ. Дампуурчихсан. Орон нутгаас ямар ч санал байхгүй. Тэгээд ингэж өгснөөс л одоо энэ тусгай хамгаалалтын газар дээр чинь л асар их зөрчил байдаг шүү дээ.

Тийм учраас орон нутаг нь энэ чинь орон нутгийнхаа өөрийн иргэдийн Хурлын чинь нэг онцгой бүрэн эрхийн нэг нь энэ юм байгаа юм шүү дээ. Уг нь бол. Орон нутгийн бие даасан байдал. Төсөв, энэ нэг газар хоёр дээр чинь иргэдийн Хурлын шийдвэр гаргадаг юм.

Тэгээд сум нь өөрөө олгох юм бол иргэдийн хурлынхаа хяналтад олгодог байхгүй юу. Сум нь, аймаг нь. Иргэдийн хурал чинь өөрийнхөө тэр баталж өгсөн газар зохион байгуулалтынх нь төлөвлөгөөг хянаад байж байдаг байхгүй юу.

Гэтэл одоо эндээс ямар ч аргачлалаар олгох гэж байгаа юм бүү мэд. Яаж олгох юм.

Тэгээд ийм байдлаар өргөдлөөр олгох юм уу, дуудлагаар олгох юм уу. Энэ чинь өчнөөн юм байна шүү дээ. Тэгээд эндээс чинь.

**Г.Занданшатар:** Тэгээд энэ агуулга нь 18.1-ээр авч. 18 дугаар зүйл Засгийн газрын бүрэн эрх гэсэн заалт л даа.

Тэгэхээр Засгийн газрын бүрэн эрхэд яам ч биш, ингээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээр л.

Тэр зөвхөн аж ахуйн нэгж ч биш, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх. Тэр битгий хэл бүр “**ашиглуулах**” эрх олгох шийдвэрийг Засгийн газар гаргана л гэсэн агуулгатай байна.

Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн хариулья. Сайд хариулья. Барилга, хот байгуулалтын сайд хариулья.

**Ц.Даваасүрэн:** Засгийн газрын хуралдаанаар биш юм аа. Засгийн газар луу нөгөө агентлагаа Ерөнхий сайдын харьяаны болгочоод байгаагаа тэгж бичсэн байна лээ.

Ерөнхий сайдын харьяанд байна. Агентлаг. Босоо тогтолцоотой байна. Газар олголт бол орон нутагт аймаг дээр хийгдэнэ. Аймаг дээр хийгдэхдээ иргэдийн Хурлын баталсан төлөвлөлтийн дагуу гэрчилгээ олгох тэр процесс нь аймгийн газрын албан дээр явна гэсэн үг. Яг тэр төлөвлөгөөнийхөө дагуу байна уу, үгүй юу гэдгийг нь хянаад л тэр гэрчилгээг нь л олгоод явах асуудал байгаа байхгүй юу.

Тэгээд яах вэ зүгээр хэдүүлээ нэг ингэмээр л байна. Шинэчлэлээ нэг хийгээд үз ээ. Болоогүй юмны төлөө болохгүй гэж ярих нь утгагүй шүү дээ. Хийгээд л үз. Одоогийн тогтолцоо чинь өөрөө болж өгөхгүй байна шүү дээ.

Тийм учраас л үүнийг өөрсдөө тэр газар дээрээ энэ нэг өөрчлөлтүүдийг нь хийгээд үзье.

Түүнээс биш газар хөдөө хотгүй наймаа болчхоод байгааг нь больё л гээд байгаа шүү дээ.

**Г.Занданшатар:** Тийм. Энэ 18 дугаар зүйл бол Засгийн газрын бүрэн эрх.

Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй. Хамт энэ орж ирэхээр тэгээд Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэхээс л өөр аргагүй л байгаа юм.

Дараа нь төрийн захиргааны төв байгууллагын эрх гэж байгаа. Үгүй яах вэ, 18 дугаар зүйл дотроо Засгийн газрын бүрэн эрх гэдэгт хамаарч байгаа юм бол одоо тэр тэр заасан зориулалтаар газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, зааг, ашиглах журмыг тогтоох, эрх бүхий байгууллагын мэдэлд шилжүүлэх асуудлыг Засгийн газрын бүрэн эрхэд хамаарч байгаа юм.

Тэгээд газрын талаар төрөөс явуулах нэгдсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж хангана гэж байгаа юм. Тэгвэл нэгдсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулахдаа газар олгох, ашиглах эрхийг иргэнд өгөх.

Ингээд яах вэ тэр улсын хэмжээний том бүтээн байгуулалт, стратегийн орд газар ч юм уу, Засгийн газар саналыг үндэслэж хэлэлцэж байж.

19 дүгээр зүйл бол төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх байхгүй юу. Тэр дээр байвал одоо яамны түвшинд ч юм уу. Тэрний доод түвшинд байвал агентлагийн түвшинд ч юм уу шийдэх байна.

Тэгэхээр үүнийгээ процессын хувьд Хууль зүйн сайд л сайн харах ёстой л доо.

Нямаагийн Энхболд гишүүн.

**Н.Энхболд:** Энэ хуулиуд дотор Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын бүтэц, төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчтэй холбоотой хоёр зохицуулалтын асуудал байна.

Асуулт юунд вэ гэхээр Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд 1 дүгээр зүйл дээр нь Улаанбаатар хотоос тухайн орон нутагт иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгээд төрийн захиргааны албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан иргэнийг энэ хуулийн 23.2-т заасан томилогдох хугацааг нь аймгийн төвийн сумд нэг жил ажилласан хугацааг нэг жил 3 сараар, аймгийн төвөөс бусад сум, тосгонд нэг жил ажилласан хугацааг нэг жил 6 сар ажилласантай тус тус дүйцүүлэн тооцож болно гэсэн байна.

Хэрэв энэ бодлогыг тууштай хэрэглэж байгаа хүмүүст нь итгэлтэй байхаар баталъя гэвэл заавал “**болно**” гэж үг оруулсан уу. Энэ болно гэдгийг нь хэн тодорхойлох юм? Хэний үзэмжээр явах юм.

Шууд үнэхээр ийм бодлого явуулъя л гэж байгаа бол тэгээд л тооцно гээд л оруулчхаж болоогүй юм уу? Энэ дээр нэг хариулт хэрэгтэй байна.

Ийм хоёрын хооронд юм хийчихээр чинь тэгээд “**болно**” гэж байгаа болохоос чамайг заавал нэг жилийг чинь нэг жил 6 сараар тооц гэсэн

алба байхгүй шүү дээ гэж хэлээд л нөгөө бодлогыг чинь нураагаад л, хүмүүсийн урам хугалаад л хаячих нэг ийм асуудал байна.

Хоёр дахь нь, дараагийн заалт 2 дээр нь төсвийн байгууллагын нягтлан бодогчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн салбарын төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлтэй адил байхаар тогтоож болно.

Миний санаж байгаагаар Төрийн албаны тухай хуульд ингэж байгууллагын доторх ажлыг нь мэргэжлээр нь тусгайлан заагаад тэрийг нь түүнтэй ингэж харьцуулна гэсэн юм байхгүй санагдаад байна.

Тэгээд нэг хууль дагаад л өөр янз бүрийн юм орж ирээд байвал дараа нь нэг хууль дээр нягтлан бодогч биш өөр нэг албан тушаалын юм орж ирээд л бас үйлчилгээний ч гэдэг юм уу оруулаад л дахиад л захиргааны ажилтантай адилхан зэрэг зиндаатай болгоно. Эсвэл үүрэг, хариуцлагынхаа хувьд арай өөр түвшинд байдаг нарийн мэргэжил шаарддаг ажлуудыг зүгээр төрийн захиргааны. Төрийн л байгууллага учраас адилтгаж тооцож байна гэсэн нэг иймэрхүү юмнууд дагаад дагаад ороод ирэх үүд нээгдэж магадгүй. Үүнийг болих хэрэгтэй.

Зүгээр нийтлэг заалт л байна уу гэхээс ингээд мэргэжлээр нь заагаад байх нь буруу байна. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

Гурав дахь асуулт. Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрыг нэмсүгтэй гэсэн байна.

Яах вэ, ингээд бодлогоо нэг цонхоор явуулж байя, эмхтэй цэгцтэй байлгая гэдэг үүднээс ингэж болох юм гэж бодож байна. Үүнийг дагаад дахиад янз бүрийн байдлаар төсөв, зардал нэмэгдэх элдэв янзын юм гарахгүй биз дээ. Орж ирэхгүй биз дээ. Ийм гурван асуултад хариулт авъя.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн сайд. Барилга, хот байгуулалтын сайд хариулна.

**Ц.Даваасүрэн:** Геодези, газрын харилцааны газар чинь одоо манай яамны харьяанд байгаа учраас тэнд ямар нэг зардал гарахгүй байхгүй юу. Бүгдээрээ л шилжинэ.

Тийм учраас тэнд нэмэлт төсөв, зардлын асуудал ерөөсөө байхгүй.

**Г.Занданшатар:** 84. Мижиддоржийн Санжаадорж. Сангийн яам, Төсвийн бодлогын газрын дарга.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Н.Энхболд гишүүний асуултад хариулья.

Эхний асуулт нь хөдөөд ажилласан төрийн албан хаагчийн ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцох асуудал байгаа.

Энэ дээр “болно” гэж үзсэн шалтгаан нь юу гэхээр энэ заалт нь доороо энэ болох, хэрхэн нэмэгдүүлэн тооцох нь Засгийн газар журмаар тогтоохоор заачхаад байгаа юм.

Жишээ нь, үр дүнтэй ажилласан байвал одоо тэрийг “болно”. Үр дүнгүй ажилласан байвал “**болохгүй**” ч гэдэг юм

уу. Ажиллаж байх хугацаандаа зөрчлийн асуудал үүсэх юм бол тэрийг ажилласан жилд нь тооцохгүй байх тийм нөхцөл үүсэх боломжтой гэж үзээд байгаа юм. Өөрөөр хэлбэл журам дээр илүү нарийвчилж оруулах юм.

Тэгэхээр үүнийг “**болно**” гэдгээр оруулчихаад байгаа. Журам дээр илүү нарийвчилчихна гэдэг асуудал нэг дэх нь.

Хоёр дахь асуудал нь, нягтлан бодох бүртгэлийн ажилчид сая хөдөө орон нутагт Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газартайгаа хамт иргэдийн саналыг сонсохоор ажиллахад нягтлан бодогч нар маш их гомдол тавьсан. Жишээ нь, сургуульд ажиллаж байгаа нягтлан байхад сургуулийнхаа албан хаагчид нь “**ТҮ**”, “**Б**”, “**Д**” гээд өөр ангиллаар ажиллаж байхад нягтлан бодогч нар нийтлэг “**ТҮ**” гэдэгтээ орчихсон байдаг.

Мөн цалин хөлс нь доогуур байдаг гэдэг асуудлууд орж ирсэн.

Тэгэхээр энэ дээр ямар шийдэл байж болох юм бэ гэдгийг нь бид харахдаа тухайн сургуульд ажиллаж байгаа нягтлан байх юм бол сургуулийн онцлогтой нягтлан хийж байгаа учраас сургуулийнхаа тэр ангилал, зэрэглэлээр цалинжаад явах, эмнэлэгт ажиллаж байгаа бол эмнэлгийнхээ ажлаар цалинжаад явах боломжтой гэж үзсэн.

Хуульд тусгайлан юу гэдэг юм, яг нягтлан бодох гэдгээр нь оруулах нь зохимжгүй байна гэж хэрвээ үзэх юм бол ажлын хэсэг дээр үүнийг нийтлэг “**ТҮ**” гэдэг байдлаар оруулж ирж болно.

Тэгсэн тохиолдолд одоо жишээ нь эмнэлэгт ажиллаж байгаа үйлчлэгч

байлаа гэж бодох юм бол одоо тэр аюулгүй хог хаягдал цэвэрлэдэг гэдэг агуулгаараа “ТҮМ” гэдэг тэр эрүүл мэндийн чиглэлийнхээ ангиллаараа цалин хөлсийг аваад явах ийм боломж бас бүрдэх боломжтой байгаа юм.

Өмнө нь бас тэгж явж байсан тийм практик байгаа.

Гурав дахь нь, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг одоо Барилга, хот байгуулалтын яаман дээр ажиллаж байгаа яг тэр бүтэц, бүрэлдэхүүн, орон тоо, мөн урсгал зардал, цалингийн сантай нь хамт яг тэр хэмжээгээр нь шилжүүлсэн учраас нэмэлт орон тоо, цалин, урсгал зардал огт нэмэгдэж байгаа зүйл байхгүй байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууна.

**Н.Энхболд:** Нэгдүгээр асуултын хувьд тэр 1 дүгээр зүйлийнхээ ард нь “болно” гэсний дараа энэ “**журмыг нь Засгийн газар гаргана**” гээд хүнд ойлгогдохоор тусгайлан биччихвэл болохгүй юу. Эсвэл өөр газар.

Тэгэхгүй л бол энэ чинь мухар. Хуулийн заалт ингэчихээр дараа нь Засгийн газраас тогтоол гарсан ч юм уу, гараагүй ч юм уу. Мэдэхгүй хүн бол өө..., энэ болно гэсэн байна гээд л. Болох болохгүйг нь би шийднэ гээд явчих ийм нөхцөл байдал үүсээд байх вий дээ.

Шууд энэ заалтынхаар бас энэ талаарх журмыг нь Засгийн газраас гаргана гээд биччихвэл болох уу? Эсвэл өөр газар тийм үг байгаа юм уу? Болно гээд л хэлчих. Тэгвэл би санаачлаад оруулчихъя. Тэрийг чинь.

**Г.Занданшатар:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Төсвийн байнгын хороон дарга асууна.

84. Мижиддоржийн Санжаадорж.

**М.Санжаадорж:** Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж. Н.Энхболд гишүүний асуултад хариулья.

Тийм. Үүнийг ажлын хэсэг дээр шийдэх боломжтой. Болно.

**Г.Занданшатар:** Хариулчихсан. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн байнгын хороо сая төсөв дагалдаж орж ирсэн хуулийн төслүүдийг хэлэлцсэн.

Хууль өргөн барьсан, хуулийн төсөл санаачилсан холбогдох салбарын сайд нар байгаагүй учраас чуулган дээр асууя гээд гишүүд хойш нь тавьсан.

Би хэд хэдэн асуудлуудыг тодруулж асууя.

Хууль зүйн талаасаа, цэвэр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж талаасаа, уул уурхайн бүтээгдэхүүний бирж талаасаа хэд хэдэн асуудлууд байна. Сайд нараас тодруулах.

Уул уурхайн биржийг бид уг нь. Нүүрсний хулгай өнгөрсөн онд гараад. Үүнтэй холбогдуулж Уул уурхайн биржийн тухай хуулийг дөнгөж хэдэн сарын өмнө баталсан. Улсын Их Хурал.

Тэгэхээр ерөөсөө Уул уурхайн биржийн тухай хуулийн амин сүнс чинь өөрөө энэ төрийн өмчийн компаниуд, тэдгээрийн хийгдэж байгаа гэрээ



хэлцлүүд. Магадгүй хуучин тэр урьдчилж хийж байсан, нууцалж хийж байсан “оффтэйк” гэрээнүүд, нүүрсний хулгайн асуудлууд л байсан шүү дээ. Ер нь бол.

Тэгээд бид цаашдаа энэ Монголын төрийн өмчийн компаниудаар дахиж ийм хулгай битгий нүүрлээсэй. Бүгд ил тод, зах зээлийн зарчмаар нээлттэй байдлаар арилжаалагддаг байгаасай гэсэн үндсэн дээр л уг нь хийсэн юм.

Тэгсэн одоор болохоор энэ хуулийн төсөл дээр яах вэ төрийн өмчит аж ахуйн нэгжүүд гэж байгаа юм. Сая Ж.Ганбаатар сайд тайлбарлахдаа тухайлсан төсөл гэж байгаа юм.

Тэгэхээр тухайлсан төсөл чинь төрийн өмчийн компанийн төсөл байх юм бол бас хамаарахгүй болчих. Урт хугацаанд энэ биржээр арилжаалах заалт чинь хамаарахгүй болчих нэг ийм байнгын шинж чанартай заалт орж ирчхэж байгаа юм биш үү? Энэ зарчим нь зөв юм уу гээд байгаа юм.

Бид тэгэхээр нүүрснийхээ хулгайтайгаа тэмцье гэхээд, хулгайтай эвлэрэхгүй, энэ асуудлыг таслан зогсооё гэхээд ингэж явж байгаа нь зарчмын хувьд зөв юм уу гээд байгаа юм.

Тэгэхээр тухайлсан төсөл байна уу, тухайлсан компани байна уу тэр төрийн өмчийнх л байвал ил тод, нээлттэй байх зарчмаар нь явуулбал яасан юм бэ л гэсэн нэг санал байна.

Хоёр дахь нь, Газрын тухай хууль яах вэ, зүгээр манайхан орон нутгийн эрх мэдэл талаасаа ингэж хандаж бас яриад байна.

Би том улс төрийнхөө шийдэл талаасаа харахаар нэг зөрчил үүсэх гээд байгаа байхгүй юу. Энэ юу гэхээр бид ингээд нэг талдаа эрх мэдлийг төвлөрүүлээд, Ерөнхий сайдынх нь доор эрхлэх асуудлын хүрээнд энэ агентлагийг нь аваачиж тавьдаг.

**Г.Занданшатар:** Асуулт. Ганзоригийн Тэмүүлэн гишүүний асуултыг эхнээс нь эхлүүлбье.

**Г.Тэмүүлэн:** Тийм.

Тэгэхээр хоёр дахь нь энэ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал.

Тэгээд Ерөнхий сайдын эрх мэдлийн хүрээнд, эрхлэх асуудлынх нь хүрээнд энэ агентлагийг аваачиж тавиад газрын асуудлуудыг тухайн газар олгох гэдэг юм уу, тухайн тэр газрын асуудалтай холбоотой бүх маргаан, энэ зөрчлийн асуудлууд ерөөсөө яг тэнд очиж таарах гээд байгаа юм.

Тэгэхээр би хууль зүйн талаасаа хараад байгаа зүйл чинь юу байна гэхээр ерөөсөө одоо юу гэдэг юм газартай холбоотой аливаа маргааны 30 хувь нь, ерөөсөө захиргааны шүүхээр орж байгаа аливаа маргааны 30 хувь нь газрын маргаан байдаг байхгүй юу. Маш олон маргаан гарч байгаа.

Тэгээд Монгол Улсын бүх иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад газар олгох энэ харилцаа чинь бүгдээрээ явж явж эцсийн эрхлэх асуудал нь Ерөнхий сайд дээр очиж таараад байдаг.

Тэгэхээр магадгүй аль нэг нь техникийн процессын алдаа гаргаад, магадгүй тэр хууль зөрччихсөн байна

гээд гараад ирчихвэл Ерөнхий сайд нь өөрөө энд хариуцлага хүлээх ийм нөхцөл байдал үүсчих вий дээ гэсэн байдал байгаад байгаа байхгүй юу. Би хууль зүйн талаасаа ингэж хараад байдаг.

Тэгэхээр магадгүй би зүгээр Ц.Даваасүрэн сайдын нөхцөл байдалд тайлбарлаж байгааг ойлгож байна.

Гэтэл хууль зүйн үр дагавар талаасаа жишээ нь Хууль зүйн яам энэ асуудлыг нь харсан юм уу? Эргээд юу гэдэг юм энэ Ерөнхий сайдыг төлөөлсөн хүн захиргааны хэргийн шүүх болгон дээр, маргаан болгон дээр очиж оролцоод байдаг. Тэгээд уначихдаг. Тэгээд магадгүй Ерөнхий сайд хууль зөрчсөн гээд эргээд Засгийн газартай хариуцлага яригдах асуудал Улсын Их Хурлаар орж ирэх асуудал болчих вий дээ. Тийм ээ. Тэгээд л Улсын Их Хурал тэр болгонд нь юу гэдэг юм хууль зөрчсөн юм уу, үгүй юм уу гэдгийг нь бараг авч хэлэлцэх болох гээд байна шүү дээ. Яг үндсэндээ. Хууль зүйн талаасаа бол.

Тэгэхээр үүнийг нэг харж үзээч.

Гурав дахь нь, аймаг, орон нутгийн удирдлагуудад Улсын Их Хурлын тогтоолоор үүрэг, даалгавар өгөх тогтоолын заалт бас орж ирсэн байна. 2024 онд Төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай гээд.

Тэгээд тогтоолын төслийн 3 дээр нь болохоор аймаг, сумын Засаг дарга нарт Улсын Их Хурал даалгах заалт байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө Улсын Их Хурал чинь шууд аймаг, сумын Засаг дарга нарт

албан даалгавар өгөх боломжгүй асуудал болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ магадгүй техникийн алдаа гарсан юм уу. Бусад хуулиас давсан зохицуулалттай харилцаа орж ирчхээд байгаа юм.

Дөрөв дэх нь, манай энэ Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үү, эсвэл хөрөнгийн биржээс санал өгсөн үү.

Хувь хүний орлогын албан татвар болоод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах харилцаа орж ирсэн.

Тэгэхээр энэ дээр юу байна вэ гэхээр гадаадын иргэн дотоодын иргэнтэй адил зарчмаар татвар ногдуулах харилцааг оруулж ирчхээд байгаа юм. Нөгөө бонд байна уу, үнэт цаас гаргах байна уу, эсвэл ногдол ашиг суутган татварын хөнгөлөлт үзүүлэх гэдэг харилцаа байгаа байхгүй юу.

Тэгэхээр би үүнийг жишээ нь магадгүй Санхүүгийн зохицуулах хороо гаднын хөрөнгө оруулалтынхаа орчныг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндсэн дээр хийсэн байж магадгүй.

Би зүгээр зарчмын хувьд шүү. Үүнийхээ дагалдах үр дагавар, сөрөг үр дагавар ч гэдэг юм уу үүсэж болох эрсдэлүүдийг нь тооцож үзсэн юм уу?

Энэ тогтвортой байдлын гэрээтэй, хөрөнгө оруулалтын гэрээтэй аж ахуй нэгжүүд чинь давхар энэ дээр хамрагдаад, ингээд нэг суутган татварын хөнгөлөлтүүд эдлээд байх, ногдол

ашгийнх нь татвараас зугтаагаад байх ч гэдэг юм уу энэ нөхцөл байдал орж ирж байгаа юм биш үү? Энэ чинь өөрөө үйлчилж байгаа нь байнгын тогтмол урт хугацаанд үүсэх байнгын шинж чанартай бас нэг ийм зохицуулалтын харьцаа болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр ингэснээр магадгүй бид татварын нэн таатай хөнгөлөлт үзүүлээд байдаг, эргээгээд ирээдүйд авах байсан томоохон татварынхаа орлогыг алдах энэ эрсдэл чинь гарч ирээд байгаа юм уу гэдэг байгаа юм.

Тэгэхээр мэдээж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж саналаа өгөөд л энэ хуулийн төслүүд л орж ирж байгаа юм болов уу гэж хараад байгаа юм.

Дээрээс нь Засгийн газрын үнэт цаас гаргах эрхтэй холбоотой асуудлууд байна. Үнэт цаас гаргах дээд хэмжээг нь тогтоогоогүй байгаа. Өрийн баталгаа гаргах дээд хэмжээг нь бас тогтоогоогүй байгаа.

Бид тогтвортой байдлын хууль, бусад хууль эрх зүйн орчныхоо хүрээнд ерөөсөө үнэт цаас гаргах болгонд л дээд хязгаарыг нь заавал ч үгүй тусгаж орж ирж байа гэсэн хуулийн зохицуулалттай.

Тэрийг нь Улсын Их Хурлаар тэр болгонд нь оруулж ирж батлуулж байх зохицуулалттай байгаа.

Гэтэл аль аль дээр нь байхгүй байгаа асуудлыг нь би ер нь дээд хязгаарыг нь тогтоох нь зүйтэй юм биш үү гэсэн нэг ийм хэд хэдэн анхаарах асуудлууд л байна даа.

Тэгээд энэ дээр та хэд маань.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Жамбалын Ганбаатар сайд.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Энэ төмөр замын холболтыг яагаад дэмжиж байгаа вэ гэдгийг.

Одоо манай өнөөдрийн тулгамдаж байгаа хамгийн гол асуудал бол ерөөсөө хүргэлт болчихоод байгаа юм. Биржээрээ хангалттай нүүрс зарах гээд байдаг. Оролцогч тал ч гэсэн их хэмжээний нүүрс авах гээд байдаг. Гэтэл хамгийн гол асуудал хүргэлт.

Тийм учраас энэ төмөр замын холболтыг холбосноороо биржийн үйл ажиллагааг 100 хувь дэмжиж байгаа юм.

Тийм учраас энэ холболтын ажил өөрөө биржийн үйл ажиллагаатай шууд хамааралтай болчихсон байгаа юм. Харин таны болгоомжлуулж хэлж байгаа энэ чинь өөрөө ингээд бүр дараа дараагийн олон юмны хаалгыг нээчих вий гэдэг дээр яг бүлэг дээр болгоомжлуулж хэлснийг би тийм байх магадлалтай гэж харсан учраас Д.Тогтохсүрэн даргын хэлж байгаа тэр нарийвчлаад зөвхөн энэ төсөл шүү гэдгээр нь үүнийг ингээд хаая гэдэг дээр. Би тэрийг тийм байх, тийм байна гэж ойлгож байгаа.

Түүнээс биш юу гэдэг юм зүгээр хэн нэгэн компанийн юм уу, ганцхан удаагийн байдлаар энэ харилцааг Засгийн газар дэмжээгүй шүү.

Г.Тэмүүлэн дарга аа. Хамгийн гол нь биржийн үйл ажиллагааг дэмжихийн тулд хил гаалийн нэвтрэх чадварыг дээшлүүлэх хэрэгтэй болчихдог. Тэгээд

хил гаалийнхаа нэвтрэх чадварыг дээшлүүлэхийн тулд энэ төмөр замын холболт зайлшгүй хэрэгтэй байгаа юм.

Тийм учраас зөвхөн энэ төмөр замын холболт гэдэг дээр л анхаарал хандуулж байгаа юм.

Түүнээс биш энэ хаалгаар бас таны хэлж байгаа Биржийн тухай хууль болзөвхөн төрийн өмчит компаниуд заавал зарах үүрэгтэй. Хувийн компаниудад үүрэг байхгүй. Зүгээр сайн дураараа оролцох л боломжтой. Тэр бол маш зөв.

Тийм учраас ялангуяа “Эрдэнэс Тавантолгой” компани ийм байдлаар хаалга нээгдээд биржийн бус замаар явчих вий гэдэг дээр би 100 хувийн болгоомжлол дээр нь хүлээж сонсож байна.

Гэхдээ энэ төмөр замын холболт өөрөө биржийн үйл ажиллагааг 100 хувь дэмжиж байгаа учраас төмөр замын холболтыг маш хурдтай, богино хугацаанд.

Тэгээд энэ харьцаж байгаа компани нь өөрөө Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит маш томоохон компани шүү дээ.

Тийм учраас бид яг энэ тусгайлсан төслийг салбарын сайдын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ ингээд нарийвчлаад өгөх нь зөв өө гэдэг дээр санал нэгтэй байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Дашзэвэгийн Амарбаясгалан. 91. Хариулна.

**Д.Амарбаясгалан:** Г.Тэмүүлэн гишүүний асуултад нэмж хариулья.

Энэ оны 07 дугаар сарын 07-нд Улсын Их Хурлаас 68 дугаар тогтоол батлагдсан. Энэ хүрээнд Засгийн газар энэ тогтоолын хэрэгжилтийг хангахаар ажиллаж байгаа.

Сая Ж.Ганбаатар сайд үндсэндээ тайлбарлалаа.

2012 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс талаас энэ Ганцмод, Цагаанхад чиглэлийн төмөр замын холболтыг хийх хоёр талынхаа яриа хэлэлцээрийн хүрээнд цаад талаасаа төмөр замаа татаад ирчихсэн байдаг.

Бидний хувьд сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд улс төржилтөөсөө болоод энэ холболтынхоо асуудлыг нэг мөр шийдэж чадалгүй өнөөдрийг хүрч ирсэн.

Хятадын талаас тавьж байгаа шаардлага юу вэ гэхээр цаашдаа Монгол Улсын нүүрснийхээ экспортыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд хамтарч ажиллая.

Тэгэхдээ Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн энэ төмөр зам цаашаагаа Хятадын тал руу шууд холбогдох нөхцөл хамгийн эхний шаардлага юм. Яагаад гэвэл 10 жилийн өмнө хоёр улс ярилцсан. Хятадын талаас 2 тэрбум гаруй долларын хөрөнгө оруулалт хийчихсэн.

Үүнийг Монголын тал хариуцлагаа үүрч холболт хийх нөхцөлөө бүрдүүлэхгүй тохиолдолд бусад холболтын цэгүүд үүнийг дагаад

удаашрах юм гэсэн ерөнхий нөхцөл үүссэн юм.

Тийм учраас энэ холболтыг хийж дараа жилүүдээс эхлээд бид жилдээ доор хаяж 60 сая тонн нүүрсийг экспортод гаргах нөхцөлөө хангах үүднээс Улсын Их Хурал дээр энэ тогтоолын төсөл хэлэлцэгдэж батлагдсан гэж үзээд хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа.

Зарчмын хувьд зах зээлийн болон өнөөдөр Засгийн газрын баримталж байгаа зарчмаас хазайж явахгүй гэдгийг сая Ж.Ганбаатар сайд үндсэндээ хэлж байна.

Биржээр борлуулагдаж байгаа нүүрсний жишиг үнэ, Монгол Улсын хилээр 6 хилийн боомтоор экспортод гарч байгаа нүүрсний жишиг үнэ зэргийг харгалзан үзэж хил нөхцөлтэйгөөр экспортод гаргах ажил явагдах юм.

Ер нь Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хийж байгаа хэлэлцээрийн хүрээнд цаашдаа бид 60 сая тонноор тогтохооргүй 70, 80, 90 сая тоннд хүргэх бодлого хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд тогтвортой томоохон худалдан авалтыг Улсын Их Хурлын түвшинд яригдаж шийдэх нь зөв юм гэж үзэж ажиллаж байна.

Хоёр дахь нь, Газрын тухай хуультай холбоотой энэ нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг ярьж байна.

Зүгээр Улсын Их Хурлын гишүүд маань харьцангуй буруу ойлголт авсан юм болов уу гэж бодлоо. Яагаад гэхээр энэ газар олголтын асуудлыг Ерөнхий сайд өөрийнхөө дэргэдэх агентлаг дээр авчирч байгаа зүйл огт биш байгаа.

Монгол Улс газрын төлөвлөлтийн нэгдсэн системтэй байх үүднээсээ аливаа орон нутгийн удирдах байгууллагын гаргаж байгаа төлөвлөлт нь улсынхаа бодлого төлөвлөлттэй уялддаг байх ёстой л энэ зарчмыг хангаж байна.

Нэг ёсондоо аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдаж байгаа төлөвлөгөө нь Монгол Улсын Геодези, зураг зүйн газрын ерөнхий төлөвлөгөөтэйгөө уялдсан эсэх дээр дүгнэлт гаргуулаад эргээд өөрсдөө л олголтоо хийнэ, өөрсдөө л хариуцлагаа хүлээнэ.

Тэр нь Монгол Улсынхаа бодлоготой нийцэж байна уу, үгүй юу гэдэг асуудлыг л Засгийн газрын түвшинд авч үзэх гэж байгаа юм. Түүнээс Засгийн газар дээр нэг ч газар олголт хийгдэх юм байхгүй.

**Г.Занданшатар:** Ганзоригийн Тэмүүлэн гишүүн. Төсвийн байнгын хороон дарга тодруулна.

**Г.Тэмүүлэн:** Сая хэд хэдэн асуултууд бас хариулагдаагүй л явчихлаа.

Саяын тэр нөгөө үнэт цаастай холбоотой ч гэдэг юм уу. Тэр юун дээр бас тайлбар өгөхгүй ингээд маргаан, үл ойлголцол үүсгээд байх вий.

Би сая тэр газартай холбоотойгоор захиргааны шүүхээр орж байгаа ерөөсөө дийлэнх маргааны чинь 30 хувь нь газартай холбоотой, газар давхцуулж олгосонтой холбоотой, чөлөөлсөнтэй холбоотой ч гэдэг маргаанууд байгаад байдаг.

Гэтэл яг эцсийн энэ асуудал хариуцсан субъект чинь Ерөнхий сайд өөрөө болчих гээд байдаг.

Тэгэхээр Ерөнхий сайд сүүлдээ магадгүй тэр шүүхийн шийдвэр дээр ялагдсан байвал Засгийн газар ялагдсан уу, Ерөнхий сайд ялагдсан гэдэг ийм улс төрийн үр дагавартай болчихоод байхгүй юу.

Тэгэхээр Хууль зүйн сайд та магадгүй хууль зүйн үр дагаврыг нь анхаарах ёстой байхгүй юу. Энэ чинь хууль зүйн маш том үр дагавартай энэ асуудал дээр яаж хараад байгаа юм бэ? Үүнийг тооцож үзсэн юм уу?

Эргээд шүүхийн маш олон процедурын болоод техникийн алдаатай шийдвэрүүд шүүхээр гардаг. Эргээд дахиад Улсын Их Хурал авч хэлэлцэх асуудал болчих юм биш үү? Энэ дээр нэг тайлбар өгөөч гэх гээд байгаа юм.

**Г.Занданшатар:** Эхлээд Дашзэвэгийн Амарбаясгалан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд хариулна.

**Д.Амарбаясгалан:** Тийм. Яг Г.Тэмүүлэн гишүүний хэлээд байгаа энэ захиргааны хэргийн шүүх дээр очиж маргаан үүсээд байгаа асуудал нь өнөөдөр бүх түвшиндээ нэгдсэн бодлогогүй байгаагаас үүдээд бий болжээ гэж дүгнэж байгаа юм.

Дөнгөж саяхан Ерөнхий сайд ахалсан газар зохион байгуулалттай холбоотой манай Барилга, хот байгуулалтын сайд оролцсон Үндэсний хороо байгуулагдаад, хороон дээр ажил байдалтай танилцахад Монгол Улсын хэмжээнд 9 газар өөрсдийн эрх мэдлийн

хүрээнд газар олголтыг шууд хийж байгаа юм.

Энэ нь хоорондоо уялдаа холбоо байхгүй байгаад байгаа учраас Ерөнхий сайдын дэргэд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар ирснээрээ улсын хэмжээний газар олголт зохион байгуулалтын асуудлыг нэгдсэн бодлогод нэгдүгээрт нь оруулна.

Хоёрдугаарт нь, энэ бодлогод нийцсэн орон нутгийн Иргэдийн хурлын шийдвэр нь цаашлаад Засаг дарга нар газраа олгох эрх нь үүснэ гэж л ойлгох хэрэгтэй.

Тэгэхээр Засгийн газрын түвшинд юм уу, Ерөнхий сайдын харьяа агентлагийн түвшинд ямарваа нэгэн байдлаар газар олгох шийдвэр гаргах эрхийг авч байгаа зүйл огтоосоо биш.

Улсын хэмжээний нэгдсэн бодлогын зохицуулалтыг хийж өгч байгаа л гэж энэ талаас нь ойлгох юм бол зөв болов уу.

Үүнийгээ баталгаажуулсны үндсэн дээр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар, Байгаль орчны яам, нөгөө дархан цаазат газруудын түвшинд газар олголтын асуудал нь аливаа байдлаар давхардал үүсэхгүйгээр шийдэгдэх боломж нь үүснэ.

Цаашдаа таны саяын хэлээд байгаа Захиргааны хэргийн шүүх дээр нийслэл олгочихсон газар, дүүрэг олгочихсон газар гээд хоорондоо зөрчилдөөд маргаан үүсдэг байдал чинь нэгмөсөн таслан зогсоогдох нөхцөл рүү бид оруулах гэж хичээж байна л гэж ойлгож болно.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн сайд нэмье. Нэмж хариулна.

**Ц.Даваасүрэн:** Г.Тэмүүлэн гишүүн ээ,

Одоо ч гэсэн Ерөнхий сайдын дэргэд агентлагууд байгаа шүү дээ. Тэр агентлагууд дээр гарсан шийдвэрийн төлөө Ерөнхий сайд хариуцлага хүлээхгүй шүү дээ. Шүүх дээр очоод.

Ялангуяа өөрийн чинь асуугаад байгаа шиг хамгийн их захиргааны хэрэг дээр очиж байгаа агентлаг нь Төрийн өмчийн хороо.

Төрийн өмчийн хорооны гаргаж байгаа тэр шийдвэрүүдтэй уялдаад Ерөнхий сайд гэдэг юм уу, Засгийн газрын хууль зөрчлөө гэдэг асуудал хөндөгддөггүй.

Тийм учраас тийм асуудал гарахгүй. Газрын агентлагаа өөрөө энэ асуудлаа шийдвэрээ гаргаад хариуцаад явах учраас тэр тал дээр санаа зовох зүйл гарахгүй. Яг бусад Ерөнхий сайдын дэргэдэх агентлагуудтай ижилхэн гээд ойлгогчхож болно.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд. Хууль зүйн бичилт нь.

Төсвийн байнгын хороон дарга Хууль зүйн сайдаас асуусан.

**Б.Энхбаяр:** Газрын харилцааны мэргэжлийн удирдлагыг нэгдсэн төвлөрсөн байдлаар зохион байгуулж байсан туршлага манай улсад байгаа.

Энэ шинэ тутам биш. 2002 оны Газрын тухай хуулиар Монгол Улсын

Ерөнхий сайдын харьяанд анх Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг байгуулж байсан.

Яагаад гэхээр тухайн үед газрын харилцааны асуудал 5 сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан.

Хөдөө аж ахуйн газар хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудал, тусгай хамгаалалт Байгаль орчны сайдын эрхлэх асуудал, хот суурин газар Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудалд, уул уурхайн газар Уул уурхайн сайдын эрхлэх асуудалд гээд.

Эндээс улбаалаад бас асуудлууд үүсдэг. Тухайн үеийн газрын харилцаан дээр гол гарсан гажуудал нийслэл болон дүүрэг, аймаг болон сумдын Засаг дарга нар төв Засгийн газартайгаа асуудал үүсгэдэг. Газар давхцуулдаг. Газрын наймаа цэцэглэсэн асуудал байдаг юм.

Тэгэхээр энэ алдаа дутагдлыг Монгол Улсын Ерөнхий сайдын харьяанд мэргэжлийн удирдлагын хувьд хангаад, яг хуулийн текстийн хувьд үнэхээр Засгийн газар өөрөө газар олгох, эзэмших, ашиглах захирамж гаргахаар бичигдсэн бол энэ алдааг хуулийн хэлэлцүүлгийн шатад мэдээж залруулж таарна.

Яагаад гэхээр Г.Тэмүжин гишүүний хэлж байгаа асуудал дээр нюанс байна. Өнөөдөр **“газар эзэмших”** эрхийн гэрчилгээ авсан **500 мянган** иргэн, хуулийн этгээд байгаа. **“Газар өмчлөх”** эрхийн гэрчилгээ авсан **300 мянга** орчим байгаа.

Тэгэхээр 800 мянга орчим газар **“эзэмших”, “ашиглах”, “өмчлөх”**-тэй холбоотой эрхийн харилцаан дээр төв

Засгийн газар өдөр тутмын шийдвэр гаргана гэж мэдээж байхгүй.

Үндсэн хууль ёсоор Засгийн газрын шийдвэрийг Улсын Их Хуралд хүчингүй болгох эрхтэй. Улсын Их Хурал өдөр болгон газар эзэмших, ашиглах Засгийн газрын шийдвэрийг хэлэлцээд явна гэж бас байхгүй. Үндсэн хуулийн цэц мөн байхгүй.

Тэгэхээр үүнийг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Д.Амарбаясгалан дарга аа, таны хэлж байгаа санаа танилцуулга дээр ч яах вэ, ер нь тийм байж болж байгаа юм.

Газрын нэгдсэн бодлого. Тэр нь яамандаа очоод газрын нэгдсэн сангийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад.

Энэ дээр бичилт нь төрийн захиргааны байгууллагын дүгнэлтэд үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглах эрх олгох шийдвэр гаргах нь Засгийн газрын бүрэн эрхэд хамаатай болчихоод байгаа байхгүй юу.

Энэ бичилтийн техникийн алдаа бол үүнийг залруулж явахгүй бол, саяын ойлголтоор явахгүй бол яг бичилтийн хувьд тэгж уншигдана.

18 дугаар зүйлд Засгийн газрын бүрэн эрх гэсэн хэсэг байгаа юм. Тэгээд үүнийгээ болохоор нөгөө аймаг, сум энэ тэрийнх хасагдчихаж байгаа юм.

Дараагийн 3 дугаар зүйл дээр Газрын тухай хуульд байгаа.

Тэгэхээр үүнийг тэгж ойлгож л явахгүй бол. Яаман дээр газар зохион

байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж батлах нь очоод, газар олгох нь Засгийн газраас очоод байгаа нэг ийм л техникийн зөрчил байгаа.

Хэрвээ энэ нь бичилтийн алдаа байна гэж үзэх юм бол үүнийг хэлэлцүүлгийн явцад засаад л явна гэж тохироод л явах л хэрэгтэй юм шиг байна.

Та яг юугаа үзээрэй. За юу. Бичилтээ. Б.Ганбат дарга үз дээ. Б.Ганбат дарга аа, нааш ир.

Мөнхөөгийн М.Оюунчимэг гишүүн. Уучлаарай. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** Гурав дахь асуулт нь би юу асуугаад байгаа шүү дээ.

Санхүүгийн зохицуулах хороо оруулсан юм уу, Хөрөнгийн биржээс санал өгсөн юм уу?

Гаднын хөрөнгө оруулалтаа татах, гадаад хөрөнгө оруулалтын орчноо сайж сайжруулах үүднээс гаднын иргэн Монгол Улсын дотоодын иргэнтэй ажил зарчмаар татвар ногдуулах харилцааг оруулж ирчхээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ чинь яг үүгээрээ зарчим нь та нар зөв. Гэтэл ногдол ашгийн гэдэг юм уу, эсвэл тэр суутган татварын хөнгөлөлтүүдийг эд нарт урт хугацаанд байнга үзүүлээд байхаар чинь эргээд магадгүй энэ хөрөнгө оруулалтын гэрээтэй, урт хугацааны гэрээтэй, магадгүй тогтвортой байдлын гэрээтэй аж ахуйн нэгжүүд дээр чинь давхар үүсэх сөрөг үр дагаврууд байгаа юм уу, байхгүй юм уу? Энэ нөлөөллийг нь судалж үзсэн юм уу? Ямар тооцоо, судалгаа үзсэн юм.



Яагаад энэ аж ахуйн нэгжүүдэд гаднынхан давуу байдал олгох энэ нөхцөл байдлыг хийгээд байгаа юм бэ л гэдэг асуудал байгаа юм.

Тэгээд судалгаатай хандсан юм уу гэдэг асуудлыг яриад байгаа шүү дээ.

Санхүүгийн зохицуулах хороо энэ дээр судалгаа хийсэн үү? Тооцож үзсэн үү?

Энэ дээр өөрсдөө ирж хуулийнхаа төсөл бодвол санаачилсан бол энэ үзэл баримтлал, агуулгыг нь тайлбарлаад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Санхүүгийн зохицуулах хорооноос асуусан уу? Бямбарагчаагийн Тэлмүүн.

**Б.Тэлмүүн:** Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн Г.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг дагаад нэмэлт, өөрчлөлтийн хуулиар энэ бол зөвхөн хувьцаа, үнэт цаас борлуулсны орлоготой холбоотой асуудал.

Энэ дээр ногдол ашгийн болон бусад төрлийн орлогын татварын хөнгөлөлт байхгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энд гадаадын оршин суугч бус татвар төлөгчид давуу эрх олгох илүү хөнгөлөлт үзүүлэх тухай асуудал тусгагдаагүй.

Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх

бодлогын үр дүнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 онтой харьцуулахад 69 хувиар өссөн байгаа.

Гэтэл Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцож байгаа этгээдүүдийн статистикийг харахад дотоодын аж ахуйн нэгж, иргэний тоо 21 мянга, гадаадаас хөрөнгө оруулж байгаа этгээд 75 ширхэг байгаа.

Тэгэхээр бид цаашдаа хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын хөрөнгө оруулагч яг олон улсын жишигт байдаг нийтлэг зарчмын дагуу ижил нөхцөлөөр татварынхаа ногдлыг тооцдог болох энэ зохицуулалтыг оруулж байгаа.

Түүнээс биш гадаадын этгээдэд илүү таатай хөнгөлөлт үзүүлж байгаа асуудал байхгүй.

Таны хэлсэн ногдол ашгийн орлоготой холбоотой асуудал нь одоогийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.5-д цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй этгээдэд зөвхөн үйлчлэхээр ингэж хязгаарласан байдгийг бас тодруулан хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төсвийн байнгын хороон дарга тодруулж асууна.

**Г.Тэмүүлэн:** Б.Тэлмүүн дарга аа, Хувь хүний орлогын албан татвар дээр чинь Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч дотоодын үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулан худалдан авсан хувьцаа, өрийн хэрэгслээ борлуулахад татвар ногдуулах орлогыг гээд ингээд ерөөсөө та хэдийн хуулийн чинь төсөл

дээр, үзэл баримтлал дээр, танилцуулга дээр чинь байгаад байгаа байхгүй юу.

Цаашид гадаадын стратегийн хөрөнгө оруулагчийг оруулж ирэхэд сөргөөр нөлөөлж байгаа энэ асуудлыг бид арилгах гэж ингэж хийж байгаа юм гээд биччихээд. Тэгсэн мөртлөө энэ дээр бид нэн таатай давуу байдал олгож байгаа зүйл байхгүй гээд яриад байдаг чинь юу гэсэн үг юм бэ?

Тэгээд би энэ чинь давхар татвартай болоод, давхар татварын гэрээтэй, хөрөнгө оруулалтын гэрээтэй аж ахуйн нэгж ч гэдэг юм уу энэ асуудлууд дээр чинь сөрөг үр дагавар үүсгэх юм уу, тооцоо судалгааг нь хийсэн юм уу? Үүнийг хийснээр та нар яг ямар хэмжээний хөрөнгө оруулалт орж ирэх гээд байгаа юм. Эсвэл үүнийг хүлээгээд байгаа гаднын аж ахуйн нэгжүүд байгаа юм уу гэдэг асуудлуудыг асуугаад байгаа шүү дээ.

Тооцоо, судалгаа хийчхээд магадгүй юу гэдэг юм тийм хэмжээний үр дагавар хөрөнгө оруулалт орж ирнэ гэдэг.

Гэтэл эсрэгээрээ үр дагавар нь тэр хэмжээний хөрөнгө оруулалтыг, татварыг бид авахгүй болж байгаа юм гэдэг тооцоо судалгаа байх ёстой болчихоод байгаа байхгүй юу.

**Г.Занданшатар:** 85.  
Бямбарагчаагийн Тэлмүүн.

**Б.Тэлмүүн:** Энэ дээр зөвхөн олон улсад үнэт цаас борлуулсны орлогыг **capital gain** [хөрөнгийн өсөлтийн ашиг] буюу тухайн үнэт цаас, хөрөнгийн худалдаж авсан үнэ, борлуулсан үнийн зөрүү ашгаас тооцдог нийтлэг зарчимтай.

Монгол Улсын нэгдэн орсон нийт 26 давхар татварын гэрээтэй улсын хувьд яг энэ зарчмын дагуу үйлчилдэг.

Гэрээгүй улсын хувьд одоо манай орчин ямар байна гэхээр гадаадын хөрөнгө оруулалт Монголын хөрөнгийн биржид хувьцаа худалдаж аваад борлуулахад нийт дүнгийнхээ 20 хувиар татвар төлж байгаа.

Тэгэхээр бид хөнгөлөлт үзүүлэх биш, олон улсын жишиг болон одоо дотоодын хөрөнгө оруулагчтай ижил нөхцөлөөр тооцдог болно.

Гэхдээ гаднын хөрөнгө оруулагчдын тооцож байгаа 20 хувийн татвар нь одоо хэвээрээ байгаа. Дотоодын аж ахуйн нэгж, иргэн 10 хувийн татвар төлөх нь хэвээрээ.

Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулагчийн хувьд хоёр дахин илүү татвар нь хэвээрээ байгаа. Бид тооцох зарчмаа нийцүүлж байгаа.

Тооцоо судалгааны хувьд би түрүүн хэллээ. Одоо хөрөнгийн биржид гадаадын хөрөнгө оруулагч нар ороход энэ хуулийн заалтаас болоод та нар дотоодын хөрөнгө оруулагчдаасаа ялгаатай олон улсад байдаггүй ийм хатуу дэглэм үйлчилж байна.

Тийм учраас та нар энэ зохицуулалтаа ч олон улсын жишигтэй нийцүүлээч ээ гэсэн ийм асуудал тавьсан.

**IPO** хийх гэж оролдож байгаа Төрийн банк, нэмж хувьцаа гаргах гэж оролдож байгаа Төрийн банк, Монголын хөрөнгийн бирж ч гэдэг юм уу эдгээр байгууллагууд гаднын стратегийн

хөрөнгө оруулагчидтай харьцахад энэ асуудлыг тэргүүн ээлжид тавьж байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг шийдсэнээрээ хөрөнгийн бирж дээр гаднын стратегийн хөрөнгө оруулагч нар орох энэ боломж нээгдэнэ.

Тодруулаад дахиад хэлэхэд Монгол Улсаас бусад улс оронтой байгуулсан 26 улсын давхар татварын хэлэлцээрийн дагуу яг одоо бид нарын энэ өргөн барьсан төслийн дагуу татварт тооцогдох суурь зарчим нь үйлчилж байгаа.

**Г.Занданшатар:** Төсвийн байнгын хороон дээрээ сайн ярилцъя. Тийм ээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

**М.Оюунчимэг:** Одоо Монгол Улсын Засаг захиргааны нэгжийн тухай хууль дээр ч байгаа. Монгол Улсын нийслэл гэдэг бол улс төр, эдийн засаг, нийгмийн гол төв нь.

Өчигдөр Монгол Улсын Засгийн газрын тэргүүн 2024 оны улсын төсөв бол энэ хот, хөдөөгийн тэнцвэрт хөгжлийг дэмжих суурь агуулгатайгаар батлагдсанаараа онцлог гэж хэлсэн.

Орон нутгийг дэмжих, хөдөөг сэргээх **“5 цагариг”** төсөл. Төсөвтэй холбоотой хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжуудыг харахад орон нутагт орон сууц барьж ашиглалтад орвол аж ахуйн нэгжүүдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, төрийн албан хаагчдын тогтвортой суурьшлыг нь хангах, цалин хөлсийг нэмэх.

Саяхан бид нийгмийн даатгалын багц хууль батлахдаа малчдын татварыг

50 хувь хөнгөлсөн гээд үнэхээр цогц арга хэмжээ, хууль эрх зүйн хувьд, санхүүжилтийн хувьд ийшээ явж байна л даа.

Гэтэл энэ хууль дээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын 1 сая 700 орчим хүн амтай хот дээр ямар тэнцвэрт байдлыг хангасан зүйл анхаарах юм бэ?

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байна, Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайд байж байна.

Засгийн газар дээр Б.Энхбаяр сайд, Н.Учрал сайд гээд хотоос сонгогдсон гишүүд байна. Бид тойрог тойглох тухай огт ярихгүй байгаа. Харин хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах суурь болно гэж яриад байгаа хэрнээ өнөөдөр Улаанбаатар хотын хүн амын 70 гаруй хувь нь амьдарч байгаа. Жишээ нь, гэр хороолол КОВИД-оос хойш, 2020 оноос хойш бүр орхигдчихсон.

Тэгээд нийслэл Улаанбаатар хот нь хариуцах юм уу, эсвэл Барилга, хот байгуулалтын яам нь тэр дэд бүтэцжүүлэх, орон сууцжуулах ажлыг нь хариуцах юм уу.

Саяхан Х.Нямбаатар дарга газартай холбоотой бүх газар олголтыг зогсоохоо мэдэгдсэн. Сая Барилга, хот байгуулалтын сайд газартай холбоотой асуудлыг цэгцэлж байгааг бас хэлж байна.

Гэтэл нийслэл Улаанбаатар хотод хамгийн том асуудал өнөөдөр газрын төлбөр, үнэлгээтэй холбоотой асуудал,

бас энэ газартай холбоотой асуудал байгаа.

Би тэгээд энэ дээр нэг санаа хэлэх гээд байна л даа. Үнэхээр хот, хөдөөгийн тэнцвэрт байдлыг хангах, дэмжих суурь агуулгатайгаар бид улсын төсвөө 2024 онд батлах гэж байгаа юм бол ядахдаа энэ дээр орон нутагт орон сууц барьж ашиглалтад оруулах аж ахуйн нэгжид татварын хөнгөлөлт үзүүлэх гэдэг дээр орон нутагт болон нийслэл Улаанбаатар хотын гэр хороололд гээд оруулчхаж болохгүй юу?

Өнөөдөр гэр хороололд барилгын аж ахуйн нэгжүүд орохгүй байгаа. Манайхан бүгд мэдэж байгаа.

Нийслэл Улаанбаатар хотынхон та нарт энэ дэд бүтцийг нь суулгаад өгчихсөн 40 тэрбумын шугам сүлжээг нь татчихсан тэр газар байшинг нь бариадхаач ээ гэхээр аж ахуйн нэгжүүд орохгүй байгаа. Ямар ч хөнгөлөлт байхгүй.

Тэнд тэр иргэн, аж ахуйн нэгж хоёр газрын үнэлгээнээс болж хэрэлдсээр байгаад тэгээд ажил нь явдаггүй. Тэгээд сүүлдээ няцаад ингээд аж ахуйн нэгжүүд нь хаяад хаяад явчихдаг.

Тэгээд үнэндээ 30 жил энэ гэр хороолол чинь ингээд байгаад байх юм уу? Хүн амьдралаа босгочихсон тэр гэр хороололд амьдарч байгаа хүмүүс чинь нэгмөсөн хөдөө орон нутаг руу явъя гээд нүүгээд явчихгүй шүү дээ.

Босгосон амьдрал байна. Үр хүүхэд, сургууль соёл, эмээ өвөө, аав ээж гээд байж байна.

Мэдээж орон нутаг руу шилжих нь шилжих байх. Гэхдээ энэ чинь ганц гэр хорооллын асуудал биш. Нийслэл Улаанбаатар хотын 1 сая 700 орчим хүн амын агаарын бохирдол, хөрсний бохирдол, хүний эрүүл мэндийн асуудал, тэгээд хавдрын асуудал гээд бүх асуудалтай энэ чинь уягдаад яваад байна л даа.

Тэгээд энэ дээрээ нээрээ үнэнийг хэлэхэд дагалдах хууль дээр ч Улаанбаатар хотын гэр хорооллыг юм уу, эсвэл дэд бүтэцжүүлэхэд, агаарын бохирдлыг, хөрсний бохирдлыг бууруулахад ийм зүйлийг тусгаж байгаа, ийм хөнгөлөлт үзүүлнэ, ийм дэмжлэг байгаа гэсэн заалт үнэндээ хаана ч алга байгаад байна.

Тэгээд яах юм бэ, Улаанбаатар хотоо эсвэл бүр Улаанбаатар хот руу өгчхөж байгаа юм уу. Эсвэл Барилга, хот байгуулалтын яам нь үүнийг ингээд хариуцаад явах юм уу?

Би энэ дээр тодорхой хариултыг өгөөч ээ гээд Хэрэг эрхлэх газрын дарга ч байж байна. Ц.Даваасүрэн сайд минь, яах вэ.

Энэ гэр хорооллын дахин төлөвлөлт дээр ямар нэгэн хөнгөлөлтийг ядахдаа дагалдах хууль дээр оруулаад тэнд аж ахуйн нэгжүүд дуртайяа орох хөнгөлөлттэй нөхцөлийг суулгаж өгмөөр байна.

Дэд төвүүд яах вэ, Эрчим хүчний сайд аа, Сангийн сайд аа. Энэ дагах хуулиуд дээр Улаанбаатар хотын гэр хорооллыг. Ялангуяа энэ чинь өөрөө нөгөө хөрс, агаарын бохирдол, нөгөө утаатай холбоотой асуудал, энэ эко жорлон, энэ хөрсний бохирдлоос болж

сая үер усны үеэр юу болов. Тийм ээ. Өнөөдөр та нар эмнэлгүүдийг яваад үз дээ. Оргүй болчихсон байна. Хүүхдүүд.

Тэгэхээр үүнийг яаж тусгах вэ?

**Г.Занданшатар:** Хэн хариулах юм? Ц.Даваасүрэн. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Тийм. М.Оюунчимэг гишүүний хөндөөд байгаа асуудал чухал асуудал.

Өнгөрсөн Засгийн газрын хуралдаанаар яригдсан байгаа.

Яаралтай горимоор хоёр хууль орж ирнэ. Түгжрэлийн асуудал, гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудал.

Энэ дахин төлөвлөлтийн хүрээнд таны яриад байгаа гэр хорооллын дахин төлөвлөлт хийж байгаа компаниудад гаалийн, НӨАТ-ын татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг хөндсөн ийм хуулийн төслүүд орж ирнэ.

Тийм учраас Та үүнийг манлайлан дэмжиж өгөөрэй гэж би хүсэх байна.

Гэр хорооллын дахин төлөвлөлт дээр нэг үүсээд байгаа хүндрэл дулаан, эрчим хүчний дутагдлын асуудлууд байгаа.

Ер нь бид, би лав Эрчим хүчний сайдаар 2017 онд томилогдоод нэг зүйлийг хэлсэн шүү дээ. Хоёр, гурван жилийн дараагаас эхлээд эрчим хүчний дутагдалд орно шүү гээд. Жишээлбэл, ард иргэдэд тэр эрчим хүчний хөнгөлөлт гээд 800 тэрбум төгрөгийг шийдэж байхад би хэлсэн.

Та бүхэн тэр үед бас надыг дэмжээд л дуугарах хэрэгтэй байсан юм.

Энэ чинь станц барих мөнгө байна шүү дээ гэж.

Хэрвээ энэ мөнгөөр станц бариад өгчихсөн бол иргэдэд илүү тусах байсан байхгүй юу. Гэтэл 800 тэрбум хаачсан. Цахилгааны төлбөрт яваад л байхгүй болчихсон юм шүү дээ.

Тэгээд ер нь жил бүр хөрөнгө оруулалтын нэмэгдэж байгаа хэмжээн дотор 100 мегаваттын станц хийчих мөнгө хөрөнгө оруулалтын багц дотор уг нь шургуулчихвал шургуулчаж болмоор л байгаа юм л даа.

Үнэхээр Их Хурал тэгж сайн хандаж чадах юм бол, та нар сайн ярьж хоорондоо шийдэж чадах юм бол нэг дулааны станцын асуудал шийдэж болно.

Үүнийг шийдэхгүй бол хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн асуудал явахгүй. Яагаад гэвэл тэр чинь дулааны эх үүсвэргүй байгаа учраас.

Өөр нэг асуудал бол Чингэлтэй, Сонгинохайрхан дээр эх үүсвэр нь шийдэгдчихсэн байгаа. Энэ дээр бид дахин төлөвлөлтийн зургууд хийгээд явж байна.

Чингэлтэйн тэр дэд төв дээр ер нь болж өгвөл бид одоо ингээд хавраас манай барилгын компаниудыг яг энэ гаргасан зургийн дагуу гэр хорооллын дахин төлөвлөлтөд оролцооч ээ гэсэн ийм зүйлийг ярьж байна.

Мөн манай барилгын салбарын төрийн бус байгууллагуудтай ярьж байна.

Компаниудаа оролцуулах талаар Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт.

Төлөвлөлтүүдийг бид хийгээд явж байгаа гэдгийг танд хэлье. Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг дээр байгаа энэ дэд төвүүдээр бид ирэх хавраас эхлээд иргэдтэй хэлцэл хийсний дагуу дахин төлөвлөлтийн ажлуудыг эхлүүлнэ гэж төлөвлөж байна.

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. 1 минут тодруулж асууна.

**М.Оюунчимэг:** 2024 оны төсвийг чинь нэн шаардлагатай хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах гэж байгаа юм чинь.

Сая Ц.Даваасүрэн сайдын хэлж байгаагаар дулааны станцын эхний 2024-2030 он хүртэл гэдэг юм уу, яг тооцоо төлөвлөлтийг нь хийж байгаад эхнээсээ тодорхой хэмжээний хөрөнгийг нь суулгаад явчих бололцоо байгаа шүү дээ.

Одоо энд ашиггүй зардлууд гээд. Ашиггүй ч юу яах вэ, танах боломжтой зардлууд өчигдөр жишээ нь Аудитын газрын дүгнэлтээр байж байна.

Яг одоо жишээ нь 42 соёлын төв барих шаардлага байна уу? Яг одоо.

Гэтэл өнөөдөр төсөв хэлэлцэж байх үед энэ 1 дүгээр сургууль, Монгол Улсын ууган сургуулийн тааз нь нурж унаад хүүхэд гэмтээд бараг амь нас нь осолдох шахаад байж байна шүү дээ.

Энэ бодит нүүр ийм байгаа учраас бид энэ дагалдах хууль дээрээ ч гэсэн ийм заалтуудыг нь, ялангуяа Улаанбаатар хотын гэр хороололтой холбоотой

хөнгөлөлтийг ч гэсэн нэг өгүүлбэрийг нь ядахдаа оруулаад өгчихвөл улсын төсвийн хүрээнд дагалдах хуулиар ч энэ тусгагдсан.

Тэр ирэх долоо хоногт орж ирэх гэж байгаа хуулиуд байгаа юм байна. Үнэхээр талархаж байна. Энэ яаралтай орж ирэх ёстой.

Тэгээд үүнийг ингээд анхнаас нь тусгаад явчих бололцоо.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Ц.Даваасүрэн сайд хариулах уу?

Дулааны станц байгуулах асуудлаа төсөв дээр ярих байх л даа. Энэ төсөв дагасан хуулиуд дээрээ тэгж ярих юм уу?

Б.Чойжилсүрэн сайд, Баттогтохын Чойжилсүрэн сайд, Эрчим хүчний сайд, Б.Чойжилсүрэн сайд картаа уншуул.

**Б.Чойжилсүрэн:** М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Энэ удаагийн төсөв дээр Улаанбаатар хотын дулааны хангамжийг нэмэгдүүлэх ийм эх үүсвэр тавьж чадаагүй ээ, М.Оюунчимэг гишүүн ээ.

Төсвийн бололцоо, орон зай тийм хангалттай байгаагүй учраас.

Бид зүгээр Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр 116 мегаваттын дулааны станцын өргөтгөлийг Амгалан дулааны станц дээр. 4 дэх зуухыг нь тавьж байна гэсэн үг.

Энэ маань ойролцоогоор 6, 7 мянган айлын дулааныг хангачих

бололцоотой ийм эх үүсвэр. Одоо 2024 оны 12 сарын сүүл, 2025 оны 1 дүгээр сард ашиглалтад орно.

Хоёрдугаарт, яг танай дүүргийн хажуу талын Сүхбаатар дүүрэг дээр Сэлбэ дэд төв дээр дулааны эх үүсвэрийг иж бүрэн барьсан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр байх.

Одоо дулаанд холбогдох хүсэлт иргэдээс хангалттай гарч өгөхгүй. Сэлбэ дэд төв маань 30 хувь хүрэхгүй ачаалалтай ажиллаж байгаа. Ийм байна.

Баянхошуу дэд төв дээр Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр газан эх үүсвэр, газаар барих эх үүсвэр ашиглалтад ороод судалгааны зураг нь хийгдээд явж байгаа.

Манай яаман дээр Эрчим хүчний хөгжлийн үндэсний төв дээр 3 газын дулааны станцын зураг хийгээд бэлэн болчихсон байгаа. 70, 70 мегаваттын 3 газар.

Өвлийн ид оргил ачааллын үед буюу 12, 1, 2 дугаар саруудад нэмэлтээр залгахаар. 150 тэрбум төгрөг байсан тохиолдолд бид нэмэлт ачаалал авахаар ийм төлөвлөлт бий.

ТЭЦ-III-ын тухайд 500 мегаваттын дулааны станцын төсөл бас байгаа шүү дээ. Оросын Холбооны Улсын хөнгөлөлттэй эх үүсвэрээр баригдахаар.

Сая Монгол Улсын Ерөнхийлөгч.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Дагасан хуулиудтай шууд холбоотой асуултууд биш байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Г.Тэмүүлэн гишүүн Төсвийн байнгын хороон дээрээ холбогдох хэлэлцсэн асуудлаа ярьж бай. Чи наадах чинь холбоогүй асуудал ярьж байна. Хэлэлцэж байгаа асуудлаа ярьж сур. Төсөв дээр ярь.

Тэр орон сууцжуулах хууль орж ирэхээр ярь. Энэ сэдэв нь биш байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одонгийн Цогтгэрэл гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга.

**О.Цогтгэрэл:** Төсөв дагаж орж ирсэн хуулиудыг Их Хурал дээр хэлэлцэж байна.

Төсөв дагаж орж ирсэн Газрын тухай хууль гээд. Энэ чинь төсвийн хуулийг дагалдаж орж ирж байгаа Газрын тухай хуулийн энэ зүйл, заалтууд бүр Газрын тухай хуулийн өөрийнх нь үзэл баримтлалын шинжтэй ийм онцгой шинж чанаруудтай заалтуудыг хөндсөн учраас Ардчилсан намын бүлэг энэ дээр завсарлага авах хүсэлтэй байгаа юм.

Яагаад гэхээр ер нь сүүлийн үед бүхий л зүйлийг төвлөрүүлсэн. Орон нутгийн өөрөө удирдах ёс, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хууль, энэ олон зүйл бүгд байхгүй болсон.

Бүхий л томилгоо бүгдээрээ төвд Улаанбаатарт шийдэгддэг. Одоо явсаар байгаад орон нутагт үлдсэн, аймаг, сумд үлдсэн тэр газар зохион байгуулалтын эрх, газар олгох эрх гээд байдаг. Энэ нь

одоо бас Засгийн газарт ирэх юм байна. Энэ зүйл, заалтаар.

Яаж ч тайлбарласан хууль дээр байгаа үг, өгүүлбэрээр Засгийн газар шийднэ.

Би бүр 23.2.4 гэдэг заалтыг уншъя.

Улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагааг эрхлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг боловсруулж, Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.

Бүр улсын хэмжээнд гэдэг чинь аймаг, суманд бүх газар зохион байгуулалтын эрхийг ямар нэгэн байдлаар Улаанбаатарт л шийдэх юм байна.

Нөгөө нутгийн өөрөө удирдах ёс, 30 жилийн өмнөх Үндсэн хуулийн үзэл санаа, энэ бүгд хаачсан бэ?

Энэ ерөөсөө сүүлийн үед орж ирж байгаа хуулиуд, тэр тусмаа энэ Газрын хууль үзэл баримтлалын шинжтэй ийм том зүйл зүгээр төсвийн хуулийг дагалдаж орж ирээд л алх цохигдоод л гардаг.

Тэгэхээр заавал үүнийг нухацтай ярилцах ёстой ийм зүйл, заалт байна.

Тэгэхээр төсөв дагаж орж ирсэн хуулийн энэ Газрын тухай хууль дээр Ардчилсан намын бүлгээс ажлын 5 хоногийн завсарлага авъя.

**Г.Занданшатар:** Тэгэхээр О.Цогтгэрэл гишүүн ээ, Ардчилсан

намын бүлгийн дарга аа, ийм байгаад байна.

Дэгийн тухай хуулиар хэлэлцэж байгаа асуудлаар завсарлага авч байгаа учраас, энэ нэг асуудал учраас салгаж завсарлага авна гэсэн ойлголт байхгүй юм байна.

Тэгэхээр би Монгол Ардын намын бүлгийн дарга, Ардчилсан намын бүлгийн дарга хоёр зөвшилцөж ойлголцоод, Д.Тогтохсүрэн дарга олонхын бүлэг шийдвэр гаргасан энэ асуудал яригдсан байна. Таны ярьж байгаа асуудлыг.

Үүнийг ингэж хэлэлцэж шийдвэрлэе. Хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд.

Энэ шаардлага хангахгүй бол нэгдүгээр хэлэлцүүлгийн үед ч гэсэн буцааж болно.

Буцаах санал хураалт гаргая гээд. Та хоёр хэлэлцээд. Тэгээд одоо цаг хугацаа шахуу, хугацаатай асуудал учраас хэлэлцэж яваад, ингэж ойлголцоод хоёр бүлгийн дарга дээр ингээд нэгдсэн байр суурь дээрээ зарчмын тохиролцоонд хүрвэл.

Тэгээд яах вэ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тайлбарлаж байгаа санаа, танилцуулга арай өөр байна л даа.

Энэ бичилт дээр Хууль зүйн сайд ч гэсэн тэр техникийн алдаа байна. Үүнийг залруулах ёстой гэж үзэж байгаа.

18.10 дахь заалтыг өөрчилье л гэж бүгдээрээ ярилаа шүү дээ.



Хоёр бүлгийн дарга, олонх, цөөхөн бүлгийн дарга ярилцаад.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэлх гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу? Содномын Чинзориг гишүүнээр тасаллаа. Сайдыг хаслаа.

Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

**Ж.Батсуурь:** Манай бүлэг О.Цогтгэрэл дарга завсарлага авъя гэсэн. Би завсарлага авах нь зөв гэж байна.

Энэ дээр манай Ардын намын бүлгийнхэн уравганаж шаравганаад байх шаардлага байхгүй.

Яагаад гэхээр өнгөрсөн 3 жилд бид бүхэн КОВИД-ын нөхцөл байдлыг бодож, ер нь их айхтар сөрөг хүчин гээд л та бүхнийг боомилоод л, хашхичаад л, наана цаана гээд байсан түүхэн тохиолдол байхгүй.

Тэгээд хааяа нэг юм гараад эргэнгүүт, сая Байнгын хороон дээр яаж байгаа юм. Байнгын хороон дээр асуудлыг гаргаад тавингуут олонхоороо заавал тэрийг авч явах гээд. Бас нэг тийм дээ, ийм дээ гэж эргэж харж ярьдаг, барьдаг тэр юм та нарт үнэндээ байдаггүй шүү дээ.

Тэгээд л төсөв тийм байна, ийм байна, бүгдийг л ойлгодог. Нөхцөл байдал ийм байна гээд л бүгдийг ойлгодог.

Тэгэхдээ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага чинь Үндсэн хуульд

тусгайлан заачихсан. Би энд аймгийн дарга хийж байсан, аймгийн Хурлын дарга хийж байсан маш олон хүмүүс байж байдаг.

Ер нь Ерөнхий сайдын яриад байгаа бодлого чинь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлбэ, төвлөрлийг сааруулъя, орон нутагт эрх мэдэл өгье гэж яриад байх шиг байгаа юм.

Гэтэл бүх үйлдэл нь төвлөрүүлэн татсан. Мөн эрх мэдлийг нь булаасан.

Нэгжийн хуулиар бид яаж ч тэмцээд бараагүй шүү дээ. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг тэргүүлэгчгүй болгоод хаячихсан. Тэнд гардаг эрх мэдэл гэж үндсэндээ юм байхгүй болгочихсон.

Бүх салбарын хуулиудаар томилгоог босоо түвшинд хийж байна. Сая Боловсролын хуулиар гэхэд бүх сургуулийн захирлыг Боловсролын яам мэддэг байх жишээний. Одоо газрын хууль тэгээд бэлтгэгдчихсэн байж байна.

Тэгэхээр одоо аймагт юу үлдсэн бэ гэхээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд чинь төсөв батлах, газрын зохион байгуулалтыг хэрэгжүүлэх ийм л бүрэн эрх үлдсэн.

Түүнийх нь нэгийг нь одоо сугалаад авч байна. Сугалаад авч байна. Энэ нь өөрөө эдийн засгийг солонгоруулах бүх үйлдлийг боомилно.

Та бүхэн бод доо. Хувийн хэвшлийг дэмжинэ. Хувийн хэвшил бүтээн байгуулалтыг хаана хийх юм. Газар дээр хийнэ.

Тэгээд тэр багт өгөх гэж байгаа газрыг, суманд өгөх гэж байгаа газрыг, аймагт өгөх гэж байгаа газрыг Засгийн газар хянаж юугаа хийх юм.

Тэр том том бүтээн байгуулалтуудаа л хяналтдаа авч байдаг юм байгаа биз. Тэр угаалгын газар, тэр засварын газар, тэр 4 айлын орон сууц, эдгээр нэг шинэ төлөвлөлтийн асуудал. Үүнийг Засгийн газар мэдэлдээ авч юугаа хийх гэж байгаа юм.

Одоо нэг агентлаг бий болчихно. Тэгээд тэр агентлаг руу явсан бичиг ирдэггүй. Хэзээ ч ирэхгүй.

Тэгтэл чинь бүтээн байгуулах сар нь 4 сар, 5 сар, гурав, дөрөвхөн сар байдаг. 4 сард явсан бичиг аягүй бол 10 сард очно.

Ингээд эдийн засгийг боомилсон бүхий л үйл ажиллагааг энэ хуулиар оруулж ирж байна.

Ер нь тэгээд бид юм хэлдэггүй шүү дээ. Та нар ноднин дагасан хуулиар Шадар сайдын орон тоо оруулаад ирээд батлуулчихаж байсан.

Өнөөдөр дагасан хуулиар Газрын хуулийн бүтэн концепцыг бүгдийг өөрчилж байна шүү дээ.

Тэгээд үүнийг нь хэлэнгүүт уравганаж, шаравганаад ойлголцъё, мэдэлцье гээд ингээд явж байдаг.

Ажлыг нь дэмжээд байх тусам давраад байгаарай. Дандаа тэгдэг. Ер нь яг бид сөрөг хүчин хийе гээд. Бид бяргүйдээ ч тэгээд байгаа юм биш. Нөхцөл байдал гадаад, дотооддоо хэцүү байна. Нийгэм өөрөө бужигнаантай

байхад бид бас дайран дээр давс нэмээд яах вэ л гээд л үг хэлдэггүй. Нэгэнт эрх барьж байгаа юм. Нэгэнт 65-аараа явчихсан юм. Нэгэнт 62-оороо бүх бяр нь байж байгаа юм. Ерөнхийлөгч нь байгаа юм. Засгийн газар нь байгаа юм. Яах вэ дээ, тэртээ тэргүй ард түмэн харж байгаа байлгүй гээд ингээд байх тусам одоо сүүлдээ бүхэл бүтэн бүлгийг завсарлага авахад уравганаж, шаравганаад байдаг болчихсон шүү дээ.

Манай бүлгийн асуудлыг та нар мэддэг болчихсон юм уу. Танай бүлгийн асуудлыг бид мэддэггүй биз дээ.

Тийм учраас завсарлага авна.

Ер нь тухайн асуудал дээр ч гээд байх юм байхгүй. Тухайн асуудал дээр ч гээд байх юм байхгүй.

Тэгээд нэг хэсэг зөндөө л юм байгаа шүү дээ. Та нар ярьж болдог, бид яагаад ярьж болдоггүй юм. Бид нарыг хааяа нэг юм хэлэнгүүт л бүгдээрээ бид л нэг олох гэсэн шиг дайрч байх юм. Та нар.

Та нараас айдаг ер нь хэн байгаа юм. Тэгээд үг хэлүүлчих л дээ. Танай Засгийн газрын сайд нар яагаад үг хэлүүлэхгүй байгаа юм.

Та нарыг үг хэлж байхад хэн ингэж дуугардаг байсан юм. Араас чинь С.Чинзориг үг хэлүүлэхгүй байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Тайван амгалан байцгаа.

**Ж.Батсуурь:** Дуугүй байж байх ёстой юм уу? Та нар одоо ямар учиртай юм бэ?

Бид 5-хан минут, 3-хан минут олддог. Та нар 65-уулаа бид нар луу дайрна.

Завсарлага авья гэнгүүт өгүүлэхгүй гээд байх юм. Муулаагүй. Намайг үг хэлүүлэхгүй байна шүү дээ. Өөрсдөө үг хэлүүлэхгүй юм чинь юу ярих юм ямар.

**Г.Занданшатар:** Тайван байцгаа. Тайван амгалан байцгаая. Бие биеийнхээ үгийг сонсож сурцгаа.

28 санал хураалт явуулна. Энэ Газрын тухай хуулиар тусдаа санал хураалт явуулна. Тэр үед нь асуудлыг хойшлуулах, эсвэл завсарлага өгөхөөр шийдээд явчих болов уу гэж. Би зүгээр чиглэлээр авья.

Тэгэхээр одоо ингээд хэлэлцүүлгээ үргэлжлүүлье.

Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Яг тухайн хуулийн төслөөр нь завсарлага авахаар бид судалж байна. Тухайн үед нь шийдье. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Төсөв дагасан хуулиудын талаар түрүүн Төсвийн байнгын хороон дээр байр сууриа тодорхой илэрхийлсэн.

Засгийн газраас Их Хуралд өргөн баригдаад ороод ирчихсэн. Одоо Их Хурал асуудлаа ярих ёстой.

Тийм учраас би Их Хурлын ажлын хэсэг онцгой анхаарал хандуулж ажиллах ёстой. Хэд хэдэн хуулиуд байгаа юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Уул уурхайн биржийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Газрын тухай хууль гээд энэ хуулиуд дээр гишүүдийн ярьж байгаа санаа оноонуудыг авч, найруулга юмнуудыг нь нэлээн сайн янзлах ёстой.

Энэ дээр бүр онцгой анхаарах ёстой гэж.

Газрын тухай хууль дээр бүр тухайлан ярих ёстой. Үнэхээр орон нутгийн эрх мэдлийг саармагжуулсан, хязгаарласан ийм байдлаар асуудалд хандаад баймгүй байгаа юм.

Тийм учраас энэ 18.1.10 чинь бол юуг Засгийн газар батлах гээд байгаа нь хүртэл тодорхой байхгүй. Нэршилгүй болчихоод байгаа байхгүй юу. Ийм ийм хуулиудад нийцүүлж тийм юмны дүгнэлтийг үндэслээд ийм юм гарга гэж хэлчихээд байгаа. Тэгэхдээ юу юм тэр нь гэдэг нь мэдэгдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Нэршил байхгүй.

Тийм учраас ерөөсөө энэ Газрын тухай хуулийг буцаачихмаар байна. Энэ төсөвт ямарваа нэгэн нөлөө байхгүй. Угаасаа Засгийн газрын бүтцэд өөрчлөлт оруулаад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг нь Ерөнхий сайдын юунд авчирчихсан. Тэгээд энд ямарваа нэгэн өөрчлөлт байхгүй.

Газрын багц хууль өргөн баригдаж орж ирээд Засгийн газар буцаагаад татсан. Тэр хуулиар дахиж өргөн барих ёстой гэж би бодоод байгаа.

Тэр битгий хэл газрын нэгдмэл сангийн ангиллыг бид өөрчлөлтийг дандаа хөөж баталж яваад байгаа. Газар

үнэхээрийн л улсын үндэс мөн юм бол ангиллын өөрчлөлтөө урьдчилж харж төлөвлөөд тэгээд түүнийхээ дагуу гүйцэтгэлээ хянаад батламжилдаг хэлбэрээрээ явах ёстой байхгүй юу.

Тэгэхгүйгээр жаал бэлчээрийн хөдөө аж ахуйн газраас нь хот суурины газар луу татаж авчхаад л, гарсан гүйцэтгэлийг нь батламжлаад л яваад байгаа нь энэ уламжлалт аж ахуй орон нутгийн иргэдийн чинь амьдралд бас тодорхой хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлээд байгаа юм.

Тийм учраас яах аргагүй энэ Газрын хууль дээр нэлээн онцгой анхаарал хандуулж, төсөл өргөн баригчид нь буцаах хэрэгтэй. Энэ төсөв батлахад ямарваа нэгэн тийм зөрчил үүсэхгүй юм байна лээ. Би судалж үзсэн юм.

Энэ хуулиар төсөвтэй холбоотой зохицуулагдсан харилцаа байна уу гээд үзэхээр байхгүй байгаа. Ийм саналтай байна.

**Г.Занданшатар:** Дэмжихгүй үг хэллээ. Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хурал дээр ч хэлж байсан.

Ирэх долоо хоногоос Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах багц хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн барихаар ярилцаж байгаа.

Ер нь Монгол Улсын энэ болж бүтэхгүй Улаанбаатар хотын түгжирсэн, утаажсан, орон сууц эмх замбараагүй болсон, хүүхдэд ээлгүй болсон, сургууль цэцэрлэггүй болсон бүх юмны уг үндэс нь газар байгаа юм.

Газар дээр очиж л зангидагдаж байгаа. Өнгөрсөн хугацааны хамгийн томоохон. Одоо их наядын хэмжээний авлига хулгай ярьдаг болсон байна л даа.

20 жилийн өмнө Монгол Улсад хамгийн их авлигад өртөмтгий байгууллага хаана байна вэ гэхэд газрын албад, гааль хоёр л яригддаг байсан юм.

Газрын албаны даргыг хэн нь тавих вэ, мэддэг байх вэ, газар олгох шийдвэрийг хэн нь мэддэг байх вэ гэдэг өөрөө асуудал. Өнгөрсөн хугацаанд Засаг дарга нар л олгож ирсэн. Нийслэлийн Засаг дарга, дүүргийн Засаг дарга нар.

Аймагт аймгийн Засаг дарга нар. Өнгөрсөн хугацааны бүх энэ авлига. Газрыг Засаг дарга нар өөрийн хувийн өмч мэт зарж эхэлсэн.

Монгол Улсын газар нэгдмэл. Монгол Улс бол нэгдмэл улс. Газрын харилцааны бодлого талын нэг алдагдсан. Тэр ч утгаараа давхцал. Малчид нь, тариаланчидтайгаа асуудал үүсдэг. Бэлчээрийн газар, тариалангийн газар гээд.

Жирийн хөдөө сууж байгаа иргэдийнх нь хотонд нь ашигт малтмалын лиценз олгочихдог. Мэддэггүй. Аймаг нь мэддэггүй бас. Тэр хотоос, төв газраас нэг лиценз олгочихсон гэнэ гээд л нэг мөнгөтэй нөхдүүд ирчихдэг.

Тийм учраас энэ тусгай хамгаалалттай газрын асуудлыг харангуут хотын дарга нь мэддэггүй. Байгаль орчны сайд өнөөдөр Улаанбаатар хотын маш том хэмжээний дүүргийн газрыг мэдээд сууж байдаг.

Магадгүй тэнд нэг Гүндалай гээд нөхөр Зайсангийн газрыг цааш нь зараад л сууж байдаг. Ийм л болчихсон.

Тийм учраас энэ газрын харилцааны бодлогыг мэргэжлийн хувьд, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хувьд нэгдсэн удирдлагаар хангая.

Энэ газар дээр байгаа авлига гэдэг юмыг таслан зогсооё. Газар бол Монгол Улсын нийт ард түмний өмч болохоос нэг Засаг даргын хувийн өмч биш ээ гэдэг бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайд газрын харилцааны энэ байгууллагаа аль нэг сайдын харьяанд биш өөрийн харьяандаа авъя гэдэг ийм улс төрийн шийдвэр оруулж ирж байгаа юм.

Тийм учраас энэ бодлогыг Улсын Их Хурал маань дэмжээсэй.

Яг Монгол Улсын Засгийн газар тэр иргэдэд газар олгох захирамжийг нь гаргах гээд байгаа гэдэг агуулга байгаа бол үүнийг хэлэлцүүлгийн шатад засаж өөрчлөх, үүнийг залруулах боломж Улсын Их Хуралд байгаа юм.

Тийм учраас энэ бичилтийн хувьд алдаатай гэдэг юм уу, бас техникийн хувьд үл ойлгогдоод байгаа энэ асуудлаар дөрөөлөөд Монгол Улсын Ерөнхий сайдын газрын мафитай тэмцье гэдэг энэ улс төрийн хүсэл зоригийг битгий мохоогооч ээ, битгий таслан зогсоогооч ээ гэж хүсэж байгаа юм.

Тийм учраас хэлэлцэхийг дэмжиж үг хэлж байгаа юм.

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолуудын төслийн талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалт явуулна.

Хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Яг тухайн Газрын хууль дээр л тэгж хэлсэн шүү дээ. Үгүй, та чинь дангаар нь авч болно гээд сая үг хэлчхээд. Та чинь дөнгөж сая дангаар нь авч болно гээд хэлэхээр.

Тийм тийм. О.Цогтгэрэл дарга Газрын хууль дээр л гэж хэлсэн.

Тийм. Газрын хууль дээрээ завсарлага өгчихье. Тэгэхгүй бол Газрын хууль чинь унах юм байна. Гишүүдийн чинь талаас олгох нь эсрэг байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ж.Батсуурь гишүүн ээ, Газрын тухай хуулийг дагаад багц хуулиуд өргөн барьчихсан бол түүнтэйгээ л хамт явах юм байна. Энэ Төсвийн тухай хууль чинь хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн. Тусдаа учраас Төсвийн тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд гэж явж байгаа юм байна. Төсвийн хууль нь дэмжигдчихсэн шүү дээ.

Тэгэхээр тусдаа авч үзэж болохоор юм байна.

Ер нь өмнөх практик бол нэг багц хууль орж ирсэн бол тэгж явж байгаа юм.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

69.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн

төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

69.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

68.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэлийн гаргасан саналын дагуу Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлыг ажлын 4 хоногийн завсарлага өглөө.

Энэ яагаад гэхээр нэгдүгээрт газрын реформ бол цогц байдлаар хийгдэх ёстой тусдаа асуудал, татвар шиг ийм нөлөөтэй хууль биш бөгөөд энэ дотор техникийн болон аль аль зүгээс ярьж байгаа зүйлүүд, Үндсэн хуулийн зөрчилтэй ч байж болзошгүй асуудлууд сөхөгдөж яригдаж байгаа учраас ажлын 4 хоногийн завсарлага өгч, энэ хүрээнд олонх, цөөнхийн бүлэг хамтарсан ажлын хэсэг гарч хууль зүйн техникийнх нь хувьд эрх зүйн дүгнэлт гаргаж, хуулийн лавлагаа гаргаад, тэгээд энэ дээрээ. Тийм. Эрх зүйн дүгнэлт гаргаж. Тэгэхдээ Байнгын хороо гаргах ёстой.

Ийм учраас Газрын тухай хуульд завсарлага өглөө.

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл

баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Кадастрын зураглал, газрын төлбөр, Геодези, зураг зүйн тухай хуулиуд чинь Зөвшөөрлийн хууль ч гэсэн.

Зөвшөөрлийн хууль чинь бас газартай холбоотой юу. Засгийн газрын тухай хууль чинь бас шууд холбогдох байх. Зүгээр агентыг нь шилжүүлж байгаа юм л даа. Тэр чинь.

Засгийн газрын хуультайгаа холбоогүй. Энэ чинь гол нь газар олгох асуудлыг яриад байх юм. Засгийн газар нь яах вэ тэр нэгдсэн бодлого, удирдлага зохион байгуулалт байх асуудлыг Д.Амарбаясгалан дарга хэлсэн.

Тэр дэмжчихлээ л дээ. Гишүүд та бүхэн.

Ардчилсан намын бүлэг зөвхөн Газрын тухай хууль дээр л гэж хэлсэн учраас тухайн хуульд нь л завсарлага. Тэр доторх заалтууд нь, тэр газар олгохтой холбоотой заалт дээр л ярьж байгаа учраас.

Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Үг хэлж болно.

57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Дэмжсэн, дэмжээгүй гишүүн. Жамбын Батсуурь гишүүнээр тасаллаа.

Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

**Ж.Батсуурь:** Үгүй яах вэ, ирэх оны төсөв, төсвийн төсөөлөл гээд яриад бид аль болох л болох, бүтэх талаас нь л дэмжээд л нөхцөл байдлуудыг аваад явъя л гэж байна л даа.

Тэгээд яах вэ, энэ чинь одоо 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж ирж байгаа. Юм болгон дээр үг хэлбэл хэлээд л баймаар байна.

Гэхдээ одоо нөгөө дуугүй байх нь дэмжсэний шинж гэдэг байдлаар л явж ирсэн. Гэхдээ яг нөхцөл байдал бас бүр ингээд бодлогын хэмжээнд, концепцын хэмжээнд эвдэрч орж ирж байгаа хуулиуд дээр бид бас үгээ хэлэх нь зөв шүү дээ.

Тэгээд хэлүүлэхгүй юм. Даа ялангуяа Засгийн газрын гишүүд нь өөдөөс орилоод чарлаад.

Тэгээд яг адилхан үг хэлж байгаа өөрийнхөө намынхныг болонгуут зөв хэлж байна, зөв хэлж байна гээд.



Тэгээд асуудалд ингэж хандаж болохгүй. Зүгээр гомдож байна. Та нарт. Ер нь зүгээр 3 жил хэцүү нөхцөл байдалд дэмжиж ажилласан шүү дээ. Дэмжиж ажилласан.

Тэгээд одоо төсөв дагасан хорин хэдэн хуульд өөрчлөлт орж байна гэдэг чинь ер нь самарч байгаа шүү дээ. Тийм.

Тэгээд үүнийгээ зохицуулаад явъя. Сайн сайхны төлөө явъя, бүтээгээд явъя гэж байна.

Тэгээд энэ хуулиудыг чинь хараад байхад орон нутаг гэж юм байхгүй болчихлоо. Монгол Улс чинь өргөн уудам нутагтай, цөөн хүн амтай, Улсын Их Хурлын 76 гишүүний чинь 52 билүү, 54 нь орон нутгаас сонгогддог.

Тэгээд энэ хүмүүсийн цаана байдаг эрх ашгийг энд гаргаж ирээд хэлэнгүүт тэгээд орилоод чарлаад хашхичаад үг хэлүүлэхгүй юм. Тэгээд дангаараа явлаа гээд 2016-2020 онд 65-уулаа, 2020 оноос хойш одоо ингээд бүх л хуулийг дураараа дургиж, дунд чөмгөөрөө найгаад сайндаа хүрчихсэн нь хаана байгаа юм.

Тэгээд одоо энэ Зөвшөөрлийн тухай хууль гээд. Яг үнэндээ Газрын хууль чинь эргээд Зөвшөөрлийн тухай хууль болохоос биш. Дээшээ татагдана гэдэг чинь дээд даргаасаа доод дарга нь зөвшөөрөл авна л гэсэн үг байхгүй юу.

Дахиад л зөвшөөрлийн тухай. Нэр нь өөр болохоос тэр чинь Зөвшөөрлийн тухай хууль гэсэн үг шүү дээ. Бараг л.

Ер нь аливаа зовлонг гэтэлье гэвэл тухайн хүнд нь, тухайн багт нь, тухайн

сумд нь үүрүүлж байж л гатлан дуулна уу гэхээс. Жишээлэх юм бол гэр бүлийн маргааныг хэн шийдэх юм. Багийн дарга шийдэх юм уу? Сумын дарга шийдэх юм уу? Гэр бүл өөрөө л шийднэ биз дээ.

Түүн шиг тухайн сумд байгаа, тухайн аймагт байгаа нутаг дэвсгэрийнхээ хаана нь дахин төлөвлөлт хийх юм, хаана нь гэр хорооллоо байгуулах юм, хаана нь орон сууцаа барих юм. Энэ асуудлуудыг одоо ингэж төвлөрүүлэн татаж агентлаг хийж, тэрний даргыг босоо томилно. Би мэдэж байна. Мэргэн хүн шиг мэдэж байна.

Тэр босоо томилсон хүмүүс цэргийн командаар ажилладаг. Танай намын тогтолцоо тийм шүү дээ.

Тэгээд дээшээ нэг бичиг явна. Хавар 4 сард явна. Ирэхгүй. 7 сард бүтээн байгуулалт. Тэр чинь зөвшөөрөл нь очоогүй юм чинь тухайн үйл ажиллагаа эхлэхгүй. Аягүй бол намар очно.

Ингээд л шат дамжлагууд нэмэгдэнэ. Энэ нөхцөл байдлыг ярья л гэж байгаа юм. Түүнээс биш.

Ер нь нэг ийм Үндсэн хуулийн концепт байна. Нутгийн өөрөө удирдах ёсыг дэндүү байхгүй болгоод авчихлаа. Хуруу хумс, шүд мүд, нүд мүд байхгүй. Одоо аягүй бол. Би дээр хэлсэн. Орон нутгийн сонгуулийн хуулиар аягүй бол аймаг, нийслэлийн иргэдийн Хуралгүй болгох гээд та нарыг гэтэж байгаа даа.

Тэгээд энэ болгоныг хэлэхээр хэлсэн болно. Ярилцъя гэхээр ярилцахгүй.

Ер нь сөрөг хүчин, парламентын засаглал гэдэг чинь харилцан ярилцаж

байж, ойлголцож байж явах ёстой юм байгаа биз дээ. Тэгээд энэ 11 хүнийг ирэнгүүт л 60, 70-аараа ирээд боорлочих юм. Тэгээд тэрийг нь давах гээд арай чанга дуугарангуут орилсон, чарласан болно. Дуугүй байгаад байхаар айж байна гэж бодоод байдаг юм уу, яадаг юм.

Тэгэхээр энэ зөвшөөрөл гэдэг өөрөө авлигал шүү дээ. Эрт дээр үеэс зөвшөөрөл өгнө гэдэг чинь тэр нэг хүнээс зөвшөөрөл авна л гэсэн үг. Тэрийг авахын тулд гуйна. Өгөхгүй бол яах вэ. Дахиад гуйна. Дахиад өгөхгүй бол яах вэ. Жижиг авлигал өгнө. Дахиад хөдлөхгүй бол яах юм. Том авлигал өгнө.

Ингээд л оймс, гутлаас нь гардаг нөгөө олон тэрбум доллар. Тэр нь явсаар байгаад 40 их наяд хүртэл хулгай луйвар дээрээ л ордог шүү дээ. Энэ мэтчилэн өдөр болгон заалт болгон дээр чинь үг хэлээд байж чадна шүү.

Тэгэхээр нөхцөл байдал хүнд байна. Төсөв мөнгөн дээрээ хурдан шуурхай явъя. Төсөв дагасан хуулиар ноднин та нар Шадар сайдын орон тоо оруулж авчирчхаад өнөөдөр Засгийн газрын бүтцийг хийчихсэн л байна шүү дээ.

Бүхэл бүтэн Шадар сайдыг төсөв дагасан хуулиар үйлдвэрлэж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Түрүүн үг хэлээд Ж.Батсуурь гишүүнээр тасалчихсан юм.

Энэ Зөвшөөрлийн тухай хуулийг бичгээр болон цаас, эсвэл цахим хэлбэрээр л гэсэн өөрчлөлт орж байгаа юм. “Бичгээр” гэдгийг “цахим хэлбэр”-ийн өөрчлөлт орж байгаа юм.

Яах вэ, зүгээр геодези, зураг зүйн. Нөгөө төв байгууллагаас, төрийн захиргааны төв байгууллагаас төрийн захиргааны байгууллага руу тэр геодези, зураг зүйн нэг эрхийг нөгөө агентлагт шилжиж байгаатай холбоотой шилжүүлж байгаа ийм л заалт байгаа.

Түүн дээр тэр бусад газарт энэ тэртэй холбоотой юм байхгүй. Ингээд санал хураалтаа явуулья.

Түрүүн Ж.Батсуурь гишүүнээр тасалчихсан юм. Тийм. Санал хураалт. Ш.Адьшаа гишүүн ээ. Ш.Адьшаа гишүүн. Санал хураалт. /алх цохив/

64.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

Наянтайн Ганибал гишүүнийг. Жамбын Батсуурь гишүүн.

Тэгээд та хоёр байна шүү дээ. Үг хэлэх, хэлэхгүйн тухай баахан үг хэллээ. Яг нөгөө хуулийнхаа дэмжих, дэмжихгүйн талаар үг хэлэхгүй бол одоо цаашаа хэлүүлэхгүй шүү.

Тэгэхгүй яг тэр тухайн хуулийнхаа л дэмжих, дэмжихгүйгээр. Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Энэ авлигалын асуудал дээр яах вэ оруулж ирж байгааг нь дэмжиж байна.

Тэгэхдээ энэ асуудлууд бид өнөөдөр ингээд нэг жижиг жижгээр

асуудлыг шийдсэнээрээ бид өнөөдөр авлигатай тэмцэж байна гэвэл үгүй байна. Монгол Улсын хувьд эдийн засгийн өнөөдрийн байгаа бүтэц чинь болохгүй байна шүү дээ.

Төрийн өмчтэй баахан компаниудыг бий болгоод, түүгээрээ дамжуулаад хулгай зэлгий хийдэг. Тэндээс орж ирсэн хэдэн татварын мөнгөнөөс, нүүрсний хэдэн төгрөгөөс худалдан авалт болгон дээр нь цавчаа байдгийг сая энэ ногоон автобус харууллаа.

Ямар бүтээгдэхүүн нийлүүлэх гэж байсныг нь бас Монголын ард түмэн бүгд мэдлээ.

Тэгэхээр өнөөдрийн энэ авлигатай тэмцэх асуудал дээр энэ жижиг асуудлыг шийдсэнээрээ Монголын авлигал ер нь хэдэн хувиар буурах юм бэ гэдэг асуудал бас гарч ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид энэ тогтолцооны өөрчлөлтөө хийхгүй бол. Та бүхний хүсээд байгаа өнөөдрийн бий болгож байгаа энэ нийгэм чинь өөрөө болохгүй байна. Энэ төрийн алба чинь өөрөө болохгүй болчихлоо.

Одоо ингээд төсөв дагуулаад хорин хэдэн хууль. Хорин хэдэн салбарыг бүгд дээр нь ингээд жижиг жижиг өөрчлөлтүүд энэ хуульдаа орчхож байгаа юм. Нөгөө нэг том хуулиудаа бүгдийг нь эвдээд байгаа байхгүй юу.

Ингээд арван хэдэн жил, одоо бараг хориод жил ингэсэн байдлаар үндсэн том концепцууд нь төсөв дагасан жижиг хуулиудаар дандаа эвдэгддэг. Энэ асуудал тэр төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, бүтээгдэхүүн худалдан

авах тэр хуульд орсон тэр өөрчлөлтүүдээ та бүхэн эргээд нэг харчхаарай. Бүр сэгчээд хаячихсан байна лээ шүү дээ. Сэгчээд хаячихсан.

Тэр КОВИД-ын үед оруулсан өөрчлөлтүүд чинь өнөөдөр хүртэл ингээд үйлчлээд яваад байна.

Нэгдүгээр зэрэглэлийн өндөржүүлсэн бэлэн байдлын асуудлын үед хийгдсэн худалдан авалтууд чинь өнөөдөр хүртэл вакцин худалдаж авахдаа тэр хуулийг дагаад, өнөөдөр бэлэн байдал нь байхгүй болсон ч гэсэн тэрийг ашиглаад яваад байна шүү дээ.

Үүнийг ер нь хэн хянах юм бэ? Энэ асуудлууд дээр ер нь хэн анхаарах юм бэ?

Тэгээд та бүхэн болохоор өөрсдөө бие биеийгээ ингээд хамгаалдаг. Магадгүй Монгол Ардын намаас бий болсон Засгийн газруудын үйл ажиллагаан дотор чинь ард түмний хүсээд байгаа тэр хяналтын асуудлууд чинь орхигдоод байна.

Та хэд бие биеийгээ нэг нам гэдгээрээ хамгаалаад байгаа байхгүй юу. Монгол Ардын намынх гэхээрээ заавал муу муухай биш шүү дээ. Миний ээж, аав бүгдээрээ л Монгол Ардын намын гишүүд.

Гэхдээ тэр хүмүүс ч гэсэн шударга асуудлыг хүсээд байна. Шударга байхыг хэлээд байна.

Тэгээд бид өнөөдөр ингэж бие биеийгээ хаацайлаад хорин хэдэн хууль дээр дандаа болохгүй, бүтэхгүй үйл ажиллагаануудыг энэ дотор ингээд шингээгээд оруулдаг энэ төсөв дагасан

олон хуулиудаа л хэдүүлээ болимоор байгаа юм.

Үндсэн хуульд нь ч бараг заачихсан байгаа шүү дээ. Хэдүүлээ том хуулиараа энэ органик хуульд өөрчлөлт оруулах тэр зарчим гэж байгаа.

Дээрээс нь, төсвийн хүрээний мэдэгдэл, эдийн засгийн хөтөлбөр гаргадаг болчихсон. Та хэд чинь Үндсэн хуульд олон том сайхан заалтууд оруулсан шүү дээ.

Тэгээд тэд нарыг чинь бүгдийг нь олон жижиг хуулиар зөрчдөг. Төсөв дагуулаад хуулиа өөрчилдөг. Бид чинь хууль баталчхаад төсвөө хийх ёстой байтал төсөв дагуулж хуулиа. Логикийн хувьд эсрэгээрээ яваад байгаа байхгүй юу.

Тэгээд үүнийг л ямар ч байсан. Уг нь 76 гишүүн байхдаа энэ асуудлыг зогсоогоод эх оронч шийдвэр гаргасан бол уг нь ирээдүйн парламент, ирээдүйн Засгийн газруудад уг нь хэрэг болох байсан юм. Харамсалтай нь ийм эрх өөрсдөдөө авч чадахгүй байна.

Энэ Газрын хууль бол үнэхээр бантан болгож байна. Газрын хууль дээр үг хэлнэ.

**Г.Занданшатар:** Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Манай 65-ын бүлэг энэ нэг хуулийг нэг харчих даа. Та нар.

Ингэж байгаа юм. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай. Бүх л том хуульд өөрчлөлт оруулна. Өөрчлөлт ороод дараа нь тэр хэвлэгдэнэ. Зөндөө юм болно.

Тэгэхдээ энд ямар үг, үсэг байна вэ гэхээр эхлээд төсөв дээр нь зэрэглэлийг нь өөрчлөөд тавьчихаж байгаа юм. Сая Н.Ганибал гишүүн хэлж байна шүү дээ.

Хууль батлагдахаас өмнө өгөх мөнгөө тэнд тохирчихсон байхгүй юу. Тэгээд тэрийгээ араас нь хуульчилж байгаа юм.

Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, нууцалбал зохих албаны ажилтнаар ажилласан хугацааг цэргийн албан хаагчийн хугацаанд тооцох ба эдгээр албан тушаалд ажилласан нэг жилийг 1.3-тай чацуу болгоно гээд л. Ингээд л нэг бүтэн хуульд өөрчлөлт оруулж байгаа байхгүй юу.

Гэх мэтчилэн ингээд 21 хуулийн бүх заалт дээр бид үг хэлээд байвал хэлээд л байна. Мууг нь хэлээд л, гуугийг нь малтаад байвал малтаад л байна.

Гэхдээ тэгдэггүй. Тэгдэггүй. Хэцүү байна. Хамтдаа урагшилья гэж байна. Хамтдаа урагшилья гэж байна. Дэмжье гэж байна. Тэгээд бид тэгж тэр болгон үг хэлээд байдаг ч үгүй. Нөхцөл байдал хүнд байж улс төрийн акц хийгээд байдаг ч үгүй.

Тэгээд хааяа нэг үг хэлэнгүүт ингээд барьж идчихгээд байдаг учраас одоо би үүнээс хойш, түүнээс цааш бүх хуулийн заалт дээр бүх зүйлийг хэлээд өгье. Бид нарыг хэлээд өг гэж байгаа ард түмэн зөндөө байж байна.

Тэгээд авлигатай ингэж тэмцдэг юм уу? Тэгвэл. Хэрвээ авлигатай тэмцэх хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа бол

концепцынхоо шинж чанартай юмнуудыг оруулаад л ир л дээ. Ерөөсөө ганцхан өгүүлбэрээр.

Тэгэхээр би үүнийг Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай гээд аягүй гоё сонсогдож байна шүү дээ. Орой мэдээгээр явна. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулж байгаа. Одоо ард түмэн юу гэж сонсох вэ. Хөөрхий минь тэр хуульд өөрчлөлт оруулаад бидний авлигачдаас салгаж өгөх гэж байгаа байх л гэж дотор нь амарна.

Тэгэхэд тэнд өөрчилж байгаа өгүүлбэр нь ерөөсөө л авлигын л хууль байхгүй юу. Авлигачдыг.

Тэгэхээр ийм байдлаар хэдүүлээ авахгүй. Тэгээд та хэд энэ байдлаа ярьж, завсарлага авъя гэхээр авахгүй байгаа учраас. Завсарлага авах юм бол хэдүүлээ концепцын хувьд ярьчихна.

Тэгэхгүй ээ. Одоо ингээд заалт бүгдээр нь яриад байхаар яриад л байна. Үгүй үгүй. Яг үнэндээ би ахиад ярих юм бол Н.Мягмараар тайлбар авмаар байна.

Дагасан хуулийн нэгэн дээр нь, зөвхөн газрынх дээр нь завсарлага өгдөг тийм заалт байх юм бол дараагийн хуулиуд дээр би яг ийм заалтаар чинь завсарлага авуулна шүү. Бүлгээр. Та хэд өгөхгүй гээд бас гонгинов.

Тэгээд одоо энэ Б.Энхбаяр, Ж.Сүхбаатар гээд энэ хуульч гишүүд яаж байгаа юм бол гээд л хавчигнаад сууж байгаа байх л даа.

Тэгээд Б.Энхбаяр уг нь гайгүй юм ярьдаг байсан юм. Засгийн газрын гишүүн болоод шууд дүр нь хувираад

бурхан царайлаад явчихлаа л даа, энэ. Одоо чамд ард түмэн итгэх ч үгүй.

Гайгүй бид нарын талд ороод бас зөв, буруу юм яриад байдаг. Одоо тэгээд Засгийн газрыг магтан дуулаад ингээд суугаад байх юм.

Газрын хууль өөрийнх нь түрүүн ярьж байсан юмных нь эсрэг ороод ирэхэд Засгийн газрын гишүүн болчхонгуутаа аа.., одоо зөв юм хийж байна гээд.

Олгодог, олгодоггүйдээ асуудал ерөөсөө яриагүй. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх хэмжээний асуудлуудыг оруулаад ирж байна гээд л ярьж байгаа байхгүй юу.

Газар зарагдана гэж байдаггүй юм. Газар дуудлагаар өгнө л гэж байдаг юм. Түүнээс газар зарагдана гэж хэзээ ч байдаггүй.

Ер нь зүгээр би нийслэлийн асуудал. Тийм. Нийслэлийн асуудлуудыг ярих нь зөв гэж бодож байгаа юм. Зөв асуудал.

Гэтэл яг үүнтэй малгайлаад Монголын нийт газар нутгийн хэмжээний бүх нэгжийн хэмжээний ийм өөрчлөлт орох нь буруу. Буруу. Ийм зүйлүүд байна. Дарга.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулья.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. /алх цохив/

70.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Наянтайн Ганибал. Тэгэхдээ ингээд хэлсэн үгээ зөрөөд баймааргүй байна. Түүрүүн Жамбын Батсуурь гишүүн хэлэхдээ тусад нь дангаар нь өгч болно гэж би бодож байна. Тэгж өгч байсан гээд тэгснээ, сая одоо болохоор салгаж өгч болохгүй гэж хэлээд байх.

Наянтайн Ганибал гишүүнээр тасалсан.

**Н.Ганибал:** Төр, хувийн хэвшлийн түншлэл.

Монгол Улсад хувийн хэвшлийнхэндээ төр боломж олгодог энэ байдлуудаа дэндүү үгүй хийж байна. Энэ угаасаа хуулиараа л ингээд үгүй хийгээд байгаа.

Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Их Хурлын гишүүд бас мэдэхгүй зөндөө асуудлууд цаана нь байгаа байхгүй юу. Мэдэхгүй.

Одоо тэр Төрийн болон албаны нууцын хуулийг ашиглаад Монгол төрийн өмнөөс нууцад оруулж байгаад төр шууд худалдан авалт хийчихсэн хэдэн худалдан авалт байгааг өнөөдөр хүртэл манай Их Хурлын гишүүд мэдэж чадахгүй байгаа.

Өнөөдөр нийслэл дээр хэд байгаа юм. Энэ асуудлыг тавиад хариу нь ирэхгүй байна. Хариу нь ирэхгүй.

Тэгээд түр хороо байгуулаад хэдүүлээ энэ асуудлуудыг ингээд гаргая гэхээр та хэд маань бас дэмжээд гарын үсэг зурчихгүй юм. Уг нь 6 гишүүн зурчихвал түр хороогоо байгуулаад Их Хурлын бүрэн эрхийнхээ тэр мэдэх...

**Г.Занданшатар:** Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. Өөр асуудал яриад байх юм та.

**Н.Ганибал:** Төрийн оролцоог хэтэрхий их бий болгож байна гэдэг чинь буцаагаад бид социалист нийгэм рүүгээ л яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр хувийн хэвшлийнхнийгээ бид энэ хуулиараа хаагаад боогоод байна. Тэр төрийн болон орон нутгийн өмчийн худалдан авах тэр хуулиар орсон өөрчлөлтүүдээ та нар эргээд нэг харчхаарай.

Хэрвээ шаардлагатай гэвэл танай бүлэг дээр би ороод өнгөрсөн 7 жилд энэ хуульд ийм ийм өөрчлөлтүүд оржээ гээд мэдээлэл хийсэн ч болно.

Энэ хуулиудаараа бид хаагаад байгаа юм. Бүр цаашлаад энэ хуулиудаар бид олон улсын хэмжээнд нээлттэй тендер зохион байгуулах эрхээсээ ухарч байгаа юм.

Энэ олон улсын хэмжээнд Монгол Улс хаалттай худалдан авалт зохион байгуулдаг улс орон болох тийм аюул хүртэл ингээд энэ хууль руугаа өөрчлөлт хийснээр ороод байгаа юм.

**Г.Занданшатар:** Тийм. Н.Ганибал гишүүн ээ, та хэд чинь яг ямар хуулиар санал гаргах гэж байгаа юм. Тэндээ дэмжсэн, дэмжээгүйгээ хэлчихмээр байна.

Тэгэхгүй бол одоо шал өөр хууль ярьсаар байгаад л тэгээд цаг чинь дуусчихлаа.

Санал хураалт явуулъя. Тийм. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 8-д заасан хууль батлагдсанаас хойш 6 сарын хугацаанд гэснийг хууль хүчин төгөлдөр болохоос үйлчлэхээс өмнө гэж өөрчлөхгүй л гэсэн хууль байгаа шүү дээ.

Санал хураалт. /алх цохив/

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг хүчингүй болгоё. Жамбын Батсуурь гишүүнийг тасаллаа.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. /алх цохив/

Жамбын Батсуурь гишүүн үг хэлнэ.

**Ж.Батсуурь:** Үгүй яах вэ, ийм л дээ. Өнөөдөр ард иргэд Монгол Улсын төсвийг хэлэлцэж байна гэж ойлгож байгаа.

Ирэх онд бид ямар цалин нэмэгдэх вэ, тэтгэвэр яаж нэмэгдэх вэ, хаанаас ямар татвар орох гэж байгаа юм гээд.

Тэгээд би Байнгын хороон дээр уул уурхай гээд яриад байхгүй, мал аж ахуйг яаж сэргээх вэ гээд олон зүйлүүдийг ярьж байгаа юм.

Эргээд судлаад үзэхэд Төсвийн тухай хуулийг хэлэлцэхэд дагасан хууль нь цөөхөн байдаг байсан.

С.Чинзориг сайд аа, би нэг үг хэлчихье. Намайг үг хэлүүлдэггүй байхгүй юу.

Тийм болохоор өнөөдөр бид олон улсад хөрөнгө оруулалт татах гээд, олон улсад Монгол Улсын эдийн засаг тогтвортой юм. Хууль эрх зүйн орчин тогтвортой юм. Гаднын хөрөнгө оруулалтуудыг татах хүсэлт бид нарт байна. Гуравдагч орны зах зээлд гарах ийм нөхцөл байна.

Үүнийхээ дагуу бид олон нийтийн хяналттай үнэт цаас гаргах, төрийн өмчийг задлах барих гээд ингээд бодлогын юмнууд орж ирвэл энэ хуулиудыг батлахад дургүйцээд байх юм байхгүй байгаа юм.

Гэтэл төсөв батлах нэрээр 27, 28 хуулийг сэглээд дээр нь баахан тогтоолууд орж ирнэ.

Одоо та нарыг энэ хууль баталж дууслаа. Хэлэлцэх үү, хэлэлцэх үү гэж баталж дуусаад тэгээд одоо Их Хурлын тогтоолууд ороод ирнэ. Зээлийн хэлэлцээрүүд ороод ирнэ.

Хүн ойлгохын арга байхгүй байдлаар ингэж. Энэ юу вэ гээд тэгэнгүүт Засгийн газрын сайд нар төсөвт өөрийнхөө эрх мэдлийг оруулж байгаа л асуудлууд. Цалингаа нэмүүлж байна, шатлалыг нь нэмүүлж байна.

Тэр болгон нь хууль дээр гацангуут нь дагасан хуульд оруулаад ирчихдэг.

Тэгээд энэ бүрийг дуугүй байгаад байнгуут та нар энэ хэд мэдэхгүй гэж ойлгоод байгаа байхгүй юу.

Энэ хэдэн тэнэг юмнууд мэдэхгүй. Тэгээд мэдэхгүй болохоороо бид нарыг хэлэхгүй байна, эсвэл айж байна гэж ойлгоод байгаа юм. Айж байна гэж ойлгодог.

Тэгэхээр парламентын нөхцөл байдлыг улам сайжруулах зорилгоор энэ төсвийг ч гэсэн хурдан түргэн явуулъя гэдэг дээр бид санал нэг байна уу гэвэл байж байна.

Тэгэхдээ бие биеийнхээ үгийг ойлголцох хэрэгтэй шүү дээ.

Ажлын хэсэг. Ойлголцъё гэдэг чинь цөөн үгээр завсарлага авъя л гэсэн үг. Айл гэрт ч гэсэн, найр наадам дээр ч гэсэн үг зөрж байгаа хүмүүс та хоёр гараад ойлголцчихоод ир гэдэг шүү дээ.

Тэр чинь завсарлага авч байна гэсэн үг байхгүй юу.

Тэгээд завсарлага авъя гэхээр нь завсарлагыг нь өгөхгүй. Тэгээд завсарлага аваад ороод ирсэн бол өдийд орж ирчхээд шуураад л явж байгаа. Тэгээд завсарлагаасаа илүү хугацаанд ингээд хууль болгон дээр асуудлаа яриад яваад байх юм бол яриад л яваад л байна.

Тэгэхээр би одоо Ардын намынхаа гишүүдийг, та нар бүлэг дээрээ мэдээж зарчим үйлчилдэг л байх.

Гэхдээ энэ дагасан хуулиуд дээр үг хэлэхгүй юм уу. Та нар чинь.

Ингээд бүх хуулиудынхаа өөрийнхөө салбарын хуулиудыг сэглүүлээд дуусгачих юм уу. Энэ нөхцөл байдал дээр анхаарах хэрэгтэй.

Тийм учраас Үнэт цаас гаргах эрх олгох тухай хууль гэдэг дээр нь харангуут төрийн компаниудыг задлах гэж байгаа, олон нийтэд арилжих гэж байгаа ийм асуудал энэ дотор үндсэндээ бараг байхгүй байна шүү дээ.

Тэгэхээр гишүүдээ энэ дагасан хуулиудыг та бүхэн маань бүгдээрээ нэг ахиж хараач ээ, нухацтай хараач ээ.

Зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт хэсэг дээр анхаарлаа тавиад.

Тэгээд тэр Ирээдүйн өв сангийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль гээд задлаад ярих юм бол далай далай юмнууд тэнд байж байгаа шүү дээ. Үүнийг Та бүхэндээ анхааруулж байна. Бид цөөхөн, 11-хэн хүн юу ярих вэ дээ. Хэдүүлээ 76-уулаа ярья л даа.

**Г.Занданшатар:** Санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/



52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг гишүүд дэмжсэнгүй.

Дараагийн санал хураалтыг явуулья. Тэгээд энэ оруулж ирсэн сайд нар өөрсдөө дэмжихгүй байгаа юм бол хэрэггүй юм байлгүй.

Болдын Жавхлан сайд.

**Б.Жавхлан:** Уучлаарай. Сая үүднээс цайгаа уух хооронд санал хураалтад хоцорчхож. Ёстой миний буруу боллоо.

Дахиж санал хурааж өгөх боломж байна уу? Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хурааж өгөөч ээ. Ажил удсандаа гишүүдээсээ хүлцэл өчье. Уучлаарай.

**Г.Занданшатар:** Дэмжсэн боловч дэмжээгүй санал өгсөн тийм л горимын санал хураагдана л даа.

Энэ Ж.Эрдэнэбат, Л.Энх-Амгалан, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ц.Сэргэлэн, Б.Жавхлан, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, С.Ганбаатар, Жамбын Батсуурь, Б.Баделхан, Ш.Адьяа, Жамбын Батсуурь гишүүн, Г.Амартүвшин.

Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Түрүүн юун дээр нэлээн анхаарлаа хандуулж байгаад. Сая яг дэмжих ёстой юун дээр энэ товч ажилласангүй. Дахин санал хураалт.

**Г.Занданшатар:** Энэ зүүн бүсийн дулааны асуудал учраас.

Жамбын Батсуурь гишүүн хүчингүйд тооцох санал хураалт явуулья гэсэн горимын санал гаргалаа. Горимын саналаар санал хураалт явуулья.

63.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

63.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт. /алх цохив/

76.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал

хураалт. Санал хураалт явчихсан. /алх цохив/

65.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үүнийг бас анхаараарай. Тийм ээ. Завсарлага. Ардчилсан намын бүлэг дээр үүнийг өөрчлөх юмнуудаа яриарай. Завсарлагынхаа хүрээнд.

“Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул дэмжсэн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

Төсвийн байнгын хороо гишүүдийн гаргасан санал, шүүмжлэлийг эхний хэлэлцүүлэг дээр анхаарч, зөрчилтэй байж болзошгүй заалтуудыг нэгтгэж, Төсвийн тухай хуулийн агуулгатайгаа нийцүүлэх, төсөвтэй шууд холбоогүй мөртлөө дагалдуулж орж

ирсэн асуудлуудыг ялгаж салгах шаардлагатай.

Г.Тэмүүлэн дарга аа.

Төсөв батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний төсөлд Засгийн газар аймаг, орон нутгийн Засаг дарга нарт бид, сумын Засаг дарга нарт Улсын Их Хурал үүрэг чиглэл өгөхгүй шүү дээ.

Тэр захиргааны эрх зүйн актын хэм хэмжээний хүрээндээ Б.Ганбат дарга үзээд Засгийн газраас чиглэл өгөхөөр юмнуудыг Улсын Их Хурал үүрэг чиглэл өгөхөөр заачихсан байна лээ.

Тэгээд үүнийг зүгээр ерөнхий утгаар нь найруулж засах. Тогтоолын төсөл дээр их ажилламаар юм билээ шүү.

Тогтоолын төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн. Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. /алх цохив/

Одонгийн Цогтгэрэл гишүүн үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** Өчигдрийн чуулганы нэгдсэн хуралдаан дээр Тусгай хяналтын дэд хорооны гишүүний асуудлаар Ардчилсан намын бүлгээс завсарлага авчихсан байсан.

Тэгэхээр өнөөдөр бас тэр Тусгай хяналтын дэд хороонд орох гишүүний асуудал эцэслэгдсэн учраас ирэх долоо хоногт Байнгын хороогоор хэлэлцэх бололцоог хангахын тулд тухайн асуудлаар авсан завсарлагын хугацааг цуцалж өгнө үү.

**Г.Занданшатар:** Ойлголоо.

Бямбарагчаагийн Тэлмүүн. Сайд та хоёрын яриаг би сая сонслоо.

Та нөгөө судалгаагаа бүтэн сайнд гаргаж өгнө шүү дээ. Тийм ээ. Нэг дэх өдөр гаргаж өгөх үү. Хэзээ гаргаж өгөх билээ? Аан.

Ардчилсан намын бүлгийн завсарлагын хугацаа дууссанд тооцлоо. /алх цохив/

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Бямбасүрэнгийн Энх-Амгалан дарга хуралдаад Ардчилсан намын бүлгийн саналыг авч үзээд Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнийхээ асуудлыг шийдвэрлэе. Шийдвэрлэх чиглэл өгч байна. /алх цохив/

---

### Дөрөв.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

---

Дараагийн асуудалд орно.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшинг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын

байнгын хорооны, Ганибалын Амартүвшинийг Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр баталсугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. /алх цохив/

Тогтоолын төсөл батлагдлаа.

Би түүрэн уншиж танилцуулсан. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга, Ардчилсан намын бүлгийн дарга, гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө бүх ард түмний санал хураалт 78 жилийн өмнө 10 дугаар сарын 20-ны түүхэн энэ өдөр зохион

байгуулагдсан Тусгаар тогтнолын санал асуулгын өдрийн мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Баярын мэнд хүргэе. /алга ташив/

Энэ санал хураалт 1945 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсад оршин сууж байгаа бүх ард түмний дунд Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг

тусгаар тогтносон улс байлгахын төлөө явуулсан бүх ард түмний санал хураалт бөгөөд 100 хувийн саналаар дэмжсэн болно.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

*Хуралдаан 6 цаг 19 минут үргэлжилж, 16 цаг 30 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**

---